

ЖОН БИВЭР



ДИЛГАН СУРДЧИЛГИЙГ ЯЛЛАХУЙ

ӨӨРИЙГӨӨ ЯЛЛАХГУЙГЭЭР “ҮГҮЙ” ГЭЖ ХЭЛЖ СУР
ХҮНД ТААЛАГДАХЫН ТӨЛӨӨ БИШ, ӨӨРТӨӨ ИТГЭЛТЭЙ БАЙЖ СУР

Эрхэм анд минь,

“Бурханаас өгөгдсөн өрх мэдэл дотроо алх. Үгүй аваас өөр нэгэн булааж аваад, таны эсрэг хэрэглэнэ.” Энэ илчлэлийг хүлээн авснаас хойш зүрхэнд минь энэ үг цуурайтсаар явсан юм. Энэ үгийг даруухнаар хүлээн авсан бүгдэд энэ үг хамгаалалт ба тэнгэрлэг мэргэн ухааны үг болдог. Айдсын Ялахуй номын хуудас бүрээс энэ талаар уншина.

Бурханд үр дүнтэй, баяр хөөртэй үйлчлэхэд айдас биднийг үхүүлдэг. Энэ бол дайсны зэвсэг. Айдас сүрдүүлгийн муу ёрын үндсийг олж бариад, яагаад танд “үгүй” гэж хэлэх хэцүү байдаг, яагаад та үнэнтэй нүүрэлдэхээс айдаг, яагаад зөрчлөөс зайлсхийдэг, яагаад бусдад таалагдах гэж хамаг эрч хүчээ бардгаа эндээс сураарай.

Миний зүрхэнд тавьсан Эзэний энэ илчлэл дэлхий даяар олон зуун сая удирдагчдыг босгон байгуулах болтугай. Танъж мэдэх бүх хүндээ энэ үгийг та дамжуулаарай. Итгэмжит энэ үгийг та хүлээн авч, бусдад дамжуулж, хүчирхэгжүүлж, баялаг амьдралыг ерөөе.

Дарамт, найдваргүй байдал, эргэлзээ, хүлээсэнд амьдралаа боолчуулах шаардлагагүй. Бурхан биднийг зоригтой байж, эрх чөлөөтэй байлгахыг хүсдэг юм шүү. Бурхан энэ номын үгээр таны амьдралыг хувирган өөрчлөөсэй гэж би залбирч байна. Та Бурхантай учирч, та болон таны халамжид байдаг олон хүний амьдрал ерөөгдөөсэй.

Христ доторх таны ах, дүү



Жон Бивэр
JohnBevere@ymail.com




MessengerX.com



MESSENGER
INTERNATIONAL
MessengerInternational.org

ЖОН БИВЭР



АЙЛГАН (ҮРДҮҮЛГИЙГ ЯЛЛАХУЙ

ӨӨРИЙГӨӨ ЯЛЛАХГҮЙГЭЭР “ҮГҮЙ” ГЭЖ ХЭЛЖ СУР
ХҮНД ТААЛАГДАХЫН ТӨЛӨӨ БИШ, ӨӨРТӨӨ ИТГЭЛТЭЙ БАЙЖ СУР

Breaking Intimidation (Mongolian) by John Bevere
© 2022 Messenger International
www.MessengerInternational.org

This book is a gift from Messenger International,
the Ministry of John and Lisa Bevere.

Additional resources in (Mongolian) are available for
free download and video streaming at
MessengerX.com and on the **MessengerX app**

To contact the author: JohnBevere@ymail.com

АЙЛГАН СҮРДҮҮЛГИЙГ ЯЛАХУЙ
Жон Бивэр

© 2022 Мессенжер Интернэйшинэл
www.MessengerInternational.org

2022 онд шинэчлэн орчуулж, найруулав.

Энэхүү номыг Христэч удирдагч нарт ҮНЭГҮЙ ТАРААХ зорилгоор
хэвлэсэн бөгөөд худалдан борлуулахыг хориглоно.
Номын зохиолч Жон Бивэр Монгол чуулганд бэлэглэв.

Монгол хэл дээрх бусад хэрэгтэй материалыа
MessengerX.com болон **MessengerX app** -аас
шууд үзэх эсвэл утсандаа татаж авах боломжтой.

Зохиолчтой холбогдох имэйл: JohnBevere@ymail.com

Библийн ишлэл: Ариун Библи
© 1995, 1996, 1997, 1998, 1999, 2000 Монголын Библийн Орчуулгын Хороо
© 2004, Ариун Бичээс Библийн нийгэмлэг



App Store is a trademark of Apple Inc., registered in the U.S. and other countries.
Google Play and the Google Play logo are trademarks of Google LLC.

Та бүхэндээ чин сэтгэлийн талархлаа илэрхийлье...

Эзний дараа орох миний хонгор найз гэргий Лизадаа баярлалаа.
Чамтай гэрлэх завшаан хайрласан Эзэндээ яаж талархахаа ч мэдэхгүй
нь. Энэ номыг хянан засварлах ажилд өөрийгөө бүрэн зориулсанд
үнэхээр баярлалаа.
Чамдаа хайртай шүү.

Хөвгүүддээ...

Миний ууган хүү Аддисон! Хүүгийн минь өр зөөлөн сэтгэл аавынх
нь зүрхийг хайлуулдаг. Чи нээрээ л нэр шигээ “итгэмжтэй” хүү шүү.
Миний удаах хүү Аустин! Миний хүүгийн бусдын төлөө гэх зүрх
сэтгэл аавыг нь дандаа баясгадаг. Аавын хүү Александр, чи бол
байгаа газраа баяр хөөр цалгиадаг хүү. Харин отгон хүү Арден минь,
чи бол аав, ээж, ах нарынхаа аз жаргал шүү.

Аав ээж хоёртоо баярлалаа. Та хоёр хүүдээ бурханлаг аав, ээж хоёр
байсанд баярлалаа. Надад сайхан аав, ээжийг занасан Бурхандаа
баярлалаа. Хайртай шүү та хоёртоо.

Messenger International байгууллагынхаа бүх ажилтан, албан
хаагчдын итгэмжтэй байдал, тус дэмд талархаж байна.

Хүний төлөө үнэн голоосоо баярлаж чаддаг анд найз Жон
Мэйсондоо талархья.

Өнөөдрийг хүртэл бидэнтэй мөр зэрэгцэн ажиллаж, чаддаг мэддэг
бүхнээрээ дэмжсээр ирсэн Карисма байгууллагынхаа хамт олонд
баярлалаа. Та нар бүгдээрээ үйлчлэлийн маань онцгой түвш бөгөөд
нөхөд билээ.

Тэгээд мэдээж хэзээ ч биднийг хөсөрдүүлдэггүй хайрлынх нь төлөө
тэнгэрлэг Аавдаа баярлалаа. Хайр, нигүүлсэл, үнэнийх нь төлөө Эзэн
Есүстээ баярлалаа. Энэ ажлыг эхнээс нь дуустал итгэмжтэй удирдсан
Ариун Сүнсэнд үнэн голоосоо баярлалаа.

Зохиогчийн үг

Энэ номыг бичиж байхад Эзэн надад ийн эш үзүүлэв:

Эцсийн энэ өдрүүдэд Миний их цэрэгт дуудагдсан хүмүүс дунд айdas сурдүүлэгт хулэгдсэн нь олон байна. Тэд Бурханд ч, хүнд ч цэвэр зүрх сэтгэлээр ханддаг боловч, настай Гидеон шиг хүнээс аих айдаст олзлогдоож (Шүүгч 6-8), Тэдэнд өгсөн Миний бэлэг авьяас бөхжсээ.

Гэхдээ Би тэдний айдсыг тасар татааж, тэднийг зуу зуугаар нь чөлөөлөхийн тулд энэ номын үг үсэг бүрийг тослноно.

Тэд өндийж босоод, Намайг ямар ч айdasгүйгээр дагана. Тэд Миний эрэмгий зоригт дайчид болж, Бурханыхаа хүч чадлаар аугаа ялалт байгуулна.

АГУУЛГА

Өмнөх үг	9
Эхлэл	11
I. Сүнсний байр сууриа байгуулахуй	
1. Эрх мэдэл дотроо алх	15
2. Сүнсний байр суурь, эрх мэдэл	25
3. Хоёр төрлийн туйлшрал	35
4. Бэлэг авьяас	45
II. Айлган сүрдүүлгийг илчлэх нь	
5. Идэвхигүй бэлэг	57
6. Айлган сүрдүүлэгт ховсдуулах	69
7. Айлган сүрдүүлгийн сүнс	79
III. Айлган сүрдүүлгийг ялахуй	
8. Бэлгээ бадраа	91
9. Айлган сүрдүүлгийн үндэс	103
10. Хүсэл хангалтгүй	115
11. Бурханаас эмээх, хүнээс айх	129
12. Үйлдэл хийх үү, мэдрэмж үзүүлэх үү?	145
13. Саруул ухааны сүнс	155
14. Давшсаар бай	169
Эпилоги	183

ӨМНӨХ ҮГ

Жон Бивэр шиг хүнтэй танилцаж, энэ олон жил хамтран зүтгэх төдийгүй нөхөрлөсөөр ирсэн маань Бурханаас заясан онцгой хайр хишиг билээ. Бурхан Өөрийнхөө хүмүүст ялалт, итгэл найдварынхаа үгийг хүргэхийн тулд Жоныг тослосон гэдэгт би итгэдэг.

Энэ ном Христийн биед нүдээ ч, цагаа ч олжээ. Уг нь Бурхан үгээ дэлхийд хүргэхийн тулд биднийг бэлэг авьяасаараа хуягласан байлтай. Гэтэл бид үүнийг нь хэрэглэх нь байтугай, Христээс олгосон онц бөгөөд бүрэн эрхт мэдлийг маань довтлох том жижиг - янз бүрийн дайралтаас болж гэрдэг ухарсаар байна.

Сатан нөхцөл байдлыг хурууныхаа үзүүрээр эргүүлж, хүмүүсийг бэлгээ хэрэглэх чадваргүй болгохын тулд бүхий л ур ухаанаа сүвэгчилдэг. Айсан боловч, адагтаа ялсан олон итгэгчийн талаар Библи өгүүлдэг. Жишээлбэл: Иошуа, Гидеон, Нехемия, Давид байна.

Чиний эсрэг бүтээгдсэн нэг ч зэвсэг бүтэлтэй болохгүй.

— Исаиа 54:17

Энэ номоор болон Ариун Сүнсний хүчээр дамжуулан итгэгч хүн бүр айдсыг тасар татаж, ялалтад хүрнэ. Бурхан Эзэн маань айдсын өөдөөс архирч чаддаг, ухрахыг мэддэггүй их цэргийг босгох болтугай!

— Жон Мэйсон

An Enemy Called Average, Let go of Whatever Makes You Stop and
Words of Promise номын зохиолч

ЭХЛЭЛ

Итгэгчид айдаггүй л гэж битгий хэлээрэй. Mash олон итгэгч айдастай амь тэмцэн зөрчилддөг. Гэхдээ уг үндэстэй нь биш, үр дагавартай нь л ноцолдоод байдаг. Үнэн тансаг эд хогшилтой нэгэн байшин байжээ. Хачирхалтай нь тэр байшин дээвэргүй юмсанж. Аадар асгахад, байшин усанд автаж, хамаг байдаг нь сүйдэв. Борооны дараа гэрийн эзэн эвдэрч хэмхэрч, бохирдсон тавилга, шал, хивсээ зайлцуулж, янзлах гэж хэдэн өдөр болсон ч, эцэстээ байшинаа урьдын адил сайхан болгож чаджээ.

Гэтэл ажил дуусахын даваан дээр өөр нэгэн шуурга дэгдэж, нөгөө сайхан байшиング чинь дахиад л сүйд хийв. Урам хугарсан гэрийн эзэн дахиад л залхаж, туйлдмаар засварын ажлаа эхлэв. Бороо дахин цутгаж, бүгдийг сүйтгэх нь гагцхүү цаг хугацааны л асуудал юм. Ингэсээр эцэстээ гэрийн эзэн хамаг хөрөнгө, хүчээ барж, ажлаа зогсоогоод, хувь тавилантайгаа эвлэрчээ.

Ямар эргүү амьтан бэ! Зүгээр л дээврээ засчихгүй гэмээр байна уу? Гэхдээ итгэгчид бид айдастай яг ингэж тулалддаг. Бид цөхрөл, урамгүй байдал, эргэлзээ, найдвар тасрах зэрэг айдсын үр нөлөөг л янзлах гэж зүдрээд байдгаас биш, айдсын хүчийг тасар татаж чаддаггүй!

Зарим нь бүр айдастайгаа бараг л яж харилцан эвтэй найртай оршиход суралцахаар янз бүрийн сэтгэл зүйч, зөвлөгч нарт хүртэл ханддаг бол, нөгөө хэсэг нь эрх чөлөө гэдэгт найдахаас айж, айдастай амьдрах гэрээнд гарын үсгээ зурчихсан явдаг. Эдгээр нь яг л онгорхой дээвэртэй, илжирсэн тавилгатай байшинд аж төрөхтэй ижил юм. Гэтэл зарим нь бүр өөрөө өөрийгөө цөлчихдөг. Итгэл найдвар тасарсан тэд усанд автсан байшинаа тэр чигээр нь хаячихна.

Энэ ном танд айдас сүрдүүлэгтэй хэрхэн зэрэгцэн оршихийг заахгүй. Энэ ном танд айдас сүрдүүлгээс чөлөөлөх Бурханы арга замыг заана. Тэр цагт л та Бурханы дуудлагыг биелүүлнэ.

Миний бие энэ номыг бичих гэж, Бурханаас заавар удирдамж

АЙЛГАН СҮРДҮҮЛГИЙГ ЯЛАХУЙ

гүйн, олон цагийг компьютерынхаа ард өнгөрөөсөн сөн. Нэгэн өглөө ажиллаж байтал Эзэний оршихуй өрөөнд залран буув. Би компьютерынхаа араас босоод, алхлан залбирлаа. Залбирч байтал Эзэний Сүнс над дээр буун ирж эш үзүүлэхэд, амнаас минь ийм үг гарав:

Хүү минь, Эцсийн энэ өдрүүдэд Миний их цэрэгт дуудагдсан хүмүүс дунд айдас сүрдүүлэгт хүлэгдсэн нь олон байна. Тэд Бурханд ч, хүнд ч цэвэр зүрх сэтгэлээр ханддаг боловч, настай Гидеон шиг хүнээс айх айдаст олзлогдож (Шүүгч 6-8), тэдэнд өгсөн Миний бэлэг авьяас бөхжээ. Гэхдээ Би тэдний айдсыг тасар татаж, тэднийг зуу зуугаар нь чөлөөлөхийн тулд энэ номын үг үсэг бүрийг тосолно.

Тэд өндийж босоод, Намайг ямар ч айдасгүйгээр дагана. Тэд Миний эрэмгий зоригт дайчид болж, Бурханыхаа хүч чадлаар аугаа ялалт байгуулна.

Энэ бол зүгээр нэг онолын хичээл биш юм. Би өөрөө ч маш олон жил айдсын хүлээстэй явсан. Гэхдээ асуудлынхаа уг үндсийг мэдэхгүй явах шиг хэцүү юм байхгүй. Харин Бурхан энэ муу ёрын дайсныг илчилсэн юм. Түүнээс хойш Бурхан даян дэлхийн итгэгчдийг чөлөөлөхийн тулд энэ үгийг хэрэглэсээр байна.

Нэгэн удирдагч “Энэ үг Америк пастор бүрийн гарт байх ёстой!” хэмээн дуу алдаж билээ. Гэхдээ энэ нь пасторуудад төдийгүй, чуулганы хүн бүрт хүрэх ёстой үг юм. Таны гартийн байгаа нь ч тохиолдол биш гэдэгт би итгэлтэй байна. Та өөрөө чөлөөлөгдсөн бол, хэрэгтэй хүмүүст нь хүргэ. Хүн хуваалцсанаараа өөрөө л бэхжэдэг.

Аяллаа эхлүүлэхээс тань өмнө би таны төлөө залбирмаар байна. Зүрх сэтгэлээ нээн, Бурханы өмнө очоод ийн залбирна уу:

Аав аа, энэ номыг унших үед Ариун Сүнсээрээ Үгээ илчлэхийг Эзэн Есүс Христийн нэрээр гүйж байна. Миний амьдралд нуугдаж байгаа бүхий л айдас, сүл талыг уг үндсээр нь илчилж, зайлтуулаач. Би Эзэн Есүсийн өмнө зоригтой ойртож очмоор байна. Амень.

I хэсэг

СҮНСНИЙ
БАЙР СУУРИА
БАЙГУУЛАХУЙ

*Бурханаас өгөгдсөн
эрх мэдэл дотроо алх.*

*Үгүй аваас өөр нэгэн эрх мэдлийг тань
булааж аваад, таны эсрэг хэрэглэнэ.*

Нэгдүгээр бүлэг

ЭРХ МЭДЭЛ ДОТРОО АЛХ

Эзэн биднийг Өөрийнх нь дуудлагыг биелүүлэхэд бэлтгэхдээ нөхцөл байдал, хүмүүсийг ашигладаг болохыг нь би Эзэнд үйлчлэх тусмаа ойлгох болсон юм.

1983 онд би инженерийнхээ ажлыг орхиод, бүтэн цагаар маш том чуулганы туслах үйлчлэлд оров. Би пастор, түүний гэргий, цуглааныхаа зочин үйлчлэгч нарыг дуудлагаа чөлөөтэй биелүүлэхэд нь тусалж, ойр зуурынх нь хэрэгцээг харгалзах үүрэгтэй байлаа. Дөрвөн жилийн дараа Бурхан намайг энэ үйлчлэлээс минь чөлөөлөөд, өөр нэгэн том чуулганы залуусын пасторын үйлчлэлд илгээв.

Миний явдаг тэр долоо хоногт цуглааны маань өөр нэгэн ажилтан залуу Бурханаас хүлээн авсан үгээ гэргийгээр минь надад дайжээ. Тэр цагаас хойш энэ үг сүүдэр дунд цэц ухаан, хүчээрээ хамгаалах номор нөөлөг, чихэнд минь сэрэмжлүүлэг болон хангинах болсон юм. Энэ үг Бурханы бүхий л үнэн үтэй адил зүрхний минь жолоо болж, манан дунд тогтоон барих суурь минь болсоор байна.

Тэр эрхэм манай гэргийд: “Хэрэв Жон Бурханаас өгөгдсөн эрх мэдэл дотроо алхахгүй бол, эрх мэдлийг нь өөр хүн булааж аваад, түүний эсрэг хэрэглэнэ” гэж хэлсэн байв. Энэ үг надад шууд тусав. Би үүнийг нь Бурханы цэц ухаан болохыг нь таньсан ч, хэрэгжүүлэх ухааныг нь олон жилийн дараа л олсон юм.

Амьдрал өөрчилсөн үйл явдал

1990 оны эхээр Эзэн надад тухайн үед аялж, үйлчлэх дуудлага өгснөө батлан ойлгуулав. Ийнхүү үйлчлэлдээ гараад удаагүй

байхад минь олон жилийн өмнө өгсөн Бурханы заавар үгийг ойлгуулж, амьдрал өөрчилсөн үйл явдал тохиосон юм.

Бид нэр бүхий нэгэн чуулган дээр Гурав дахь өдрийн оройноос Бүтэн сайн өдөр хүртэл цуглаан хийхээр төлөвлөөд байлаа. Бурханы Сүнс маш хүчтэй нүүж, бөөн бөөн чөлөөлөлт, эдгэрэл, аврал өрнөв. Өдөр ирэх тусам, Бурханы оршихуй орой бүр улам л жинтэй бууж байлаа.

Эхний долоо хоногт Нью Эйжийн хөдөлгөөнд оролцож явсан нэгэн хатагтай сүр жавхлантайгаар чөлөөлөгдөв. Чухам энэ үйл явдал л цааш, цаашдын цуглааныг бадраасан өөрчлөгч үйл явдал болсон гэлтэй. Долоо хоногийн дотор хүмүүс цуглаанд суух гэж зуун дөч, тавин км газраас ирдэг болов.

Пастор нь: “Бид энэ цуглааныг таслан зогсоож болохгүй. Бурхан бидэнд илүү ихийг бэлтгэсэн болтой” гэж хэлсэн бөгөөд би ч санал нийлэн, бид цаашдаа хорин нэгэн удаагийн цуглаан хийв. Бурханы уг түргэн горхи шиг гүйж, Сүнсний бэлэг цуглаан болгон дээр ажиллаж байлаа.

Цуглааны хоёр дахь долоо хоногийн дундуур, нэг орой номлож байхдаа би, хөгжимчид, дуучид руу эргэж харснаа (тэнд хорин тав орчим хүн байв): “Энэ тайзан дээр нүгэл байна. Гэмшихгүй бол, Бурхан илчилнэ” гээд хэлчихэв.

Өөрийгөө ингэж хэлэхийг дуулаад: “*Пөөх, энэ уг хаанаас гарав аа?*” гэж бодлоо. Заримдаа Бурханы тосолгоо аянга мэт буух үед номлогч хүний чих хэлсэн үгээ сүүлдэж сонсдгийг өдий олон жил номлосон хүнийхээ хувьд би мэнэ. Тэнгэрийн онгodoор ярих үед энэ эш үзүүллийн номлол бий болдог.

Би хэлсэн үгдээ хэсэг эргэлзэж эхэлсэн боловч, Бурханаас гэдгийг нь мэдэж байсан болохоороо, эргэлзээгээ бушуухан сэгсэрч хаялаа. Тэгээд дахиж бодсонгүй. Миний дээр номлолын зузаан тосолгоо тогтох байлаа.

Цуглаан ирэх тусам, хүмүүсийн тоо өссөөр байв. Гурав дахь долоо хоногийн дундуур би дахиад л номлож байхдаа, тайзан дээр байгаа хүмүүс рүү эргэн, хуруугаа зааж байгаад, Ариун Сүнсний тосолгоогоор: “Энэ тайзан дээр нүгэл байна. Та нар гэмшихгүй бол, Бурхан илчлээд, та нарыг зайлцуулна!” хэмээн чангаар мэдэгдлээ. Миний эрх мэдэл, баталгаа өсч байгааг би мэдрэв. Энэ удаа би Бурхан өргөөгөө нүглээс хуу цэвэрлэж байгааг мэдсэндээ, нэгээхэн ч эргэлзсэнгүй.

Шүү эсвэл шүүгд

Амьдралд маань нүгэл шургабал, Ариун Сүнс ухааруулж, заавар өгнө. Гэтэл бид сонсохгүй бол хөрч, мохож эхэлнэ. Ингэсээр эцэстээ зүрх маань Бурханыг мэдрэхээ болино.

Тэр үед бид Бурхан биднийг болоод бидний эргэн тойрныхныг хамгаалахын тулд бурууг маань илчлүүлэхээр хэн нэг хүнийг бидэн рүү илгээнэ. Биднийг ичээж, шившиглэх гэсэндээ бус, харин анхааруулж, хамгаалах гэсэндээ л тэр. Тэр үед нь ч сонсохоос татгалзаад байвал, шүүх бууна. “Бид өөрсдийгөө нягталсан бол шүүгдэхгүй байхсан. Харин бид шүүгдэхдээ өртөнцтэй хамт яллагдахгүйн тулд Эзэнээр сахилгаждаг” (1Коринт 11:31-32).

Бурхан биднийг шийтгэлээсээ хэлтрүүлэхийн тулд гэмших хугацаа олгон, бидний нүглийг тэвчин өнгөрөөдөг. Тэр бүү шийтгэхдээ ч, дэлхийтэй хамт яллахгүйн тулд л шийтгэнэ. Тэнэмэл хүү гахайн хороонд ороод л ухаан орсон байдаг. Нүглээ хийсээр яваад, адагтаа Эзэнээсээ: “Би та нарыг танихгүй. Ёс бусыг үйлдэгч та нар Надаас зайл” (Матај 7:23) гэдэг үг сонсож байхаар гахайн хороонд ухаан орсон нь дээр!

Бид гэмшихгүй бол - Бурхан биднийг зовоохыг хүсэхгүй байсан ч, гарцаагүй зовно. Энэ талаар Паул “Үүнээс болж та нарын дунд сул дорой, өвчтэй нь олон байгаа бөгөөд нэлээд нь нойрсож байна” (1Коринт 11:30) гэсэн буюу. Нүгэл адагтаа сүнсний ч, биеийн ч үхлийг авчирна. Тэр өдөр Эзэн тайzan дээр суугаа хэн нэгэн хүнийг гэмшүүлэх гэсэндээ, ялын мэдэгдэл хэлсэн мэт санагдсан юм. Гэхдээ чухам хэний нүглийг яллаж байгааг мэдсэнгүй.

Гэнэтийн айлган сүрдүүлэг

Маргааш орой нь пастор, бид хоёр албан өрөөндөө цуглаандаа бэлтгэж байтал, цуглааны ахлах орж ирээд, магтаал, хөгжмийн үйлчлэлийнхэн унжуу, гутруу байдалтай байгааг дуулгалаа. Пастор тэднийг олон өдрийн цуглаандаа ядраад тэр байх гэж бодоод: “Мэдрэмжээ хойш тавиад, гараад Бурханыг магт гэж хэл” гэлээ.

АЙЛГАН СҮРДҮҮЛГИЙГ ЯЛАХУЙ

Би ахлах руу хараад: “Ямар нэгэн асуудал гараа юу?” гэж асуув.

Гэтэл ахлах: “Юу л даа, тэд таныг өөрсдөд нь хатуурхаж байна гэж үзжээ. Асуудал байгаа бол, нийтийн өмнө биш, хувьчлан ярих ёстой гэж байна” гэж хариуллаа.

Гэтэл энэ эгшин нь тун эгзэгтэй эгшин байсныг нь би тухайн үед мэдээгүй юм. Энэ нь Бурханаас олгосон үйлчилж, хамгаалах эрх мэдлийг минь шүүхэд дуудсан үйл явдал байжээ. Дайсан тэр цуглаанд өрнөж байгаа үйл явдалд дургүйцэж, таслан зогсоохыг хүссэн байна.

Тухайн үед мэдээгүй боловч, надад сонголт байжээ - хөгжмийн үйлчлэлийнхэнд хэлсэн үгээсээ ухраад, айлган сүрдүүлэгт бууж өгснөөрөө, эрх мэдлийн байр сууриа алдах эсвэл эрх мэдэл дээрээ зогсоод, Бурханы хэлсэн үг дээр бат байж, айлган сүрдүүлгийн хүчийг ялах.

Тэр даруй надад “Жон, чи яах гээж тэр хүмүүсийг ичээв? Эргэлдээж, чичлээд байхгүй, зүгээр л номлохгүй яав? Одоо цуглааны хүмүүс тайлан дээрх хүмүүсийн хэн нь нүгэлтэн болохыг олох гээд завгүй байгаа. Гэтэл хэн ч биши байвал, яах уу? Нүгэлтэй байсан ч, хэзээ ч илчлэгдэхгүй бол, яана? Хүмүүс сэжиглэсээр... цэвэр хүмүүс зовсоор.... Чуулган бүдэрнэ. Би энэ чуулганд хийсэн сайн сайхнаа устгачихав уу? Тэгсэн бол, нэр хүндээ алдана. Гэтэл аялах үйлчлэл маань дөнгөж эхэлж байдаг” гэж бодогдоо.

Иймэрхүү бодол ар араасаа оюун санааг маань бөмбөгдсөөр байлаа. Хамаг айдас *Одоо би яана аа?* гэдэг ганц бодлыг бүслэн хуралдав. Айлган сүрдүүлэг ингэж л төвлөрлийг өөрчилдөг. Учир нь: Айлган сүрдүүлгийн үндэс нь айдас байдаг бөгөөд айдас нь хүмүүсийг өөр дээрээ төвлөрөхөд хүргэдэг. Хайр дор айдас үгүй. Харин төгс хайр нь айдсыг хөөн зайлцуулна (1Иохан 4:18).

Пастор юм хэлсэнгүй. Бид гурав гар гараа барин, тэр оройн цуглаан дээр Бурхан хүслээ биелүүлэхийн төлөө залбирлаа. Тэгээд өнгөрсөн гурван долоо хоног хийсэн шигээ л, тайз руу явцгаав. Магтаал, хүндэтгэлийн үеэр Эзэн зүрхийг маань дүүргэхгүй байгааг анзаарав. Надад чиглүүлэг мэдрэгдэхгүй байсан ч, би *Бурхан итгэмжтэй. Индрийн ард гарах үедээ би юу хэлэхээ мэдэх болно* гэж бодлоо.

Магтаал, хүндэтгэл дуусч, пастор зарлал хэлэх үеэр би

зүрхэндээ юм мэдрэхгүй хэвээрээ л байлаа. Тэгээд *Намайг босоход, Бурхан наадад чиглүүлэг өгнө гэж* бодлоо. Би голдуу Бурханы онгodoор ярьдаг хүн л дээ. Гэвч цаг өнгөрөх тусам, зовнил маань өссөөр байлаа. Учир нь Бурхан наадад уг өгөхгүй бол, би хэлэх үггүй болно гэдгээ мэдэж байв.

Тэгтэл пастор намайг танилцууллаа. Би индэр дээр гарч очихдоо бас л чиглүүлэггүй байсан болохоороо “Залбирцгаая” л гэлээ. Залбирсан боловч бас л чиглүүлэг ирсэнгүй. Бүр нилээд хэдэн минут залбирлаа. Ядаж байхад, залбирал маань ч амьгүй. Яг л баахан уг амнаас минь гараад, хөлд маань унаад байх шиг. Тэгээд *Би одоо яадаг билээ?* гэж бодлоо. Тэгээд өмнө Дуулал номоо зааж байсан номнолоо хэлэв.

Номлол маань ч ямар ч амьгүй, тосолгоогүй байлаа. Би бодлоо эвлүүлэх гэж зүдэрч байв. Бурхан хаяад явчихсан мэт. Толгойд *Би яах гэж тэгж хэлэв ээ?* Энэ бүхэн юунд хүргэв? гэж л бодогдоно. Яг л Ариун Сүнсээр биш, эргэлзээгээр хөтлүүлсэндээ тэгж хэлсэн мэт санагдав. Би Бурхан гарч ирээд, намайг энэ аймшигаас аварна хэмээн өөрийгөө тайвшруулсаар байлаа. Тийм боловч, байдал улам л дордсоор. Тэгээд гучин таван минутын дараа би үгээ ч, цуглаанаа ч дуусгав.

Би эргэлзэж самуурсаар байрлаж байсан газартаа ирлээ. “Бурхан минь, Та яагаад ирсэнгүйв? Өмнөх цуглаан бүр гайхамшигтай, хүчтэй байсан. Гэтэл өнөөдрийн цуглаан ямар ч амьгүй. Би л тэнд суусан бол, дахиж эргэж ирэхгүй. Үнэндээ би өөрөө ч буцаж очмооргүй байна.” Тэр шөнө шуудай элс залгичихсан юм шиг л хажуулав.

Маргааш өглөө нь нөгөө шуудай элс чинь овоолон болчихсон сээрэв. Хүнд жинд дарагдсандаа орноосоо ч босохыг хүссэнгүй. Дусал ч баяр хөөр байхгүй. Тэгэхээр нь залбирлаа. Тэгээд Бурханаас асуулаа: “Та яагаад ирээгүй юм бэ?”

Нам.

“Би нүгэл хийсэн үү? Таныг гашуудуулав уу?”

Бас л нам. Цаг гаруй залбирсан боловч, уг бүрээ зөөх гэж зүдрэв.

Би магтаалын хөгжим тавиад, дагаж дуулах гэж үзлээ. *Бурхан дарамтын сүнсний оронд магтаалын хувцас өмсгөдөг.* Би үүнээс салах ёстой гэж бодов. Гэвч хагас цаг ямар ч амьгүй гэнгэнэв. Уур ч хүрэх шиг: “Би яасан юм бэ? Яагаад хариулахгүй байгаа юм бэ?”

Өдрийн хоолны дараа ойролцоо эзгүй талбай руу явлаа. *Би диаволыг хулбэл, болчихно гэж бодлоо.* Гэвч надаас өөр хүлээтэй амьтан байсангүй. Би гадаа гурван цаг залбирч, диавол руу хашхирсаар, хоолой таг соөв. Ингэж байтал, явж шуглаандaa бэлдэх цаг боллоо. Би *Ийм их эсэргүүцсэн юм чинь, өнөө орой Бурхан хүчтэй бууж ирнэ.* Жон, зүгээр итгэлээр л алх хэмээн өөрийгөө тайтгаруулж байлаа.

Магтаал, хүндэтгэл, зарлал, өргөл явж дууссан ч, надад урьд оройн хоосролоос өөр юм мэдрэгдсэнгүй. Би мөн л *Намайг босонгуут, Бурхан хурч ирнэ* гэсэн гаргалгаатай л байлаа. Намайг танилцууллаа - юу ч өөрчлөгдсөнгүй. Би чиглүүлэг хүссэн ч, нам гум.

Би бас л өмнө зааж байсан номлолоо гаргаж ирсэн ч, бүр ч орон гаран юм болов. Надад ямар ч амь, чиглүүлэг, тосолгоо байсангүй. Ийнхүү таван минут хэртээ ээрч муурсныхаа дараа би: “Найзууд аа, бүгдээрээ залбирах хэрэгтэй байна. Юу гэдгийг нь мэдэхгүй - гэхдээ нэг л биш байна!” гэж хэллээ. Чуулган тэр чигээрээ босч зогсоод, шатан залбирав.

Айлган сүрдүүлэг илчлэгдэв

Тэгтэл гэнэт Бурхан хорин дөрвөөс илүү цагийн дараа анх удаа надтай ярихыг нь би сонсов. Бурхан: “Жон, чи чиний ард тайзан дээр зогсож байгаа хүмүүсээс сүрджээ. Чи эрх мэдлийн байр сууриасаа унаж, чиний доторх Бурханы бэлэг унтраас” хэмээн айлдав.

Энэ зөвлөн зэмлэлийг дагаж, сүнсэнд минь гэрэл зүсэн орж ирэв. Хүмүүс дахин таван минут залбирах хооронд Бурханы Сүнс намайг Библиэр дагуулан, эрчүүд, эмэгтэйчүүд айж сүрдэхдээ, дотор нь буй Бурханы бэлгийг унтраасан үй олон түүхийг харуулсан юм. Тэд эрх мэдлээсээ ухарч, Сүнс доторх үр нөлөөгөө алджээ. Дараа нь Сүнс миний өнгөрсөн амьдралыг харуулаад, адилхан алдаа гаргасныг минь ойлгуулав.

Би ч тэр даруй залбираараа айлган сүрдүүлгийн сүнсийг хугачиж гарлаа. Номын маань эпилоги хэсэг дээр ийм залбирлын жишээ бий. Тэгээд далан таван минут Бурханы өгсөн Бичээсийг яг л шатаж байгаа хүн шиг номлов. Номлолын дараа чуулганы гуравны хоёр нь айлган сүрдүүлгээс чөлөөлөгдөхөөр урагшaa

гарч ирсэн юм. Тэр өдөр тэрхүү сэргэлтийн конференцийн хамгийн хүчтэй цуглаан болов.

Гэтэл долоо ч хүрэхгүй хоногийн дараа Бурхан тайзан дээрх нүглийг илчилж эхэлсэн юм. Аргил гитарчин нь цуглааныхаа дараа гадуур цэнгэж, архиддаг, нэг дуучин нь цуглааныхаа охинтой унтдаг байсан нь ил болж, хоёулаа үйлчлэлээсээ хөөгджээ. Аргил гитарчин нь цуглаанаасаа явсан бол, дуучин нь гэмшээд, Эзэнтэй амьдрах зам мөрөө засчээ.

Хэсэг хугацааны дараа магтаалын удирдагч нь хэсэг нөхөдтэйгээ цуглааныг хагалан бутаргасан байна. Чуулганы дөрөвний нэг нь тэднийг дагаад явжээ. Тэгтэл магтаалын удирдагч нь завхайралд холбогдоод байсан бөгөөд жилийн дараа нөхрөөсөө салсан байна. Хамгийн сүүлд тэрбээр өөр эртэй амьдарч байгаа нь сонсогджээ. Цуглаан хагалан бутаргах ажиллагаанд оролцсон гэр бүлүүдээс ганц л хос гэр бүлээ хадгалж үлдсэн байна.

Ийм л хүмүүс намайг хатуурхлаа хэмээн гомдоллож байж. Бурхан тэдэнд анхааруулсан. Тэд тэр анхааруулгыг нь зүрхэндээ хүлээгээд авчихсан бол, хичнээн сайхан.

Би тэр чуулганд дахиж хоёр удаа очихдоо, тэднийг урьд урьдынхаасаа эв нэгдэлтэй, хүчтэй болсон байхыг харж билээ. Пастор нь: “Бурхан чуулганыг маань цэвэрлэж, биднийг илүү хүчтэй болгосон. Манай магтаал хэзээ ч ийм эрх чөлөөтэй байгаагүй!” хэмээн тайлбарлаж билээ. Түүнчлэн өмнө тулгардаг байсан эвдрэлцэл, дайралт байхгүй болсон гэв. Бурхан алдаршиг!

Бүгдэд хамаатай үг

Хэдийгээр энэ үг надад үйлчлэлийн зөрчил дунд илчлэгдсэн ч, сургамж нь дан ганц индрийн ард зогсдог хүмүүст хамаатай гэдэгт итгэхгүй байна. Христэд итгэдэг олон хүн айлан сүрдүүлэгтэй тэмцэлддэг. Айж сурдсэн хүмүүс ихэнхдээ тулалдаж байгаагаа ч мэддэггүй. Сатаны бүх хэрэгслийн нэгэн адил айлан сүрдүүлэг нь зүсээ хувиргадаг мөн санаандгүй байхад ирдэг чанартай. Бид үүний уг үндсийг нь мэдэхгүйгээр, сэтгэл санааны өвчин, эргэлзээ, итгэл дутах гэх мэт үр нөлөөг нь л мэдрээд байдаг. Би өөрийгөө айж сурдсэн гэдгээ мэдсэн

бол, тэр цуглаан дээр тэгтэл зөрчилдөхгүй байх байж.

Надад зааж өгсөн Бурхандаа талархъя.

Бидний ихэнх маань айлган сүрдүүлгийг өөрийг нь - уг үндэстэй нь юутай хийтэй нь шийдвэрлэхийн оронд үр дүн, үр жимстэй нь цухалдаад л үзэлцээд байдаг. Тиймээс хэсэгтээ тайвшрах боловч, зөрчил нь дуусдаггүй. Та модны бүх жимсийг түүж авсан ч, үндэс нь байгаа цагт үр жимс нь ургасаар л байна. Энэ тойрог үнэхээрийн цуцаамаар. Учир нь бид хэзээ ч энэ байдлаасаа салахгүй юм байна гэж бодоход хүрдэг. Тэгээд найдвараа алдаад, Бурханы дуудсан газраас хaa хол очоод нутаглаачихна.

Энэ номын үнэн танд айлган сүрдүүлгийг таниулж сургахаас гадна айлган сүрдүүлгийн хазаарыг авч хаях мэдлэг суулгана. Энэ үнэнийг уншиж, хэрэгжүүлэхдээ, та Эзэн Есүс Христийн зарцын дуудлагаа биелүүлэхээр чөлөөлөгдхийн төлөө би залбирч байна.

Та амьдралдаа байгаа айлган сүрдүүлэгтэй нүүрэлдэхээс айж байж мэдэх. Бид амьдралдаа ямар нэгэн зүйлд дарлагдахаараа бушуухан шиг салахыг хүсдэг ч, түргэн засвар нь голдуу маш өндөр өртөгтэй тусдаг: Энэ нь “богино настай” байдаг. Тиймээс би энэ үнэнийг өөрөө хүлээж авсан шигээ нэг нэгээр нь тайлмаар байна. Дараагийн гурван бүлгээрээ маш чухал суурийг цутгах бөгөөд сүнсний байр суурь, эрх мэдлээ ойлгож авах гэсэн сэдвээр эхлүүлье.

*Сатан Есүст булаалгасан эрх мэдлээ
эргүүлж олохын тулд биднийг
байр сууринас маань унагахыг санаархдаг.*

Хоёрдугаар бүлэг

СҮНСНИЙ БАЙР СУУРЬ, ЭРХ МЭДЭЛ

Тэгэхээр, цөмөөрөө надад ирсэн үгийн хэлэлцүүлгээр эхэлье: Бурханаас өгөгдсөн эрх мэдэл дотроо алх. Үгүй аваас эрх мэдлийг чинь өөр хүн булааж аваад, таны эсрэг хэрэглэнэ.

Нэгдүгээрт - Есүст итгэдэг хүмүүс бидэнд сүнс дотор эзэлдэг газар, байр суурь гэж байдгийг ойлгох нь чухал. Энэ байр суурьтай хамт эрх мэдэл ирнэ. Дайсан энэ эрх мэдэлд л санаархдаг. Сатан биднийг Бурханаас өгөгдсөн эрх мэдлээс татгалзуулж чадбал, эрх мэдлийг маань булааж аваад, бидний эсрэг хэрэглэнэ. Энэ нь бидэнд төдийгүй мөн бидний халамжин дорх хүмүүст ч нөлөөлнө.

Сүнс доторх эрх мэдлийн байр суурийн талаар өгүүлдэг олон Бичээс бий. Эдгээрээс цөөн хэдийг үзье.

Хамгийн Дээд Нэгэний халхавчинд оршигч нэгэн Төгс Хүчит Нэгэний сүүдэр дор амьдарна (Дуулал 91:1).

Тэр намайг таалсан учир Намайг уудам газарт авчран аварсан билээ (Дуулал 18:19).

Хөл минь тэгш газарт зогсном Цугларалтуудад би ЭЗЭНийг ерөөнөм (Дуулал 26:12).

Итгэгч хүмүүс сүнс дотор бодитой газрыг эзэлдэг. Тиймээс та итгэгч хүнийхээ хувьд тэр газраа мэдээд зогсохгүй, тэндээсээ

АЙЛГАН СҮРДҮҮЛГИЙГ ЯЛАХУЙ

үйл ажиллагаагаа явуулж чаддаг байх ёстой. Та байр сууриа мэдэхгүй бол, Христийн бие дотор горим ёсоороо ажиллаж чадахгүй.

Энэ байр суурийг ч, дагалдах эрх мэдлийг нь ч алдах боломжтой. Библийн тодорхой жишээ гэвээс Искариотын Иудас юм. Есүсийг тэнгэрт өргөгдсөний дараа дагалдагч нар нь залбирахаар цуглажээ. Тэр үед Петр Иудаст юу тохиосныг тайлбарласан:

Энэ нь Дуулал номд “Түүний орон гэр нь эзгүйрч, Тэнд нь хэн ч бүү сууг” гээд, “Харгалзах үүргийг нь өөр нэгэн аваг” гэж бичигджээ (Үйлс 1:20).

Иудас нүгэл үйлдэхдээ сүнс доторх байр сууриа мөнхөд алджээ (Үйлс 1:16-17). Энэ бол итгэгчдийг сүнсний эрх мэдлээс нь унагадаг дайсны үндсэн арга зам билээ. Дайсан ингэж л Адам, Ева хоёр унагааж, байрнаас нь зайлцуулж, тэдний дээр болоод тэдний захиргаан дорх бүх зүйл дээр эрх мэдлээ тогтоосон юм.

Адам, Ева хоёр газар дэлхий дээрх хамгийн өндөр байр суурийг эрхшээж байсан. Амьд амьтан бүхэн, байгаль дэлхий тэр аяараа тэдний эрх мэдэл дор байсан. Бурхан: “тэднээр далайн загас, огторгуйн шувууд, мал адгуус, бүх газар дэлхий, газраар мөлхдөг мөлхөгч бүгдийг захирууулья” (Эхлэл 1:26) хэмээн айлдсан. Тэр үед энэ дэлхий дээр сүнсний ертөнцөд болоод бодит ертөнцөд хүн төрөлхтний эрх мэдлээс дээгүүр Бурханаас өөр хэн ч, юу ч оршиж байсангүй.

Адам эрх мэдлийнхээ байр суурийг эзэлж байхад өвчин, газар хөдлөлт, гай гамшиг, ядуурал гэж байгаагүй. Адамыг Бурхантай нөхөрлөж, Бурханы төлөөний эрх мэдэл, хүчээр захирч байх үед энэ газар дээр тэнгэрийн ноёрхол тогтож байжээ. Гэтэл Адамын нүгэлтэй хамт түүний эрх мэдэл дорх бүх юм мөхөв. Адам нүгэл үйлдэхдээ, сүнс доторх байр сууриа Бурханы дайсанд шилжүүлжээ.

Үүнийг нь Бичээс Есүсийг цөлд өдсөн Сатаны сайрхлаар гэрчилдэг. Сатан Есүсийг өндөр уулан дээр аваачин, дэлхийн бүхий л хаанчлалыг харуулаад:

“Энэ бүх эзэмшил болон эдгээрийн сүр хүчийг би Чамд

өгье. Учир нь энэ бүгд надад өгөгдсөн юм. Би хүсвэл хэнд ч үүнийг өгч чадна” (Лук 4:6) хэмээн мэдэгдсэн байdag.

Бурхан эрх мэдлийг Адамд итгэмжилсэн байтал Адам эргээд Сатанд барьчихсан. Адам байр сууриа төдийгүй, Бурханы хариуцуулсан бүхнийг алдсан билээ. Яваандаа бүхий л хослон зохицол, эрэмбэ дараалал завхарчээ.

Үүний нэгэн жишээ нь амьтны ертөнц болой. Цэцэрлэгт Бурхан, Адам хоёрыг захирч байхад, арслан бусад амьтдаа барьж иддэггүй байсан (Исаиа 65:25). Аварга могой хорт хазуургүй байсан (Исаиа 65: 25). Хурга ишиг нь чоно тэргүүтэй араатны идэш болохоос айдаггүй байж (Исаиа 3:21). Гэтэл Нүглийн дараа нүцгэн хүнийг хувцаслахын тулд гэмгүй амьтдыг золионд гаргахыг нь бид үздэг (Эхлэл 3:21). Хожим хүн бөгөөд түүний нэгэнтээ захирч байсан амьтны хооронд дайсагнал, айдас бий болохыг үзнэ (Эхлэл 9:2).

Нүглийн нөлөөнд орсон өөр нэгэн талбар нь газар шороо юм. Нэгэнтээ арвин их үр жимс авчирдаг байсан хөрс шороо нь эдүгээ хараагдаж, хүнтэй дайсагнав (Эхлэл 3:17-19). Ром 8:20 бидэнд “Учир нь бүтээл өөрийнхөө хүслээр бус, харин өөрийг нь захирсан Түүний улмаас хоосонд захирагдсан боловч найдвар дор” гэдэг.

Газар дээрх байгалийн, сүнсний бүх юмс дуулгаваргүй байдлын үр нөлөөнөөс мулттраагүй. Гэм, гэмиин шийтгэл, үхэл, өвчин, ядуурал, газар хөдлөлт, гамшиг, хортон шавьж зэрэг нь дэлхийд нэвчив. Тэнгэрийн эрэмбэ, эрх мэдэл алдагдав. Адамын ууган хүү нь үзэн ядахыг, атаархахыг, алахыг сурсан. Бурханы хамгаалж, хангахын төлөө өгсөн эрх мэдлийг эдүгээ дайсан аваад, бүх бүтээлийг устгаж, алахын төлөө хэрэглэх болов.

Эрх мэдлийг сэргээсэн нь

Хүн эрх мэдлийн байр сууриа алдсан учраас, гагцхүү хүн өөрөө л эргүүлэн сэргээж чадах байв. Хэдэн мянган жилийн дараа Есүс төрөв. Эх нь Бурханы гэрээний ард түмний охин байсан бол, Аав нь Бурханы Ариун Сүнс болой. Есүс тал хүн, тал Бурхан байгаагүй. Есүс Иммануел “Хүний дүрээр илчлэгдсэн Бурхан” байв (Матай 1:23). Есүс хүн байсан гэдэг баримт нь

алдагдсан зүйлийг эргүүлэн олох эрхийг Түүнд олгосон болой. Тэрбээр Бурханы Хүү байсан учраас, хүний дээр тогтоосон дайсны эршхээлээс эрх чөлөөтэй байсан юм.

Тэрбээр хийсэн бүхнээрээ, хэлсэн бүхнээрээ Бурханы хүслийг илчилсэн болой. Түүний оршихуй дор нүгэл ноёрхж чадахгүй учраас, нүглүүд уучлагдсан. Өвчин, эмгэг нь Түүний эрх мэдэл, хүчинд сөгдсөн (Лук 5:20-24). Байгаль өөрөө Түүний тушаалд захирагдсан (Марк 4:4). Тэрбээр Адамын татгалзсан эрх мэдэл дотор явсан. Адамын Бурханаас хүлээн авсан боловч, алдсан эрх мэдлийг Есүс дуулгавартай байдал, тахилаараа сэргээхдээ, Бурхантай тогтоох бидний харилцааг ч сэргээсэн юм.

Есүс Аав руугаа явахдаа: “Тэнгэр газар дээрх бүх эрх мэдлийг Надад өгсөн. Иймээс та нар яв, бүх үндэстнийг дагалдуулагтуун, Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр тэдэнд баптисм хүртээ, та нарт тушаасан бүгдийг минь сахин биелүүлэхийг тэдэнд заа. Харагтуун, үеийн төгсгөл хүртэл Би та нартай үргэлж хамт байх болно” (Матай 28:18-20) хэмээн айлдсан.

Есүс Адамын алдсан бүхнээс ч ихийг эргүүлж олсон нь тодорхой байна. Сатан, Адам хоёр газрыг л захирч байсан бол, Есүсийн газрыг ч, тэнгэрийг ч захирав. Есүс Сатаны тогтоосон эрх мэдлийн байр сууриас ч дээш гарчээ. Есүс байр суурь, эрх мэдлээ илчилснийхээ дараа бидэнд “Тиймээс яв” гэсэн буюу. Есүс яагаад Түүний эрх мэдэл, бидний дуудлагын хооронд холбоо тогтоов? Хариултыг нь элч Паулын бичээсээс харж болно.

Эрх мэдлийн байр суурь

Паул бидний төлөө “итгэдэг бидэнд хандсан Түүний хүч чадлын яндашгүй аугааг мэдэх болтугай. ...Тэрээр Христ дотор энэ л хүчээр нөлөөлж, Түүнийг үхэгсдээс амилуулаад тэнгэрлэг оршихуйд (газруудад) баруун гартаа залж...” (Ефес 1:19-20) хэмээн залбирсан. Энэ нь ганц газар биш байгааг тэмдэглэнэ үү. Паул газруудад хэмээн тодорхой хэлжээ. Учрыг нь хэдэн эшлэлийн дараа тайлсан байна: “тийн амьдарч байхдаа энэ ертөнцийн замнал ба агаарын хүчний ноёрхогч, дуулгаваргүй хөвгүүдийн дотор ажиллагч тэр сүнсийг дагадаг байв. ...Есүс

дотор биднийг Түүгээр амилуулж, Түүнтэй хамт тэнгэрлэг оршихуйд (газруудад) суулгасан (Ефес 2:2,6). Энэ газрууд нь Түүний авран сэргээсэн хүүхдүүдийн оршин байх газар болой.

Тэгэхээр, орших газрууд гэдэг нь хаана байдаг, ямар байр суурь болохыг нь асуух хэрэгтэй. Хариулт нь Ефес 1:21 дээр бий: “бүх засаглал, эрх мэдэл, хүч, ноёрхол түүнчлэн энэ үед төдийгүй ирэх үед нэрлэгдэх аливаа нэрээс ч дээгүүр болгожээ” (тодруулгыг нэмэв).

Христ дотор нууцлагдсан, авран сэргээгдсэн хүнд эдүгээ сүns дотор диаволаас дээгүүр байр суурь өгөгджээ. Есүс “Харагтуун, мөгөй ба хилэнцэт хорхойнуудад халдах, дайсны хамаг хүчээс дээгүүрх эрх мэдлийг Би та нарт өгсөн. Та нарт юу ч хор учруулахгүй” (Лук 10:19) хэмээн чангаар мэдэгдсэн.

Тэгэхээр бид “Тиймээс яв” гэдэг тушаалыг ойлголоо. Есүс итгэгч хүмүүст итгэмжилсэн эрх мэдлээ ойлгожээ. Дахин төрсний эрх маань биднийг дайсны эрх мэдэл, хүчээс хавьгүй дээгүүрх тэнгэрлэг газруудад байршуулсан байна.

Сатан Есүст булаалгасан эрх мэдлээ эргүүлж авахын тулд эрт дээр үед Адам, Ева хоёрыг “янзалсан” шигээ, эдүгээ биднийг сүns доторх байр сууриас маань түлхэж унагахыг санаархдаг. Сатан хувь хүмүүсийн эрх мэдлийн байр суурийг хулгайлах юмуу тэднийг байр сууриас нь унагаж дөнгөбөл, дахин үйл ажиллагаагаа явуулах эрхтэй болно. Паул: “Диаволд байр бүү өг” (Ефес 4:27, тодруулгыг нэмэв) хэмээн тодорхой хэлсэн. Итгэгч - бид сүns доторх газраа алдаж үл болно.

Хаанчлалын зэрэг зиндаа

Бурханы хаанчлал нь жинхэнэ хаанчлал гэдгийг бид ойлгох ёстой. Хаанчлалд зэрэг зиндаа гэж бий. Тэнгэрийн нутаг дэвсгэрт дээр ч ялгаагүй. Зэрэг зиндаа өндөр байх тусам нэр нөлөө, эрх мэдэл өндөр байна.

Цэцэрлэгт Сатан арслан, заантай хөөцөлдөөгүй. Сатан эрх мэдлийг мэддэг учраас, Бурханы хүний араас явсан. Тэрбээр хүнийг “янзалчих” юм бол, түүний захиргаа, халамжин доорх бүхнийг өөрийн болгоно гэдгийг мэдэж байжээ.

Тиймээс дайсан чуулганы араас явахдаа, удирдлагыг нь онилдог. Саяхан нэгэн том чуулганы пастор гэргийгээсээ

салахаар шийджээ. Энэ шийдвэрт нь бичээсийн учир шалтгаан байхгүй бөгөөд шийдвэр нь гэргий, үр хүүхдэд нь хүнд цохилт болов. Доорх удирдагч нар нь пасторынхаа шийдвэртэй халз туталт, пастор нь тэдэнд “таалагдахгүй бол, яв” гэжээ.

Тэрбээр Бурханы тушаалыг санаатайгаар зөрчөөд, чуулган даяараа салалт, мэхлэлийн сүнсийг тархаажээ. Үүнээс нь хойш чуулганд нь - тэр бүү хэл чуулганых нь удирдлага дунд гэр бүл салалт газар авсан байна. Олон хүн урам алджээ. Цочирдож хямарсан хүмүүс хэнд итгэхээ мэдэхгүй, чуулганаас чуулган руу тэнэдэг болов. Сатан *гэрийн* эзнийг байр сууриас нь унагахад, түүний дор байсан хүмүүс хамгаалалтаа алддаг.

Аав, ээжүүд Бурханы тушаалыг зориудаар зөрчихийг би харсан. Тэгээд эрт орой хэзээ нэгэн цагт үр хүүхдэд нь ч эцэг, эхийнхээ мөрөөр явна. Тэд үүнийгээ хараал гэж нэрлэж болох ч, хамгийн гол нь яагаад ийм зүйл болно вэ? Эцэг эх нь нүгэл хийхдээ, сүнс доторх эрх мэдлийн байр сууриа алдах үед үр хүүхдэд нь дайсны өмнө хамгаалалтгүй болжээ.

Эзэний дайсанд боломж олгох

Энэ зарчмыг Давидын амьдрал дүрслэн харуулдаг (2Самуел 8-18). Давидын удирдлага дор хаанчлал нь бэхжин, тогтнов. Бурхан ч Давидыг охид, хөвгүүдээр ереөв. Тэгтэл Давид Бурханы өгөөгүй зүйлийг аваад, Батшебатай завхайрсан. Батшеба жирэмсэлсэн бөгөөд хамгийн ярвигтай нь эр нөхөр нь Давидын төлөө хязгаар нутагт байлдаж явав.

Давид Батшебагийн нөхөр Уриаг авчраад, эхнэртэй нь унтуулаад, гарсан хүүхдийг нь түүнийх мэт болгох төлөвлөгөө боловсруулжээ. Гэтэл Давидад болоод түүний хаанчлалд үнэнч Уриа журмын нөхдөө дайтаж байхад, эхнэртэйгээ унтаж, биесийн жаргал хөөхгүй хэмээн хатуу шийдсэн байлаа. Давидын нүглээ аргалах төлөвлөгөө бүтэлгүйтэв. Эзгүй хойгуур нь эхнэр нь бие давхар болсныг Уриа удахгүй олж мэднэ. Хүүхдийнх нь эцэг Давид гэдгийг төдөлгүй улсаараа мэдэх болно.

Тиймээс Давид Уриаг цааш нь харуулахаар шийдэн, хөнөөх ялыг нь гартийн атгуулаад, фронт руу илгээжээ. Уриаг галын шугам дунд оруулав. Уриаг дайсанд олзлогдоход, бусад цэргүүдэд ухрах тушаал өгчээ. Уриа дайсандaa алуулав.

Давидын ганц завхайрал нь заль мэх, худал, аллагад хүргэжээ.

Төдөлгүй эш үзүүлэгч Натан Давидад нүглийг нь илчлэв. Давид “Би Эзэний эсрэг нүгэл үйлдэв” гэсэн. Тэгтэл Натан Давидад “ЭЗЭН чиний нүглийг тайлсан тул чи үхэхгүй” (2Самуел 12:13) гэжээ.

Давид гэмшээд, уучлагдсан. Бурхан түүнийг нүглээс нь хэлтгүүлсэн (Исаиа 43:25-26). Тийм боловч Натан Давидад “Гэлээ ч хийсэн энэ хэргээрээ чи ЭЗЭНИЙ дайснуудад доромжлох боломжийг өгсөн...” (2Самуел 12:14) хэмээн анхааруулжээ.

Давид уучлагдсан ч, амьдралаа болоод гэр бүлээ Бурханы дайсанд нээж өгчээ - тэр дунд бодитой дайсан төдийгүй, сүнсний ч дайсан орно. Үүнээс болж Давидын гэр бүл ч, Израиль үндэстэн ч маш их зовсон байдаг.

Батшебагаас төрсөн Давидын ууган хүү нас барсан. Давидын ууган хүү, хаан ширээний залгамжлагч Амнон эцэг нэгт дүү Тамарыг хүчиндсэн. Давидын хүү, Тамарын ах Абсалом охин дүүгийнхээ өшөөг аваад, эцэг нэгт ах Амноныг алсан.

Абсалом Израилийн олон эрсийн зүрхийг Давидаас урвуулж, сэнтийг нь булаасан. Тэрбээр аавынхаа шивэгчидтэй нөхцөж, Давидын намнуулахаар Израиль эрчүүдийг илгээсэн.

Давид нүглээрээ гэр бүлээ Бурханы дайсанд нээж өгсөн учраас, түүний гурван хүү нь амия алджээ.

Бурханд үйлчилдэг эцэг эх нь нүглээрээ сүнс доторх байр сууриа алдсан учраас, үйлчлэгч нарын хүүхдүүд хар тамхинд орж, чуулгантай дайсагнаж, тачаал, гомосекс явдалд боолчлогдсон байхыг би үзсэн. Бид Библийн “Ах дүүс минь, багш нар бид үлэмж хүнд шүүлтэд орно гэдгийг мэдэн, та нараас олноороо багш бүү бол” (Иаков 3:1) гэдэг үгд нухацтай хандах ёстой. Удирдагч нар (пасторууд) нь дуулгаваргүй үйлдлээрээ үлэмжийн нөлөө үзүүлдэг учраас л тэднийг хатуу шүүнэ гэж хэлсэн учиртай. Тэд өөрийгөө төдийгүй, халамжин дорх хүмүүсээ хорлодог. Бурхан Давидыг училсан шигээ л тэднийг училдаг. Тийм боловч, тэд тарьснаа л хураана. Тэд дайсандаа байраа өгсөн!

Энэ бол хатуу үг. Би энэ үгийг хамаг л айdas, чичрэлээрээ чин зүрхнээсээ танд хэлж байна. Би нэн ялангуяа үйлчлэл дунд даанч дээ гэмээр их эмгэнэл үзсэн. Бид хэнийг ч яллаж, шүүх ёсгүй. Бид унасан нэгнээ училж, гараа сунгах ёстой. Тийм боловч би энэ үгийг дайсны бай болсон хүмүүст заавар,

анхааруулга болгон бичиж байна. Бид бүгдээрээ даруу байдал, сэргэлт дотор алхах ёстай.

Би дөрвөн хүүтэй. Тэднийхээ төлөө үлэмж үүрэг хариуцлагатай болохоо би мэднэ. Тэд Бурханы хүүхдүүд бөгөөд миний бие болбоос тэдний дээр Бурханы тавьсан нярав төдий. Би байраа диаволд өгснөөс болж, тэдний амьдрал сүйдэхийг хэзээ ч хүсэхгүй.

Би халамжлах үйлчлэлд байхдаа, үйлчилж байгаа хүмүүсээ аахар шаахар юмст түүргэлгүй, Бурханы дуудлагыг биелүүлээсэй гэсэндээ халамжилдаг байлаа. Хувцсыг нь цэвэрлүүлэх, хүүхдүүдийг нь сургууль гэрийн хооронд зөөх, машиныг нь угаалгах гэх мэт ажил хийнэ. Гэтэл нэгэн өдөр Бурхан надад үйлчлэлийн талаар нүдийг маань нээсэн нэг үг хэлсэн юм. Бурхан надад: “Хүү минь, чи энэ ажилдаа алдаа гаргабал, жирийн ажил учраас амархан залруулж болно. Харин үйлчлэлд гаргасны дараа чи хүмүүсийн амь амьдралыг хариуцах болно” гэсэн билээ.

Эрх мэдлээсээ татгалзах

Энэ бүлгээрээ танд сүнсний байр суурь, эрх мэдлийг ойлгуулахыг зорьлоо. Эрх мэдлээ Бурханы дайсанд алдсан хэд, хэдэн хүний жишээг ч үзлээ. Сатан эрх мэдлийг чинь авахын төлөө амьдралыг чинь нүгэлтэй хутгах гэж эрээ цээргүй улайлрана. Та Бурханд хамаг зүрхээрээ үйлчлэхээр шийдсэн бол, Сатан таныг ч бас айлан сүрдүүлгээр дамжуулан Христ доторх байр сууриас чинь унагах гэж оролдоно.

Айлан сүрдүүлгийг ялах эхний алхам нь энэ асуудалтай зүрхээрээ халз тулах юм. Харин үүнийг хэрхэн хийхийг дараагийнхаа бүлгээр дүрслэн тайлбарлая.

*Амьдрал болгох цэцүү ухаан,
зан чанаар үгүй аваас илчлэл хоосон болно.*

Гуравдугаар бүлэг

ХОЁР ТӨРЛИЙН ТҮЙЛШРАЛ

Бурханы Сүнс нүд ирмэхийн зуур таны сүнсэнд бөөн, бөөн эрдэнэс асгаж чадна. Тийм боловч амьдрал болгох цэц ухаан, зан чанар үгүй аваас энэ илчлэл хоосон болно. Ариун Сүнс намайг айлган сүрдүүлэгтэй хэрхэн нүүр тулах талаар бичээсээр дагуулан сургахдаа, итгэгч хүний амьдралын тэнцвэрийг алдагдуулдаг хоёр туйлыг харуулав: Эхний туйл нь эрх мэдэлтэй хөөцөлдөх бол, нөгөө нь хуурамч даруу байдал юм. Зөв зүйтэй тэнцвэрийг хуурамч даруу занг бус, харин бурханлаг зан чанарыг хөгжүүлж, эрх мэдэлтэй хөөцөлдөх бус, харин бэлгээ сэрээсэн Тимотын амьдралаас үзэж болно.

Цэвэр зүрх

Цаг хугацаа өнгөрөх тусам, Тимотын итгэмжтэй үйлчлэх чанар улам л батлагдав. Тэрбээр сайн мэдээний үйлчлэгч болтлоо дэвшин, сүүлдээ Ефесийн чуулганы пастораар томилогджээ. Тимотод хандсан хоёрдугаар захидалдаа Паул:

“Чамд буй жинхэнэ итгэлийг дурсан бодоход, энэ нь анх чиний эмэг эх Лой, эх Юник нарт байсан бөгөөд чамд ч бий гэдэгт итгэж байна. Энэ шалтгааны улмаас, миний гар тавигдсанаар чамд буй Бурханы бэлгийг сэргээхийг сануулъя” (2Тимот 1:5-6) гэж бичсэн байdag.

Паул Тимотын итгэлийг жинхэнэ болохыг нь дурьдсан байгааг тэмдэглээрэй. Тэр залуугийн зүрх цэвэр байж. Тэр дүр эсгэгч байгаагүй. Өөр нэгэн захидалдаа Паул “Тимотыг та нар уруу удахгүй илгээнэ... Та нарын төлөө үнэхээр санаа

тавих адилхан санаатай хэн ч надад алга. ... Тимот надтай хүү нь эцэгтээ үйлчилдэг шиг сайнмэдээнд үйлчлэн өөрийгөө нотолсныг та нар мэднэ”(Филиппой 2:19-22) гэсэн буй.

Тимотын зан чанарт ямар ч асуудал байгаагүй нь тодорхой байна. Зан чанар бол Христэд итгэгчид бидний тэргүүний зорилго, тэмүүлэл байх ёстой. Аав маань эрх хүчийг бус, зан чанарыг хүсдэг. Олон чуулган бурханлаг зан чанарыг хойш тавиад, эрх хүч, Сүнсний тосолгоог хайдаг нь харамсмаар. 1Коринт 14:1 дээр “Хайрыг мөшгөгтүн. Сүнслэг бэлгүүдийг хүсэн тэмүүл” гэсэн. Гэтэл бид энэ тушаалыг завхруулсан. Бид бэлэг, тосолгоотой хөөцөлдөөд, хайрын үр жимсийг амьдралдаа зүгээр л ургаад ирээсэй гэж хүсдэг. Гэвч бид хайр дотор явахаас нааш Түүний мөн чанарыг олж авахгүй.

Эхний туйлшрал: Зан чанартай бус, эрх хүчтэй хөөцөлдөх

Христэд итгэдэг зарим хүн гайхамшиг, эш үзүүлэл, тосолгоотой цуглааны төлөө хэдэн зуун бээр газрыг ч туулаад ирдэг атлаа зүрхэн дэхь уур хилэн, үл учлал, гашуудал хорслоо шийдвэрлэх хүсэлгүй байдаг. Үүнийг нь тэдний зан чанарын бус, эрх хүчний сонирхлоос нь харж болно.

Цуглаан дээрх сүнсний илрэлүүд нь үнэхээр Бурханых байж болох ч, бид заавал ч үгүй дотоод хүнийхээ асуудлыг шийдвэрлэх ёстой. Дотоодынхоо асуудлыг шийдвэрлэх хүсэлгүй байх нь олон хүнийг заль мэхэнд унагадаг. Хэдийгээр өнөөдөр чуулган сэргэж байгаа ч, нүглийг заавал шийдвэрлэх ёстой. Хүмүүс Бурханы хүчээр өлсөж байгаа нь сайхан ч, цэвэр зүрхийг орхигдуулахгүй байцгаая.

Бурханд үйлчилдэг олон хүн унадаг. Гэхдээ тэд хамгийн анх ёс бус зүйлд оролцохдоо л унаж эхэлсэн юм биш. Тэд бүр өмнөөс буюу үйлчлэлийнх нь амжилт Бурхантай тогтоох дотно харилцаанаас нь чухал болж эхлэх тэр үеэсээ унаж эхэлдэг. Энэ үзэгдлийг бид Бурханд үйлчилдэг хүмүүсээс төдийгүй, чуулган дундаас ч харж болно.

Есүс “Зүрхэндээ цэвэр ариун байгсад ерөөлтэй еэ! Тэд Бурханыг харах болно” (Матай 5:8) гэсэн. Есүс “Амжилттай үйлчлэлтэй хүмүүс ерөөлтэй” гэж хэлээгүй. Есүс цэвэр зүрхгүй

хүн Бурханыг үзэхгүй гэсэн! Мэдээж Есүс л бидэнд цэвэр зүрх өгч чадна. Гавьяа байгуулснаар цэвэр зүрхтэй болохгүй. Энэ нь үнэлэшгүй үнэтэй атлаа үнэгүй ирдэг зүйл. Бурханы Хүүгийн амиар олдсон гэдэг утгаараа үнэлэшгүй үнэтэй, Түүнийг хайж байгаа бүгдэд үнэ төлбөргүй очдог гэдэг утгаараа үнэ төлбөргүй юм.

Би “Бурхан минь, төөрөгсдийг аврахын тулд намайг ашиглаач. Хүмүүсийг эдгээж, бөөн бөөнөөр нь чөлөөлөхөд намайг ашиглаач” гэж их гүйдаг байж билээ. Амны уншлага болсон энэ залбирал маань Бурханыг эрэн хайх цагийн маань ихэнхийг авна. Амжилттай үйлчлэгч болох нь миний оройн дээд хүсэл байлаа.

Тэгтэл нэгэн өдөр Есүс намайг байгаа онохгүй байгааг харуулав. Тэрбээр: “Жон, Иудас чөтгөрүүдийг хөөж, өвчтэйг эдгээж, сайн мэдээг номлосон. Тэрбээр миний дагалдагч болохын тулд бизнесээ орхисон. Гэхдээ тэр өнөөдөр хаана байгаа вэ?” гэдэг үгээрээ намайг зог тусгав. Яг л тонн тонн тоосгоор дарчих шиг л болов! Тэгээд: “Христэд итгэх итгэлийн дээд зорилго нь Бурханы хүч юмуу үйлчлэл биш, харин Намайг танин мэдэх явдал” (Филиппой 3:10-15-ыг үзнэ үү) гэж хэлэв.

Хожим манай Лизаг яг энэ үгээр залбирч байтал, Есүс: “Чи найздаа ашиглуулж үзсэн үү?” гэж асуужээ.

-”Тийм ээ, үзсэн.”

-”Тэгээд ямар байсан?”

-”Муухай. Урвалт шиг.”

Тэгтэл Бурхан: “Лиза, би хүмүүсийг ашигладаггүй. Би

хүмүүсийг тосолдог, эдгээдэг, өөрчилдөг, Өөрийнхөө дүр төрхөөр баталгаажуулна уу гэхээс биш, ашигладаггүй” гэж хэлжээ.

Эмэгтэй хүн эр хүнтэй гагцхүү хүүхэд олж төрүүлэх зорилгоор л гэрлэсэн байвал, яах уу? Эмэгтэй хүсэн хүлээсэн хүүхдээ төрүүлэхийн төлөө л нөхөртэйгээ ойртохоос биш, хүнийх нь хувьд огт сонирхогч.6

Мэдээж хачин сонсогдож байгаа ч, энэ нь “Хүмүүсийг аврахын төлөө намайг ашиглаач” гэж хаширах атлаа Бурхантай Өөртэй нь дотно нөхөрлөдөггүй байдлаас маань ялгаатай гэж үү? Бид Бурхантай дотно бол, Түүний санасан арга замаар л үржинэ: “Харин Бурханаа мэдэгч ард түмэн хүчирхэг болж, үйлдэл хийнэ” (Даниел 11:32).

Паулд Бурханыг таньж мэдэхээс өөр амбици байгаагүй (Филиппой 3:8-10). Моос “...замуудаа надад мэдуулээч” (Гэтлэл 33:13) хэмээн хашхирсан. Давид ч “ЭЗЭНээс миний гуйсан, эрэх ганцхан зүйл гэвэл ЭЗЭНИЙ гоо сайхныг харж, сүмд нь бясалган, Амьдралынхаа бүхий л өдрүүдэд ЭЗЭНИЙ өргөөнд суух явдал” (Дуулал 27:4), “Бурхан, ...Усгүй, хуурай, ангамал газарт Сэтгэл минь Танаар цангаж, Бие махбод минь Таныг Хүсэн тэмүүлж байна” (Дуулал 63:1) хэмээн ахин дахин уйлан хайлсан.

Юу, юунаас илүү Бурханыг дотно мэдэх хүсэлтэй Библийн эрчүүд, эмэгтэйчүүд Бурхандаа итгэмжтэй байж, Түүний тогтоож өгсөн замыг дуусган дуусгалтаа явсан байдаг. Тэд хүчирхэг үнэн шударгын нууцыг сурсан байдаг. Тэд Бурханыг үнэн голоосоо хайхдаа, Түүний зүрхийг олж харсан байдаг.

Зарим хүн эш үзүүлэх чадвар, бэлгээ яаж л бол яаж хэрэглэдэг чадвараа сүнсний төлөвшилтэй эндүүрэх нь бий. Гэтэл бэлгэ авьяас чинь олж авдаг бус, зүгээр л өгөгддөг зүйл. Ярьдаг илжиг сүнсний талбарыг олж харсан. Гурван удаа донгодсон тахиа Петрт ухаарал авчирсан. Ингэлээ гээд энэ амьтад сүнслэг болчихсон уу?

Олон хүн Өөрийг нь Эзэн хэмээн дуудаад, хаанчлалд нь багтана гэдэгт найдах боловч, няцаагдана гэдгийг Есүс хэлсэн. Тэд гайхамшиг үйлдэж, чөтгөрийг хөөж, Есүсийн нэрээр эш үзүүлсэн хүмүүс. Гэтэл Есүс тэдэнд: “Би та нарыг танихгүй. Ёс бусыг үйлдэгч та нар Надаас зайл!” (Матай 7:23) гэж хэлнэ.

Бурханы тосолгоо нь Түүний зөвшөөрөл биш. Саул Бурханаар няцаагдсан хойноо эш үзүүлсэн байдаг (1Самуел 19:23-24). Бурханы Хүүг алах цорын ганц зорилго өвөрлөсөн Кайфас ч эш үзүүлсэн (Иохан 11:49-51). Бид Бурханы хүслийг дагахын тулд Бурханы зүрхтэй байх ёстой. Эс бөгөөс Бурханы тосолгооны сүүдэр дор хуульчлал, хуульгүй байдал хоёрын дунд самуурч амьдарна. Балаам эш үзүүлсэн бөгөөд эш үзүүлэл нь биелсэн ч, Израилийг амлагдсан газартаа орох үед мэргэч төлгөчийн нэгэн адил цаазлуулсан.

Паул Тимотын зан чанарыг цэвэр зүрх, итгэмжтэй үйлчлэлээр нь хэмжсэн. Бид ч бас өмнөө энэ жишигийг тавьж, Ариун Сүнсээр үнэн зөвөөр нь хэмжүүлэх ёстой. Айлган сүрдүүлгийн сүнстэй хийх тулаанд энэ амин чухал нөхцлийг хэтэртлээ цохон тэмдэглэнэ гэж үгүй. Энэ бэхэлгээгүйгээр, үгийн үнэн таныг чөлөөлөхгүйгээс гадна сайнаасаа илүү мууг хийх буй за. Учир нь үг өөрөө бус, үгийн цаад сүнс, агуулга нь чөлөөлөх хүчийг тээдэг юм.

Үүнийг ойлгохын тулд Петрийн анхааруулгыг санацаа: “Хайрт ах Паул маань өгөгдсөн мэргэн ухааныхаа дагуу та нарт бичсэнчлэн бидний Эзэний тэвчээрийг аврал хэмээн тооц. Тэрчлэн түүний бүх захидалд эдгээрийн талаар бичсэн юм. Захидлуудад нь ойлгоход хэцүү зарим зүйл байдаг бөгөөд юу ч мэдэхгүй, туйлбаргүйчүүд Бичвэрийн бусад зүйлсийг гүйвуулдаг шигээ тэдгээрийг ч мушгин гүйвуулж өөрсдийгөө сүйрүүлдэг” (2Петр 3:15-16).

Бид Бурханы хүчээр амьдрах томъёог хайснаас, Бурхантай зөв харилцаа тогтоох нь чухал. Бүгдээрээ 2Тимот дээрх Паулын эхлэл мэдэгдлийг үзье. Тимотын цэвэр зүрхийг бататгасныхаа дараа Паул “Энэ шалтгааны улмаас, миний гар тавигдсанаар чамд буй Бурханы бэлгийг сэргээхийг чамд сануулъя” (2Тимот 1:6) хэмээн бичжээ. *Иймээс* гэдэг уг нь “Энэ учраас” гэсэн утгатай. Тиймээс Тимотын итгэл жинхэнэ байгаагүй бол, амьдралдаа Бурханы бэлгийг бадраах Паулын заавар нь хүчингүй болох байж. За цаашаа явцгаая.

Нөгөө туйлшрал: Хуурамч даруу зан

Чамд буй жинхэнэ итгэлийг дурсан бодоход, энэ нь анх чиний эмэг эх Лой, эх Юник нарт байсан бөгөөд чамд ч бий гэдэгт итгэж байна. Энэ шалтгааны улмаас, миний гар тавигдсанаар чамд буй Бурханы бэлгийг сэргээхийг чамд сануулъя (2Тимот 1:5-6).

“Энэ шалтгаанаар би чамд сануулъя.” Паул “Ахлагчид гар тавихад эш үзүүллэгээр дамжин чамд соёрхогдсон бэлгийг бүү үл хайхар” (1Тимот 4:14) хэмээн эхний захидалдаа Тимотод хэлсэн ятгалгынхаа талаар ярьжээ. Паул захидаа нээмэгцээ л нэн тэргүүнд Бурханы бэлгийг хайхрахгүй явж болохгүйг хоёр дахь удаагаа яаран сануулсан байна.

Бурханы бэлгийг эс хайхрах нь юу гэсэн уг болохыг мэдэхийн тулд эсрэг утгыг нь харцгаая. Эс хайхрахын эсрэг утгатай үгс нь:

“Биелүүлэх, хүрэх, үйлдэх, анхаарах, халамжлах, дүүргэх, дүгнэх, бодолцох, гүйцэх” юм.

АЙЛГАН СҮРДҮҮЛГИЙГ ЯЛАХУЙ

Энэ бүх үг нь үйлдэл, эрх мэдлийн үг байна. (Англи хэл дээр) ихэнх үг нь үйл үгийн ч, нэр үгийн ч хэлбэрээр хэрэглэгдэнэ. Мөн эерэг бөгөөд шийдэмгий өнгө аястай үгс байна. Тэгвэл Бурханы Үгийг цааш нь улам нарийн зүйтэй ангилахын тулд эс хайхрах гэдэг үгийн утгыг шалгаж үзье:

Зөрчих, татгалзах, үл хэрэгсэх, үл тоох, үл тооцох, хараагүй, мэдээгүй царайлах, үл тоомсорлох, анзаарахгүй байх, үнэлэхгүй байх, тохуурхах, нүд үзүүрлэх.

Эдгээр нь үйлдэл, шийдэмгий байдал, эрх мэдлийн хомсдлыг цохон тэмдэглэсэн сөрөг үгс ажээ. Бидэнд даалгагдсан юмсыг тоохгүй байх нь ноцтой бөгөөд хурц асуудал болно. Ингэснээрээ бид алдагдал хүлээнэ.

Эрх мэдэлтэй хөөцөлдөхийн нөгөө туйлшрал нь миний хэлдгээр - хуурамч даруу зангаар амьдрах явдал юм. Ингэж амьдардаг хүмүүс Бурханы зан чанарын араас явахын чухлыг хүлээн зөвшөөрдөг ч, үүнээс хэтэрдэггүй. Тэд айdag учраас, амьдралд нь буй Бурханы бэлгийг зоригтой хэрэгжүүлдэггүй. Тэд Христэд итгэдэг хүний зан чанар, хайр биш гэж үзсэндээ, нүүрэлдэхээс айдаг.

Би тэднийг “энхийг сахигчид” гэж нэрлэдэг. Эхлээд харахад энхийг сахих нь зөв зүйтэй мэт боловч, Есүс “энхийг сахигчид ерөөлтэй” гэж хэлээгүй, харин “Амар тайвныг тогтоогсод ерөөлтэй” (Матай 5:9) гэсэн. Энхийг сахигч нь ямар ч үнээр хамаагүй бүхий л төрлийн нүүрэлдээнээс зайлсхийдэг. Тэрбээр энх тайвантай андуурсан өөрийнхөө хуурамч аюулгүй байдлыг баталгаажуулахын тулд яахаас ч буцахгүй.

Тэгвэл энхийг тогтоогч нь өөртөө санаа зовдоггүй учраас, ямар ч үнээр хамаагүй зоригтой нүүрэлдэнэ. Гагцхүү ийм нөхцөлд л жинхэнэ энх тайван тогтоно.

Бурханы хаанчлалд энх тайван байдаг (Ром 14:17). Тийм боловч, нүүрэлдээнгүйгээр энх тайван тогтохгүй. Яг л Есүсийн хэлснээр “тэнгэрийн хаанчлал хүчирхэгжихэд, хүчирхийлэгчид ч бас хүчээ авав” (Матай 11:12). Бурханы хаанчлалын өргөжин тэлэлтэд түрэмгий эсэргүүцэл тулгарна.

Бид *Tooxgүй байвал, аяндаа алга болно гэж их эндүүрдэг. Гэхдээ сэрээд, нүүрэлдэхээс нааш өөрчлөгдөхгүй гэдгийг ухаар!*

Тиймээс л Иуда ариун хүмүүст анхааруулжээ:

Хайртууд аа, би та нарт бидний хуваалцдаг авралын тухай бичихээр бүх зүтгэлээ гаргаж байхдаа, ариун хүмүүст тушаагдсан итгэлийн төлөө тэмцэхийг ятган бичих шаардлагатай хэмээн бодлоо (Иуда 3).

“Сайн сайхан болно гэдэгт найд” гэж хэлээгүй, харин “итгэлийнхээ төлөө тэмц” гэсэн байхыг тэмдэглээрэй. Тэмц гэдэг нь тулаанд дайтах, тулалдахын нэр. Христэд итгэх итгэл нь амархан амьдрал биш! Бурханыг дагахтай хамт жирийн ч, сүнсний ч талбар дээр үлэмж эсэргүүцэл, зөрчил тулгарна!

Паул Тимотыг “Христ Есүсийн сайн цэрэг адил надтай хамт зов. Ямар ч цэрэг цэрэгт татагчдаа таалагдахын тулд аж амьдралын явдалд хутгалддаггүй” (2Тимот 2:3-4) хэмээн тэнхүүлсэн. Бид дайтаж байна. Тиймээс цэрэг хүн шиг бай. Мууд бүү дийлд, мууг харин сайнаар дийл (Ром 12:21).

Ефест пастораар үлчилж байсан Тимотод хандсан Паулын захидал нь байлдааны тушаал байв. Тимотод бэрхшээл тулгарсан. Илчлэх ёстой хуурамч доктрин, таслан зогсоох ёстой зөрчил, өрсөлдөөн, хүчтэй, төлөвшсөн чуулганыг байгуулахын тулд удирдагч нарыг төрүүлэх асуудал гарсан. Үүнээс гадна нүүрэлдэх ёстой бас бус үүрэг хариуцлага байжээ.

Мэдээж нүүрэлдэх үй түмэн асуудал байсан гэдэгт итгэлтэй байна. Чуулган доторх төлөвшилгүй, дорой хүмүүс Тимотын эсрэг ял, гүтгэлгэ тарааж байсан гэдэгт эргэлзэх юм алга. Хажуугаар нь Тимот нас гэдэг өөр нэгэн асуудлыг ялж гарах ёстой байж. Тимот олон томчуудтай цуглааны залуу пастор байв. Энэ нь айлган сүрдүүлэгт үүд нээх бас нэгэн шалтгаан болж. Гэвч энэ бүхний нүүрэн дээр Паул Тимотод өөрт нь юу байгааг санан, хүчтэй хэвээрээ байхыг зааварласан. Паул Тимотод Бурханаас хүлээн авсан эрх мэдэл дотроо зогсохыг байнга сануулдаг байж. Гэхдээ Тимот их бага хэмжээгээр няцсан учраас л Паул түүнд:

“Эдгээрийг тушаа, заа.” (I Тимот 4:11)

“Тэднийг гэм зэмгүй байлгахын тулд эдгээрийг тушаа.”
(I Тимот 5:7)

АЙЛГАН СҮРДҮҮЛГИЙГ ЯЛАХУЙ

“Иймд хүү минь, Христ Есүст буй нигүүлслээр зоригтой бай” (II Тимот 2:1) хэмээн тус тус зааварлажээ.

Магадгүй Тимот Бурханд хайртай хэрнээ нүүрэлдэхээс айdag хүмүүсийн нэг байсан байж мэдэх. Нүүрэлдэхээс айх айdas нь хүнийг амархан айлан сүрдүүлгийн идэш болгодог.

Ийм айdas танд танил байгаа бол, энэ үг танд урам, эрх чөлөөг авчрахын төлөө бичигдсэн болно. Бурхан таныг эрх чөлөөтэй байж, Түүний хүссэн бүхнийг биелүүлэсэй гэж хүсдэг. Айж сүрдсэн хүн баяр хөөргүй болно. Баяр хөөр үгүй бол, хүч үгүй болно. Айdas байгаа газарт энх тайван байхгүй. Харин тушиж байсан зүйлээ тасар татах юм бол, бөөн, бөөн баяр хөөр, амар тайвныг олно!

Энэ бүхэн наадад ямар хамаатай гэж?

Дөрөвдүгээр бүлэг

БЭЛЭГ АВЬЯАС

Энэ хүртэл бид айлган сүрдүүлгийн талаар болоод чуулганы удирдлагад айлган сүрдүүлгийн үзүүлдэг үр нөлөөг авч үзлээ. Гэтэл энэ номыг уншиж байгаа олон хүн бүтэн цагаар үйлчилдэггүй байж болох. Тиймээс “Энэ бүхэн надад ямар хамаатай гэж?” гэж асууж байж болох.

Бурхан итгэгч бүрт сүнс доторх газар, байр суурь өгдөг. Бурхан биднийг “Есүс дотор биднийг Түүгээр амилуулж, Түүнтэй хамт тэнгэрлэг оршихуйд суулгасан” (Ефес 2:6) хэмээн Паул тайлбарласныг санаж байна уу? Тэнд л Бурханы авран сэргээсэн хүүхдүүд байх учиртай. Үүний байршил нь “бүх засаглал, эрх мэдэл, хүч, ноёрхол түүнчлэн энэ үед төдийгүй ирэх үед нэрлэгдэх аливаа нэрээс ч дээгүүр.... Бурхан бүх юмыг Түүний хөл дор захируулж, Түүнийг чуулганд бүх юмын дээрх Тэргүүн болгож өгөв. Чуулган нь Түүний бие тухайлбал бүхний дотор бүгдийг Дүүргэгчийн дүүрэл болой” (Ефес 1:21-23).

Чуулган нь Христийн бие болой. Хүний бие өөр, өөр үйл ажиллагаа, чадвартай олон эд эрхтэнтэй байдаг шиг Христийн биеийн гишүүд ч өөр, өөр дуудлага, бэлэгтэй байна. Тэдгээрийн зорилго, үйл ажиллагааг Бурхан шийддэг юм. Аль, аль нь чухал бөгөөд аль нь ч бие даасан тусгаар биш.

Бүх чөтгөрийн сүнс Есүсийн хөл дор орсныг Паул мэдэгдсэн. Тэгэхээр энэ үг ямар ч чөтгөр нь итгэгч хүний дээр эрх мэдэлгүй болохыг дурсэлж байна. Та Христийн биеийн хөл байсан ч, чөтгөрүүд таны дор байх нь. Есүс “Харагтун, могой ба хилэнцэт хорхойнуудад халдах, дайсны хамаг хүчээс дээгүүрх эрх мэдлийг Би та нарт өгсөн. Та нарт юу ч хор учруулахгүй” (Лук 10:19) гэсэн. Тийм боловч, бид Бурханаас өгөгдсөн эрх

мэдэл дотроо явахгүй, хэрэгжүүлэхгүй бол, өөр нэгэн нь биднээс булааж аваад, бидний эсрэг хэрэглэнэ! Дайсан сүнс доторх бидний байр суурийг авахын төлөө явдаг.

Хэрэглэхийн төлөө өгөгдсөн

Тимотод бичсэн Паулын захиалыг цааш нь үргэлжлүүлэн судлая.

Энэ шалтгааны улмаас, миний гар тавигдсанаар чамд буй Бурханы бэлгийг сэргээхийг чамд сануулья (2Тимот 1:6).

Бэлгийг Грекээр *カリスマ* гэнэ. Стронгийн тайлбар толиос үзбэл, “сүнсний соёрхол - бэлэг” хэмээн тодорхойлжээ. Мөн Вайны толь бичиг дээр “Ариун Сүнсний үйл ажиллагаагаар итгэгч хүний дээр соёрхогдсон нигүүлслийн бэлэг” гэх. Тиймээс карисма гэдэг үг нь итгэгчдийг боловсруулахдаа Бурханы хэрэглэдэг сүнсний чадварыг дүрслэх ажээ.

Сүнсний талбар дээрх *カリスマ* гээр буюу Бурханы чадваргүйгээр юу ч хийх боломжгүй. Үүнгүйгээр бид номлож, дуулж, эш үзүүлж, удирдаж, тэр бүү хэл үйлчилж ч чадахгүй. Энэ нигүүлсэлгүйгээр ямар ч амь бий болохгүй. Бурханд өөрийнхөө арга зам, чадвараар үйлчлэх гэсэн хүний оролдлогоос амьгүй шашин л төрнө. Бурханы бэлэггүйгээр бусдад үйлчлэх нь хоосон хүчин зүтгэл л болно.

Энэ бэлэг нь хэдийнээ Тимотын дотор байсныг тэмдэглээрэй. Бурхан хүнд бэлгээ суулгах үед бэлэг нь ирээд явчихдаггүй, харин дотор нь амьдардаг. Учир нь Бурханы бэлгүүд (*カリスマ*) ба дуудлага нь буцалтгүй ажээ (Ром 11:29). Энэ бэлэг буюу хүч нь хүн бүрт Бурханы өгсөн дуудлагыг биелүүлэх багаж зэмсэг болно. Бэлгээ хэрэглэж ажиллуулах нь бидний хувьд хэвийн, дадмал байх ёстой. Хүний эд эрхтнүүдийн үүрэг, ажиллагаа нэг ажиллаад л, нэг болиод л байдаггүй шиг Бурханы бэлгүүд ч ялгаагүй болой.

Паул Ромын итгэгч нарт “Учир нь та нарыг батжуулахын тулд сүнслэг зарим бэлгийг (*カリスマ*) та нартай хуваалцахсан гэсэндээ та нарыг харахыг би ихэд хүсдэг” (Ром 1:11) гэсэн.

Бурханы хүүхдүүдийг Бурханы хүслийг биелүүлэх чадвартай болгодог эдгэр бэлэггүйгээр чуулган байгуулагдахгүй. Дараах эшлэлийг анхааралтай уншина уу:

Хүн бүр хүлээн авсан бэлгээрээ (*карисмагаараа*) бие биедээ Бурханы олон төрлийн нигүүлслийн сайн нярвууд шиг үйлчил (1Петр 4:10).

Энэ эшлэлээс бид гурван зүйлийг үзнэ:

1. Хүн бүр бэлэг хүлээн авдаг.
2. Бид бэлгийн нярвууд болохоос, бэлэг бидний өмч биш.
3. Бэлэг нь Бурханы олон талт нигүүлслийн нэгээхэн хэсэг нь.

1. Хүн бүр бэлэг хүлээн авдаг.

Энд “хүн бүр хүлээн авсан бэлгээрээ бие биедээ үйлчил” гэж хэлсэн байгааг тэмдэглэнэ үү. Петр “Сонгогдсон цөөхөн хэд нь бэлэг хүлээж авсан” гэж хэлээгүй. Үгүй юм. Хэрэв та дахин төрсөн, Сүнсээр дүүрсэн бол, Бурханы бие дотор ажиллах Бурханы бэлгийг хүлээж авсан л байгаа. Энэ биед хэрэгцээгүй, гологдол хэсэг байхгүй.

Ефес 4:7 дээр Паул “Харин Христийн бэлгийн хэмжээгээр бидний хүн нэг бүрд нигүүлсэл өгөгдсөн” гэсэн. Мөн 1Коринт 7:7 дээр “Бүх хүн над шиг байгаасай гэж би хүсдэг. Гэхдээ хүн бүрд өөрийнх нь бэлэг Бурханаас байдаг бөгөөд нэг нь ийм байхад нөгөө нь өөр байдаг” гэсэн.

Хэрэв бид үүнийг үл тообол, үйлчлэлдээ чадваргүй, дүйцэхээргүй байна. Үүнчлэн, дуудлага маань биелэхгүй Нялх хүүхэд биеийнхээ эд эрхтнийг хэрэглэж сурдаг шиг, бид ч Түүний бие дотор үйлчлэхийн төлөө бэлгээ хөгжүүлж, дадлагажуулж сурх ёстой. Түүний биеийн нэг ч хэсэг энэхүү ер бусын чадвараас гадуур ажиллахгүй.

2. Бид бэлгийн нярвууд болохоос, бэлэг бидний өмч биш.

Бид бэлгийг өмчлөхгүй болохоор энэ бэлгийг үл ойшоо юмуу амин хувийнхаа ашиг сонирхлын төлөө хэрэглэж

боловхгүй. Үүнийг бид дураараа хэрэглэх эрхгүй. Энэ бэлгийг бусдад үйлчлүүлэхийн төлөө бидэнд өгсөн. Бид үүний төлөө хариуцлага хүлээнэ.

Талантын сургаалт үлгэрийг санаж байна уу? Эзэн нь “Нэгэнд нь тэр тав, нөгөөд нь хоёр, өөр нэгэнд нь нэг талантыг тусбүрд нь чадварынх нь дагуу өгсөн” (Матай 25:15). Тэгээд эзэн нь холын аянд гарчээ. Эхний хоёр хүн талантаяа ухаалгаар хэрэглээд, өсгөсөн бол, гурав дахь хүн нь булчихсан.

Эзэнийгээ эргэж ирэхэд, эхний хоёр хүн нь хүлээж авсан талантаяа хэрхсэнээ тайлagnaад, тус бүр эзнээсээ: “Сайн байна, итгэмжтэй, сайн зарц” гэдэг үг сонссон.

Тэгтэл гурав дахь хүн тайлангаа тавьсан. Тэрбээр айсандaa талантаяа нуучихжээ. Тэрбээр эзнээ шударга бус, хэтэрхий ихийг шахаж шаарддаг этгээд хэмээн үзжээ. Тиймээс үл тоосон, амиа хичээсэн, хайхрамжгүй зангаа зөвтгөсөн. Тэгээд үндсэндээ эзэндээ: “Май, энийгээ буцаагаад ав” гэж хэлжээ.

Хариуцуулсан юмд нь зарц нь хэр дургүйцэж байгааг үзээд, эзэн нь зарцаа залхуу, муу амьтнаар нь дуудаад, ганц талантыг нь хурааж аваад, хоёр дахин үржүүлсэн хүнд өгөөд, мөнөөх итгэмжгүй зарцыг гаргаж хаяжээ (Матай 25:16-30).

Бүх нярав нярвын ажлаа тайлagnадаг шиг бид ч хариуцан хүлээн авсан зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ. Бэлгийг өөрөөр чадвар гэх бөгөөд “хүчин чадал, ур чадвар, гоц чадвар, онцгой эрх” гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл талант. Энэхүү сургаалт үлгэрээс бид Бурханы бидэнд даалгасан бэлэг, чадвар, талантыг арчилж, хөгжүүлэх нь хэр чухал болохыг тодорхой харлаа.

Бурхан Паулд заах болоод элчийн үйлчлэлийг даалгасан. Тэрбээр “Хүчнийхээ үйлдлээр надад өгсөн, Бурханы нигүүлслийн бэлгийн дагуу би энэ сайнмэдээний үйлчлэгч болсон” (Ефес 3:7) гэжээ. Паул бэлэгтээ итгэмжтэй хандахыг юу юунаас чухалчилж байгаа тэмдэглээрэй.

Учир нь надад энэ алба тохоогдсон тул би сайнмэдээг тунхагласнаараа сайрхах юм алга. Учир нь би сайнмэдээг эс тунхаглаваас золгүй еэ! Би үүнийг хүслээрээ хийвэл шагнал хүртэнэ. Хүслийн минь эсрэг байлаа ч нярвын үүрэг нь надад даалгагдсан юм (1Коринт 9:16-17).

Паул: “Би золгүй еэ” гэжээ. Золгүй гэдэг чинь тун хатуу үг. Есүст одорхой хувь хүн, хот дээр шийтгэл буухыг анхаарулахдаа энэ үгийг хэрэглэсэн байдаг. Тэрбээр хэдийнээ байхгүй болсон Хоразин, Бетсайд хотуудыг золгүй еэ гэсэн (Матай 11:21-22). Түүнчлэн бичээч нарыг болоод Фарисайчуудыг (Матай 23) мөн Иудасыг (Матай 26:24) золгүй еэ гэсэн.

Иуда чуулган доторх муу ёрын хүмүүст оноогдох шийтгэлийн талаар өгүүлэхдээ, золгүй еэ гэсэн. Илчлэл ном дээр Бурханы шийтгэлд өртөх дэлхийн оршин суугчдын талаар өгүүлэхдээ энэ үгийг хэрэглэсэн (Илчлэл 8:13). Золгүй гэдэг үгээр Паул Бурханы бэлэгт хариуцлагатай бөгөөд итгэмжтэй хандах нь ямар чухал болохыг цохон тэмдэглэжээ.

Хөгжүүлээгүй булчин агшдаг шиг, Христэд итгэдэг хүн бэлэг юмуу дуудлага дотроо ажиллахгүй бол, итгэлээсээ няцна. Ажиллагаагүй итгэгч хүн өөрийгөө тусгаарлахдаа, амархан дайсны идэш болно.

Миний бие Бурханы аугаа эрчүүд, эмэгтэйчүүдийн түүхийг судлахдаа, дуудлагаа хайхралгүй, үл тоосон хүмүүс нь унасан байхыг үзэж билээ. Тэд магадгүй үйлчлэлээ үргэлжлүүлэх нь үргэлжлүүлсэн ч, зүгээр л өнгөрсөн он жилүүдийнхээ үйлчлэлийн эрчээр л өнхөрчээ. Тэд Бурханы бэлгийг бусдыг хамгаалж, бусдад үйлчлэхийн төлөө ашиглалгүй, амин хувийнхаа төлөө хэрэглэсэн байна.

Давид хаан тулалдаж байх ёстой цагаараа дэмий гиюүрч яваад, нүгэлд унасан.

Хавар цаг, хаад дайнд морддог үеэр Давид, Иоабыг түшмэдүүд болон бүх Израилийн хамт илгээхэд тэд Аммоны хөвгүүдийг сүйрүүлж Раббаг бүслэн авав. Давид харин Иерусалимд үлджээ (2Самуел 11:1).

Давид - хаан байсан. Бурхан Израилийг хоньчлуулж, хамгаалуулахын төлөө Давидыг хаан болгосон. Тэрбээр Иерусалим дахь гэртээ тухлаад, байгуулсан ялалтаа амталж суух бус, тулалдаж явах ёстой байсан. Давид урьд урьдынхаа хүч хөдөлмөрийн өгөөжийг эдлэн, амарч байжээ. Тэгээд гиюүрсэндээ тагтнаасаа алсын бараа ширтэж байгаад, усанд орж байгаа Батшебаг олж харжээ. Дараа нь юу болсныг бид мэднэ.

АЙЛГАН СҮРДҮҮЛГИЙГ ЯЛАХУЙ

Гол санаа нь бид энд амрах гэж ирээгүй. Үнэндээ, бидний амийг худалдаж аваад, эргүүлж бидэнд хариуцуулсан учраас, амь амьдрал маань ч биднийх биш юм. Бид байнгын оршин суугч нар бус, харин аялагч нар. Олон хүн яг л эцсийн зогсоол дээрээ ирсэн юм шиг, энд мөнх амьдрах юм шиг аягладаг!

Есүс “Миний хоол бол Намайг илгээсэн Түүний хүслийг үйлдэн, ажлыг нь гүйцэлдүүлэх явдал” (Иохан 4:34) гэсэн. Бид ч ийм л хоолны дэглэм баримтлах ёстой. Есүс хүчээ хадгалахад юу шаардлагатайг мэддэг байсан.

Бид том үүрэг хариуцлагатай хүмүүс. Бид чуулганд явах атлаа амьдралдаа юу ч хэрэгжүүлэхгүй бол, Бурханы Үггүйгээс болж таргална. Езекиел 34:20 дээр Бурхан энэ талаар анхааруулсан буй: “Тиймийн тул, Эзэн БУРХАН тэдэнд ийнхүү айлдаж байна. «Харагтуун. Би, зөвхөн Би тарган хонь болон туранхай хонины хоорондохыг шүүх болно.”

Хүн биеийн ч, сүнсний ч хүчээ хоол хүнснээс авдаг. Бид Бурханы хангамжийг хувийнхаа төлөө хэрэглэж, хүслийг нь биелүүлэхээ больчихбол, яг л хоол хүнсний дутагдалд орсон хүн шиг ядарч, хүчээ алдана. Ингэж хүчээ алдсан хүнд энэ дэлхийг сөрж сэлэх бус, дагаж хөвөх нь хавьгүй амар болно. Бид амиа бодсон, амиа хоохойлсон, амиа бордсон, дураараа хүн болж хувирна.

Бид том үүрэг хариуцлагатай хүмүүс. Бид чуулганд явдаг ч, амьдрал дээрээ юу ч хэрэгжүүлдэггүй, Бурханы Үгийн хомсдолд орсон хүмүүс болж болохгүй. Езекиел 34:20 дээр Бурхан “Харагтуун. Би, зөвхөн Би тарган хонь ба туранхай хонины хоорондохыг шүүх болно” хэмээн айлдсан.

Тарган хонь гэж хэн бэ? Бусдыг хайхралгүй, Бурханы сайн сайхнаар өөрийгөө бордсон хүмүүс. Бурхан тарган хоньдыг юу гэж хэлснийг үзнэ үү:

Сайн бэлчээрт идээшилж, хөлөөрөө бэлчээрийнхээ үлдсэнийг талхлах бөгөөд тунгалаг усыг ууж, үлдсэнийг нь хөлөөрөө булин гартуулах нь та нарын хувьд ялимгүй зүйл гэж үү? ...Та нар бөөрөөрөө бас мөрөөрөө түлхэж, хамаг сул доройг гадагш тартал нь тэдэн уруу эврээрээ мөргөж байгаа учраас Би сүргээ аварч, тэд олз болохгүй. Би хонь хонины хоорондохыг шүүх болно
(Езекиел 34:18, 21-22).

Бурханы бэлэг нь бидний төлөө биш юм. Бурхан биднийг сайн сайхнаараа шалгана. Бид амьдралдаа байгаа Бурханыхаа чадварыг сүл дорой, нялх залуу, бүл чадалгүй хүмүүсийг бүрэн бүтэн байлгахын төлөө хэрэглэх ёстай.

Үүнийг бүгүй гүйвуулаарай. Хүч хөдөлмөрийнхөө үр шимийг эдлэлгүй л яахав. Бурхан биднийг амраана ч, сэргээнэ ч. Тийм боловч, фокус маань ганцхан өөрийгөө л тойроод эргээд байвал, бид таргалж, хайхрамжгүй болно. Хүний өөрийнх нь төлөө үйлчилдэг бэлэг, талант үржихгүй.

Хүний биеийн эд эрхтэн бүр бусад эд эрхтэндээ хариуцлагатай. Хөл чинь явахгүй байвал, бие бүхлээрээ зовно. Уушги, зүрх чинь зогслоо гэвэл, бусад эд эрхтэн чинь ч зогсоно! Сатан биднийг өрөөл дээр бус, өөр дээр маань төвлөрүүлж чадбал, бие бүхлээрээ зовно.

3. Бэлэг нь Бурханы олон талт нигүүлслийн нэгээхэн хэсэг нь.

Түлхүүр үг нь олон талт буюу “олон талтай”. Петр бэлгийг үндсэн хоёр ангилжээ. Эхнийх нь аман буюу өгүүлэх бэлэг. Хоёрдугаарх нь үйлчлэл буюу үйлчилдэг бэлэг. “Ярьдаг нь Бурханы илэрхийллээр яриг. Үйлчилдэг нь Бурханаас тэтгэгдэг хүчээр үйлдэг” (1Петр 4:11).

Тэгвэл Паул дээрх хоёр ангиллыг нарийвчлан задлаж өгчээ. Ром номын дараах хэсгийг үзнэ үү:

Нэг биед олон эрхтэн байдгийн адил мөн бүх эрхтэнд ижил үйл ажиллагаа байдаггүйн адил, бид олуулаа Христэд нэг бие бөгөөд хүн бүр нэг нэгэндээ эрхтэн юм. Бидэнд өгөгдсөн нигүүлслээр бэлгүүд маань ялгаатай. Эш үзүүллэг нь итгэлийнхээ хэрээр үйлчлэл нь үйлчлэлээр, сургагч нь сургаалаар, ятгагч нь ятgalгаар, өгөгч нь өгөөмрөөр, удирдагч нь хичээнгүй зүтгэлээр, өршөөгч нь баяртайгаар үйлд (Ром 12:4-8).

Аман ангилалд: эш үзүүлэх, заах, ятгах, удирдах зэрэг нь орж байгаа бол, үйлчлэх ангилалд: үйлчлэх, өгөх, өршөөл багтаж байна.

Энэ санааг тодруулъя. Та аман бэлэгтэй хүнд юмуу удирдагч

хүнд итгэмжтэйгээр үйлчилж, өөрийгөө батлахаас нааш өөрөө аман бэлгийг хүлээн авч, удирдаж болохгүй. Олон хүн бусдын төлөө амия зориулан үйлчилж чадахгүй байж өөрөө удирдаж, номлохыг ихэд хүсэх. Ийм хүн хичнээн авьяас бэлэгтэй байсан ч, өөртөө ч, өрөөлд ч үйлчилж чадахгүй. Үйлчлэлээр дамжин зан чанар нь боловсроогүй хүн хүмүүсийг удирдлагынхаа байр сууриар далайлган дарангуйлж л чадах байх..

Тэгэхээр, дутмаг ойлголтоос болж хоёр туйлшрал гардгийг би үзсэн. Эхнийх нь өөрийгөө бусдаас дээгүүр тавьсан хүмүүс байна. Аман бэлгийг л цорын ганц бэлэг мэт эндүүрсэн энэ хүмүүс “Энэ л үйлчлэлийн амин цэг, Бурханд өөрөөр үйлчлэх арга зам байхгүй” гэж итгэдэг.

Энэ буруу юм. “Учир нь биеийн эрхтэн ганц биш, харин олон. Бүхэл бие нүд байсан бол сонсгол нь хаана байхсан билээ? Бүхлээрээ сонсгол байсан бол үнэрлэхүй нь хаана байх билээ?” (1Коринт 12:14,17). Тэд бүгд ам байхын түүс болдог. Гэтэл хэсэг бүр чухал. Тусlamжийн үйлчлэлгүйгээр, аман үйлчлэл хязгаарлагдана. Хүмүүс байгаа бэлгээрээ бус, мөрөөддөг бэлгээрээ ажиллахыг хүсэх!

Нөгөө нэг туйлшрал нь үйлчлэл нь номлогч наараар юмуу цуглааны ажилтнуудаар хязгаарлагдана гэдэг итгэл үнэмшил. Энэ сэтгэлгээ нь биеийг эрэмдэглэж, тахир татуу хүний төвшинд үйлдэхдэд хүргэдэг.

Паул “Бүр мөхөс мэт санагдах эрхтэн харин ч биед илүү хэрэгтэй байdag.

Бидэнд тийм ч эрхэм биш санагддаг биеийн эрхтнүүдээ бид илүү эрхэмлэн хувцасладаг бөгөөд хүндлэлгүй харагддаг эрхтнүүддээ илүү хүндэтгэлийг үзүүлдэг” (1Коринт 12:22-23) хэмээн тайлбарласан. Энэ уг нь нүднээс далд байдаг юмсыг чухалчилж байна. Бурхан далд юмсыг ил юмсаас илүү чухал болгож бүтээсэн. Хүн ярихгүйгээр амьдарч чадах ч, элэг, зүрхгүйгээр амьдрахгүй. Элэг, зүрхгүйгээр алхаж, ярих гээд үзээрэй дээ.

Анхны чуулган бэлэгт хэрхэн хандаж байсныг Үйлс ном өгүүлдэг. Үйлчлэл нь номлож, эдгээж, чөлөөлж, эш үзүүлэхээс өргөн зүйл болохыг анхны Христэд итгэдэг хүмүүс ойлгожээ. Үйлс 6 дээр Иерусалимын чуулганд явдаг, анхаарал халамж дутагдсан бэлбэсэн эхнэрүүд гарна. Тэдэнд өдөр тутмын хүнс, ойр зуурын хэрэгцээ шаардагдсан байдаг.

Энэ асуудал чуулганы удирдлагад хүрэхэд, тэд “...ах дүү нар минь, Сүнс болон мэргэн ухаанаар дүүрэн, нэр хүнд бүхий долоон эрийг та нар дундаасаа сонго. Тэгээд энэхүү үүргийг тэдэнд хариуцуул” (Үйлс 6:3) хэмээн шийдвэрлэдэг. Тийм эрчүүдийг олоод удирдлага дээр авчирсан хойно дараах үйл явдал болжээ: “Тэгээд тэднийг элч нарын өмнө ирүүлэхэд тэд залбирцгааж, гараа тэдэн дээр тавив. Бурханы уг түгэн тархсаар Иерусалим дахь дагалдагчдын тоо үлэмж ихээр нэмэгдсээр байсан бөгөөд тахилч нараас маш олноороо энэхүү итгэлд дуулгавартай болж байлаа” (Үйлс 6:6-7).

Удирдлага нь тэдний дээр гар тавьсны дараа юу болсон? Үйлчлэх бэлэг хүртээгдэн, үр дүнд нь Бурханы Уг түгэн дэлгэрч, дагалдагч нарын тоо үржжээ. Тэр эрчүүд хүртээгдсэн бэлгээ хэрэглэсэн. Энэ бол гайхамшигтай баримт. Бэлбэсэн авгайчуулыг хоол хүнсээр хангасан эрчүүд Бурханы Угийг түгэнэн дэлгэрүүлж, дагалдагч нарын тоог үлэмж үржихэд хүргэсэн байна!

Хүмүүс бүгдээрээ (удирдагч нар болоод чуулган бүхлээрээ) эрвийх дэrvийхээрээ үйлчлэхгүй байгаа нь өнөөгийн чуулганууд олигтой өсөхгүй байгаагийн нэгэн шалтгаан гэдэгт би итгэдэг. Бэлгээ ажиллуулж байгаа ганц удирдагч тоотой хүмүүсийг авралд хүргэдэг бол, даяар чуулган хөдлөх үед хавьгүй том үр дүнд хүрдгийг Үйлс ном харуулдаг.

Пентекост өдрийн дараа Петрийг номлоход “турван мянга орчим хүн нэмэгдсэн” гэдэг (Үйлс 2:41, тодруулгыг нэмэв. Түүнчлэн 47-аар эшлэлийг үзнэ үү). Петрийг Иерусалимын гудмаар явж, эдгэрлийн тосолгоогоороо бөөн, бөөнөөр нь эдгээх үедч “Эзэндуулам олон хүн итгэж, эрэгтэй, эмэгтэйчүүд олноороо тогтмол нэмэгдэж байлаа” гэдэг (Үйлс 5:14, тодруулгыг нэмэв).

Гэтэл “өдөр бүр сүм дотор бас айлаас айлд зааж, Есүс бол Христ гэдгийг тунхаглахaa эс зогсоосны” (Үйлс 5:42) дараа итгэгч хүмүүс мөнөөх бэлбэсэн авгайчуудыг халамжлан үйлчилж эхэлсэн бөгөөд тэр үед чуулган “үлэмж үржсэн” (Үйлс 6:7) гэдэг.

Тэгвэл өнөөдөр пасторууд сайн дурынхнаас бараг л гүйж гувшиж байж, үйлчлүүлдэг. Тун харуусмаар. Гэтэл удирдагч нар нь ингэж гүйж байхыг Үйлс номоос үзэхгүй. Тэд зөөгчийн үйлчлэлийн байр суурийг ихэд чухалчлан үзсэндээ, авьяас чадвараараа бус, зан чанараараа тэнцэх эрчүүдийг сонгон

шалгаруулаад, тохоон томилсон. Тэд өнөөдрийн бидний юмын чинээ үзэхгүй зүйлийг ихэд чухалчилж үзжээ.

Итгэмжтэй байх үүрэг хариуцлага

Итгэдэг хүн бүр тэдэн шиг үйлчилдэг бол, юу болох бол? Ёстой л нүд үзээгүй, чих сонсоогүй юмсыг үзэх байх даа бид. Сэргэлт нь номлогч нарт бус, бүтэн биед хамаатай зүйл. Хүн бүр байр сууриа эзлэх ёстай.

Бэлэг нь Бурханы бидэнд өгдөг чадвар болохыг санаарай. Бидэнд даалгаагүй зүйлд бид хариуцлагагүй. Хөл харааны төлөө хариуцлага хүлээхгүй. Гэлээ гэхдээ, Бурханы хүсэл гагцхүү Сүнсний чадвараар л гүйцэлдэнэ. “Бид чухамхүү аливааг өөрсдөөсөө мэт зүтгэж чадахгүй ч бидний чадвар Бурханаас юм” (2Коринт 3:5).

Дайсан энэ бүх бэлгийн хамтын үйл ажиллагааг л тасалдуулахыг зорьдог. Тасалдуулж чадбал, өсөлтөд маань томоохон гарз учирна! Бурхан биднээс бэлгээ татахгүйг дайсан мэддэг учраас, биднийг Бурханы өгсөн бэлгийг хэрэглэлгүй, цалгардуулахад хүргэхийг санаархана. Харин үүнийгээ айлган сүрдүүлэг гэдэг үндсэн аргаараа гүйцэтгэнэ.

II ХЭСЭГ

АЙЛГАН
СҮРДҮҮЛГИЙГ
ИЛЧЛЭХ НЬ

Яагаад ийм олууллаа үүр нөлөөгүй байна?

Тавдугаар бүлэг

ИДЭВХИГҮЙ БЭЛЭГ

Итгэгч хүн бүр Бурханаас ирсэн талантыг буюу бэлгийг дагалдаж ирдэг эрх мэдлийн байр суурийг эзэлдэг бөгөөд чөтгөрийн хамаг эрх мэдлийн дээгүүр, Есүс Христийн дотор нуугдаатай байдгийг бид хэдийнээ сурсан. Тэгвэл, яагаад бидний олонх маань ийм үр нөлөөгүй байна? Үүнд хариулахын тулд Тимотод бичсэн Паулын захидалыг дахин уншъя:

Энэ шалтгааны улмаас, миний гар тавигдсанаар чамд буй Бурханы бэлгийг сэргээхийг чамд сануулья (2Тимот 1:6).

“Сэргээхий” Грекээр аназопурео гэдэг ба “шинээр асаах юмуу тултал нь дүрэлзүүлэх” (Вайны толь бичиг) гэсэн утгатай. Паул залуу Тимотыг бэлгээ идэвхитэй байлгахын тулд (карисмагаа) өрд, бадраа хэмээв! Бэлэг нь автомат зүйл биш. Үүнийг гал шиг л өрдөж, асааж байх ёстой!

Зарим гэнэн цайлган, цэвэр зүрх, санаатай хүмүүс Бурхан ямар нэг зүйлийг хүссэн л бол, бий болгоно гэж итгэдэг. 1795 онд Эдмунд Бурк “Сайн хүмүүс юу ч хийхгүй байхад л ёрын муугийн ялалтад “буян болно”¹ гэж хэлж байжээ.

Тимот цэвэр зүрхтэй байсан. Паул түүний зан чанарыг магтан сайшаасныг санаж байна уу? “Та нарын төлөө үнэхээр санаа тавих адилхан санаатай хэн ч надад алга. Тэд бүгд Христ Есүсийнхийг бус, өөрсдийнхийг эрдэг. Харин Тимот надтай хүү нь эцэгтээ үйлчилдэг шиг сайнмэдээнд үйлчлэн өөрийгөө нотолсныг та нар мэднэ” (Филиппой 2:19-22). Тийм боловч Паул Тимотод бэлэгтээ хайхрамжтай хандаж, идэвхитэй байлгахыг хоёрын хоёр удаа анхааруулсан.

АЙЛГАН СҮРДҮҮЛГИЙГ ЯЛАХУЙ

Тэгэхээр, бүгдээрээ хоёр асуултанд хариулах ёстой: 1). Бэлгийг юу идэвхигүй болгодог вэ? 2). Бэлгийг хэрхэн сэргээх вэ? Хоёрдугаар асуултад дараа дараагийн бүлгээрээ хариулах бол, одоо эхний асуултаа үзье. Бурханы бэлгийг юу идэвхигүй болгодог вэ?

Хариулт нь дараах эшлэлд байна:

Энэ шалтгааны улмаас, миний гар тавигдсанаар чамд буй Бурханы бэлгийг сэргээхийг чамд сануулья. Учир нь Бурхан бидэнд айдсын бус, харин хүч, хайр ба биеэ захирах сүнсийг өгсөн (2Тимот 1:6-7).

Айдсыг Грекээр делиа гэдэг. Энэ нь зүрхгүй байх, хулчийхыг хэлэх бөгөөд Бичээс дээр нэг ч удаа сайн утгаар хэрэглэгдээгүй (Вайны толь бичиг). Долдуугаар эшлэлийг нь Нью Интернэйшнэл Вержн Библиэс уншья:

Учир нь Бурхан бидэнд зүрхгүй байх сүнсийг өгөөгүй.

ЭнАйVi Библийн орчуулагч нар энэ эшлэлд зүрхгүй байх гэдэг үг яг тохирно гэж итгэсэн бөгөөд би ч бас тэгж итгэж байна. Энэ утгаараа Паул Тимотод: “Зүрхгүй байдлаас чинь болж бэлэг чинь идэвхигүй байна” гэж л хэлжээ. Тэгвэл би үүний утгыг нь өөрчлөхгүйгээр хэлье:

“Тимоот, айдас сүрдүүлгээс болж Бурханы бэлэг идэвхигүй байна!”

Айж сүрдсэн итгэгч нар үйлдэлгүй байдлаараа сүнс доторх эрх мэдлээ алдахад, эцэстээ тэдний дотор Бурханы суулгасан бэлэг идэвхигүй болон унтардаг. Өөрөөр хэлбэл, дотор нь байгаад байгаа хэрнээ ажиллагаагүй.

Мичиганы удирдагч надад “магтаал, хүндэтгэлийн удирдагч нар таныг хатуурхаж байна гэнэ” гэж хэлэх үед би өөрийгөө тэдэнд хатуурхаж л гэж бодсон. Би сүрдсэн. Тэгсэн гэнэт Бурханы бэлэг унтарч, би өмнөх арван найман удаагийн цуглаанд номлосон шигээ тосолгоотой номлож чадаагүй. Надад Бурханы амь намайг орхисон мэт санагдсан. Эргэлзээ хуралдаж, би

шийдэмгий байдлаа алдаж, хүмүүстэй нүүрэлдэхийг хүсээгүй. Яагаад? Яагаад гэвэл би аиж сүрдсэн учраас, Бурханаас хүлээж авсан эрх мэдлээ тавиад туучихжээ.

Айлган сүрдүүлгийг тодорхойлох нь

Одоо *айлган сүрдүүлэх*, *айлган сүрдүүлэг* гэдэг үгийн тодорхойлолтыг үзье. *Аиж сүрдэхийг* Оксфордын англи хэлний толь бичигт дараах байдлаар тодорхойлжээ:

1. Зүрх үхэх.
2. Айдаст автах.
3. Ухаанаа алдтал айх, сүрдэх.²

Тэгвэл Мириам - Вебстерийн эрдмийн толь бичиг дээр (арав дахь хэвлэл) дараах байдлаар тодорхойлсон байна:

Заналхийллээр дамжуулан (эсвэл дамжуулах мэт) урамгүй болгох, хөшөөх, дарамтлах.³

Оксфордын Англи хэлний толь бичигт *айдас сүрдүүлэг* гэдэг нэр үгийг дараах маягаар тодорхойлжээ:

1. Айлган сүрдүүлэх юмуу айлгах үйлдэл.
2. Аиж сүрдэх бодит байдал, нөхцөл.
3. Заналхийллэл, түрэмгийллээр дамжуулан аливаа үйлдэл хийхийг нь албадах юмуу хүчээр таслан зогсоох.⁴

Айлган сүрдүүлэг нь таныг үйлдэл хийхээс хорьж, хөшөөж, захиргаандаа хүчлэн оруулах зорилготой. Айлган сүрдүүлэг нь таныг дорд байдал, айдсын мэдрэмжээр дарамтлах санаатай. Санаатайгаар эсвэл санаандгүйгээр захиргаан дор нь яваад орчихбол, та айлган сүрдүүлэгчийнхээ боол болно. Та Бурханы хүслийг биелүүлэх эрх чөлөөгөө алдаж, айлган сүрдүүлэгчийнхээ хүсэлд захирагдана.

Эцэстээ Бурханы бэлэг - таны доторх Бурханы чадвар ажиллахаа болино. Эдүгээ танаас эрх мэдлийг чинь хурааж

авсан бөгөөд үүнийг чинь таны бөгөөд таны нөлөөллийн давхарга дорх хүмүүсийн эсрэг ашиглана.

Айлган сүрдүүлгийн эх ундарга нь айдас бөгөөд айдас нь бидний дайсан диаволаас үндэстэй. Диавол - бүхий л зүрхгүй байдал, айдсын эх үүсвэр юм (Эхлэл 3:1-10 (ялангуяа 10-аар эшлэл)). Диавол бидний бодол, төсөөлөл, алсын харааг довтлон, айлган сүрдүүлэхийн тулд өөрийнхөө талынхныг болоод нөхцөл байдлыг ашиглана. Ясан ч бай, түүнд биднийг хянаж, хязгаарлах гэсэн ганц л зорилго бий.

Елиа айж сүрдсэн үү?

Елиа маш том хүчийг эрхшээсэн хүн байсан. Тэрбээр Бурханаас эмээдэггүй, ёрын муу хааны өмнө зогсоод “Намайг тушаахаас нааш энд хэдэн жилийн турш бороо ч бүү орог, шүүдэр ч бүү бууг” (1Хаад 17:1) гэж мэдэгдсэн. Елиа бурхангүй хаанаас айгаагүй.

Дараа нь Елиа хэдэн жил гайхамшигаар аж төрсөн. Түүнийг эхлээд хэрээнүүд тэжээгээд, дараа нь тэр их гамшиг, өлсгөлөн дунд хүнс, тос нь хорогдоогүй бэлбэсэн авгай тэжээсэн. Тэр бэлбэсэн авгайн хүү нь гэнэт үхэхэд, Бурхан Елиагийн залбирлыг сонсоод, хүүг үхлээс амилуулсан. Елиа үнэхээрийн хүчтэй үйлчлэлтэй хүн байв.

Олон жилийн дараа Елиа дахиад л хааны өмнө зогссон. Хаан их ган гачгаас үүдсэн гай зовлонд Елиаг буруутгахдаа “Израилийн үйлийг үзэгч чи юу?” (1Хаад 18:17) гэсээр уgtжээ.

Гэтэл Елиа өөдөөс нь айсан ч шинжгүй “Би Израилийн үйлийг үзээгүй, харин та болон таны эцгийн гэр ЭЗЭНий тушаалуудыг огоорон Баалыг дагаж явснаар ингэсэн” (1Хаад 18:18) гэж хариулдаг. Тэгээд хаанд Баал, Ашерагийн 850 зөнчийг Израилийн ард түмэнтэй хамт бүгдийг нь Кармел уулан дээр цуглуулахыг хэлсэн.

Тулааны өдөр хэн нь жинхэнэ Бурхан болохыг үзэхээр Израиль бултаараа цуглав! Елиа бурхаддаа тахил өргөхийг Баал, Ашерагийн зөнчдөд хэлээд, өөрөө ч бас Эзэнд тахил өргөөд: “Галаар хариу өгөх бурхан нь л Бурхан мөн” (1Хаад 18:24) гэж тунхагласан.

Эзэн Бурхан галаар хариулахад, Израилийн ард түмэн

нүүрээрээ хөсөр унаад, Бурхан руугаа эргэсэн. Тэгээд Елиа тушаал өгөн, 850 хуурамч зөнчдийг алуулжээ.

Дараа нь Елиа ямар ч борооны шинжгүй байхад бороо дуудан, үнэн голоосоо залбирсан. Хэдхэн минутын дотор тэнгэр харанхуйлан, ширүүн бороо цутгасан. Ахабыг ордон руугаа зугтахад, Бурханы мутар Елиагийн дээр бууж, тэрбээр Ахабын сүйх тэргээс ч хурдан гүйжээ.

Энэ бол Елиагийн ганц өдрийн л амьдрал. Ард түмэн Бурхан руугаа эргэж, ёрын хүмүүс алуулж, олон жилийн ган гачиг төгссөн. Елиа Бурханы дуу хоолойг тодорхой сонсож, үйлдэж, аугаа гайхамшиг бүтээдэг байжээ.

Хааны хатантай тулав

Гэтэл тэр өдөр Ахабын хатан Иезебел зөнчдийг нь хэрхсэнийг дуулаад, Елиад үгээ дайжээ: “Хэрэв би маргааш өдийд чиний амийг тэдгээр эш үзүүлэгчдийн амь шиг болгохгүй бол бурхад намайг шийтгэг, бүр илүү үйлдэг!” (1Хаад 19:2). Хатан өөрийнх нь номнолыг хэлдэг зөнчдөө алдсандаа галзууртлаа уурлажээ. Гэтэл Елиа хэрхэн хариу үйлдсэнийг үзнэ үү:

Елиа айн босож, амия аврахаар зугтан Иудад харьялагддаг Beeршебад ирэв. Тэнд өөрийн зарцыг үлдээв. Харин тэрээр өөрөө нэг өдөржингөө алхсаар цөлд хүрээд, нэгэн тац модны доор суув. Тэрээр үхэхийг хүсэмжлэн —Одоо хангалттай. ЭЗЭН минь, би эцэг өвгөдөөсөө дээрдэх юмгүй тул одоо миний амийг аваач гэж хэлэв (1Хаад 19:3-4).

Елиа аугаа ялалт байгуулсан өдрөө л амия авран зугтжээ. Тэрбээр Иезебелээс сүрдэж, урам алдсандаа үхэхийг хүсч. Иезебел Елиаг Бурханы зорилгыг биелүүлэхээс нь таслан зогсоо зорилгоор айлган сүрдүүлжээ. Иезебел Елиагийн ард түмэнд үзүүлсэн нөлөөг буцааж, сөнөөж, замаасаа зайлцуулахыг хүссэн байна. Хэдийгээр хатан Елиаг алж чадаагүй ч, үхэхийг хүсэн, амия авран зугттал нь айлгаж чаджээ. Елиа санаандгүйгээр хатны төлөвлөгөөтэй хавсрان ажиллажээ. Уг нь Елиа үүнийгээ ухаарсан бол, зугтахгүй байж.

Айлган сүрдүүлгийн шинж тэмдэг

Айлган сүрдүүлэг нь эргэлзээ, урамгүй байдал, гутралыг тархаадаг. Айлган сүрдүүлэг нь таныг эрүүл ухаантай үзлээ алдахад хүргэдэг. Бүх зүйл аймшигтай, хэцүү, боломжгүй харагдана. Айлган сүрдүүлэг хүчтэй байх тусам, төдий чинээ урам, найдвараа алдана. Айлган сүрдүүлгийг үтэр түргэн шийдвэрлэхгүй аваас, айж сүрдээгүй үедээ яасан ч хийхгүй байсан юмсаа хийхдээ хүрнэ. Энэ чинь л айлган сүрдүүлгийн зорилго.

Би айлган сүрдүүлгийн сүнсэнд довтлуулсан тохиолдлуудаа санаахдаа, Елиаг ойлгох шиг болдог. Айлган сүрдүүлэг хэрхэн ажилладгийг мэдэхээсээ өмнө би зочид буудлынхаа өрөөнд урам, найдвар тасран судаг байлаа. Тэгээд Энэ бухэн хэнд ч хэрэгтэй юм? Чи өөрийгөө хэн гэж бодоов? гэж бодно. Заримдаа маш муундаг цуглаан хийсний маргааш өглөө ч ийм бодол орж ирнэ.

Нэг удаа өдөржин юу ч хийж чадахгүй байснаа санаж байна. Тэр хүнд дарамтаас салах арга байсангүй. Залбирсан ч, Бурхан байхгүй мэт. Елиатай адил би өөрийгөө, өөрийгөө, өөрийгөө л бодож байлаа. Ямар ч үр нөлөөгүй, үйлчлэл маань ч хэнд ч хэрэггүй санагдана. Тиймээс л Елиа: “Одоо хангалттай. ЭЗЭН минь, би эцэг өвгөдөөсөө дээрдэх юмгүй тул одоо миний амийг аваач” (1Хаад 19:4) гэж хэлээ байх.

Тэр урамгүй өдрийн адаг дээр Бурхан надад Елиа Иезебелээс айж сүрдсэнийг харуулав. Тэгээд би тэр айлган сүрдүүлэгч, урамгүй байдлын сүнсний хүссэнээр авирлаж байгаагаа ойлгосон юм. Тэр сүнс намайг Бурханы хийлгэхээр илгээсэн ажлаас ухраахыг хүсчээ. Тэр чуулганы зарим хүн Бурханы надаар дамжуулан хэлүүлсэн гэмшил, ариун байдлын үгд дургүйцэн байв.

Би тэр даруй өдөржин зөрчилдсөн шинж тэмдгийн үндсийг буюу айлган сүрдүүлгийн сүнсийг мөшгив. Тэгээд зоригтойгоор тасар татан чөлөөлөгдж, эргэлзээ, гутралаас суллагдлаа. Тэр оройн цуглаан ямар хүчтэй байсан гэж бодно! Айлган сүрдүүлгийн сүнстэй хэрхэн тулахыг хожим дэлгэрэнгүй тайлбарлана. Харин одоо айлган сүрдүүлгийг хэрхэн танихыг Елиагийн амьдралаас харцааяа.

Чи энд юу хийнэ вэ?

Елиа Иезебелийн айлган сүрдүүлэгтэй халз тулаагүй учраас, эрх мэдлээсээ ойчжээ. Үүнээс нь болж түүний үйлчлэлийн бэлэг дарагдаж, Бурханы хүсээгүй чиглэл рүү явсан. Тулаанаас зугтаж яваа энэ Елиа өмнө тулаанд угтан орж байсан Елиагаас тэс өөр хүн шиг харагдаж байсан нь эргэлзээгүй. Тэрбээр зарцаа үлдээчихээд, эсрэг өөдөө эргэн, Хореб уул руу дөчин өдөр, шөнө гүйсэн. Тэнд хүрсэн хойно нь Бурхан түүнээс хамгийн түрүүнд “Елиа, чи энд юу хийж явна вэ?” (1Хаад 19:9) хэмээн асуужээ.

Төсөөлж байна уу? Сэтгэл санааны өвчин тусч, дөч хоног гүйж, эцэж цуцсан Елиа үхлээс өөр хүсэх юмгүй болтлоо гутарчээ. Гэтэл Бурхан түүнээс “Чи яагаад энд байна вэ?” хэмээн асуусан. Бурхан Елиагаас “Чи яагаад ажил үүргээсээ зугтаад, энд нуугдана вэ?” гэж л асуужээ.

Та Бурхан Өөрөө Елиаг дөчин өдөр, шөнө гүйх чадалтай болгох гээж хоёр зүсмэй бялдуу өгүүлэхээр тэнгэрэлчээ илгээсэн байлтай? Тэгээд яахаараа ийм сонин юм асуудаг билээ? гэж бодож байгаа байх.

Бурхан Елиаг зугтхаар шийдсэнийг мэдэж байсан. Ямар нэг зүйлд шулуудсан хүнийг Бурхан хэдийгээр Өөрөө хүсээгүй байсан ч, хорьж зогсоодоггүй.

Моабын хаан Балак Израилийг хараалгуулахаар Балаамыг урьж залах үед Бурхан яг л тэгсэн. Уг нь Эзэн Балаамд битгий яваарай гэсэн. Гэтэл Балаам Бурханаас хоёр дахь удаагаа асуусан бөгөөд энэ удаа Бурхан таалсан мэт Балаамд явахыг зөвшөөрсөн байdag.

Маргааш өглөө нь Балаам илжгээ эмээллээд явахад нь Библи “түүний явснаас нь болж Бурхан уурласан” (Тооллого 22:22) гэдэг. Бурханы тэнгэрэлч Балаамыг алахаар бууж иржээ.

Бурхан Өөрөө Балаамд явах зөвшөөрөл өгчихөөд, яахаараа явсанд нь уурлав? Бурхан Балаамын зүрхийг мэдсэн учраас, явахыг нь зөвшөөрчээ. Балаам Бурханыг дагахаасаа илүү Балакийн мөнгө, хүндэтгэлд дурласныг Бурхан мэднэ. Ямар нэг зүйлд шулуудсан хүнийг Бурхан хэдийгээр Өөрөө хүсээгүй байсан ч, хорьж зогсоодоггүй.

Елиагийн хувьд яг л ийм явдал болсон. Бурхан Елиаг Баалын зөнч нартай тулсан шигээ буцаж очоод, Иезебелтэй тулаасай

гэж хүссэн. Тэгсэн цагт Кармел уулнаас эхэлсэн зүйл гүйцэлдэх байлаа. Гэтэл Елиа Иезебелтэй нүүр тулахыг хүсээгүй. Елиа тэр их дарамтаас зайлхыг хүссэн. Тиймээс Бурхан Елиагийн аян замд шаардлагатай хүнсийг өгүүлэхээр тэнгэрэлчээ илгээжээ. Бурхан Елиаг Хореб ууланд хүртэл нь хүлээгээд, айж сүрдсэн асуудлыг нь шийдвэрлэхийг хүсч байв.

Энэ бүхний цаана

Елиагаар эхлүүлсэн Бурханы ажил Иезебелтэй тулахаас нааш дуусахгүй. Тэр эмэгтэй л Израилийн хамаг зовлонгийн үүр уурхай байв. Библи “ЭЗЭНий мэлмийд ёрын мууг үйлдэхээр өөрийгөө худалдсан Ахаб шиг хүн үнэндээ байсангүй. Түүнийг эхнэр Иезебел нь уруу татсан юм” (1Хаад 21:25) гэдэг. Елиа зугтаагүй байсан бол, Эзэн Елиатай Кармел уулан дээр хамт байсан шигээ л байх байсан. Гэтэл Елиа Иезебелээс сүрдээд, эрх мэдлээсээ ойчсон. Даалгавраа биелүүлэх бэлэг нь унтарчээ.

Тэгэхээр, Бурхан Елиагаас юу хийж явааг нь хоёр удаа асуусан хойноо юу айлдсаныг нь үзье:

Яв, Дамаскийн цөл уруу явах замаараа буц. Чи Хазаельг Арамын хаанаар томилон тослох болно. Мөн Нимшийн хүү Иехүг Израилийн хаанаар томилон тосолж бас Абел-мехолагийн Шафатын хүү Елишаг өөрийнхөө оронд эш үзүүлэгчээр томилон тослох болно. Хазаельн илднээс зугтсан хүү Иехүгийн гарг орж үхэх болно. Иехүгийн илднээс зугтсан хүү Елишагийн гарг орж үхэх болно (1Хаад 19:15-17).

Бурхан Елиад өөрийнхөө оронд Елишаг эш үзүүлэгчээр, Иехүг Израилийн хаанаар тосло хэмээснийг тэмдэглэнэ үү. Бурханд Иезебелээс зугтахгүй хоёр эр байжээ. Тэд Бурханы даалгаврыг гүйцэлдүүлнэ.

Елиаг Иезебелийн айлган сүрдүүлгээс зугтах үед өмнө эхлүүлээд байсан ажил нь зогсжээ. Израилийн хамаг бузар муугийн нөлөөг Иезебел л хөдөлгөж байсныг санаарай. Удирдагчийн буруу нөлөөтэй халз тулж, таслан зогсоохгүй бол, төд удалгүй ёрын муу доод хүмүүсийг нь эрхшээнэ.

Есүс “Бяртай эрийг эхлээд хүлэхгүй бол хэн гэрт нь орж, эд хөрөнгийг нь дээрэмдэж чадах билээ? Тэгж байж л гэрийг нь дээрэмдэнэ” (Марк 3:27) гэдэг зарчмыг зааж өгсөн байдаг. Хүчтэй эр нь удирдагч хүн бол, гэр нь удирдагчийн мэдлийн нутаг дэвсгэр, нөлөөлөл, нөлөөллийнх нь үр дүн, үр жимс, өмч хөрөнгө болно. Тэгэхээр, энэ тайлбараар Есүсийн үгийг дахин нэг уншаад үзье:

“Удирдагч хүнийг эхлээд хүлэхгүй бол хэн нутаг дэвсгэрт нь нэвтэрч, нөлөөллийнх нь үр дүнг тонож чадах билээ?
Тэгж байж л нутаг дэвсгэрийг нь тононо шүү дээ”
(Марк 3:27).

Та “Гэхдээ Ахаб удирдагч нь байсан. Гэтэл Елиа түүнээс айгаагүй” гэж магадгүй. Тийм бөгөөд үгүй. Удирдагч гэдэг нэр алдрыг нь Ахаб зүүж байсан ч, тэрбээр эрх мэдлээ гэргийдээ алдсан байв. Тиймээс сүнсний талбар дээр - Израиль дахь шүтээн мөргөлийн цаад “хүчтэн” нь Иезебел байжээ. Тэр хүүхэн л Баалын мөргөлийг хөгжөөн баясгагч байв. Түүний нөлөөгөөр л Бурхандаа итгэмжтэй үлдсэн долоон мянган хүнээс бусад бүх Израиль хүн жинхэнэ Бурханаасаа уrvасан. Иезебелтэй халз тулчих амьтан байхгүй учраас, нөлөө нь бөх чигээрээ үлджээ.

Би ч ийм байдлыг ахин дахин хардаг. Пастор, удирдагч нэртэй атлаа гэргий, туслах, зөвлөлийн гишүүд, диконууд, өмгөөлөгч гэх мэт голдуу өөрсдийг нь тулж түшиж байх ёстой хүмүүсийнхээ дарангуйлал, айлан сүрдүүлэгт автсан хүмүүс байна. Тэд удирдагч нэр зүүсэн хүнээ хянан захирч, тайзны араас үзүүлбэрийг дохиж байдаг.

Гэр бүлд ч ийм байдал байна. Аав ээж нь үр хүүхдээсээ аиж сүрдэнэ. Эр нөхөр нь гэргийгээсээ аиж сүрдэнэ. Тэд өрх гэрээ тэргүүлэхээ болжээ. Мэдээж удирдагч хүн гэртээ байна уу, эрх мэдэл дээрээ ч байна уу - эргэн тойрныхоо хүмүүсийн зөвлөгөөг сонсох ёстой. Тэгж байж л тэрбээр Бурханы өгсөн бэлгээр гэр бүл, үйлчлэлээ хамгаалж, үйлчилнэ.

Елиагийн амия авран зугтсан түүхийг цааш нь уншбал, Елиагийн ажил замхарч эхэлжээ. Ахаб ард түмнээ ёрын муугаар дарангуйлдаараа дарангуйлсаар байсан. Эр нөхөр, улсын дээр тогтоо Иезебелийн эрх нөлөө улам өссөн. Елиа Баалын эш

үзүүлэгч нартай мөргөлдөж, даяар түмний нүдэн дээр Бурханы хүчийг гэрчлэн харуулсан ч, Баалын мөргөл дахин сэргэсэн. Елиа Иезебелээс зугтахдаа, Израилийн ард түмний урмыг хуу хамаад зугтжээ. Ахаб уксэн ч, хоёр хүү нь үргэлжлүүлэн захирахдаа, ард олныг шүтээн мөргөлийнхөө лагд улам шигдүүлэв (1Хаад 22:51-2Хаад).

Эрх мэдлээ алдахгүй хоёр эр

Елиа энэ бүх завхрал, ялзралын эх ундаргаас зугтсан. Иймээс Эзэн тэр ёрын эмэгтэйтэй мөргөлдөж чадах хоёр эрийг тослон гаргаж ирэхийг Елиад зааварлав. Иезебелийг эцэстээ Иеху алсан юм (2Хаад 9:30-37). Эмэгтэй Иехуг хянан захиргаадах гэж үзэхэд, Иеху айлган сүрдүүлэгт нь автаагүй. Тийнхүү халз тулж, алсны дараа Иезебелийн нөлөө нурсан (2Хаад 10).

Дараа нь Иеху эрчүүдтэйгээ Ахабын далан хөвгүүнийг алсан. Тэрбээр Баалын мөргөлчдийг цуглуулаад, илдээр хөнөөсөн. Иеху Баалын сүмд очоод, ариун дагшин газрыг нь галдсан. Эрчүүд нь Баалын баганыг нураагаад, сүмийг нь үнсэн товрог болгосон. Иехугийн талаар Библи:

“Иеху ингэж Израилиас Баалыг устгав” (2Хаад 10:28)
гэдэг.

Бурхан Елиад “Иехугийн илднээс зугтсан хүн Елишагийн гаргт орж үхэх болно” (1Хаад 19:17) гэсэн. Анх Елиагийн хийх ёстой байсан ажлыг эдүгээ хоёр хүн гүйцэлдүүлжээ. Елиа өөрөө айж сүрдсэндээ эрх мэдлийнхээ байр сууриас бууж өгсөн учраас л Бурхан Елиад Елишаг “өөрийнхөө оронд эш үзүүлэгчээр” тосол хэмээсэн. Иеху, Елиша хоёр Бурханы өгсөн эрх мэдлийг Ахабын гэрийнхэнд алдаагүй учраас, Бурханы бэлэг ажилласаар, ард түмнийг Баалын мөргөлөөс чөлөөлжээ.

Бид айж сүрдэхдээ, эрх мэдлийн байр сууриасаа буудаг. Үүний гороор үйлчилж, хамгаалах ёстой Бурханы бэлэг унтарна. Ийнхүү бид өөрөө ч мэдэлгүй айлган сүрдүүлэгчийнхээ ажил үйлсийг бүтээгээд өгдөг.

Хуучин гэрээн дээр Бурханы хүмүүс давшихын оронд ухарсан жишээ олон бий. Паулын хэлдгээр “Энэ бүхэн жишээ

болон тэдэнд тохиолдсон бөгөөд үүнийг үеийн төгсгөл тохиож буй бидэнд сануулга болгон бичжээ” (1Коринт 10:11). Мөн Ром дээр ч хэлсэн бий: “Эрт үед бичигдсэн аливаа зүйлс нь биднийг сургахын тулд бичигдсэн юм” (Ром 15:4). Би номдоо Хуучин гэрээнээс олон жишээ хэлнэ. Учир нь Хуучин гэрээний жишээгүйгээр Шинэ гэрээний хэрэгжүүлэлтийг бүрэн ойлгох боломжгүй. Дараагийн бүлгээрээ айлан сүрдүүлэг нь хэрхэн удирдагчийн доторх төдийгүй, түүний удирдаж буй хүмүүсийн доторх Бурханы ажилд саад хийдгийг үзнэ.

*Айсан хүн Бурханд бус,
айсан зүйлдээ мөргөдөг.*

Зурагадугаар бүлэг

АЙЛГАН СҮРДҮҮЛЭГТ ХОВСДУУЛАХ

Aйлан сүрдүүлэг нь биднийг сүнсний талбарт ховсдож, зөв хэмээн мэдээд байгаа зүйлээ хийлгүй, буулт хийж, өөр нөхцөлд хэзээ ч зөвшөөрөхгүй байсан зүйлээ зөвшөөрөх юмуу хүлцэхэд хүргэдэг.

Үүний нэгэн жишээ нь Хуучин гэрээний Ели ба түүний хөвгүүдийн түүх болно. Хаант засаглал тогтохоос өмнө Израилийг түүхэн эгзэгтэй үед нь Бурханы тодруулан, тохоон томилсон шүүгч нар захирдаг байв. Дэйкийн Библийн дагуу, Ели гуай Израилийн арван тав дахь шүүгч байжээ. Шүүгч төдийгүй тэрбээр мөн долоо дахь тэргүүн тахилч байж. Ели Израилийг дөчин жил шүүжээ. Түүний хоёр хүү Хофни, Финехас нар ч тахилч нар байв. Тэгэхээр, Елигийн удирдлага дорх сүнсний уур амьсгал ямархуу байсныг үзэцгээе:

Балчир хөвгүүн Самуел, Елигийн дор ЭЗЭНд үйлчилж байв. Тэр өдрүүдэд ЭЗЭНий үг ховор, үзэгдлүүд ч цөөн байв (1Самуел 3:1).

Израильчууд Торатай байсан учраас, энд өгүүлсэн Эзэний үг гэдэг нь Бичээсийг хэлээгүй, харин Бурханы арга зам, төлөвлөгөөг заасан, Бурханаас эхтэй ухаарал, гэгээрлийг хэлжээ. Бурхан хүмүүстээ ил чөлөөтэй өгүүлдэг байсан цаг мартагдсан дууль болжээ. Номын зохиолч нам гүм байв. Түүний дуу хоолой ч сонсогдох нь ховор.

Тэгэхээр, Бурхан яагаад ингэх болов? Үүний хариултыг нь

2-аар бүлгээс олж болно:

Ели өндөр настай болжээ. Өөрийнх нь хөвгүүд бүх Израильд юу үйлдэж байгааг, тэд бас чуулганы асрын үүдэнд үйлчилдэг эмстэй унтаж хэвтдэг тухай Ели сонсдог байв (1Самуел 2:22).

Елигийн хөвгүүд болох Хофни, Финехас нар муу ёрын хүмүүс байв. Тэд Израилийн эмэгтэйчүүдтэй садарлаад зогсохгүй, Бурханы оршихий тогтдог майхан сүмд мөргөл үйлдэхээр ирсэн эмэгтэйчүүдтэй ч садарлахаасаа эмээж ичдэггүй байж. Бурханаас эмээх нь яагаав?

Тэдний завхрал хормойн явдлаар хязгаарлагдаагүй. Тэд мөн хүмүүсийн тахил өргөхөөр авчирсан түүхий маҳыг нь булааж авдаг байсан. Энэ нь хуультай харшилдаж байсан бөгөөд Эзэний ч, мөргөлчдийн ч өмчийг дээрэмдсэн хэрэг байв. Үүнээс болж Израилийн ард түмэн тахилыг жигшихэд хүрчээ. Хофни, Финехас хоёр Израилийн хүмүүст бүдрүүлэх чулуу болсон байна. Тэдний үйлдлээс болж хүмүүс Бурханы юмсыг жигшив.

Ели хөвгүүдийнхээ авир үйлдлийг мэдэж байсан ч, тэднийг байр сууриас нь зайлцуулалгүй: “Би энэ ард олноос ёрын муу хэргийг чинь сонслоо. Та нар ийм хэрэг юунд үйлдэнэ вэ? Ингэж болохгүй, хүүхдүүд минь. ЭЗЭНий хүмүүсийн дунд яригдаж буй, надад сонсогдсон энэ сураг сайн юм огт биш” (1Самуел 2:23-24) гэх маягаар хөнгөн зэмлээд өнгөрнө. Гэтэл хөвгүүдэд нь хатуу гар хэрэгтэй болоод байсан. Тэд ямар ч гэмших зүрхгүй байсан тул тэднийг майхан сүмийн тахилчийн үүрэгт ажлаас нь бүр мөсөн чөлөөлөх ёстой байж.

Бурханы эш үзүүлэгч Ели дээр ирээд: “Миний орших газарт Миний тушааснаар Надад өргөсөн өргөл, тахилууд дээр та нар яагаад дэвсэлж бас Миний ард түмэн Израилийн тахил бүрийн дээжээр нь өөрсдийгөө таргалуулан хөвгүүдээ Надаас илүү дээдэлж байна вэ?”...Намайг хүндэтгэгчдийг Би хүндэтгэнэ. Харин Намайг үл тоомсорлогсдыг Би үл хайхарна (1Самуел 2:29-30) гэж хэлжээ.

Хүндэтгэх гэдэг нь “дээдлэх, үнэлэх, хүндэтгэх” гэсэн утгатай. Ели хөвгүүдтэйгээ халз тулж, сахилгажуулахаас татгалзахдаа, тэднийг Бурханаас дээгүүр тооцдогоо харуулжээ. Айж сүрдсэн хүн айдаг зүйлээ Бурханаас илүү хүндэтгэдэг.

Тэрбээр үүнийгээ ухаарсан ч бай, ухаараагүй ч бай, аиж сүрдсэн зүйлдээ захирагддаг. Ели аиж сүрдээгүй байсан бол, хөвгүүдийнхээ явдлыг өөрөөр шийдвэрлэх байсан.

Хожим Елигийн талаар Бурхан Самуелд “Түүний хөвгүүд өөрсдөдөө хараал авчирсан бөгөөд тэр тэднийг хазаарлаагүй тул түүний мэдсэн хилэнцийн учир өөрийнх нь гэрийг мөнхөд шийтгэхээр зэхж байгаа хэмээн Би түүнд хэлсэн билээ” (1Самуел 3:13) гэсэн байдаг.

Израилийн шүүгч болоод тэргүүн тахилч нь хөвгүүдээсээ айсан учраас, Эзний уг ховор, ёрын муу хазааргүй ноёрхож байв! Ели эрх мэдлийн байр сууриа алдаж, Израилийг зөв шударгаар шүүх, үйлчлэх чадвар нь угүй болжээ. Бурханы зорилго нурсан. Израиль дотроосоо ялзарч байхад, эргэн тойрных нь дайснууд хүчирхэгжиж байв. Удирдагч нар эрх мэдлээсээ татгалзсан учраас, халамжин дорх хүмүүс нь зовжээ.

Танил дүр зураг байна уу?

Харамсалтай хэдий ч, олон аав үр хүүхдээсээ аиж сүрддэг. Би залуусын пастор байхдаа, Христэд итгэдэг гэр бүлүүдийн аврал эрсэн, цөхрөлийн дууг их сонсдог байв. Аав, ээжийгээ үл тоодог өсвөр насынхан олон. Тэд аав, ээждээ ямар ч хүндэтгэлгүй хандана. Аав, ээжээ бүр нэг тээр шаасан янзтай. Би ч ангайж гайхсандaa, хүүхдээ засдаггүй тэр аав, ээжийн нүдэн дээр нь, өмнөөс нь хүүхдийг нь засч өгнө. Гэр бүлд нь ямар ч эрэмбэ дараалал байхгүй, анахи ноёрхоно. Аав, ээж нь үр хүүхдээ засах эрх мэдлээсээ татгалзжээ. Гэр бүлдээ эрэмбэ журам тогтоож, бурханлаг хүүхдүүд өсгөхийн төлөө аав, ээжид нь өгөгдсөн Бурханы бэлэг буюу хүч унтарчээ.

Энэ асуудал гэр бүлээр хязгаарлагдахгүй, чуулганд ч ил задгай. Би зуу зуун чуулганд очиж үзэхдээ, хичинээн олон удирдагч хүмүүсээсээ айдгийг үзээд, цочирдож билээ. Тэдгээр чуулганы уур амьсгал нь яг л Елигийн захиргаан дорх Израилийнхтай адил: Бурханы дуу хоолой ховор.

Эдгээр удирдагч нар эрх мэдлийн байр сууриа алдсан учраас, Бурханы хүч ховорджээ. Пасторууд нь цуглаан болгон дээр номлож, магтан хүндэтгэж байгаа ч, Бурханы оршихуй байгаа үгүй нь мэдэгдэхгүй.

Пастор нь нэг бол дуулгаваргүй хүмүүсийг гомдоохгүй, асуудалтай нүүрэлдэхгүй, зөөлөн номлол бэлтгэнэ эсвэл хэсэг хүнээс айж сүрдсэн байдлаа нуухын тулд хэдэн хонио чанга дуу, хатуу үгсээр жанчина. Тийм боловч аль ч давхарга дээр сүнсний амь үгүй.

Библи Бурханы оршихуйг ховор гэсэн. Амь амьдрал үе үе жаал жаалхан пургих боловч, Бурханы оршихуй тогтохгүй, Үг нь ч амьд усны оргилуур шиг чөлөөтэй садрахгүй.

Амьд үхдэлийн чуулган

1990 онд би нэгэн чуулганд үйлчилдэг байлаа. Хүмүүс нь өөрсдийгөө амьд бөгөөд Бурхантай хамт нүүж байна л гэж үзнэ. Нэгэн Бүтэн сайн өдөр номлотол, уг минь буцаж нүүрийг маань цохиод байх шиг санагдав. Тоосгон хананд хандаж номлоод байх шиг л. Агаарт төө зузаан эсэргүүцэл тогтоно.

Би учрыг нь олохгүй байв. Пастор нь гэргийтэйгээ миний уулзаж учирч явсан хамгийн эелдэг, зөөлөн хүмүүсийн нэг. Хүүгийнх нь магтаал хүндэтгэлээ удирдаж байгаа нь ч хайр хүрмээр. Тэгээд цуглааны дараа тэдэнтэй өдрийн хоолонд орох хүртлээ баахан гайхширч билээ.

Пастор нь: “Жон, чамаас асуух юм байна. Манай чуулганд салсан хос байдаг юм. Тэд одоо ч цуглаандаа явсаар, ирээд танхимиын хоёр талд суусаар байгаа. Тэгтэл манай угтагчийн багийг удирддаг эрэгтэй нь цуглааны маань нэгэн zaluu бүсгүйтэй танилцаж, болзож эхэлсэн юм. Тэгээд хэсэг хугацааны дараа нэг гэрт ороод, одоо хамтран амьдарч байгаа. Би яах ёстой вэ?”

Тэр пасторыг надаас ингэж асуусанд нь би итгэж ядав. Тэгээд гайхаад: “Та түүнийг чуулганаасаа хөөгөөгүй юм уу?” гэж асуулаа.

Пастор: “Үгүй. Гэхдээ би түүнийг угтагчийн багийн удирдагчаасаа буухыг хүссэн” гэж хариулдаг байгаа.

Би тэр пастор, гэргий хоёрт нь цаг гаруй номлов. Би тэдэнд Паул Коринтын чуулганы ахлахуудад юу гэж заасан тухай хэллээ. Коринтын чуулганы нэгэн хүн ёс бус амьдарсан. Паул тэднийг “Та нар ихэрхэж, харин ийм зүйлийг үйлдэгч нь дундаас чинь зайлцуулагдахын төлөө гашуудсангүй” (1Коринт 5:2) хэмээн хатуу зэмлэсэн. Паул тэр этгээдийг чуулганаас хөө гээд, учрыг

нь тайлбарлажээ: “Зуурсан гурилыг жаахан хөрөнгө бүхэлд нь исгэдгийг та нар мэдэхгүй гэж үү?” (1Коринт 5:6) Гурилыг жаахан хөрөнгө бүхлээр нь хөөлгөдөг. Паул чуулган доторх хайхраагүй, тоогоогүй, санаатай нүгэл нь талхны хөрөнгөтэй адил хэмээв.

Тэгээд би тэр пасторт: “Та тоолгүй үлдээсэн нүглийг чуулган даяараа тархааж байна. Үүний үр дагаврыг та л Бурханы өмнө хариуцна! Хоньчин хүн тэжээхээс гадна хамгаалах ёстой. Та хонин сүргээ тэжээх дуртай ч, нүүрэлдэх дургүй учраас, хонин сүргээ хамгаалахаас айж байна. Гэтэл аль, аль нь чухал! Та тэр эртэй хатуу боловч хайраар нүүрэлдэх ёстой. Тэрбээр газар дээрээ гэмшихгүй бол, чуулганаасаа хөө” гэж хэллээ. Бид хонин сүргээ тэжээхгүй бол, хонь өлсөж үхнэ. Бид хонин сүргээ хамгаалахгүй бол, хонь араатны идэш болно.

Пастор, түүний гэргий хоёр зэвхий цагаан болов. Гэргий нь: “Би цаашид үйлчлэх эсэхээ мэдэхээ байлаа. Би хүмүүсийг хайлрахыг л хүсдэг” гэв.

Тэгэхээр нь би түүнд: “Та хүмүүсээ хамгаалахгүй бол, найр тавьсан хайр нь үнэндээ жинхэнэ хайр биш” гэж хэлэв.

Тэр хоёр чуулганыхаа зарим хүмүүсээс айж сүрдсэнээ хүлээн зөвшөөрсөн юм. Тэгээд уушгия нээн, бусад асуудлаа ч дэлгэлээ. Магтаал, хүндэтгэлийн багийнх нь зарим хөгжимчид ямар ч хүндэтгэлгүй авирладаг аж. Тэгэхээр нь би цуглааны үеэр зөрчилдөж байсан уур амьсгалын учрыг сая л олсноо хэлсэн юм.

Орой нь намайг номлож байтал, нэгэн эр хэлээр үг дамжуулж эхлэв. Би түүнд Бурхан Өөрөө Өөрийгөө тасалдуулдагтүйг тайлбарлаад, ярихаа зогсоохыг хүсэв. Мөнөөх эр ойлгоод, яриагаа зогсоотол, нэг гитарчин нь над руу: “Ариун Сүнсний хөдөлгөөнд саад хийдэг хүний номлолыг тэвчихгүй. Би явлаа!” гэж хашхичсаар, харайж гарлаа. Тэрбээр эхнэрээ хөтлөөд, аргил гитарчиндаа явъя гэтэл, нөгөөх нь ч бас эхнэрээ аваад, бүгд шуургалан гарч одов. Агаарт түгшүүр тогтоож, гишүүд ч уймэлдлээ.

Би ч тэр даруй Ариун Сүнснээс зааварчилгаа асуутал, Ариун Сүнс “Тэдэнд эрх мэдлийг зааж өг” гэв. Би ч эрх мэдлийн талаар заатал, Бурханы амар тайван чуулганд бууж, Түүний эрэмбэ журам тогтлоо.

Намайг дууссан хойно Эзэн надад: “Одоо хэлээр ярихыг нь таслан зогсоосон хүндээ ярьсан зүйлээ хөрвүүлэхийг хэл” гэлээ. Би ч яльгүй эргэлзснээ, нөгөө хүнд: “Эрхэм ээ, боломжтой бол,

Бурхан одоо таныг нөгөө үгээ хэлээсэй гэж хүсч байна” гэлээ. Мөнөөх эрхэм хэлээр үгээ дамжуулаад, тайлбарыг нь ч хэлэв. Тэрбээр: “Эзэн айлдруун: Энэ чуулганд нүглийн халдвартайхыг Би үзэв. Би зарцдаа нэгээхэн хэсгийг нь л харууллаа. Миний үгд анхаар. Учир нь энэ Миний үг болой.”

Би ч тэр чуулганд газар авсан нүглийг бодоод уйлж эхэллээ. Пастор ч барьц алдан, самгарджээ. Удирдагч нар нь Бурханы халамжлаарай хэмээн даалгасан хүмүүсээс нь айж сүрдсэнээс болж, нүгэл идээлжээ.

Хожим пастор нь нөгөө эртэй бас хамтран амьдарч байсан бүсгүйтэй нь нүүрэлдсэн тухай сонсоод, би баярлаж билээ. Тэд хоёулаа гэмшээд, тус тусдаа амьдрах шийдвэр гаргажээ.

Зөвлөлийн гишүүдээсээ сүрдсэн пастор

Нэг удаа нэгэн чуулган дээр Бүтэн сайнаас Гурав дахийн орой хүртэл цуглаан хийсэн юм. Цуглаан маань гэмшил, эдгэрэл, чөлөөлөлт, хүч чадлаар дүүрэн байлаа. Тэр чуулганд санхүүгийн тэсрэлт болж, хүмүүсийн тоо нь ч өсчээ. Гэтэл Хоёр дахь өдрийн орой цуглаан эхлэхээс өмнө пастор нь уйлж гарав.

Би ч явав ийв л гэлээ.

“Жон, би чамд атаархаагүй. Гэхдээ би яагаад Бурханы хөдөлгөөнийг үздэггүй юм бэ? Би Ариун Сүнсээр дүүрсэн хүн. Гэвч миний цуглаан дээр Сүнсний нэг ч бэлэг ажилладаггүй. Хэн ч эдгэрдэггүй, чөлөөлөгдөггүй, бүх зүйл хэцүү байдаг.”

Тиймээс би “байцааж” эхлэв. Гэтэл чуулганых нь зөвлөлд мөнөөх пастораас өмнө Ариун Сүнсийг хүлээж авсан хоёр хос байдаг ажээ. Тэгээд тэр дөрвөн хүн пасторт юу хийхийг нь, чуулганаа яаж хийхийг нь заадаг гэнэ. Тиймээс би тайлбарлалаа: “Та зөвлөлөөсөө айдаг ажээ. Та Бурханы өгсөн эрх мэдэл дээр буцаж зогсоод, тэд биш, та пастор нь гэдгийг хэлэх хэрэгтэй.”

Маргааш нь би тэдэнтэй ярилцав. Тэр дөрөв дургүйцэж, чуулганаасаа явав. Цуглаан товлосон хугацаанаасаа сунаж, сүүлчийн орой хэсэг хүмүүс залбируулахаар урагш гарч иртэл, Эзэн надад: “Энэ хүмүүсийн төлөө чи залбирахгүй, пастор залбирна” хэмээв.

Би пастор руу хартал, түүнийг Бурханы хүч нөмөрсөн байхыг үзлээ. Би “Пастор аа, Бурхан таныг энэ хүмүүсийн төлөө залбир гэлээ” гэв.

Пастор тэр хүмүүсийн дундуур гүйв. Хүмүүст хүрэх төдийд л тэд Бурханы хүч дор унаж байлаа. Зарим нь бүр хүрэхээс нь өмнө ч унав. Тэд пасторыг очоогүй байхад л Бурханы ер бусын хүчинд автаж байлаа.

Чөтгөрийн нөлөөнд автсан нэгэн охин сүр жавхлантайгаар чөлөөлөгдөв. Мөнөөх хэсэг хүмүүс Ариун Сүнсний үйлчлэээр бүгд хэдхэн минутын дотор газарт тэрийв! Пастор над руу ганц эргэж харснаа, өөрөө шалан дээр гэдрэгээ ойchoод өгсөн юм. Тиймээс гэргий нь цуглаанаа хаав. Хагас цагийн дараа хоёр хүн хамжиж байж, пастораа шалан дээрээс босгосон юм. Тэр чуулган мөнхөд өөрчлөгджээ.

Пастор өөрөө сүрдсэн учраас, дотор нь буй Бурханы хүч унтарчээ. Үүнээс нь болж Бурханы оршихуй, хүч чуулганд ховордож. Харин пастор тэр айлган сүрдүүлгийн хүчийг тасар татахад, Бурханы бэлэг чөлөөтэй урсаж эхэлсэн байна.

Өөр тавилттай адилхан түүх

Энэ зарчим олон чуулган, хувь хүний амьдралд батлагдахыг би гэрчлэн харсан. Нэг удаа гадаадын нэгэн чуулганд үйлчлэхдээ, пасторууд болоод удирдагч нар нь айлган сүрдүүлэгтэй зөрчилдөж байхыг тодорхой үзэв. Бүтэн долоо хоног би тэднийг сүнс дотор хүчээ хадгалж, Бурханы өндөр дуудлагын төлөө давшихыг урамшуулан ятгав. Намайг явснаас хойш дөрвөн сарын хугацаанд тэр чуулган гурав дахин ессөн гэх! Тэд дөрвөн зуун хүний суудалтай танхимаасаа хоёр мянган хүний суудалтай том цэнгэлдэх рүү нүүжээ. Хожим намайг эргэж очиход, пастор нь айлган сүрдүүлгийг ялснаас хойш чуулган нь тэс өөр болсныг хэлж билээ.

Өөр нэг удаа би Атлангад гурван өдөр үйлчлэхээр уригдав. Сүүлчийн орой айлган сүрдүүлгийг таслах талаар номлотол, хүмүүсээсээ сүрдэх айсаасаа сүр жавхлантай чөлөөлөгдсөн пастор нь: “Та, бушуу буцаж ирээд, бүтэн долоо хоног зааж өгөөч” гэсэн юм.

Тиймээс би гурван долоо хоногийн дараа эргэж ирээд, есөн цуглаан хийв. Бурханы ер бусын оршихуй, хүчинд автсан хүмүүс шөнө дунд өнгөрсөн хойно цуглаанаасаа зөөлгүүлж гарч байлаа. Бурханы оршихуй, хүчинд автаад өндийж ч дийлэхгүй

байгаа хүмүүсийг яах вэ хэмээн ажилчид нь пасторынхаа гэр рүү шөнө дунд залгах тохиолдол ч гарч байв. Тэд Бурханы ийм их хүчийг хэзээ ч үзээгүй ажээ.

Үүний дараа тэр цуглаан есөн сарын турш амралтын өдрүүдээр сэргэлтийн цуглаан хийжээ. Цуглаан нь ямар хүчтэй байсныг, гишүүдийнх нь амьдралд ямар гайхамшиг өрнөж байгааг пастор нь над руу утасдаж хэлнэ. Тэнд хэзээ ч хоёр ижил цуглаан болоогүй гэнэ. Чуулган нь дөрвөн зуугаас долоон зуу болтлоо өсөв! Айлган сүрдүүлгийг тасар татсан миний тэр оройн номлол л түүний амьдрал, үйлчлэлийг эргүүлэх цэг болсныг пастор надад хэд хэдэн ч удаа хэлж билээ.

Өөр нэгэн чуулган. Магтаал хүндэтгэл нь бараг л унтуулах шахаж байв. Пастор нь гараад, зарлал хэлээд, өргөлийн талаар “заав”. Энэ бүхэн нь миний хэзээ ч үзээгүй, уйтай үйл явдал байлаа. Цуглааны дараа хоолон дээр пастор нь хөл бөмбөг гэх мэт дэмий зүйлсийн талаар ярив. Бас л хамгийн уйтгартай өдрийн хоол!

Маргааш орой нь Бурхан надаар айлган сүрдүүлгийг тасар татах талаар заалгав. Номлол ид дундаа орж байтал, мөнөөх пастор шалан дээр хөсөр унаад, амьдрал, үйлчлэлдээ хүлээн зөвшөөрч байсан сул талаа гэмшсэн юм. Би Бурхан түүний амьдралд ажлаа хийж байгааг мэдэж байсан ч, тийм хүчтэй хийх юм чинээ санасангүй.

Маргааш нь пастор над руу ярив: “Жон, гэргий маань ганц л цаг унтсан, харин би орондоо ч орж чадсангүй! Бид хоёр шөнөжин гэмшиж, уйлж, инээлзэ. Тэгээд дусахаараа дахиад л эхэнэ. Гэмшээд, уйлаад, инээгээд л.”

Тэр өдөр пастор зөвлөлтэйгээ уулзаад, тэдний өмнө Бурханы дуудсан удирдагч байж чадаагүйдээ уччлал эрэн, гэмшжээ. Эцэст нь зөвлөлийн хэд хэдэн гишүүн нь цаашид түүнийг хянаж чадахгүй болсноо мэдээд, чуулганаасаа явсан бол, бусад нь пастортайгаа нийлэн, өсөлтийг нь дэмжжээ.

Чуулган нь ч, пастор нь ч мөнхөд өөрчлөгджээ. Дөрвөн жилийн дараа - эдүгээ тэдний магтаал хүндэтгэл амьд болжээ. Тэд өнгөрсөн хоёр жилийн турш амралтын өдрүүдээр сэргэлтийн цуглаан хийж байгаа аж. Пастор надтай ярихаараа, Бурханы үйлсийг, түүгээр дамжуулан ярьж байгаа үгсийг, чуулганд нь өрнөж байгаа үйл явдлыг л ярина. Би ч тэр чуулганд хэд хэдэн удаа эргэж очсон бөгөөд очих болгонд улам л сайжирсаар

байдаг юм. Тэр пастор ч бас айлган сүрдүүлгийг тасар татах тухай заасан миний энэ номлол түүний амьдрал, үйлчлэлийн эргэх цэг болсныг ахин дахин хэлдэг.

Энэ чөлөөлт дан ганц пастор, удирдагч нарын дотор бус, итгэдэг бүх хүний дотор өрнөдөг. Айлган сүрдүүлгийн хүлээсийг тасар татахад амьдралынх нь тал бүр хэрхэн чөлөөлөгдсөн талаар хувь хүмүүс ч бидэнд олонтаа гэрчилдэг.

Нэгэн эмэгтэй айлган сүрдүүлгийг тасар татах талаар миний заасан цуглаанд суужээ. Цуглааны дараа амьдралаас нь айdas, айлган сүрдүүлгийн атга тавигдахыг мэдэрсэн байна. Гэтэл хэд хоногийн дараа нэгэн шөнө тэрбээр охинтойгоо гудмаар явж байгаад дээрэмчдэд олзлуулжээ. Гурван залуу нөгөө хөёрыг бушуухан бүслэн буу тулгаад, түрийвчийг нь булаасан байна.

Гэтэл эмэгтэйн дотор маш том зориг төрж, тэрбээр байдаг чангараа хэлээр залбирчээ. Буу тулгасан залуу: “Дуугүй бол!” гэж хаширсан ч, эмэгтэй больсонгүй. Гурван залуу үймэн самуурах хооронд охин нь бушуухан гэртээ гүйж ороод, 911-ийг дууджээ. Тэгтэл нөгөө залуу түрийвчийг нь аваад зугтсан байна.

Маргааш өглөө нь Христэд итгэдэг нэгэн залуу ээжийндээ очихдоо, явдаг замаасаа арай өөр замаар явж байж гэнэ. Гэтэл модон дундаас нөгөө эмэгтэйн түрийвчийг олоод, утасдсан байна. Тэгээд хоёул баярлалдав. Маш бага хэмжээний мөнгө л алдагдаж, үнэмлэх, бичиг баримт нь хэвэндээ байж байжээ.

Тэр эмэгтэй “энэ үг л түүнийг зориг оруулж, амийг нь аварсан” гэдэгт итгэлтэй байгаагаа манай Лизад хэлсэн юм. Өмнө нь тэрбээр маш амархан аиж сүрддэг байсан болохоор, ийм нөхцөлд хэзээ ч ингэж зоригтой халз тулж чадахгүй байж. Тэрбээр чөлөөлөгдсөндөө хөл хүрэхгүй хөөрч байв!

Энэ бүх гэрчлэлийн төлөө Бурхан л алдаршиг. Миний бие ч мөн айлган сүрдүүлгийн боол байсан боловч, Түүний нигүүлслээр чөлөөлөгдсөн! Олзны хүмүүсийг чөлөөлөх цэц ухаан, хүч Бурханаас л ирнэ.

Бид айdas, сүрдүүлэг гэж юу болохыг тодорхойлж, эдгээр нь Бурханы хүч, бэлэгт саад учруулах юмуу дийлэнх тохиолдолд таслан зогсоодгийг үзлээ. Гэхдээ бүгдээрээ зүгээр нэг онол үзээд өнгөрөхгүй, харин айлган сүрдүүлгийн үхлийн атгыг эвдэж сурцгаана.

Сүнсний тэмцэлд сүнсний туслацаа хэрэгтэй.

Долдугаар бүлэг

АЙЛГАН СҮРДҮҮЛГИЙН СҮНС

Айлан сүрдүүлгийг таньж, шийдвэрлэхийн тулд бид хоёр зүйл дээр тогтох ёстай. Нэгдүгээрт - айдас, зүрхгүй байдал нь сүнс гэдгийг мэд. Хоёрдугаарт - энэ нь Бурханаас биш гэдгийг мэд.

Учир нь Бурхан бидэнд айдсын бус, харин хүч, хайр ба биеэ захирах *сүнсийг* өгсөн (2Тимот 1:7, тодруулгыг нэмэв).

Сүнсийг Грекээр *φνευμα* гэх бөгөөд энэ үгээр Ариун Сүнсийг, хүний сүнсийг, чөтгөрийн сүнсийг аль алийг нь нэрлэдгийг Стронгийн конкорданс хэлдэг. Айлан сүрдүүлэг нь хандлага юмуу зан чанар биш, харин *сүнс* юм.

Айлан сүрдүүлэг нь сүнс учраас, үүнтэй оюуны юмуу хүслийн төвшинд тэмцэлдэх боломжгүй. Эерэг бодол сэтгэлгээтэй байлаа гээд айлан сүрдүүлгийг ялахгүй. Сүнсний эсэргүүцэлд сүнсний туслалцаа шаардлагатай. Үүнийг сүнсний талбарт шийдвэрлэх ёстай.

Бодоод үз дээ: Заримдаа ухааны бядтай, биеийн бяртай хүмүүс өөрөөс нь оюунаар ч, тамир тэнхээгээр ч дорой хүмүүсээс аиж сүрддэг. Яагаад тэр вэ? Бүх зүйл сайн сайхан байхад л тэд нөхцөл байдал нь дордох бий, өөрчлөгдөх бий хэмээн байнга айдаг. Тэд магадгүй хэзээ ч болохгүй зүйлээс өөрийгөө хамгаалахад хамаг цаг, эрч хүчээ зориулна. Тэд ирээдүйгээс айсандаа, одоо байгаа сайн сайхнаа хэзээ ч эдэлдэггүй. Ямар ч утгагүй хэдий ч, та

АЙЛГАН СҮРДҮҮЛГИЙГ ЯЛАХУЙ

тэдэнд яаж ч учирлан тайлбарласан бай - тэд айсаар л байна. Тэд зүрхгүй байдал, айдсын сүнстэй ажээ. Тэд бодитой сул талтай бус, харин сүнсний сул талтай тэмцэлдэх аж.

Тэгвэл хэзээд санаасандаа хүрдэг эрчүүд, эмэгтэйчүүдийг аваад үз. Тэдэнд байр суурь, боловсрол байх үгүй нь хамаагүй. Тэд эрх мэдлийн байр суурьгүй боловч, эргэн тойрных нь хүмүүс тэдэнд байраа тавьж өгөөд, захирагддаг. Яагаад тэр вэ? Тун энгийн. Тэд бусдыг айлган сүрдүүлгийн сүнсээр захирдаг. Тэд айлган сүрдүүлгийг өөртөө ашигтайгаар эргүүлэхийг мэнэ.

Би нэг удаа маш амжилттай бизнестэй нэгэн хүнтэй өглөөний хоол идэж билээ. Тэрбээр аврагдахаасаа өмнө бизнесийн өртөнцөд хэрхэн ажиллаж, амьдардаг байсан тухайгаа ярив. Тэгээд: “Би хүмүүсийг айлган сүрдүүлэх маягаар бизнестээ хэрэгтэй бүхнээ авч чаддаг байлаа. Би хотын захиргаагаар алхаж явахдаа, айлган сүрдүүлгийн хүч над дээр байгааг бодитоор мэдэрдэг байсан шүү. Хүмүүс надаас аиж байгаад би дуртай байсан. Би хотын зөвлөлөөс хүссэнээ авдаг байсан” хэмээн ярьж билээ. Тэрбээр айлган сүрдүүлгийн сүнстэй байжээ. Түүнийг өөрөөс нь хамаагүй эрх мэдлэлтэй хотын удирдагч нар сөрж зүрхэлдэггүй байж.

Хянан захиргаадагч сүнс

Елиа Баалд мөргөж байгаа Израильчуудаас айгаагүй. Бүхэл бүтэн үндэстний эсрэг ганцаар зогсдог, аймшиггүй зоригт хүн байна! Елиа 850 хуурамч эш үзүүлэгчээс ч айгаагүй. Мянга шахам шашны удирдагчийг сөрөн зогсоно гэдэг ер бусын зориг! Елиа Израилийн хааны уур хилэнгээс ч айгаагүй. Ихэнх хүмүүс ингэж чадахгүй. Тийм атал Елиа ганц эмэгтэйгээс сүрдээд, амиа авран зугтаж, үхэхээс өөр хүсэлгүй болдог! Ойлгоход бэрх.

Сэтгэл зүйч нар Елиаг эмэгтэй хүнээс айdag байж хэмээн тайлбарлаж болох ч, энэ найдваргүй баталгаа болно. Яагаад гэвэл Израиль улс чинь дан ганц эрчүүдээс бүрдээгүй шүү дээ! Үгүй юм аа. Үнэндээ энэ нь үндэстэн, хаан, хуурамч эш үзүүлэгч нар ч хажууд нь жулдах, сүнсний асар том зөрчил байжээ. Елиа хаанд ч, эш үзүүлэгч нарт ч байгаагүй, Иезебелийн доторх айлган сүрдүүлгийн хянан захиргаадагч аварга сүнстэй мөргөлджээ.

Энэ сүнсний мөн чанарын талаар Бичээс юу хэмээснийг харцаа. Иеху, Иорамын хүү хоёрын яриаг үзнэ уу:

Иорам, Иехүг хараад —Иехү, амар тайван уу? гэж асуусанд Иехү —Чиний эх Иезебелийн завхайрал болон *ид шид* олширсоор байхад юун амар тайван байх билээ? гэв (2Хаад 9:22, тодруулгыг нэмэв)

Ид шид гэдэг үгд бүү бүдрээрэй. Ид шид гэхээр шүүрэн дээр дүүлж, шидэт шингэн хэрэглэж, шившлэгэ хэлдэг, хамар дээрээ том үүтэй эмгэнийг бүү төсөөлөөрэй. Хянан захиргаадахыг хүссэн хүн илбэ шидийг хэрэглэдэг. Тийм ээ, чөтгөрийн сүнсийг идэвхижүүлдэг илбэ шид, хяналтын хэлбэр бий. Тийм боловч илбэ шид нь үүгээр хязгаарлагдахгүй. Паул Галатын чуулганыг “Мунхаг галатчууд аа, хэн та нарыг ховсдов? Есүс Христ нүдэн дээр чинь нийтийн өмнө загалмайд цовдлогдсон бус уу?” (Галат 3:1) хэмээн зэмлэсэн байдаг. Энэ илбэ шид нь шидэт ус, шившлэгээс болоогүй. Паул Галатчуудыг Бурханы тодоос тод илчилж өгсөн зүйлийг эс дагахад хүргэсэн хуурамч багш нарын тухай хэлжээ. Тэр багш нар нууц шүтлэгийн эзэд нь байгаагүй ч, хянан захиргааддаг сүнстэй байжээ. Тэгээд энэ нь чуулган даяар нөлөөлсөн байна.

Иезебел яг ийм хянан захиргаадаж, айлган сүрдүүлдэг, хүчтэй сүнсээрээ Израилийн хааныг, ард түмнийг, эш үзүүлэгч нарыг гэдрэг ухрахад хүргэжээ. Елиа хүртэл үүнд нь өвдөг нугарч, амиа авран зугтсан. Айдсыг зүрхэндээ нэвтрүүлбэл, та амар тайван, итгэлтэй байдал, тэвчээр, эр зориг, шийдэл, аюулгүй байдал зэргээ алдана. Энэ жагсаалт үүгээр ч дуусахгүй.

Хүмүүс айдсын тамлалыг зэрэг сэтгэлгээгээр дарах гэж оролдохыг би үзсэн. Тийм боловч тэд айдсын эх үүсвэртэй нь бус, үр нөлөөтэй нь ноцолдоод байгаа учраас, хэзээ ч зугтахгүй. Та модны жимсийг түүбэл, хэсэгтээ жимсгүй байв ч, тодорхой хугацааны дараа дахиад л ургаад ирнэ. Үндэс нь байгаа цагт мод үр жимсээ ургуулсаар байна. Тиймээс та айлган сүрдүүлгийн хүчийг эвдэхийн тулд үүний цаана орших сүнсний хүчтэй нь хөөцөлдөх хэрэгтэй.

Чуулган доторх хянан захиргаадаж, айлган сүрдүүлдэг сүнс

Бурханы өмнө зөв зүрх тээдэггүй хүмүүс чуулганд олон бий. Тэд хүссэнээ авахын тулд удирдлагаа айлган сүрдүүлдэг. Юмс тэднийхээр өрнөж байгаа цагт тэд жигтэйхэн дуулгавартай харагдана. Сул удирдлагатай газар ийм хүмүүс чуулганы үйл ажиллагааг өрнүүлдэг.

Би маш олон чуулганаар зочилж явахдаа, айлган сүрдүүлэгтэй тулгарав ч, юутай тэмцэлдээд байгаагаа, хаанаас эхтэй болохыг нь мэдэхгүй байх үе олон байдаг байв. Шалтгаан нь: Айлган сүрдүүлэг нь өөрт нь бууж өгсөн ямар ч хүнийг - тэр байтугай итгэгч хүнийг ч эрхшээж чаддаг сүнс юм. Библи итгэгч хүмүүсийг диаволд орон зайд өгөхгүй байхыг анхааруулдаг (Ефес 4:27).

Хэд хэдэн жишээ хэлье. Ингэснээрээ би “хэт сүнслэг” юмуу “чөтгөрийн өвчтэй” гэж дуудуулах эрсдэлд орохоо мэнднэ. Тулгарах асуудал бүрт чөтгөрийг буруутгадаг хүмүүс байдаг л даа. Гэхдээ чөтгөрийг буруутгадаг хүн хийсэн үйлдэлдээ хариуцлагаа хүлээдэггүй. Ийм хандлага нь Есүс дээр бус, диавол дээр төвлөрдөг. Библи бидний хараагаа диавол дээр бус, Есүс дээр байлга гэсэн. Тэр л бидний итгэлийн зохиолч бөгөөд төгсгөгч (Еврей 12:2).

Би үүнийг Есүс дээр төвлөрч амьдрах гэж ойлгодог. Үүнд маань диавол саад учруулах гэвэл, бил түүнийг Бурханы Үгээр бут цохиод, Есүсийг үргэлжлүүлэн дагах ёстой! Халлелүяа! Тийм боловч айлган сүрдүүлгийг үр дүнтэй эвдэхийн тулд нэг зүйлийг мэдээрэй - энэ нь тоохгүй байвал, аяндаа алга болчиходог сүнс биш шүү. Харин ч үүний эсрэг нь үнэн байх.

Довтолгоо

Би айлган сүрдүүлэг сүнс болохыг баталсан олон жишээнээс ганцыг л хэлье. Нэг удаа Өмнөдийн нэгэн чуулганд цуврал цуглаан хийж байлаа. Цуглаанаа Бүтэн сайн өдөр эхлүүлсэн бөгөөд эхний цуглаан маш хүчтэй болов. Хожим бид тэр цуглаан дээр бичсэн CD-гээ сургалтын хөтөлбөртөө хэрэглэж

билээ. Цуглааны дараа айлган сүрдүүлсэн юмуу сөрөг үг хэлсэн хүн байсангүй. Харин ч эргэн тойрны маань хүмүүс тун өөдрөг байв. Гэвч үдээс хойш нь би урам алдаж, эргэлзээтэй зөрчилдөж эхлэх нь тэр. Байдал нэг л биш байгааг мэдсэн ч, юунаас эхтэй болохыг нь мэдсэнгүй. Гэхдээ эрээ цээргүй айлган сүрдүүлэгтэй тулах үед л илрэдэг шинж тэмдэг болохыг танив. Тэр орой Эзэн надад эрх мэдлийн талаар номлох заавар өгсөн бөгөөд олон ч хүн ерөөгдөв.

Цуглааны дараа пастор намайг өрөөндөө дагуулж ороод: “Таны номлол яг байгаа оносон номлол байсныг та мэдэхгүй байх” гэж хэлээд, үдээс хойш түүнийг нэгэн эмэгтэй гишүүн нь дуудаж уулзаад: “Пастор аа, би энэ хүний номлолтой санал нийлэхгүй байна. Тэр хүмүүст хатуурхаж байна. Та түүнтэй адилгүй учраас, өнөө оройноос энэ цуглааныг хаана гэдэгт найдаж байна. Би өнөө орой ирэхгүй. Гэртээ үлдээд, энэ хүний эсрэг залбирна” гэж хэлснийг дуулгав.

Тэр их гутрал хаанаас ирснийг би шууд л ойлголоо. Тэгээд пастораас тэр эмэгтэйг зассан эсэхийг асуутал, өршөөнгүй пастор маань “засаагүй” гэв. Тэрбээр тэр эмэгтэйд Эзний мутарт даатга гэж хэлсэн ажээ. Хэрэв пастор эрх мэдэл дээрээ зогсоод, түүнийг зассан бол, үдээс хойш маань өөрөөр эргэх байж. Бидний нүүр тулаагүй зүйл, хэзээ ч өөрчлөгдөхгүй. Муу ёрыг тоохгүй орхибол, улам л бэхжинэ! Тэр явдал бид хоёрт хоёуланд маань сургамж болсон юм. Эзэн энэ явдлаар дамжуулан надад эрх мэдэл дээрээ зогсож, айлган сүрдүүлгийн сүнсэнд бөхийхгүй байхыг зааж өгөв.

Юу болсныг би мэдээгүй ч, Ариун Сүнс мэдэж байсан болохоор, тэр сүнстэй индрээс халз тулгуулжээ. Гэтэл пастор мэдэж байсан. Энэ явдал пасторын нүдийг нээжээ. Тийнхүү тэр цуглаан тэр жилийн хамгийн хучирхэг цуглаан болов. Би тэр цуглаанд дахиж очсон бөгөөд пастор, бид хоёр ч сайн нөхөд болцгоосон юм.

Айлган сүрдүүлэгч, хянан захиргаадагч сүнстэй тулгарсан өөр нэгэн тохиолдол

Өөр нэгэн удаа намайг гадаадад мянгаад хүмүүсийн тусгай цуглаанд номлохыг хүсэв. Би өдөр нэг, орой нэг - өдөрт хоёр

удаа заах ёстай байлаа. Эхний хоёр цуглаан маш хүчтэй болов. Би ариун байдал, гэмшилийн талаар заасан юм. Гэвч цуглаан тус бүр дээр эсэргүүцлийн уур амьсгал мэдрэгдээд байлаа. Хоёр дахь цуглааны дараа би үдээс хойшжингоо өрөөндөө дарамт, гутралтай тэмцэв. Энэ бол айлган сүрдүүлэгч, хянан захиргаадагч сүнс гэдгийг мэдсэн ч, надад муу үг хэлсэн хүн байгаагүй учраас бас л шалтгааныг нь олохгүй байлаа. Гэвч төдөлгүй өөрийгөө махан биетэй бус, харин муу сүнснүүдтэй тэмцэлдэж байгаагаа мэдэв.

Итгэгч хүмүүс сүнс дотор амьдарч сурах ёстай. Таныг юу эсэргүүцэж байгааг Бурханы Сүнс илчилнэ. Ялгаж сурахгүй бол, бид үр нөлөө дээр нь л анхаараад байна. Би юутай тэмцэлдэж байгаагаа мэдээгүй бол, *Би яагаад сэргэл санааны хямралтай тэмцэлдэнэ вэ? Надад энд ирэх хэрэг байв уу? Би яах гээж эхнэр, хүүхдүүдээ орхиод ирэв? Би дуудлагагаа олохгүй байх шиг байна. Ер нь аялахаа больдог ч юм уу?* гэх зэргээр эргэлзэх байсан биз. Хэрэв би үйлчлэлд таарахгүй гэдэг энэ эргэцүүллээ шулуутгаад байсан бол, айлган сүрдүүлэгч, хянан захиргаадагч сүнсний зорилго бүрэн биелэх байв. Би тэр хүмүүст хандсан Бурханы хүсэл дээр бус, өөр дээрээ л төвлөрөх байлаа.

Тийнхүү үдээс хойшжин тэмцэлдэв. Орой нь намайг цуглаанд аваачихаар ирсэн орчуулагчдаа үдээс хойшжин айлган сүрдүүлэгтэй зөрчилдсөн тухайгаа хэлтэл, орчуулагч маань: “Би ч бас!” гэх нь тэр. Бид хоёр хоёулаа адилхан шинж тэмдэгтэй тэмцэлджээ. Тэр орой би айлган сүрдүүлгийн талаар номлосон бөгөөд олон хүн чөлөөлгдөв.

Маргааш өглөө нь индрийн ард гартал, тосолгоо байсангүй. Бурхан нам гүн байв. Би Эзэнээс үг хүлээн, тайzan дээр хэдэн минут зогслоо. Өөрөө ч залбираад, хүмүүсийг ч залбирахад уриалсан ч, ямар нэгэн зүйл хийх удирдамж, тосолгоо - юу ч ирсэнгүй. Энэ бол тулаан гэдгийг би зүрхэндээ мэдэв. Энэ тулаан тэр чигээрээ намайг чиглэснийг ч ойлгов. Би миний эсрэг хэлэгдсэн үгийг тасар татах ёстойгоо мэдлээ. Бурхан:

Чиний эсрэг бүтээгдсэн нэг ч зэвсэг амжилт олохгүй.
Шүүх дээр чиний эсрэг боссон хэл бүрийг чи яллана.
ЭЗЭНий зарц нарын өв нь энэ бөгөөд Тэдэнд Надаас зөвтгөл ирнэ” гэж ЭЗЭН зарлиг болгов (Исаиа 54:17)
гэдэг.

Би айлган сүрдүүлгийн довтолгоог нураан, намайг эсэргүүцсэн үг бүрийг яллав. Хүмүүсийн бодлоос ч айсангүй. Сүнсний үг хүрдэг зүрхээ сонсох нь л хамгийн зөв байдгийг би мэднэ.

Гэтэл Эзэний үг гал шиг л харван орж ирэв. Хүмүүсээр юу хийлгэх ёстойг Бурхан тодорхой айлдлаа. Хоёр, гуравхан минутын дотор Бурханы хүч газардав. Хүмүүс Ариун Сүнсээр дүүрч, өөрийн мэдэлгүй хөхрөлдөж эхлэв. Бурхан асар хүчтэй нүүж байсан тул надад номлох ч шаардлага байсангүй. Тэр өдөр үдийн арван таван цаг гэхэд хүмүүс танхимдаа байсаар байсныг хожим сонсож билээ. Тэр хүчирхэг тэсрэлтэд зүрх минь баясав. Гэтэл би тэр сүнстэй халз тулаагүй бол, тийм зүйл болохгүй байх байсан.

Гэвч тэр цуглааны цагийн хуваарийг гаргасны дараа нэгэн эмэгтэй үйлчлэгч зохион байгуулагч - удирдагчтай уулзаад: “Яахаараа Жон Бивэр бүх цуглаан дээр номлох ёстой юм? Өөр номлогч нар номлох хэрэгтэй шүү дээ” гэж хэлсэн тухай хожим би орчуулагчаасаа олж мэдсэн юм. Тэр эмэгтэй өөрөө номлохыг хүсч л дээ.

Түүнчлэн тэр эмэгтэйн талаар хачин жигтэй зүйл ч олж сонсов. Тэрбээр “чөлөөлөхдөө” нүдний дусаалга хэрэглэх, арьсан дээр нь дарс түрхэх зэрэг бичээсийн бус зан үйл хийдэг аж. Түүний өөдөөс хэн ч, юу ч хэлдэггүй юмсанж. Үнэндээ удирдагч нь түүнд тус цуглаан дээр үйлчлэх тусгай цаг гаргаж өгчээ. Удирдагч нар энхийг бодолцсондоо, халз тулахын оронд ихэвчлэн буулт хийдэг нь харамсалтай. Гэвч буулт нь хэзээ ч амар хялбар арга зам байдаггүй, ихэвчлэн өндөр өртгөөр ирдэг.

Цуглааны дараа би удирдагчтай уулзаад, тэр эмэгтэйн талаарх үг үнэн эсэхийг асуулаа. Удирдагч үнэн л гэлээ. Тэгэхээр нь Бурханы хүссэн чигийг тодорхойлоод, номлогч нарыг сонгочихоод байхад, тэр эмэгтэй түүний сонголтыг шүүсэнд нь зовниж байгаагаа илэрхийлээд, энэ бүхэн нь эмэгтэй түүнийг хянан захиргаадах санаатай байгаагийн шинж болохыг хэллээ. (Тэр эмэгтэй удирдагч ч биш, тэр удирдагчийн чуулганы гишүүн ч биш байв).

Тэгээд: “Та яагаад энэ цуглаанд тэр эмэгтэйг номлуулах гээд байгаа юм?” гэж асуулаа.

Гэтэл удирдагч: “Жон, би түүнд тэр зан үйлээ боль гэж хэлсэн” гэв.

АЙЛГАН СҮРДҮҮЛГИЙГ ЯЛАХУЙ

Би түүнд: “Та түүний бичээсийн бус зан үйлийг болиулсан ч, тэдгээрийн цаад сүнс нь байсаар л байна. Түүний зүрхний нөхцөл өөрчлөгдөхгүй. Та удирдагч хүнийхээ хувьд энх тайвныг хадгалахыг хүссэн ч, эцэстээ та айлган сүрдүүлэгч, хянан захиргаадагч сүнсийг үйлчлэл, эрх мэдлийн байр сууринд тавьжээ. Энэ чинь айлган сүрдүүлэгч сүнсэнд миний болоод өөрийнх нь дургүй хүргэсэн хэний ч эсрэг босох хууль ёсны эрхийг олгожээ” хэмээн тайлбарлалаа.

Тэгээд юу болсныг ойлгуулах үүднээс амьдралынхаа нэгэн жишээг хуваалцав. Намайг коллежид сурангaa залуусын цуглаанд үйлчилж байх үед нэгэн орой маш хүчтэй магтаал, хүндэтгэлийн цуглаан болсон юм. Олон залуус уйлав. Өрөө Бурханы амар тайван, оршихуйгаар дүүрэн. Бид бүтэн дөчин минут магтан дуулав. Тэр үед хүмүүсийн аяар мэгших дуунаас өөр чимээгүй, нам гүм байлаа.

Гэтэл гэнэт миний урьд нь харж байгаагүй нэгэн залуу үл мэдэх хэлээр ярьж эхлэв. Ингэтэл өрөө хачин жигтэй, таагүй мэдрэмжээр дүүрэв. Тэгж байтал тэр хэлийг нь залуугийн хажууд сууж байсан (бас л хэзээ ч харж байгаагүй) бүсгүй бүр ч хачин маягаар орчуулав.

Би Эзэний оршихуйд магтан хүндэтгээд, хараа хяналтаа алдчихсан байсан болохоор, болж өнгөрсөн явдлыг дуугүй л өнгөрөөв.

Эмэгтэйг үгээ дуусгасан хойно уур амьсгал орвонгоороо эргэсэн байлаа. Эзэний оршихуй хэдийн явжээ. Одоо юм хэлэхэд оройтсныг би ойлгов. Тэд хэдийнээ хийдгээ хийжээ. Тиймээс би хүмүүсийг суухыг хүсээд, долоо хоног тутмын зарлалаа хэлээд, өргөл аваад, номлож эхлэв.

Номлож байхдаа Энд амь байна уу? Би юу хийгээд байна аа? Би яагаад үүнийг хэлчихэв ээ? хэмээн бодож байлаа. Надад номлох тосолгоо байсангүй. Миний эсрэг ямар нэгэн зүйл тэмцээд байх шиг л санагдаж байлаа. Бурханы бэлэг яагаад ажиллахгүй байгааг ойлгохгүй байсан тул би хүмүүсээс залбирахыг хүсэв. Гэтэл Эзэн надад: “Чи тэр эрэгтэй, эмэгтэй хоёртой нүүрэлд” гэв.

Би Хориод минут өнгөрчихөөд байна. Одоо нүүрэлдээд нэмэргүй гэж бодлоо. Тиймээс Эзэний үгийг хойш тавиад Би дахиад жсаахан залбирчихъя гэж л бодов. Бид залбирлаараа сүнсний эсэргүүцэлтэй тулсаар л байлаа.

Хэдэн минутын дараа би бууж өгөөд: “Бурхан минь, юу болоод байна аа?” гэж хэллээ.

Гэтэл сүнсэнд маань мөн л “Чи тэдэнтэй нүүрэлд” гэх нь сонсогдов.

Одоо бүр ч их цаг өнгөрчихсөн. Тиймээс “Боломжгүй. Хүмүүс намайг хачин гэж бодно” гэж бодлоо. Бид дахин арваад минут залбирсан ч, юу ч өөрчлөгдсөнгүй. Тэгээд би урам алдаад, цуглаанаа дуусгав.

Тэр орой надад хүнд байлаа. Би Бурханаас юу болсон талаар ч асуусангүй, зүгээр л унтахаар хэвтлээ. Маргааш нь бүр ч хүнд сүнстэй сэрэв. Тиймээс залбирахаар явлаа.

“Бурхан минь, өчигдөр яах нь тэр вэ?”

-”Бурхан минь, өчигдөр орой юу болсон бэ?”

-”Жон, Би чамайг тэр эрэгтэй, эмэгтэй хоёртой нүүрэлд гэсэн. Би чамайг цуглаан байна уу, өөр зүйл байна уу - аливаа зүйлийг удирдах байр сууринд тавих үед чи тэр цуглааны эмх журам, эрх мэдлийн төлөө хариуцлага хулээнэ. Хариуцлагыг Би чамд даатгасан учраас, Өөрөө хариуцахгүй.

Би Адамыг цэцэрлэгт тавихдаа, түүнд цэцэрлэгийг хамгааларай гэсэн. Диавол устгахаар ирэх үед Би харгис хатуу үр дагавар нь ганц Адамд бус, хүн төрөлхтөнд ирэхийг мэдэж байсан ч, бууж ирээд, гараас нь жимсийг нь цохиж унагаагүй! Би өгснөө буцааж авдаггүй. Би тэр хариуцлагыг Адамд өгсөн. Өчигдөр чамайг нүүрэлдээрэй гэсэн эрэгтэй, эмэгтэй хоёр эсэргүү сүнстэй улс байсан. Чи нүүрэлдээгүй учраас, тэр сүнс цуглаанаар нэг тархсан. Чи эрх мэдлээ өгсөн учраас, Миний Сүнс авагдсан юм.”

Би тэр даруй гэмшиж, дахиж ингэхгүй гэж шийдэв.

Энэ түүхийг гадаад пасторт ярьсны дараа тэрбээр яагаад тэр эсэргүү үйлчлэгчтэй нүүрэлдэх ёстойгоо ойлгосон юм. Бурханы ухаарал зүрхэнд нь гийхэд, түүний нүүр гэрэлтэж байлаа. Тиймээс би: “Та энэ хүмүүсийн хоньчин хүнийхээ хувьд, тэднийг тэжээхээр бараахгүй, хамгаалах үүрэгтэй. Хамгаалах нь нүүрэлдэх явдал” хэмээн дахин зоригжуулав.

Тэгээд: “Хүмүүс танаас юм гүйхад, та үгүй гэж хэлэх ёстойг зүрхэндээ мэдээд байгаа атлаа эв найрамдлаа бодсондоо тийм

гэж хэлэх үе танд байдаг уу?” гэж асуулаа.

Удирдагч: “Тийм ээ, гардаг” л гэж байна. Тэгээд хэсэг чимээгүй болсноо, над руу бодлогиширонгуй харцаар хараад: “Энэ чинь хоёр нүүр, тийм үү?” гэв.

Би ч зөвшөөрөөд: “Таны зөв. Энэ хоёр нүүр буюу буулт чинь айлган сүрдүүлгээс төрдөг юм” гэлээ.

Тэрбээр зүрхгүй сүнстэй байснаа гэмшээд, шууд л айлган сүрдүүлэгч нарын учрыг олохоор хөдлөв. Хожим түүнтэй уулзахад, тэрбээр “Би чөлөөлөгдсөн!” гэх шиг нүүр дүүрэн мишээж байв.

Тэгэхээр, эдгээр халз тулааны таагүй жишээ нь хэдхэн л эрс тэс тохиолдол гэдгийг мэдээрэй. Би ямар ч эсэргүүцэлгүй, үлэмжийн эрх чөлөөтэй зуу зуун цуглаанд номлосон. Эрх чөлөө нь хэвийн зүйл бол, эсэргүүцэл нь гаж зүйл. Таны тусын тулд л би эдгээр жишээг ийнхүү дэлгэрэнгүй ярих боллоо.

Хэдийгээр би дандаа үйлчлэлтэй холбоотой жишээ ярьсан боловч, зарчим нь амьдралын тал бүр дээр хэрэгжинэ. Айлган сүрдүүлэг нь сүнс бөгөөд үүнийг зохих ёсоор нь шийдвэрлэх ёстой. Сүнсний тулааныг махан биеийн зэвсгээр тэмцэх гэж оролд бол, наанадаж цөхөрнө, цаанадаж шархдаж, ялагдана.

Учир нь бид махбодод алхдаг ч, махбодын дагуу дайтдаггүй.

Бидний байлдааны зэвсэг нь махбодынх бус, харин ялагдашгүйг ч ялж чадах Бурханы хүчит зэвсгүүд юм. Бид цэцэрхлийг нурааж,

Бурханы мэдлэгийн эсрэг босогч алив бардамналыг устгаж, бодол бүрийг Христийн дуулгаварт олзолдог (2Коринт 10:3-5).

Айлган сүрдүүлэгч дайсан бидний сэтгэлийг довтолдог. Үүнийг сэтгэл зүйгээр юмуу эерэг бодлоор дийлэхгүй. Айлган сүрдүүлгийн өөдөөс барих ёстой зэвсэг маань Сүнсний илд бөгөөд Бурханы Үг дээр бат зогсох! (Ефес 6:17). Дараагийн бүлгээрээ айлган сүрдүүлэгтэй халз тулах үед таны доторх Бурханы бэлэг сэргээг талаар үзнэ.

III ХЭСЭГ

АЙЛГАН
СҮРДҮҮЛГИЙГ
ЯЛАХУЙ

Хүн намайг яах юм бэ?

Наймдугаар бүлэг

БЭЛГЭЭ БАДРАА

Айлган сүрдүүлэг нь биднийг эрх мэдлээсээ татгалзахад хүргэж, тийнхүү бэлгийг маань унтраах л зорилготой. Тэр цагт бид өөрийнхөө хүч, чадвараар ажиллахдаа тултлаа дорддог. Ийнхүү бид довтолгооноос хамгаалалтын байр сууринд шилжинэ. Тэгээд өөрийнхөө сүл дорийг мэдсэн бид улам л аль болох аюулгүй, тухтай нөхцөл рүү ухарна.

Бэлгээ сэргээ

Тэгэхээр, айлган сүрдүүлэг нь бэлгийг унтуулдаг юм бол, юу сээрээдэг юм бол? Хариулт нь: *эр зориг*. Айлган сүрдүүлэг нь хүнийг ухрахад хүргэдэг бол, эр зориг нь яг эсэргүүцлийг чиглэн дайрахад хүргэдэг. Айж сүрдсэн хүн яаж эр зоригийг олох вэ?

Учир нь Бурхан бидэнд айдсын бус, харин хүч, хайр ба биеэ захирах сүнсийг өгсөн (2Тимот 1:7).

Эр зориг нь хүч, хайр, эрүүл ухаан зэрэг чанараас төрдөг. Эр зориг нь өөрөө чанар биш юм. Зоригтой гэмээр атлаа авир гэж авах юмгүй хүмүүс байдаг. Жинхэнэ эр зориг Бурханаас ирдэг бөгөөд бурханлаг чанараар цэнэглэгдсэн байдаг. Бурханы зан чанараар дүүргэгдсэн эр зориг л бидний амьдралд бэлгийг сээрээдэг.

Зарим хүн зоригтой атлаа зан чанаргүй байдаг. Тэд бага зэргийн эсэргүүцэлтэй эсвэл огт эсэргүүцэлгүй үед маш зөв үг хэлж, зөв үйлдэл хийж чадна. Тийм боловч хүч нь гүехэн, өнгөц

байдаг. Тэд эр зоригтой царайгаараа мэдлэггүй, хайхрамжгүй байдлаа далдлах. Тэдний үндэс нь тачир бөгөөд хүчтэйхэн шуурганаар ил гараад ирнэ. Цаг агаар сайхан үед модны үндэс хэр гүн, гүехнийг мэдэх боломжгүй. Үнэхээр хүчтэй юу, сул уу гэдгийг нь түүвээгч салхи л илчилнэ.

ХЭН НЬ ХҮЧТЭЙ ВЭ?

Дуулал 27:1 дээр Давид “ЭЗЭН миний гэрэл хийгээд Аврал минь болой. Хэнээс би эмээх юм бэ?” гэж хэлсэн. Давид Эзэнийг хүч, чадлынхаа эх ундарга гэжээ. Тэрбээр Бурханаас том нь байхгүйг мэддэг болохоороо “Би хэнээс ч айхгүй!” хэмээн зоригтой тунхагласан.

Тэрбээр итгэл дүүрэн тунхаглаад зогсохгүй, амьдарсан. Давид Бурханыг мэддэг байсан учраас, Бурханы хүчийг ч мэддэг байсан. Энэ эр зориг нь Давидыг хувь тавилангаа биелүүлж, үнэн зөвөөр удирдах чадвартай болгосон. Давидын залуу насыг үзье.

Давид бол Бетлемхем аймгийн Иессегийн наймдугаар хөвгүүн. Түүний гурван том ах нь Саулын цэрэгт алба хаадаг байсан. Гэтэл Филистиний цэргүүд Израилийг дайрчээ. Тэдний цэргийн манлай Голиат өдөр бүр гарч ирээд “Та нар юунд тулалдахаар жагсан гарч ирэв? Би филист хүн, харин та нар Саулын боолууд биш үү? Өөрсдөөсөө нэг хүнийг сонгож, над уруу явуулагтун. Хэрэв тэр хүн надтай тулалдаж дөнгөөд, намайг албал бид та нарын боол больё. Хэрэв би түүнийг ялж, албал та нар харин бидний боол болж бидэнд үйлчлэгтүн”(1Самуел 17:8-9) гэж бархиран, зүрхийг нь үхүүлж байв.

Ер нь бол Израильчууд ийм үгийн хариуд шууд л тулалдана. Гэвч Голиат жирийн цэрэг байсангүй. Зарим тооцооллоор, түүнийг гурван метр давсан өндөртэй байсан гэдэг. Үүнийг төсөөлөхийн тулд сагсан бөмбөгийн цагиргийг нэг хараадхаарай. Голиатын толгой сагсан бөмбөгийн торны цагиргаас ч давах нь байна! Тэрбээр том биетэй төдийгүй, гарамгай дайчин байв. Жадны үзүүр нь л гэхэд дангаараа долоон кг. Голиат хүрэл дуулга өмсөж, 60 орчим кг хуяг өмсөнө!¹ Хуяг дуулга, зэр зэвсэг нь нийлээд 90 гаруй кг болж байсан нь Давид хүүгээс ч хүнд болж таарах байх. Голиат үнэхээр зүрх үхүүлэм сүр

бараатай байжээ. Библи “Саул болон бүх Израиль энэ филист хүний үгийг сонсоод зориг нь мохож, тэд ихэд айв” (1Самуел 17:11) гэсэн.

Гэтэл энэ үеэр аав нь хоньчин Давидыг ах нартаяа ойр зуурын юм аваачиж өгөөд, байр байдлыг нь мэдээд ир гээд явуулжээ. Давид идэж уух юм хумаа тушаачихаад, ах нартайгаар уулзахаар чавхдав. Төдөлгүй аварга Голиат Израильчуудыг дөч дэхь өдрөө зовоохоор гарч иржээ.

Давид Голиатын хэмжээг үзсэндээ бус, харин Израилийн цэргүүдийн байж байгаа царайг хараад нүдэндээ ч итгэсэнгүй. “Израилийн бүх эрчүүд тэр хүнийг хараад, түүнээс ихэд айн зугтав” (1Самуел 17:24). Давид *Манай талд Хэн байгааг тэд мартаа юу?* Энэ этгээд *халз тулаанд биднийг бус, Бурханыг дуудаж байна шүү дээ!* гэж бодоо байх.

Тиймээс Давид “Энэ филист хүнийг алж, Израилиас ичгүүр шившиглэлийг арилгах хүнийг яах вэ? Амьд Бурханы цэргийг шившиглэн ичээгч энэ хозлуулаагүй филист хүн хэн юм бэ?” (1Самуел 17:26) хэмээн зоригтой шаарджээ. Агаарт хурц мөргөлдөөн хуралдав. Давидаар хулчгараа илчлүүлсэн ах нар нь шаралхав. Бяцхан дүүгээрээ ингэж хэлүүлсэндээ, дургүй хүрсэн нь тодорхой. Энэ үг тэдний хэзээ ч нүүрэлдэж байгаагүй сул талыг нь ил гаргажээ. Тэд буулт дээрээ тулгуурлан, дор доороо дуугаа хураасаар байсан аж.

Тиймээс ах нар шившигээ нуухын тулд Давидыг гоочлов. Голиатаас айсан ах нар бяцхан дүүгээ айлган сүрдүүлэхийг оролджээ.

Түүний том ах Елиаб, Давидыг хүмүүстэй ярьж байхыг сонсжээ. Елиаб Давидад ихэд уурлан —Чи ер нь яах гэж наашаа ирэв? Эзгүй талд байгаа тэр хэдэн хонио чи хэнд орхиод ирэв? Би чиний их зан, муу санааг чинь мэднэ. Чи тулалдааныг үзэхээр ирсэн биз дээ? гэж загнав (1Самуел 17:28).

Елиаб зориг оржээ - уураар зориг оржээ. Тэрбээр Израильд тулгарсан асуудлыг биш, Давидын зан чанарыг довтолсон. Айж сүрдсэн хүн дарамтаас зугтах зам хайдаг. Дорой хүн шалтаг хайдаг бол, түрэмгий хүн үнэнийг хэлсэн хүн рүү хариу дайрч, ялладаг.

АЙЛГАН СҮРДҮҮЛГИЙГ ЯЛАХУЙ

Елиаб Давидыг их зантай, муу санаатай гэсэн. Гэтэл Давид тийм байгаагүй. Тэрбээр Бурханы зүрхийг мөшгидөг хүн байсан. Давид Эзэний өмнө бардам бус, даруу байсан.

Түрэмгий зан чанартай хүмүүс худлыг үнэн мэт харагдуулахаар айлган сүрдүүлгийг ашигладаг. Та ийм хэмжээний довтолгоог давж гарахын тулд сүнс дотор байх ёстой.

Елиаб магад атаархсан байх. Елиаб ах нь байсаар байтал, Самуел Давидыг хаанаар томилсон. Магадгүй тэрбээр аугаа удирдагч, дайчин чанартай хүн байсан байх. Самуел ч Елиабыг үзээд, Эзэний тослогдсон нэгэн өмнө маань зогсоож байна! гэж бодсон ч, Эзэн үүгээр Самуелд хичээл зааж өгсөн байдаг: “Түүний гаднах байдлыг болон нурууных нь өндрийг бүү хар. Би түүнийг нь үл хэрэгсэв. Учир нь Бурхан мөхөс нэгэнтэй адил хүний гаднах төрхийг хардаггүй. ЭЗЭН зүрхийг нь хардаг” (1Самуел 16:7).

Тэгэхээр хэнийх нь зүрх бардам байв? Бурхан Елиабыг байр суурь, дүр төрхөөс нь болж сонгох ч үгүй, голох ч үгүй гэдгээ Самуелд илчилжээ. Бурхан зүрхийг л шүүдэг. Бурхан зүрхэндээ бардам хүнд дургүйцдэг (Иаков 4:6). Елиаб бардам зүрхтэй байсан учраас, Бурхан түүнийг голజээ. Тэгэхээр, Давидыг яллаад байсан зан чанар нь Елиабт өөрт нь байж. Тэр бардам байв!

Ер нь бол - айлган сүрдүүлэг нь өөрт байгаа сүл талаа хаацайлахын тулд түүгээрээ таныг буруутгадаг. Гаднаа цэвэр үйлдэлтэй ч, дотроо бохир зүрхтэй хүмүүс ямагт цэвэр зүрхтэй хүмүүсийг довтолно. Цэвэр зүрхтэй Тимот айлган сүрдүүлэгт өртсөнийг санаарай. Ефесийн чуулганд Елиаб шиг л завхарсан зүрхтэй эрэгтэй, эмэгтэй хүмүүс байсан гэдэгт би итгэлтэй байна.

Есүс ч зогсоо зайгүй айлган сүрдүүлэгтэй нүүрэлддэг байсан. Цэвэр бус Фарисайчууд, хуульчид Есүсийг гоочилж, үгээр нь ороохыг оролддог байсан. Есүсийг айлган сүрдүүлж чадах л юм бол, эрхшээлдээ оруулж чадна. Тиймээс тэд Түүнийг урвагч, ховдог, архичин, чөтгөртэй, нүгэлтэн гэх зэргээр өөрсөддөө байдаг чанараар элдэвлэж байсан.

Бохир нь яагаад цэврийг айлган сүрдүүлэхийг оролддог вэ? Өөрсдийгөө ялаас суллаж, хяналтаа тогтоохын тулд. Ингэж чадбал, тэд өөрсдийнхөө зүрхийг шалгаж, гэмшээд байх шаардлагагүй болно. Елиаб гоочилж, айлган сүрдүүлэх дайралтаараа өөрийгөө дарамтаас чөлөөлж, дүү Давидаа эрхшээлдээ оруулна гэдгийг мэдэж байв.

Ийнхүү байдал эргэжээ. Эдүгээ Давид довтолгооны бай болов. Тэрбээр өөрөөс нь хавьгүй том бие хаатай ахынхаа дайралтад өртөв. Ах нар томроогоороо бас л эвгүй шүү. Давид Елиабын хүссэнийг хийхгүй бол, хариад хэцүүднэ. Давид үнэнийг хэлснийхээ төлөө үр дагаврыг нь магадгүй насаараа төлөх байх. Ингэх хэрэгтэй гэж үү?

Давид ганц Елиабаас шахалт үзсэнгүй. Тэнд байсан бүх хүн Елиабын талд оров. Хулчийснаа бяцхан хүүгээр илчлүүлнэ гэж ярихгүй! Давидын хувьд цаашаа зүтгэлгүй, ухарсан нь дээр байв. Айлган сүрдүүлэгч Елиабын хамсаатнууд үүнийг л хүсч байлаа.

Гэтэл Давид Бурханы талд үлдэж, өөрийг нь чиглэсэн айлган сүрдүүлгийг тасар татахаар шийджээ. Давид Елиабаас “Би яласан юм бэ? Зөвхөн асуусан шүү дээ” (1Самуел 17:29) гэж асуусан. Тэрбээр үнэндээ: “Миний үг үнэн бус уу? Та нарын зориг хаачаав? Би айхгүй байна. Та нар сүүлийн дөч хоног айсан. Тэгвэл Бурхан тэр хөвч хөндүүлэгч Филистиинээс аиж сүрдэлгүй, тулалдах хүнийг олох ёстой шүү дээ! Би энд ирсэн ч учиртай байх” гэж хэлжээ.

Дараа нь Давидыг хааны өмнө аваачив. Голиатаас айсан Саул хаан ч Давидад “Чи тэр филист хүн уруу очиж, түүнтэй тулалдаж чадахгүй. Чи ийм залуу бага хүн, харин тэр залуу байхаасаа цэргийн хүн байсан” (1Самуел 17:33) хэмээн учирлажээ. Хэдийгээр энэ үг нь том ахынх нь үг шиг хорон байгаагүй ч, аиж сүрдсэн хаан залуу Давидыг бас л голжээ.

Гэтэл Давид хаантайгаа ахтайгаа ярьснаасаа арай өөрөөр ярьжээ:

Боол нь эцгийнхээ хонийг хариулдаг байсан. Арслан юмуу баавгай ирээд, хонин сүргээс минь хурга авч явахад би араас нь хөөж очоод, түүнийг довтолж, түүний амнаас хургаа авардаг байсан. Хэрэв тэр над уруу дайрвал би сахлаас нь шүүрэн авч түүнийг цохиж алдаг байв. Таны боол би арслан, баавгайн аль алиныг нь алсан билээ. Тэр хозлуулаагүй филист хүн амьд Бурханы цэргийг шившиглэсэн тул тэдний нэгэн адил болох болно гэж хэлэв. Давид цааш нь —Арслан, баавгайн савраас намайг аварсан ЭЗЭН тэр филист хүний гараас ч намайг аварна гэв. Саул, Давидад —Явагтун, ЭЗЭН чамтай хамт байх болтугай (1Самуел 17:34-37) гэж хариулав.

АЙЛГАН СҮРДҮҮЛГИЙГ ЯЛАХУЙ

Давид ах нартайгаа болоод цэргүүдтэй шууд ярьсан бол, хаантайгаа ярихдаа, өндөр эрх мэдэлтэнтэй ярьж байгаагаа ойлгожээ. Давид хаандаа хүү нь авдаа ханддаг шиг хандсан байна. Тэрбээр туршлагаа яриад, Эзэнийг Чөлөөлөгч хэмэн дуудахдаа, хааныг ялгаж салгаж ойлгоно гэдэгт найджээ.

Энэ шийдвэрийн хариуцлага, тооцоо нь хаанд үлдэв. Тулаанд ялагдбал, улсаараа боол болно. Давид байлдах ёстай бол, Бурхан хааны зүрхийг эргүүлнэ гэдгийг мэдэж байв. Бид өөрөөсөө дээгүүр эрх мэдэлтэнтэй хүндэтгэлтэй харилцах ёстай. Давидын үгийн дараа Саул түүнийг тулаанд орохыг нь зөвшөөрчээ. Хаан “Яв даа, Эзэн чамтай хамт байг” гэжээ.

Давид Саулын хуяг дуулгаас ч татгалзсан. Давид өөрийгөө Бамбай бөгөөд Халхавч болсон Эзэнийхээ хамгаалалт дор тавиад, нэг гартаа юм хумаа, нөгөө гартаа дүүгүүрээ бариад, таван мөлгөр чулуу олж авахаар горхи руу явжээ. Филистинчүүдийг ойртоож ирэхэд, Давид амьдралд нь тохиосон хамгийн том айлган сүрдүүлэгтэй мөргөлдөв. Одоо сүрдэх юм бол, Бурханы бэлэг унтраад зогсохгүй, Давид өөрөө амиа алдаж, ард түмэн нь боол болно.

Филист хүн Давидыг хараад, залуухан, улаа бутарсан агаад сайхан төрхийг нь үзэж түүнийг үл тоомсорлов. Филист хүн, Давидад —Чи юунд таяг барьж над уруу ирэв? Би нохой юм уу? гэв. Филист хүн өөрийнхөө бурхдаар Давидыг хараав. Филист хүн, Давидад —Нааш ир, би чиний махыг огторгуйн шувууд, хээрийн араатанд өгье гэж занав (1Самуел 17:42-44).

Голиат Давидыг сүр бараагаараа төдийгүй, үгээрээ сүрдүүлэхийг оролджээ. Давидыг хараасныхаа дараа тэр үлэмж биетэн Давидыг хэрхэг гэж байгаагаа нэгт нэгэнгүй дурсэлжээ. Хүчний харьцаа илт зөрүүтэй боловч, Давид өөрийнхөө хүчийн эх үүсвэр, зэр зэвсэгт нэг ч эргэлзсэнгүй:

Давид филист хүнд —Чи илд, бамбай, жад барьж над уруу ирж байгаа бол харин би чиний доромжилсон Израилийн бүх цэргийн Бурхан, түг түмдийн ЭЗЭНий нэрээр чам уруу ирж байна. Өнөөдөр ЭЗЭН чамайг миний гарг

өгнө. Би чамайг алаад, чиний толгойг биеэс чинь таслан авна. Өнөөдөр би филист цэргүүдийн хүүрийг огторгуйн шувууд, хээрийн араатанд өгнө. Бүх улс, Израильд Бурхан байна гэдгийг үүгээр мэдэх болно. Энэ цугласан олон ч ЭЗЭН илд, жад хэрэглэлгүй аварна гэдгийг мэдэх буй заа. Энэ тулалдаан ЭЗЭНИЙХ бөгөөд ЭЗЭН та нарыг бидний гаргт өгнө гэв (1Самуел 17:45-47).

Давид Бурханы итгэмжтэй байдлыг зоригтой тунхагласан. Израиль эрчүүд Голиатын хэмжээг харсан бол, Давид Бурханыхаа хэмжээг харсан! Давид дайсныхаа өөдөөс ам хэлээрээ төдийгүй, ажил үйлээрээ ч бат гүйхийг Израиль эрчүүд харсаар зогсчээ.

Давид уутандаа гараа шургуулан, нэг чулуу гаргаж аваад, дүүгүүрээр дүүгүүрдэн филист хүний духыг онов. Чулуу дух уруу нь зоогдон ороход тэр нүүрээрээ газар шаан уналаа (1Самуел 17:49).

Давидын эр зориг халдвартлаж, Израилийн найдвар дахин сэргэв. Филистиний цэргийн манлай нь ухэхэд, Израилийн талд Бурхан зогсож байв. Израильчууд Филистин рүү дайран хөөж, ялалт байгуулав.

Давид ганц үйл явдлаар гурвын гурван айлган сүрдүүлэгтэй тулгарчээ. Нэгдүгээрт - ах нар нь цэргүүдтэйгээ нийлэн гоочилж, гүтгэж, урам алдуулах гэж оролдсон. Давид тэдний сүрдүүлэгт автсан бол, зүрхээ Бурханаас эргүүлж, Түүнийг дагахаа болих байв. Тэрбээр зүгээр л хариад, Бурханы бэлэг унтрах байлаа. Тэгсэн бол тэс өөр үр дүн гарах байв: Улэмж биетэн Давидын гаргт үхэлгүй, Израилийг үргэлжлүүлэн дарамталсаар, харин Бурхан ажлаа хийлгэх өөр хүний эрэлд гарах байв.

Хоёрдугаарт - Давидыг хаан нь үл тоож, зоригийг нь мохосон. Давид ухарсан бол, Бурханы бэлэг унтрах байв. Гэтэл Давид хаанаасаа ч айхыг зөвшөөрөөгүй. Тэрбээр төрийнхөө тэргүүнийг хүндэтгэсээр байсан боловч, тулалдах зөвшөөрөл авч чаджээ.

Гуравдугаарт - Давидыг Филистиний үлэмж биет цэрэг айлган сүрдүүлсэн. Тэр цэрэг сүр бараагаараа айлгаад зогсохгүй, дээрээс нь өөртөө аймшигтай итгэлтэй байсан.

Тэрбээр Давидыг нэг их ач холбогдолгүй, өчүүхэн амьтан мэт үзжээ. Давидыг айлган сүрдүүлж чадах юм бол, доторх бэлгийг нь унтраагаад, эцэстээ амийг нь авах байв.

Гэтэл Давид дайсныхаа аминд хүрэх Бурханы хүчинд итгэл төгс байсан. Энэ эр зориг нь Давидын доторх Бурханы бэлгийг сэрээж, тэрбээр Израилийн армийг дөч хоногийн турш айлган сүрдүүлж, дарангуйлсан үлэмж биетнийг ялав!

Шинэ гэрээний хүч

Коринтын чуулганд бичсэн захидалдаа Паул үхлийн үйлчлэлийн алдрыг (Хуучин гэрээ) Сүнсний үйлчлэлийн алдартай (Шинэ гэрээ, 2Коринт 3:7-8) жишсэн. Паул хуучны алдар нь Израилийн хүүхдүүдийг Мосегийн царай руу харж чадахгүй байтал, тийм цог жавхлантай байсан юм бол, амийг өгөгч, шинэ гэрээний үйлчлэл нь бүр ч хүчтэй байх учиртай гэх!

Паул “шинийг” “хүчний давамгайлал нь биднийх биш, харин Бурханых гэдгийг харуулахын тулд бид энэхүү эрдэнэсийг шавар савнуудад тээдэг” (2Коринт 4:7) хэмээн дүрсэлжээ. Паул Бурханаа ч мэддэг, түүнд байгаа хүч нь Өөрийнх нь биш гэдгийг ч мэддэг байж. Паул цааш нь:

“Арилж буй нь алдартай байсан бол мөнх үлдэх нь илүү их алдартай байна. Иймээс бид тийм найдвартай байж, үнэнхүү зоригтой байдаг” (2Коринт 3:11-12) гэсэн.

Энэ хүч нь эр зоригийг боловсруулдаг. Өөрийнхөө хүчинд итгэдэггүй итгэгч хүний дотор аугаа эр зориг оршдог. Тэд нөхцөл байдал, хүн, диаволаас айж сүрддэггүй. Учир нь Бурхан айж сүрддэггүй. Еврей 13:5-6 дээр бидэнд ингэж амлажээ:

Байгаа юмандаа сэтгэл хангалуун байж, амьдрал чинь мөнгийг хайрлахаас чөлөөтэй байг. Учир нь Тэр Өөрөө “Би чамайг хэзээ ч орхихгүй мөн чамайг хаяхгүй” гэж айлдсан. Тиймд бид зоригтойгоор “Эзэн миний туслагч. Би айхгүй. Хэн надад юу хийж чадах вэ?” гэдэг.

Бид Хүн намайг яаж чадах вэ? хэмээн зоригтой тунхаглах хэрэгтэй.

Энэ итгэл дүүрэн байдал итгэгч хүн бүрт боломжтой. Итгэхгүй бол, итгэгч гэж нэрлүүлээд яах вэ? Юунд итгэх гэж? Бурханд итгэх! Жинхэнэ итгэгч хүнийг ямар ч хүн, диавол нь сүрдүүлэхгүй. Яагаад? Есүсээс болоод. Энэ нэрээс өндөр, хүчтэй, аугаа нь угүй. Тэрбээр Өөрөө “Харагтун, мөгөй ба хилэнцэт хорхойнуудад халдах, дайсны хамаг хүчээс дээгүүрх эрх мэдлийг Би та нарт өгсөн. Та нарт юу ч хор учруулахгүй” (Лук 10:19) гэсэн.

Ойлгомжтой бус уу? Тэрбээр хүмүүстээ дайсны хамаг хүчээс дээгүүр хүчийг өгсөн. Айлган сүрдүүлэг нь дайсан юм. Айлган сүрдүүлэг танд “Би чамаас илүү хүчтэй. Чи ухраад, миний хэлснийг хий! Хийхгүй бол, хохь чинь шүү” гэж худлаа ярьдаг.

Бид айлган сүрдүүлгийн энэ худлыг сонсоод байвал, Бурханы бэлэг унтарч, бид байнгын дарамт дор амьдарна. Харин итгэмжтэй Бурханаа мэддэг бол, бид хамаг хүчээс дээгүүрх хүч дотор амарч, айлган сүрдүүлэгч үлэмж биетэнтэй Давидтай хамт эрэлхэгээр мөргөлдөж чадна.

Итгэл чинь хэт ярвигтай учраас, итгэж чадахгүй байна уу?

Энэ бүх үнэнийг ойлгоход хэцүүгүй. Үнэндээ маш энгийн. Жинхэнэ сайн мэдээ ярвигтай байдаггүй. Хүмүүс итгэхгүй учраас л бүтэлгүйтдэг.

Өөрөөсөө асуугаад, шударгаар хариулаарай: Та Бурханы үгд итгэж байна уу эсвэл харж байгаа, туулж байгаадаа итгэж байна уу? Бүх юмыг амьдралынхаа өнгөрсөн туршлагаар хэмжээд байвал, та хэзээ ч давж өсч чадахгүй.

Та итгэлээ бусдад тохиолдсон зүйл дээр суурьлуулж байна уу? Таны итгэлцлийн төвшин бусдын итгэмжтэй байдлаар хэмжигдэж байна уу?

Эдгээр асуултад тийм гэж хариулсан бол, цааш нь илүү гүн ухах хэрэгтэй. Та өөрийнхөө болоод өрөөлийн өнгөрсөн амьдралын бүтэлгүйтлийг тайлбарлах гэж оролдохдоо, юмсыг улам ээдрээтэй болгож байна уу? Ээдрээтэй итгэл нь үлэмж биетийг сөнөөхгүй. Ээдрээтэй итгэл нь биднийг өөрчилж

АЙЛГАН СҮРДҮҮЛГИЙГ ЯЛАХУЙ

чадахгүй зүйлийнхээ учрыг олох гэж дэмий оролдсоор, цаашаа нүүдэл хийхэд эргэлздэг, “эргэцүүлэл гайхшралын” хоригдол болгодог.

Итгэгчид бид яагаад зүгээр л итгэж болдоггүй юм бол? Яагаад бид айдсаараа сайн мэдээг ээдрээтэй болгоно вэ?

Битантай өөрийнхөө мартагдашгүй нэгэн явдлыг хуваалцмаар байна. 1980 он юм даг. Би Хойд Каролинад аж төрдөг оюутан хүү байлаа. Нэг удаа үүрийн дөрвөн цагт өөрийнхөө хашхирах дуунаар дуг нойрноосоо дав хийн сэрэв.

“Би итгэх хүнийг хайж байна!”

Энэ үг намайг дэлсэв. Ор маань хөлсөндөө норжээ. Бурхан надтай жирийн бус, ер бусын аргаар ярьсныг нь би мэдэв.

Тэр үед *Бурхан яагаад надад гүн гүнзгий зүйл хэлэлгүй, ийм ойлгомжтой зүйл хэлнэ вэ?* Мэдээж Бурхан хүмүүсийг итгээсэй гэж хүсдэг! гэж бодогдов.

Маргааш өглөө нь мөнөөх үг миний дотор шуурсаар байлаа. “Би зүгээр л итгэх хүнийг хайж байна, би зүгээр л итгэх хүнийг хайж байна” гэсэн шивнээ дотор минь ахин дахин эргэсээр байлаа. Тэгээд би тэр үгийг ахин дахин сонсохдоо, Бурхан надад байдаг л зүйлийг үзүүлээгүй, харин Бурхантай амьдрах амьдралын амин түлхүүрийг үзүүлсэн болохыг нь ойлгов.

Би Сайн мэдээг судлахдаа, хүмүүсийн итгэлгүй байдал Есүсийг хичнээн гашуудуулж байсныг олж харав. Нэгэн залуугаас чөтгөрийг хөөж чадахгүй байгаа дагалдагч нараа Есүс хатуу зэмлэсэн байдаг:

Итгэлгүй, завхарсан үеийнхээн. Хэдий хүртэл би та нартай хамт байх юм бэ? Хэдий хүртэл Би та нарыг тэвчих юм бэ? (Матай 17:17).

Дагалдагч нартаа ямар хатуу үг хэлээ вэ! Есүс өнөөгийн олон удирдагч нар шиг өөх ч биш, булчирхай ч биш нэгэн байсангүй! Итгэхгүй аваас, тэдний доторх Бурханы бэлэг унтрахыг тодорхой хэлсэн. Дагалдагч нар нь Өөрийг нь гашуудуулж байгааг Есүс тэдэнд мэдүүлсэн.

Тэгвэл ямар ч асуудалгүй, шууд итгэдэг хүмүүс Есүсийг хичнээн баярлуулгийг би бас олж харсан. Ромын цэрэг итгэлээрээ Есүсийн анхаарлыг Израильчуудаас илүү татсан. Тэрбээр Есүст манайд ирээд ч хэрэггүй. Та зүгээр үгээ хэлэхэд л

манай зарц эдгэрнэ гэсэн байдаг. “Есүс үүнийг сонсоод гайхаж, дагаж явсан олонд —Үнэнээр Би та нарт хэлье. Би ийм агуу итгэлийг Израильд хэнээс ч олоогүй юм байна” гэв (Матай 8:10).

Бид Есүсийг гэртээ урьдаг ч, ирэхээр нь баахан байцаадаг. Бид итгэлийг түвэгтэй болгосон. Тэгэхээр, итгэл гэж юу вэ? Бурхан хийнэ хэмээн амласнаа хийнэ гэдэгт итгэх.

Есүс бидэнд дайсны хамаг хүчээс дээгүүр хүч чадал, эрх мэдлийг өгсөн гэсэн. Бид ердөө Түүнд итгэж, тэр хүч, эрх мэдэл дотор алхахад л болно. Итгэлийн алхаагаа айdas, эргэлзээ, өнгөрсөн алдаа, бүтэлгүйтлээрээ хүндруүлэх хэрэггүй. Тэгэх юм бол, эр зоригоо тонуулж, Бурханы чадвар руу хөрвож чадахгүй. Бидний доторх Бурханы бэлэг унтарна!

Завиа орхиж, амьдралын шуурган дунд усан дээр итгэл дүүрэн гишгэхээсээ өмнө зүрхнийхээ сэдлийг мэдэх хэрэгтэй! Эс бөгөөс живнэ! Дараагийн бүлгээрээ амьдруулдаг сэдэл, живүүлдэг сэдлийн ялгааг сурцгаая.

*Бүрхан бидний хүссэнээр үйлдэж байгаа цагт
итгэлтэй байх амархан.*

Есдүгээр бүлэг

АЙЛГАН СҮРДҮҮЛГИЙН ҮНДЭС

Айж сүрдэхээс эрх чөлөөтэй байх нь экстроверт байхтай ямар ч холбоогүй. Миний мэдэх хамгийн нийтэч хүмүүс айлган сүрдүүлэгтэй зөрчилдөж байхыг би үзсэн. Үнэндээ тэдний халгиж цалгисан зан чанар нь дотроо тэмцэлдэж байгаа зүрхгүй байдлынх нь халхавч байж таараах нь олонтаа. Зарим хүн таагүй байх тусмаа, чалчаа болчихдог.

Түүнчлэн айж сүрдэх нь их, бага тосолгоотой байхтай ч холбоогүй. Хүчирхэг үйлчлэл хийдэг ч, айлган сүрдүүлэгтэй зөрчилддөг байсан эрчүүдийг би мэднэ. Дээр нь тосолгоо тогтох үед сул дорой нь Бурханы тосолгоонд дэвтгэж, тэд аймшиггүй болж хувирдаг. Гэтэл тосолгооных нь нөмрөг тайлгадах үед дотор нь айдас, чичрэлтэй тэмцсэн хүн л үлдэнэ. Ялангуяа нүүр нүүрээрээ тулах үед тэдний зүрхгүй байдал аргалахын аргагүй, ил тод болно гээч. Яаж мэдэж байгаа юм гэж үү? Яагаад гэвэл би тийм хүн байсан.

Та нийтэч, хүчтэй, болд - тэр бүү хэл тосолгоотой атлаа айлган сүрдүүлэгтэй зөрчилдөж байж болох. Дарамт ихсэх үед таны эд бүтэц ил болно. Зүрхгүй байдлын сүнстэй байх нь зан чанарын доголдол, биеийн хүч, тосолгоотой ямар ч холбоогүй. Тиймээс, юу хүмүүсийг айлган сүрдүүлэгт эмгэг болгодог вэ?

Гадаад үзэмж - үнэн

Үннд хариулахын тулд Симон Петрийг ажиглана уу. Тэрбээр санал бодлоо нуудаг, бүрэг хүн байгаагүй. Тэр болд хүн байсан.

Петр гаднаа хүч хаттай, айдасгүй хүн байв. Петрийг юу ч айлган сүрдүүлж чадамгүй харагдаж байсан ч, айлган сүрдүүлж чаджээ. Тэрбээр үхэхээс айсандаа Есүсийг гурван удаа няцаасан. Тэгэхээр, айж сүрдэхгүй байх нь хүчтэй зан чанартай холбоогүй байх нь. Хүчтэй зан чанартай хүн айж сүрдэгтгүй байсан бол, Симон л хамгийн түрүүнд Есүсээс урвалгүй, үнэнч хэвээрээ үлдэх байж.

Симон Петрийг хэрэг дээрээ “тахиа” байсан гэж ярьдаг л даа. Тэгвэл би үүнд чинь ингэж хариулъя: Бүрэн зэвсэглэсэн хамгаалагч нарын өөдөөс босоод, дайрах зүрхтэй тахиа хэд байдаг бол? Гэтэл Петр ингэсэн! Иохан 18:3:

Тэгтэл Иудас цэргийн баг, ахлах тахилч нар болон фарисайчуудаас харуулуудыг нь дагуулж ирэв. Тэд дэнлүү, бамбар, зэвсэг барин хүрч ирлээ. ...Симон Петр илдээ сугалаад, тэргүүн тахилчийн зарцын баруун чихийг тас цавчжээ. Тэр зарцын нэрийг Малх гэдэг байв (Иохан 18:3,10).

Надад лав ерөөсөө ч тахиа шиг санагдахгүй байна. Симон Петр цэргүүдийн өөдөөс дайрсан атлаа зарц охины өмнө хулчийсан уу? Тийм ээ, яг тэгсэн. Зарц охин түүнийг сүрдүүлсэн! “Петрийг гадаа хашаан дотор сууж байтал нэгэн шивэгчин түүнд ойртон ирээд, —Чи ч бас Галилын Есүстэй байсан шүү дээ гэхэд, тэр харин бүгдийн өмнө үгүйсгээд —Юу ярьж байгааг чинь би мэдэхгүй байна гэв” (Матай 26:69-70).

Петр юунаас болоод ингэтэл хувирav?

Зоригтой царай

Үүнд хариулахын тулд тэр оройн явдлаас арай өмнө юу болсныг үзье. Дагалдагч нар бултаараа Дээгүүр өнгөрөхийн баяраа тэмдэглэсэн. Есүс тэдэнд “Та нар энэ шөнө Надаас болж бүгд бүдрэх болно. Учир нь “Би хоньчинг цохино, хонин сүрэг тарж бутарна” гэж бичигдсэн билээ” (Матай 26:31) гэсэн. Гэтэл Петр гоцолж ирснээ: “Танаас болж бүгд бүдэрлээ ч би хэзээ ч бүдрэхгүй” (Матай 26:33) хэмээн тунхагласан. Урам зоригийн яруу жишээ байна. Есүс тэр тоонд Петрийг багтаахдаа, алдсан гэмээр харагдаж байв.

Гэтэл Есүс Петрийн сэтгэл рүү цоо ширтээд, түүнийг засчээ: “Үнэнээр Би чамд хэлье. Энэ шөнө азарган тахиа донгodoхоос өмнө чи Намайг гурвантаа үгүйсгэнэ” (Матай 26:34). Есүс Петрийн итгэлтэй байдлыг пал хийтэл авч! Есүс Петрийг бүдэрээд зогсохгүй, Өөрийг нь няцаанаа гэв.

Ийм тохиолдолд сул зан чанартай хүн гэдрэг ухрах байх. Эзэн алдаа гаргав уу? Гэтэл Петр “Би Тантай хамт үхэх ёстой болсон ч Таныг үгүйсгэхгүй” (Матай 26:35) гэж хэлсэн. Үнэндээ “шавь нар нь бүгдээрээ бас тэгж хэлцгээв” (Матай 26:35).

Сэдэл нь гадаад байдлаасаа өөр байж болно

Гаднаа энэ эрчүүд бүгдээрээ л аугаа зоригтой, цэвэр сэдэлтэй юм шиг харагдаж байв. Гэхдээ нарийвчлан үзбэл, тэднийг Бурханы хайраас өөр зүйл хөдөлгөж байсныг мэдэж болно.

Есүс тэдэнд анхааруулсан. Тэрбээр дагалдагч нартаа “Харин үзэгтүн, Надаас урвагч нэгний гар Миний хамт ширээн дээр байна” (Лук 22:21) гэж хэлсэн. Тэдний нэг нь Есүсээс урвана гэж бодох юутай аймшигтай, юутай аюултай. Энэ бүх хугацаанд Есүстэй хамт амьдарч, алхаж байсан, Есүсээр хайрлуулж, халамжуулж байсан дагалдагч нь эдүгээ Мессаина Эзэнийхээ эсрэг эргэх!

Хэн үүнийг хийх, чухам юу хийхийг нь Есүс Өөрөө анхнаасаа мэдэж байсан ч, дагалдагч нартаа анх дуулгасан нь энэ байж. Энэ мэдэгдэл хичнээн аймшиг, хар сэр дагуулсныг төсөөлж байна уу?

“Бидний хэн нь тийм зүйл хийх юм бол?” (Лук 22:23) Тэдний нэг нь хүний ухаанд багтамгүй, ийм ёрын хэрэг үйлдэх чадалтай гэдэгт тэд итгэж ядан, аймарч уймрав. Тэгэхээр, энэ мөрдөн байцаалтын сэдэл нь юу байв? Мэдээж бүгдээрээ л Есүст санаа тавьсандаа л тэр байлгүй дээ. Гэхдээ яг тийм байв уу? Тэдний хооронд өрнөсөн харилцан яриа бүгдийг илчилнэ. Дараагийн эшлэлийг үзнэ үү:

Тэрчлэн тэдний дунд хэн хамгийн агуу нь байх талаар ч маргаан дэгджээ (Лук 22:24).

Тэдний мөрдлөгийн учир шалтгаан нь амия бодох санаа, бардамнал байсан нь эндээс тодорхой харагдаж байна. Есүс хэзээ мөдгүй баривчлагдан, тэргүүн тахилчид тушаагдан, алгуулна гэж байхад, дагалдагч нар нь эрх хүч, байр суурийн төлөө өрсөлдөн тэмцэлдэж эхэлжээ. Юу гээчийн амия бодсон явдал вэ!

Энэ маргааныг хэн толгойлсныг нь бараг л тааж байна. Урьд өмнө манлайлагч зангаараа удирдагчийн чанараа байнга харуулдаг байсан Петр л байх.

Магадгүй Петр дагалдагч нарт өөрийгөө тэдэн дундаасаа усан дээгүүр явсан цорын ганц хүн болохоо бушуулан сануулсан байх (Матай 14:28-31). Эсвэл өөрийгөө Есүсийг хэн болохыг түрүүлж тааснаа (Матай 16:15-16) сануулаад, хамгийн сүүлд нь хувирлын уулан дээр Есүс, Моше, Елиа гурвыг үзсэн (Матай 17:1-8) явдлаа дүгнэлт болгон дурьдсан байх.

Магадгүй, Петр өөрийгөө арван хоёр дундаасаа хамгийн мундаг нь гэдэгт итгэл дүүрэн байсан байх. Гэхдээ энэ итгэлтэй байдал нь хайранд үндэслэж байсан уу? Тухайн үедээ Петр тэгж л бодсон байх. Гэвч өөр байсан нь хожим нь илрэдэг. Түүнийг итгэлтэй байдал нь амия бодсон зан, бардамналд зоогдсон байжээ. Үүнийг тогтоогоод, цаашаа явцгаая.

Тосон шахуурга

Есүс тэдний хамт Гетсемани гэдэг газар ирж, шавь нартаа —Намайг тэнд очиж залбирах зуур энд сууцгааж бай гэв (Матай 26:36).

Гетсемен гэдэг үг нь “toson шахуурга”¹ гэсэн утгатай үг. Тосон шахуурга нь чидун жимснээс тосыг нь тунгааж авдаг. Чидунаас тосыг нь гаргаж авах нь тийм амар хялбар зүйл биш. Маш их даралтаар шахаж байж л чидуны дотроос тос нь гарна. Гетсемен нь ийм даралтын газар - гэхдээ чидун жимсийг бус, харин зүрхийг шаҳдаг. Хүчтэй даралт дор бидний дотор байгаа зүйл гадагш гардаг бөгөөд гарсан зүйл нь биднийг гайхшуулах нь олонтаа. Өөрөөр хэлбэл, сорилт (дарамт) ирэхэд, бидний зүрх шалгагдаж, илчлэгддэг.

Бичээс Есүсийг Петр, Иаков, Иохан гуравтай Гетсемен рүү яваад “зовж, шаналж эхлэв” (Матай 26:37) гэдэг. Есүс тосон шахуургад

орсон тул сэтгэл нь “үгээр илэрхийлэмгүй тарчилжээ”. Есүс хамгийн том тулаандаа оржээ. Энэ нь Аавынхаа хүслийг биелүүлэх үү эсвэл Өөрийгөө аврах уу гэдэг сорилт байв.

Зарим хүн Есүсийг нүгэл үйлдэх чадваргүй байсан гэж үздэг. Гэхдээ Есүс “бүх талаар бидэн шиг соригдсон Нэгэн” (Еврей 4:15) гэдгийг бид санах ёстой. Сорилт гэдэг тэмцэх ёстой зүйл. Есүс зөрчлөөс автомат дархлаатай байгаагүй, зүгээр л тэдгээрийг ялж гардаг байсан юм. Яагаад? Яагаад гэвэл Есүс Өөрийнхөө хүслийг хэрэгжүүлээгүй. Тэрбээр нүгэл үйлдэх чадваргүй байсан бол, өдөөгдөх ч боломжгүй байх байсан шүү дээ. Энэ нь Есүсийн алдрыг бууруулах бус, харин ч нүгэл үйлдээгүй учраас, Тэрбээр ямар нандин болохыг нь тодосгож байгаа юм.

Есүс цэцэрлэгт “Эцэг минь, болж өгвөл Надаас энэ аягыг өнгөрүүлээч. Гэвч Миний хүслээр биш, харин Таныхаар болог” (Матай 26:39) хэмээн хүссэн.

Анх удаа Есүсийн амьдралд Бурхан Аавын хүсэл, Хүүгийн хүсэл хоёр зөрчилдөхийг харж байна. Гетсемен хүртэл тэдний хүсэл эгнэгт нягт байсандаа, бид Есүсийн амьдралаас гагцхүү Аавынх нь хүслийг л олж хардаг байв. Гэтэл энэ тулааны дарамт Есүсийн сэтгэлийг хүү татсан. Энэ нь Түүнийг чангааж чадах цорын ганц зүйлийг илчилж байв - Аавынхаа хүслийг өөр маягаар биелүүлэх сонголт хийгээд, Өөрийгөө аврах. Есүс өмнө Фарисайчуудад “Тиймээс Эцэг Намайг хайрладаг. Учир нь Би амиа буцааж авахын тулд амиа өгнө. Хэн ч амийг минь Надаас авахгүй. Харин Би Өөрөө түүнийг өгнө. Амиа өгөх эрх мэдэл Надад бий, буцааж авах эрх мэдэл нь ч бий. Энэ тушаалтыг Би Эцэгээсээ хүлээн авсан юм” (Иохан 10:17-18) гэж хэлсэн.

Есүс Өөрт нь ирэх зөрчлийг бүр эртээс мэдэж байжээ. Тэрбээр Иерусалимд ирэхээсээ өмнө энэ тухайгаа дагалдагч нартаа гурван удаа хэлсэн. Түүний зовох, үхэх, үхлээс амилах нь Бурхан Аавын хүсэл гэжээ.

Хэдэн өдрийн өмнө Есүс дагалдагч нартаа “Надад үйлчлэх нь Намайг дага. Би хаана байна, Миний зарц бас тэнд байх болно. Надад үйлчилбэл тэр хүнийг Эцэг минь хүндэлнэ. Сэтгэл минь одоо шаналж байна. Би юу гэж хэлэх юм бэ? “Аав аа, Намайг энэ цагаас авраач” гэх үү? Гэвч үүний л төлөө Би энэ цагт ирсэн” (Иохан 12:26-27) хэмээн итгүүлсэн байdag.

Есүс Аавынхаа нэрийг алдаршуулахын тулд сайн дураараа амиа үхлийн хөлд тавьжээ. Тэрбээр дөнгөж сая энэ зарчмыг дагалдагч

нартайгаа хуваалцав: “Амиа хайрлагч нь түүнийгээ алдана. Энэ өртөнцөд амиа үзэн ядагч нь түүнийгээ мөнх аминд хүртэл хадгална” (Иохан 12:25).

Энэ бичээст хоёр хариулт агуулагдаж байна - ягаад Петр ам гарсан зүйлээ биелүүлж чадаагүй байхад, Есүс чадав? Есүс амиа алдахын тулд Аавынхаа хүслийг Өөрийнхөө амиас илүү хайрласан. Петр өөрийгөө аминаасаа илүү Есүст хайртай гэж бодсон ч, Гетсемений шахуурга дор орох үед сэдэл нь ил болжээ.

Цэцэрлэгт Есүс Аавынхаа хүслийг зүгээр мэдэх нь хангалтгүй байв. Эдүгээ Тэрбээр энэ хүслийг амьдруулах ёстой байв. Гэвч энэ нь дэндүү хэцүү байсандаа, Есүс Ааваасаа өөр арга зам байгаа эсэхийг хүртэл асуужээ. Тэрбээр амиа хамгаалах энэ өдөөлтгэй цусаар хөлрөх хүртлээ чөлөө завгүй тэмцэлджээ (Лук 22:44).

Өдөөлтийг эсэргүүцэх Есүсийн хүч нь Түүний хайртай бас хайргүй зүйлээс үндэслэж байв. Тэрбээр Аавыгаа гэх хайрынхаа улмаас л Өөрийгөө алдсан билээ (Иохан 14:31). Энэ хайр нь урьд өмнө хэний ч байлдан дагуулж чадаагүй зүйлийг буюу өөрийгөө хайрлах хайрыг ялан дийлсэн! Тос хага үсэрч, Есүс Аавыгаа дан амаараа бус мөн золиос, дуулгавартай байдлаараа хайрладаг болох нь бүрэн батлагджээ.

Тэгвэл одоо “шахуурга” буюу дарамт Петр ба дагалдагч нарт хэрхэн нөлөөлснийг үзнэ үү.

Сүнс хүсэв ч, бие мөхөс

Есүс цагийн турш хүсэлтэйгээ тэмцэлдсэн хойноо босоод, дагалдагч нар дээрээ очтол, “уй гунигаасаа (шаналлаасаа) болоод унтаж буй тэднийг олж харжээ (Иохан 22:45). Дагалдагч нар аугаа нэгнээ шалгаруулах маргаанаа зогсоогоод, гашуудал, гунигт автжээ. Тосон шахуурганд Есүс ганцаараа ороогүй, дагалдагч нар ч бас орж!

Тэд өөрсдийгөө аврах өдөөлтгэй тулгарчээ. Гэвч тэд Аавын хүсэл дээр бус, өөрийнхөө хүсэл дээр төвлөрсөндөө, өндийх ч чадалгүй болжээ. Тэдэнд Есүстэй адил Бурханы хүсэл дээр дахин төвлөрөх хүсэл байсангүй. Гэтэл бид амиа нарийлан хайрлаад байх юм бол, хэзээ ч амиа өгтэл тулалдаж чадахгүй.

Бодоод үз дээ: Есүс амиа алдахын төлөө тэмцэлдэж байхад, дагалдагч нар тулаанаас унтаж зугтсан. Есүс онцгойлон Петрт

“Та нар Надтай ганц цаг ч сэргэг байж чадсангүй юу? Уруу татагдахгүйн тулд сэргэг бай, залбир. Сүнс чухамдаа тэсэн ядаж байна, харин махбод дорой” (Матай 26:40-41) гэж хэлсэн.

Эрэлхэг амлалтын эр - Петр залбирахын оронд унтаж хэвтэв. Тэрбээр хүний чадлаас дээд хүч чадал руу татагдахыг хараахан сураагүй байсан болохороо, өөрийгөө хүний аргаар буюу нойроор хамгаалжээ.

Бидний сүнс юмуу зүрх хүсэлтэй байж болох ч, махан бие маань хэзээд өөрийгөө хамгаалахыг л зорьдог. Тэгээд хэрэв махан биеэ цовдолж чадахгүй бол, эцэстээ хүссэнийг нь өгөх л болно. Петр Есүст итгэмжтэй байхыг хүссэн ч, махан биедээ дийлдээд, чадаагүй. Тэрбээр амиа Бурханы хүслээс илүү хайрласан. Петр зүрхнийхээ жинхэнэ төрхийг хүлээн зөвшөөрөөгүй. Тэрбээр өөрийгөө үнэхээр Есүсийн төлөө амиа өгч чадна гэдэгт итгэсэн. Тийм боловч “шахуургаас” Сүүлчийн зоог дээр болсон үйл явдлыг давжсүүдэрлэсэн“амиабодох, бард амнал”гэсэнхоёрзүйл гарчээ.

Хоёр өөр үр дүн

Дагалдагч нар нь унтаж байхыг үзээд, Есүс дахин залбирахаар явжээ. Тэгээд эргэж ирэхэд нь дагалдагч нар мөн л “зовхи доаахгүй” унтаж байв (Матай 26:43). Есүсийг анхааруулаад байхад ч, дагалдагч нар өндийж чадаагүй байна. “Тэр тэднийг дахин орхиж холдон яваад, гурав дахь удаагаа залбирч, нөгөө үгээ л хэлжээ. Тэгээд Тэр шавь нар дээрээ ирж,— Та нар унтаж, амарсаар л байна уу? Харагтун, цаг нь айсүй. Хүний Хүү нүгэлтнүүдийн гарт тушаагдаж байна” (Матай 26:44-45) гэжээ.

Есүс тулаанд ялснаа мэдэх хүртлээ гурван цаг залбирсан байна. Эдүгээ тэрбээр Аавынхаа хүсэлтэй нэг цул болжээ. Эдүгээ Тэрбээр Еврей удирдагч нар, Ромын цэргүүдийн гараар айсүй айлган сүрдүүлэгтэй халз тулахад бэлэн болжээ.

Улайрсан хавчлага дор ч цэх зогсоо Есүсийг Ромын захирагч өөрөө биширсэн. “Ахлах тахилч нар болон ахлагчдаар яллуулахдаа Тэр юу ч хариулсангүй. Пилат Түүнд —Тэд ямар олон зүйл Таны эсрэг гэрчилж байгааг Та сонсохгүй байна уу? гэхэд Тэр түүнд ганц ч үг хариулсангүйд захирагч ихэд гайхжээ” (Матай 27:12-14).

Эр зориг чанга яриа эсвэл олон үгээр илрэхгүй. Чимээгүй байхуйд ч эр зориг оршино. Худал ялаар нүүр, нүдгүй булж байхад ч чимээгүй үлдэх. Есүс эс хариу үйлдлээрээ эрх мэдлээ хадгалжээ. Хүмүүс Түүний дээр эрх мэдэлгүй болохыг Есүс мэдэж байв. Есүс хариу үйлдсэн бол, хүмүүс Түүний дээр эрх мэдлээ тогтоох байлаа. Хүмүүс ял, заналхийлэл, эрх мэдлийн байр сууриараа Есүсийг хянан захирагаадах гэж оролдсон. Ийм хүмүүсийн өөдөөс хариу үйлдэх нь мунхаг явдал болно. Учир нь тэдэнд үнэн падгүй. Есүс амиа хэдийнээ Аавдаа өгсөн учраас, хүмүүс амийг нь авч чадахгүйг мэдэж байв!

Есүс яллагч нартайгаа тулж байх үеэр Петр гадаа галын дэргэд дулаацаж байлаа. Тэрбээр мөнөөх удирдагч нарын зарц нараас аиж сүрдсэндээ, Есүс мэдэх ч үгүй хэмээн гүрэлзсэн (Матай 26:69-75). Петр Есүсийг няцааснаас үхсэн минь дээр гэж хэлсэн ч, аиж сүрдсэндээ хийхгүй гэсэн яг тэр зүйлээ хийжээ. Шалтгаан нь: Петр аминдаа хайртай байжээ.

Петр том үгээрээ Есүст том хайртайгаа харуулсан ч, үйлдэл нь бүр ч том дуугарав. Петрийн хулчгар байдлын үндэс нь амиа хайлрах хайр байжээ. Энэ нь Петрийн урьд урьдын эрэлхэг мэдэгдэл, үйлдлээр сайн далдлагдаж байсан ч, түүний дорой сүнсийг тосон шахуурга ил болгожээ.

Айдас, аиж сүрдэхийн үндэс нь амиа хайлрах хайр байдаг. Төгс хайр айдсыг хөөж, бидэнд эр зориг хайлрадаг. Хайраас төрсөн эр зориг нь айлган сүрдүүлгийн атгыг задалдаг. Төгс бус хайр буюу амиа хайлрах хайр нь айлган сүрдүүлэгт үүд нээж өгнө.

Үүгээр шүүлтийн өдөр биднийг зоригтой байлгахын тулд хайр нь бидний дунд төгс болов. Учир нь бид энэ ертөнцөд Түүн шиг байдаг. Хайр дор айдас үгүй. Харин төгс хайр нь айдсыг хөөн зайлцуулна. Учир нь айдаст ял байдаг. Айдаг нэгэн нь хайр дор төгс болгогдоогүй байна (Иохан 4:17-18).

Айсан, сүрдсэн хүн өөр дээрээ төвлөрдөг учраас, айдас, сүрдүүлэг хоёр түүнд томорч харагддаг. Айсан, сүрдсэн хүнийг “Би яана аа? Би яах бол?” гэсэн бодол тамлана.

Есүс “Нөхдийнхөө төлөө амиа зориулахаас илүү агуу хайр байхгүй” (Иохан 15:13) гэсэн. Есүсийг хайлрах хайраараа

жинхэнээсээ амия өгч байгаа хүн өөрийгөө яана ийнэ гэдэгт зовохгүй. Учир нь бид Түүний мэдэлд даатгагдсанаа мэднэ. Тэр цагт л бид үхэж, Түүний дотор нууцлагдана. Амь маань цаашид биднийх биш, Түүнийх болсон учраас, санаа зовох хэрэггүй. Тэр биднийг худалдаж авсан учраас, бид хэрхэх нь Түүний мэдэл. Бид хайрлаад, дагахад л болно.

Айдас биднийг тамлах учиргүй. Учир нь үхсэн хүнийг тамлах боломжгүй. Авсан дотор байгаа хүнд буу тулгаж, заналхийллээ гээд дальдчих ч үгүй.

Тэгвэл бусад нь ясан?

Бусад дагалдагч нар ясан? Тэд Петртэй нийлэн, Есүсийг няцааж байснаас үхсэн нь дээр гэж мэдэгдэж байсан. Тэгвэл тэд тосон шахуургаас ямар дүнтэй гарцаав? Тэд Петрээс ч өмнө арилцгаасан. Матай 26:56 дээр “Тэгтэл шавь нар бүгд Түүнийг орхин зугтжээ” гэдэг.

Дагалдагч нар бүгдээрээ л өөрийнхөө төлөө айсан. Тэд ч бас залбирахын оронд унтсан. Есүстэй барьсан Сүүлчийн зоог дээр тэд хэн нь аугаа болох талаар маргалдсан. Тэд яг л сонсохгүй байгаа юм шиг эсвэл сонсож чадахгүй байгаа юм шиг байжээ. Тэд: “Би яана аа?” гэдэг ганц үгийг л сонссон. Тэдний аминдаа хайртай нь тосон шахуурга дор илчлэгджээ.

Тэдний сэдэл ч Петрийнхээс ялгараагүй. Есүсийг авч явсан цэргүүдийг дагасандаа, Петр хамаагүй хүнд байдалд оржээ.

Эр зориг болгон хайраас эхтэй гэвэл эндүүрэл

Юу Петрт цэргүүдийн өөдөөс илд барин босох эр зориг хайрлав хэмээн та гайхсаар байж магадгүй. Би л хувьдаа - бусдад таалагдах хүслээс нь төрсөн гэдэгт итгэдэг. Бодоод үз дээ. Тэд дөнгөж сая хэн нь аугаа болох талаар мэтгэлцсэн. (Энэ сэдэв тэдний дунд анх үүсч байгаа хэрэг биш. Дагалдагч нар байнга өрсөлддөг байв.) Петр энэ бүхнийг мартаагүй бөгөөд яг одоо түүнд аугаа итгэлээ батлан харуулах боломж олджээ.

Тийм боловч Петр нөхдөөсөө хол, тэргүүн тахилчийн зарц нартай хамт галын дэргэд суух үед жинхэнэ сүл тал нь ил гарав.

Түүний айдас нь голдуу чанга зан чанараар нь халхлагдаг байжээ.

Петрийн хуурамч эр зоригийг урьд урьдын үйл явдлууд нь ч илчилдэг байв. Тухайлбал, усан дээгүүр алхсан явдал. Бусад дагалдагч нар нь харж суухад, Петр “Эзэн, хэрэв Та мөн юм бол усан дээгүүр алхаж, Тан дээр очихыг надад тушаагаач” (Матай 14:28) гэж хашхирсан. Тэгээд завинаасаа гараад, тэнгисийн мандал дээгүүр алхсан. Магадгүй, нөхдөө алмайруулах гэсэн эр зориг байсан юм болов уу. Гэвч усан давалгаанд дунд ормогцоо Петр Есүсээс аврал эрэн хашхирсан. Тэрбээр усан дээгүүр явахдаа, нөхөд нь хажууд нь байхгүй ухаараа байх. Тэгээд дарамтанд ормогцоо, Есүсээс аврал эрэн хашхирчээ.

Петр цэцэрлэгт байхдаа Есүс өмнө олон удаа өөрийг нь аварч байсан шигээ энэ удаа ч бас аварна гэж бодоо байх. Түүний ч зөв байв. Гэвч Петр болоод дагалдагч нар Есүсийг баривчлагдана чинээ санаагүй. Хэдийгээр Есүс тэдэнд ахин дахин хэлсээр байсан ч, тэд Есүсийг газар дээр хаанчлалаа байгуулна гэдэгт итгэсээр байж (Үйлс 1:6, Матай 16:21).

Бурхан бидний хүслээр үйлдсээр байгаа цагт итгэлтэй байх амархан. Гэвч Түүнийг гэнэтийн бэлэг барих үед бид салганаад явчихдаг. Амьдрал, үйлчлэлд маань биднийг барьц алдуулах, гэнэтийн юм тохиох үед бид эр зоригоо алддаг. Бид нүд үзүүрлэгдэж, хавчигдаж, шүүгдэхэд ихэвчлэн бэлтгэлгүй байдаг. Яг л хүүхэд шиг бид өөрийнхөө сурсан дадсан зүйлдээ л дуртай. Бид хүссэн зүйлээ хүссэн цагтаа авахгүй үед зүрх маань шалгагдана. Шүүх бидний зүрхийг жинлэдэг. Бурхан бидний хүссэнийг өгсөөр байгаа цагт, амьдрал дардан үед итгэлтэй харагдаж болох ч, юмс өөрөөр эргэх үед сэдэл маань илчлэгдэнэ. Есүс энэ нөхцлийг тайлбарлажээ:

Үүнчлэн тэдгээр нь чулуурхаг газар таригдсан ба тэд үгийг сонсоод тэр даруй баяртайгаар хүлээн авдаг. Гэвч тэд үндэсгүй тул түр зуурынх бөгөөд дараа нь үгнээс болж зовлон, хавчлага тохиолдоход шууд л бүдрэн унадаг (Марк 4:16-17).

Дагалдагч нарт үндэс байгаагүй учраас, тэсч гараагүйг тэмдэглээрэй. Биднийг бат байлгах үндсийг хэрхэн хөгжүүлэх вэ? Бид юун дээр үндэслэх вэ? Ефес 3:17 биднийг Христийг

хайрлах хайран дээр үндэслэж, суурьлаарай гэдэг. Жинхэнэ хайр өөрийгөө бодохгүй. Тачирхан үндэстэй хайртай хүмүүс амар хялбар байгаа цагт л тэсдэг. Тэд Христтэй хамт цовдлогдоогүй бөгөөд Есүсийг Өөрийг нь хайж бус, гарыг нь харж ирдэг!

Жинхэнээсээ хайрладаг хүмүүс гагцхүү Түүнийг бөгөөд Түүний таалдаг юмыг л хайдаг. Хайр хариу нэхдэггүй, харин өгдөг. Юмс санаагаар нь болохгүй байсан ч, сэдэл нь хэвээрээ л үлдэнэ. Хайр нь урам хугардаггүй (урам мөхдөггүй) учраас, айж сүрдэхгүй.

Айлган сүрдүүлгийн хүчийг тасар татах эр зориг нь Бурханы хайраар цэнэглэгдэх ёстой. “Учир нь Бурхан бидэнд айдсын бус, харин хүч, хайр ба биеэ захирах сүнсийг өгсөн” (2Тимот 1:7). Айлган сүрдүүлгийг ялахад хүч чухал хэдий ч, дангаараа хангалтгүй. Дарамтанд орохоороо тосолгоотой эрчүүд ч айлган сүрдүүлгийн өмнө бэмбэгнэдгийг өмнө хэлсэн билээ.

Эрүүл саруул ухаан ч дангаараа хангалтгүй. Есүсийг Мессаина болохыг Ариун Сүнс Петрт илчилсэн (Матай 16:13-18). Гэхдээ Петр Бурханы хайраар дүүрэх үедээ л жинхэнээсээ амиа зориулсан билээ. Энэ талаар дараагийн бүлгээрээ үзье.

*Айлган сүрдүүлгийг ялах цорын ганц зам нь
амиасаа татгалзах.*

Аравдугаар бүлэг

ХҮСЭЛ ХАНГАЛТГҮЙ

Сайхан санаа хангалтгүй. Петр үхлийн нүүрэн дээр ч үнэнч болохоо харуулахыг хүссэн. Тийм боловч энэ хүслийн хүч нь өөрөө урт насгүй байв. Зүрхэн дэхь айdas нь Эзэнээ хайрлах хайрыг нь давжээ. Есүс үхлээс амилуулагдсан хойноо энэ талаар анхааруулсан буй.

Иохан 21-ээр бүлэг дээр Есүс дагалдагч нар дээрээ ирээд, өглөөний цайнд нь загас, талх бэлтгэж өгсөн. Тэгээд Петрээс “Надад хайртай юу?” хэмээн гурван удаа асуужээ. Эхний хоёр удаа нь Есүс хайрыг дагалдах үйлдлийг илэрхийлсэн *агапао* гэдэг үг хэрэглэжээ. Гэвч Петр хариулахдаа, тухай бүр *fileo* гэдэг Грек үг хэрэглэсэн байна. *Fileo* нь ямар ч үйлдэлгүй, цэвэр хайрын мэдрэмж, дурлалаар хязгаарлагдсан үг юм.

Есүс Петрээс гурав дахь удаагаа асуухад нь Петр гашууджээ. Есүс гурав дахь удаадаа *fileo* гэдэг үгийг хэрэглэсэн. Есүс асуулт дахь хайраа үйлдэлгүй, дан мэдрэмжийн төвшинд бууруулжээ. Петр шаналсандaa “Эзэн, Та бүх юмыг мэддэг. Танд хайртайг минь Та мэднэ” (Иохан 21:17) гэж хэлсэн нь “Би Танд сайныг Та мэднэ” гэсэн утга илэрхийлж байлаа.

Есүс үндсэндээ: “Чи Намайг амия зориултал хайрлаж чадах уу?” гэдэг асуултаар эхлүүлжээ. Энэ хайрыг *agapaо* гэнэ. Петр өөрийнх нь хайр сэтгэл мэдэмж, дурлахуйн хэмжээнд байгааг чин үнэнэсээ л хулээсэн. Петр Есүсийг няцаагаад нэг их удаагүй байгааг санаарай. Петр өөрийгөө ямар дорой байгааг хүлээн зөвшөөрчээ. Түүний дурлахуйн хайр нь амия өгөх чинээний хүчтэй байж чадаагүй.

Эцэст нь Есүс Петрээс “Чи Надад сайн уу?” гэж асуужээ. Учир нь: Есүс Петрийг хараахан агапао хайранд хүрэхгүй, эмтэрсэн хүн болоод байгааг мэдэж байв.

Есүс Петрт эхний хоёр асуултаа ямар санаагаар асууснаа тайлбарлахыг хүсэхдээ, “Үнэнээр үнэнээр Би чамд хэлье. Чи залуу байхдаа бүсээ өөрөө бүслээд, аль хүссэн зүтгээ явдаг байсан. Харин өтлөхдөө чи гараа сунган, өөр хүн чамайг бүсэлж, чиний хүсээгүй газарт чамайг аваачих болно гэж айлдав. Петр ямар үхлээр Бурханыг алдаршуулахыг илэрхийлэн Есүс үүнийг хэлжээ. Ингэж айлдаад Есүс, Петрт —Намайг дага” (Иохан 21:18-19) гэжээ.

Есүс Петрт “Чи мэдрэмж бүхий хайрынхаа хүчээр зүтгээд бүтэлгүйтсэн хэдий ч, хамгийн том айдастайгаа нүүр тулсан ч, төгс хайрын хүчээр ялалт байгуулах өдөр айсуй” гэж хэлсэн гэдэгт би итгэдэг. Энэ хүртэл Петр хүнийхээ чадвараар тултал хайрласан ч, бүтэлгүйтжээ. Харин үүнээс хойш Петр Есүсийг дагахдаа, *агапо* хайранд боловсорно. Энэ хайрыг бидний зүрхэнд Аав цутгадаг учраас, энэ хайр хүний хүслээс төрөхгүй. Бурханы хайр (*агапэ*, *агапо*) нь бусдын төлөө үхэхээс айдаггүй.

Есүс Петрийг дахин “шахуулахдаа” ялалт байгуулна гэдгийг нь хэлэн, урамшуулжээ. Петр “Есүсийг няцаасанд орбол, үхсэн нь дээр” хэмээн тавьсан ам тангаргаа биелүүлэх болно. Айдас, айлан сүрдүүлгийн атгаас чөлөөлөгдсөн Петр өөр хүн болно.

Бурхан энэ бүхнийг бидний л төлөө үйлддэг. Бурхан биднийг аиж сүрдэх үед бэхжүүлнэ. Бурхан биднийг ялан ялтал маань хэдэн ч удаа хамаагүй айдастай мөргөлдүүлнэ. Бид хүчээ барахаараа, Бурханы хүчийг дууддаг. Бурханы хүч байхад, бүтэлгүйтнэ гэж үгүй. Учир нь хайр хэзээ ч хөсөрдүүлэхгүй (1Коринт 13:8). Бурхан биднийг айдастай зоригтой тулаасай гэж хүсдэг.

Үүнийг надаас зайлцуулаач!

Паул үүнийг сайн мэднэ. “Мөнөөх агуу гайхамшигт илчлэлүүдээс болж махбодод минь өргөс өгөгдөж, өөрийгөө хэт дөвийлгөхөөс сэргийлж намайг Сатаны зарлага элч дэлссэн аж” (2Коринт 12:7).

Зарлага гэж Грекээр тэнгэрийн биетийг хэлэх (Стронгийн толь бичгийг үзнэ үү). Энд Паулыг цохиулахаар Сатаны илгээсэн муу тэнгэрэлчийг хэлсэн гэдэгт би итгэдэг. Тэр биет нь Паулыг хаана л очно, бөөн, бөөн асуудал учруулдаг байж. 2Коринт 11:24-27 дээр Паул өөрт тулгарсан зарим асуудлаасаа бичжээ.

Иудейчүүд намайг таван удаа гучин ес ташуурдсан. Намайг саваагаар гурвантаа жанчиж, нэг удаа над уруу чулуу шидэцгээж байв. Гурван удаа би усан онгоцны сүйрэлд өртөж, гүн тэнгист өдөр шөнийг өнгөрөөж байлаа. Ахин дахин аялахдаа, гол усны аюул, дээрэмчдийн аюул, овог нэгтний аюул, харийнхны аюул, хот дахь аюул, цөл дэх аюул, тэнгис дэх аюул, хуурамч ах дүүсийн дундах аюул, зүдэл зүтгэл, дараа дарамт, байнгын нойр дутал, өлдөл цангалаа, үргэлжийн мацаг, ноорол нүүцгэрэл, даарагал хөрөлд байлаа.

Паул хaa л очиж номлоно, тэнд нь Сайн мэдээг жадлан эсэргүүцнэ. Хот бүрийд түүнийг гинж, гай зовлон хүлээнэ. Тэрбээр ташуурдуулсан, саваадуулсан, чулуугаар нүүлгүүлсэн, усан онгоцны сүйрэлд өртсөн, дээрэмдүүлсэн нь наад захын л асуудал. Тиймээс Паул энэ талаараа Бурханд ханджээ.

Үүнийг надаас ангижруулж өгөөч гэж энэ талаар би Эзэнээс гурвантаа хүсэмжлэн гүйсан юм (2Коринт 12:8).

Эсэргүүцэл, хавчлагаас ангижрахыг хүссэн Паулын сэтгэлийг ойлгомоор. Харин гэтэл Бурхан түүнд ингэж хариулжээ:

“Миний нигүүлсэл чамд хангалттай. Учир нь мөхөсдөлд [Миний] хүч бүрэн төгс болдог” (2Коринт 12:9а).

Эзэн үндсэндээ: “Паул минь, эдгээрийг зайлцуулж өгөөч гэж бүү гуй. Харин чиний хүчин чадал дутах зүйл дээгүүр Миний нигүүлсэл ба хүч чамайг өргөөд гаргахын төлөө гуй. Паул минь, садаагүй газар - хүч хэрэггүй. Тулаан дунд л ялалт буй. Тулаан бэрх байх тусам, ялалт аугаа байна. Жинхэнэ цэрэг зөрчлөөс бус, зөрчил рүү гүйдэг юм” хэмээн айлдажээ.

Ид тулаан дунд намайг байлдаанаас гаргаач гэж бүү залбир. Энэ чинь ялалт байгуулахын төлөө Бурханы нигүүлслийн төлөө гүйх цаг. Хүн хүнийхээ хүчээр дийлэшгүй зүйлтэй тулгарах цагт Бурхан алдаршдаг. Тэр цагт л Бурханы хүч бүгдэд харагдахаар бидэн дээр оршино. Бурханы нигүүлсэл бидэнд тулгарах айdas, саад болгоныг ялан дийлнэ! Бурханы дараах үгээр өөрийгөө урамшуулаарай!

Биднийг Христ дотор ямагт ялуулдаг бөгөөд Түүний тухай мэдлэгийн анхилуун үнэрийг хaa сайгүй биднээр түгээдэг Бурханд харин талархал нь байг (2Коринт 2:14).

Харин Эзэн Есүс Христээр маань бидэнд ялалт өгдөг Бурханд талархал нь байх болтугай (1Коринт 15:57)

Хэн биднийг Христийн хайраас салгах юм бэ? Гамшиг уу, шахалт уу, хавчлага уу, өлслөлөн үү, нүцгэрэл үү, аюул уу, илд үү? «Таны төлөө бид Бүхэл өдөржингөө хядуулжээ, Нядлагдах хонь мэтээр бид тооцогджээ» гэж бичигдсэн юм. Харин бид энэ бүхний дотор биднийг хайрладаг Түүгээр дамжин давуулан дийлдэг (Ром 8:35-37).

Байлдан дагуулагч эсэргүүцэлтэй халз тулаад, ид тулаан дундаас ялгууснаар гарна! Паул үүнээс зуурсан тул зовнил нь найдвар болон хувирчээ. Тэрбээр:

Тэр надад “Миний нигүүлсэл чамд хангалттай. Учир нь мөхөсдөл [Миний] хүч бүрэн төгс болдог” гэж айлдсан. Иймд Христийн хүч надад орших тул би ихэд баяртайгаар мөхөсдөлөөрөө илүү сайрхана. Иймд Христийн төлөө мөхөсдөл, доромжлол, гачигдал, хавчлага, шахалтдаа би баяртай байна. Учир нь би хэзээ мөхөсдөнө, тэр үедээ хүчтэй байдаг (2Коринт 12:9-10) гэжээ.

Паул “баяртай байна” гэж хэлснийг тэмдэглээрэй. Хичнээн хүн ял, хэрэгцээ, хавчлага, зовлон дунд баярладаг билээ? Гагцхүү Христийн дотор нуугдсан хүн л (Галат 2:20) ийм дарамт дунд баярлаж чадна. Тэрбээр Христийг өргөмжлөхөөр амьдардаг нэгэн юм. Паул Христ алдаршин тодрох хүртэл өөрийг нь тулж түших Бурханы нигүүлсэлд найдаж болно гэдгийг мэдэж байв.

Паул Есүсийг амь биеэсээ ч илүү хайрласан. Тэрбээр Христийн төлөө үхэхэд ч - гэхдээ хамгаас илүү амьдрахад бэлэн байв. Филиппойд бичсэн захильтыг нь үзнэ үү:

Юунд ч ичихгүй, харин бүрэн зоригтой байх юмсан гэсэн миний хүслэн болсон горьдлого болоод найдварын дагуу одоо ч урьдын адил амиар ч бай, үхлээр ч бай биед минь

Христ өргөмжлөгдөх болно (Филиппой 1:20).

Паулын хувьд Христийг амиараа эсвэл үхлээрээ алдаршуулах нь ялгаагүй байжээ. Гол нь Христ л алдарших! Паул өвчин эмгэг тусч үхэх талаар хэлээгүй. Есүс эдгээрийг загалмай дээр авсан. Өвчин, эмгэг нь Есүст алдрыг авчрахгүй. Өвчинөөр үхснээрээ Есүсийг алдаршуулна гэж бодох нь нуглийн боол байсаар үхснээрээ Есүсийг алдаршуулна гэж бодохтой л адил, алдаатай сэтгэлгээ юм. Есүс аль, алийг нь загалмай дээр авсан (Исаиа 53:4-5). Дуулал 103:2-3 дээр “Сэтгэл минь ээ, ЭЗЭНИЙГ магтаж, Ач тусыг нь ч бүү март. Тэрээр бүх хилэнцийг чинь училж, Бүх өвчнийг чинь илааршуулдаг” гэдэг. Тэгэхээр, Паул өвчин, эмгэгийн талаар яриагүй байх нь. Тиймээс бид: “Эзэн минь, Та хүссэн арга замаараа л алдари! Үүнд диавол гар хөлөө дүрэхгүй!” гэсэн хандлагатай байх ёстой.

Паулын амиа хайрлахгүй хайр нь ямар ч айлган сүрдүүлгийг нэвтрүүлэшгүй эр зоригийг бий болгожээ (Филиппой 1:20-ийг үзнэ үү!) Паул хот бүрийд хавчлага, заналхийлэлтэй тулгарахаа мэдсэн ч, давшсаар байж. Паул хүнээс айгаагүй. Тэрбээр Ефесийн ахлахуудад ингэж бичжээ:

Үзтүгэй, эдүгээ би Иерусалим уруу Сүнсээр хүлүүлэн явж байхдаа ч надад тэнд юу тохиолдохыг мэдэхгүй. Зөвхөн хүлээс болон зовлон намайг хот бүрд хүлээж байгаа гэдгийг Ариун Сүнс надад гэрчилдэг (Үйлс 20:22-23).

Юутай зөгнөлтэй үг вэ! Өнөөдөр ийм үгийн төлөө нааш, цааш гүйх хүн хэд бол? Үгүй биз ээ, хүмүүс ийм үг сонсохыг хүсэхгүй л болов уу. Бид бүгдээрээ сайхан үг сонсохыг хүсдэг ч, Бурхан найдвар, урам авчрахын тулд айсуй бэрхшээлийг бас анхааруулдаг. Паул шинээр итгэсэн хүмүүсийг “Бид олон зовлон туулж байж Бурханы хаанчлалд орох ёстой” (Үйлс 14:22) хэмээн хатуужуулжээ.

Бидний явсан зүг бүрий хавчлага, эсэргүүцэл угтана гэдэг эш үзүүлэл хүлээж авбал, бид ер нь яах бол гэж гайхах юм. Мэдээж Бурханаас хүлээж авсан жинхэнэ үг бүр ийм байхгүй л дээ.

Гол нь олон хүн Бурханы үгийг хайж байгаа хувь хүнд бурууг нь хөхүүлэн дэмжсэн үг “эш үзүүлээд” байдагт л хамаг асуудал оршино. Тэдгээр нь хүмүүсийг бизнестээ, үйлчлэлдээ хөгжин

цэцэглэж, бүх юм сайн сайхан болно гэсэн таатай, чимэгтэй үгс байж таардаг. Тиймээс олон хүн Бурханы гарыг харсандаа л Бурханы араас явж, үлчилдэг. Тэд үхнэ үү, амьдарна уу хамаагүй - хайраараа Бурханыг алдаршуулах ямар ч сонирхолгүй. Гинж, зовлонгийн эш үзүүлэл - үгд Паул юу гэж хариулсныг үзнэ үү:

Гэвч би Бурханы нигүүлслийн сайнмэдээг гэрчилж, Эзэн Есүсээс хүлээн авсан үүрэг, албаа гүйцээхийн тулд өөрийн амийг юман чинээ бодолгүй явж ирсэн (Үйлс 20:24).

Паул амия юмын чинээ бодоогүй нь түүний нууц. Түүнчлэн Бурхан түүний амьдралд хандсан төлөвлөгөөндөө сорил, хавчлагыг багтаасныг тэрбээр ойлгодог байжээ. Гэхдээ Паул амь биеэсээ илүү Есүсийг хайлласан. Паулын амьдрал уралдаанаа дуусгахын нууцыг зааж байна. Амиасаа татгалзаад, Христийн амийг авах. Харин энэ нь тав тухаасаа татгалзаад, таа тухгүй зүйлийг буюу загалмайг авах гэсэн утга илэрхийлэх нь олонтаа.

Энэ Сайн мэдээ Америк Сайн мэдээ мөн үү?

Энэ бүхэн манай орчин цагийн Христэд итгэх шиг сонсдохгүй байгааг би мэднэ. Бидний амьдарч, номлодгоос тэс ондоо байгаа биз. Би ч бас ингэж амьдарч чадаагүйгээ хүлээе. Би ч бас энэ олон жилийнхээ хугацаанд “toson шахуургад” цөөнгүй ороод гарагдаа, жинхэнэ зүрхээ илчлүүлж үзсэн. Олон ч удаа зүрхийг минь өөрчлөөч гэж Эзэн рүү хашхирсан. Би элдвийн сорилтод зовсон ч, үүндээ үлэмж баярлахыг (1Петр 1:6-7) сурсан билээ. Мөн дараах бичээсийг тодорхой ойлгож авсан:

Иймээс Христ нэгэнтээ махбодоороо зовсон тул та нар ч гэсэн ижил санаагаар өөрсдийгөө зэвсэглэ. Учир нь махбодоороо зовсон нь нүглийг дуусгасан. Энэ нь биеэр амьдрах үлдсэн хугацаандаа цаашид хүний хүсэл тачаалын төлөө бус, харин Бурханы хүслийн төлөө амьдрахын тулд юм (1Петр 4:1-2).

Бид зовлон дунд төлөвшдөг. Би зовлонгийн талаар сургадаг

шашны үзэл суртлын талаар яриагүй шүү - тухайлах юм бол, Бурханд таалагдахын төлөө өвчин, ядуурлыг хүлээн авах зэрэг. Түүнчлэн дуулгаваргүй, хайхрамжгүй байдлаас юмуу бурханлаг бус зан үйлдлээс болдог зовлонгийн талаар ч яриагүй. Үүнд Бурханыг алдаршуулах юм байхгүй! Би Христийн үзсэн - бүх талаараа соригдсон боловч, нүгэлгүй үлдсэн (Еврей 4:15) зовлонгийн талаар ярьж байна. Петр “эргэн тойрны хүмүүс юмуу махан бие маань нэг зүг рүү явахыг шахаж байхад, Бурхан нөгөө зүг рүү чиглүүлэх үед хүмүүнд тулгардаг эсэргүүцлийн” талаар хэлжээ. Энэ үед бид Есүсийг хайрлах хайраас бат үндэслэхгүй бол, айлан сүрдүүлэг давамгайлж эхэлнэ.

Петртэй адил би ч бас Есүсийн төлөө амиа алдсан ч хамаагүй гэж хоосон ярих хэмжээнд бус, харин өөрийнхөө амийг бөгөөд хүслийг жинхэнээсээ үхүүлэх хүртлээ дагамаар байна. Тэр л алдарших болтугай! Үүнийг гагцхүү Түүний нигүүлслээр л хийнэ. Тэрбээр нигүүлслээ дарууд өгдөг (Иаков 4:6). Тиймээс л Паул хавчлагын талаар Иохан юу хэлснийг үзнэ үү:

Тэд түүнийг Хурганы цус, өөрсдийн гэрчлэлийн үгээр ялжээ. Тэд үхэн үхтлээ амиа хайрлаагүй юм
(Илчлэл 12:11).

Би энэ бичээсийг олон ч сонсож, олон ч ярьж явлаа. Гэхдээ эхний хагасыг нь л. Олон хүн сүүлийн хэсгийг нь орхигдуулдаг. Энэ хэсэг нь манай Барууны соёлд хоцрогдсон бичээс. Бид үхсэн ч хамаагүй, амиа хайрлахаас татгалзахаас нааш айлан сүрдүүлгийн тулаанд ялахгүй. Аминдаа хайртай бол, амиа аврахыг л оролдоно.

Бурханы эрчүүд, эмэгтэйчүүд ээ, та бүхэн үнэнийг мэдлээ: Айлан сүрдүүлгийг ялах цорын ганц зам нь амиасаа татгалзах. Үүнийг уншихдаа, Бурхан руу хашхирч унш. Ухралгүй, итгэх зүрхтэй бай. Зүрхийг чинь чухам энэ хайраараа - хэзээ ч ухардаггүй хайраараа дүүргэж өгөхийг гүй. Тулгарах саадыг даван туулах нигүүлслийг нь Бурханаас гүй. Хүнд хэцүү газраар явах завшааны төлөө Бурханаас гүй. Газар дэлхий дээр Бурханы өрнүүлж буй үйл хэргийн тогоонд буцалж байхын төлөө гүй. Амар хялбар амьдралыг бүү гүй. Харин Түүнийг алдаршуулах амьдралыг гүй.

“ТЭГВЭЛ ЭНЭ ХҮН ЯАХ БОЛ?”

Бүгдээрээ Есүс амилуулагдсан хойноо дагалдагч нартаяа өглөөний хоол бэлтгэж өгсөн түүх рүү дахин буцацгаая. Цайны дараа Есүс Петрт “өрөөл” айлдаагүй ч, Петрийг цаашид өөрийнхөө хүслийг өөрийнхөө хүчээр биелүүлэхгүй, харин хамгийн том айдсаа ялан дийлийн гэсэн амлалт бүхий үгийг хэлсэн. Есүс Петрийг Өөрт нь үнэнч байсныхаа төлөө, итгэлийнхээ төлөө алгуулна гэжээ. Петр өмнө нүүрэлдэж чадахгүй байсан зүйлээ ялан дийлийн. Есүс ирээдүйд бий болох, шинэ Петрийг харжээ. Есүс төгс ажлыг харжээ.

Петр тэр үед ч бэлэн болоогүй л байсан. Өөрт нь юу тохиох талаар сонссоныхоо дараа Петр Иоханыг хараад, Есүсээс: “Тэгвэл Эзэн минь, энэ хүн яах бол?” (Иохан 21:21) гэжээ. Петр өөрийгөө бусадтай харьцуулсаар л байна. Тэр үндсэндээ: “Би тийм зам туулах ёстой юм бол, энэ хүн юу туулах бол?” гэж асуужээ.

Харин Есүс түүнд “Хэрэв Би ирэх хүртэлээ түүнийг байлгая гэж хүссэн ч чамд ямар хамаа байна? Чи Намайг дага” (Иохан 21:22) хэмээн хариуулж.

Өөрөөр хэлбэл: “Чамд юуны хамаатай?! Өөрийгөө бусадтай бүү харьцуул. Зүгээр Намайг л дага” гэжээ. Маш олон хүн амьдрал, үйлчлэлээ бусдын үйлдэл, үгээр хэмждэг. Сантиметр, километрийн хооронд том ялгаа байх шүү. Чуулганы дийлэнх хүмүүс тааллаараа, амар, тухтай амьдардаг. Бид өөрийгөө бусадтай харьцуулахдаа, өөртөө тун дажгүй (үнэндээ тун царцуу) харагдана. “Би олноос дутахгүй л явна” гэдэг нь хуурамч тайтгарал шүү. Үүнд “чи ОК бол, би ч ОК” гэдэг хууран мэхлэл явдаг. Гэтэл бидэнд нэг л жишиг; нэг л хэмжүүрийн нэгж бий. Бид бусад номлогч, чуулган, ах эгч дүүсийнхээ жишигээр явахгүй. Есүс л бидний жишиг болой! Есүс Петрт Иоханыг дага гэж хэлээгүй. Есүс Петрт “Намайг дага!” гэсэн.

Есүс өөрийгөө няцаасан замаар явжээ. Есүсийг дагах хүсэл, санаатай байх нь хангалтгүй. Үйлдэх ёстой! Дараахыг уншина уу:

Тэрээр хурсан олныг шавь нарынхаа хамт дуудаж тэдэнд хандан —Хэн нэг нь Миний араас дагахыг хүсвэл тэр

өөрийгөө үгүйсгэн, загалмайгаа үүрч Намайг дага. Хэн амиа аврахыг хүснэ, тэр түүнийгээ алдана (Марк 8:34-35).

Есүс амиа аврахыг хүсэхийн төдийд л амиа алдана гэж хэлснийг тэмдэглэнэ үү! Айхтар байгаа биз! Энэ дэлхийн хөөцөлддөг юмыг хүсэхэд л - бүр хэзээ ч олж авч чадахгүй байсан ч - амиа алдах нь байна. Тийм боловч, Есүс цааш нь юу хэлснийг үзнэ үү:

Харин хэн Миний төлөө, сайнмэдээний төлөө амиа алдана, тэр түүнийгээ аварна (Марк 8:35).

Есүс Миний төлөө амиа алдахыг хүссэн хүн гэж хэлээгүйг бас тэмдэглээрэй. Хүсэх нь хангалтгүй! Петр Есүсээс уrvасан шөнөө уг нь Есүсийг дагахыг л хүсч байсан. Гэвч сэдэл нь Бурханы хайраар юмуу хүчээр бэхжээгүй байсан тул ялагджээ.

Зүрхээ шалга

Үүнийг уншихдаа, сэдлээ шалгана уу. Та Есүс Христийн жинхэнэ дагалдагч уу эсвэл Түүнийг өөрийнхөө тогтоосон параметр дотроо л дагадаг уу? Та амиа золиос болгох хил хязгаараас хaa хол - хувийнхаа хил хязгаар дотор үлдэж байна уу? Энэ хил хязгаар чинь таныг Есүсийн явдаг замаас хорьсоор, эцэстээ тэнцэхгүй байхад хүргэх боломжтой юу? (2Коринт 13:5)

Есүсийг дагах уу үгүй юу гэдгээ шийдэхийн тулд эхлээд үнэ өртгийг нь мэд. Тийм ээ, та зөв ойлголоо. Энэ амьдрал өндөр өртөгтэй амьдрал шүү. Амийг чинь авна л гэж мэд. Есүс Өөрийг нь дагах хүсэлтэй хурсан олонд яг ингэж хэлэхийг сонс доо:

Есүстэй хамт үй олон хүн явж байв. Тэр эргэн тэдэнд — Хэрэв хэн нэг нь Над дээр ирж, өөрийн эцэг эх, эхнэр хүүхэд, ах эгч дүүсээ төдийгүй өөрийн амийг хүртэл үл ойшохгүй бол тэр Миний шавь байж чадахгүй. Загалмайгаа үүрэлгүй Намайг дагагч нь Миний шавь байж чадахгүй. Та нарын хэн чинь цамхаг барихыг хүсвэл эхлээд суугаад, үүнийг дуусгахтайгаа юу хэмээн зардлыг нь тооцоолохгүй вэ? Эс тэгвээс, суурийг нь тавьчихаад

АЙЛГАН СҮРДҮҮЛГИЙГ ЯЛАХУЙ

дуусгаж чадахгүйг нь харсан бүхэн түүнийг шоолж, “Энэ хүн барьж эхэлсэн ч дуусгаж чадсангүй” гэх болно. Иймээс та нарын хэн нь ч байгаа бүхнээсээ эс татгалзваас Миний шавь байж чадахгүй (Лук 14:25-30, 33).

Эцсээ хүртэл тэвчихийн үнэ өртөг энэ. Ялагч нар үхэх хүртлээ амиа хайлраагүйг бид Илчлэл номоос уншсан. Харамсалтай нь, өнөөгийн Америкийн чуулгануудыг ингэж дурслэх боломжгүй.

Амь амьдралынхаа эзэн суусаар байгаа эрчүүд эмэгтэйчүүдийн олон жишээг би хэлж чадна. Намайг пастораар үйлчилж байхад, нэгэн залуу бүсгүй: “Жон пастор аа, би өөртөө таалагддаггүй. Намайг өөртөө таалагддаг болохын төлөө залбирч өгөөч” гэж гомдоллож билээ.

Тэгэхэд нь би түүн рүү хараад: “Наадах чинь чиний асуудал!” гэж хэлсэн юм.

Эмэгтэй баахан гайхав. Тэрбээр намайг зөвлөгөө өгөөд, дараа нь залбирч өгнө гэж бодсон болтой. Тэрбээр намайг өөрийг нь тайтгаруулахын тулд эелдэг зөвлөн хандана гэж бодсон болтой. Гэтэл миний хариулт түүнийг үсэртэл нь алгаджээ. Үндсийг нь шийдвэрлэхгүйгээр асуудлаа хүүрнэх нь бус, үнэн л биднийг чөлөөлнө.

Би түүнээс асуулаа: “Библийн хаана нь өөрийгөө үнэл, өөртөө таалагд гэж байна? Есүс биднийг Өөрийг нь дагахын төлөө үхэх ёстой гэсэн! Үхсэн хүн авсан дотроо өндийж суугаад: “Хөө, та нар надад юу өмсгөчихөө вэ? Таалагдахгүй байна! Үсийг минь яасан онцгүй янзлаа вэ? Хүмүүс юу гэж бodoх бол?” гэж хэлдэггүй.

Би түүнд өөрийгөө үнэлэх үнэлгээ, өөртөө таалагдах талаар Библи өгүүлдэггүйг харуулахыг хүсэв. Өөртөө таалагдах нь Есүсийг хайлрлаж, дагах шаардлага биш. Тэр бүсгүй мөнхийн бус, зуурдын юмс дээр төвлөрчээ.

Бид өөрөө өөртөө таалагдаж - сэтгэл санаа баяртай, ажил үйлс маань бүтэмжтэй сайхан байгаа цагт л Бурханд үйлчилнэ гэж үгүй. Бид ийм хүмүүсийг “сайн цагийн нөхөд” гэдэг. Үүнтэй адил зөвхөн сайн цагийн Христэд итгэдэг хүмүүс гэж байна. Тэд ухаалаг бус хүмүүс. Тэд эрт, орой хэзээ нэгэнтээ дургүй зүйлтэйгээ тулах л болно. Үүнд бэлтгэлгүй байсан хүмүүс шууд ухардаг. Тэд чуулгандаа явсаар, арван хувь, өргөлөө өргөсөөр, хэлээрээ ярьсаар, ухаантай зөв юм өгүүлсээр байж болох ч,

зүрхэндээ Бурханы мөрөөр явахаа болжээ. Бурханы хайр хязгааргүй. Бид Бурхантай хамт алхах бол, хязгаараа таягдах хэрэгтэй.

Өөрчлөгдсөн хүн

Үйлс номын Петрийг үзэх юм бол, зарц нарын өмнө хулчийгаад, Есүсийг няцаасан этгээд мөн гэдэгт итгэж ядмаар. Тэрбээр Ариун Сүнсээр дүүрэхдээ, Есүс бол Эзэн бөгөөд Мессаиа мөн болохыг Иерусалим даяар эр зоригтой тунхагласан. Түүнийг баривчлаад, Есүсийг цовдолсон удирдагч - тахилч нарын өмнө авчирсан. Ийнхүү тэрбээр зарц нарын өмнө бус, харин Есүсийг ялласан зөвлөлийн өмнө зогсов. Петр тэдэн рүү зоригтой хараад “Та нар Мессаиа Есүс Христийг цовдолсон бөгөөд Түүнээс өөр хэний ч дотор аврал үгүй” (Үйлс 4:8-12) хэмээн тунхаглажээ.

Петр, Иохан нарын эр зориг зөвлөлийг алмайруулж, тэд Бурханы үйлсийн өөдөөс юу ч хэлж чадаагүй. Тэр хүмүүс хянан захиргаадахын мастерууд байсан тул айлган сүрдүүлэх ажилдаа оржээ.

Тэд өөр хоорондоо “Ямар хүч, ямар нэрээр та нар үүнийг үйлдэнэ вэ?” (Үйлс 4:7) гэлцэв.

Тэр удирдагч нар Есүсийг цовдлоод удаагүй байгааг санаарай. Мөн Есүс Петрийг Өөртэй нь адилхан алуулна гэдгийг хэлчихсэн байсан. Тэгэхээр энэ бүхэн нь хоосон сүрдүүлэг байгаагүй. Петр, Иохан хоёр алуулж болохо ч мэдсээр байж “Та нарыг Бурханаас илүү сонсох нь Бурханы өмнө зөв үү? Өөрсдөө шүүн тунгаагтун. Учир нь бид үзсэн, сонссоноо ярихаа зогсоож чадахгүй” (Үйлс 4:19-20) хэмээн аймшигтгүй хэлжээ.

Иоханыг эс тооцбол, Петр зөвлөлийн өмнө ганцаараа байсан. Эдүгээ түүнд гайхуулаад байх юмуу араас нь дэмжээд өгөх хэн ч байхгүй. Гэтэл энэ удаа Петр тэс өөр эр зоригтой болжээ. Тэрбээр Есүсийн хайраар дүүрчээ. Иохан, тэр хоёр суллагдаж, бусад дагалдагч нартайгаар учран золгоод, юу болсон, ямар заналхийлэл ирсэн талаар бүгдийг ярьжээ. Үүний дараа тэр эрчүүд Бурханаас юу үйлдэхийг гүйсныг үзнэ үү:

Одоо Эзэн, тэдний заналхийллийг хараач. Таны үгийг ярих зоригийг боолууддаа соёрооч. Таны ариун зарц Есүсийн нэрээр эдгээх гайхамшиг ба тэмдгүүдийг үйлдүүлэхийн тулд Та мутраа сунгаач гэв (Үйлс 4:29-30).

Тэр эрчүүд өөрсдийг нь асуудалд оруулсан яг тэр зүйлийг улам ихээр гүйжээ. Сайн мэдээг номлох нь амь насыг нь эрсдэлд оруулахыг тэд мэдэж байсан. Тийм боловч үргэлжлүүлэн номлосоор байсан бөгөөд Бурхан ч аугаа гайхамшгаа итгэмжтэйгээр үргэлжлүүлэн үйлдсээр байв. Тэд айж сүрдэж, Бурханы бэлгийг унтраагаагүй. Үнэндээ Бурханы хүч хэт хүчтэй байсандаа, Петрийг явж өнгөрөхөд сүүдрийнх нь тусгалаар эдгээх гэж Иерусалим хотын гудмаар өвчтэй, зовлонтой хүмүүсийг дамнуурга дээр өрж тавьдаг байжээ (Үйлс 5:15).

Тэргүүн тахилч, зөвлөлийнхөн ч яахав - айлган сүрдүүлэхдээ гарамгай улс. Тэд дагалдагч нарыг баривчлуулаад, шоронд хийж дөнгөв. Тэгээд тэргүүн тахилч “Энэ нэрээр сургаал заахгүй байхыг бид та нарт хатуу тушаасан. Гэтэл хараач, та нар Иерусалимыг сургаалаараа булж орхиод тэр хүний цусыг бидэнд нялзаахыг бодож байна” (Үйлс 5:28) гэсэн.

Гэтэл Петр үүнд нь мөн л эрэлхэгээр хариулжээ:

Бид хүнээс илүүтэйгээр Бурханд дуулгавартай байх ёстой. Та нар Есүсийг модонд өлгөж алсан ч Түүнийг өвөг дээдсийн маань Бурхан амилуулсан билээ. Израильд гэмшил ба нүглийн училал соёrhoхын тулд Бурхан Түүнийг Эхлүүлэгч хийгээд Аврагч болгон баруун гартаа өргөмжилсөн. Эдгээрийн гэрч нь бид төдийгүй, Түүнд дуулгавартай байгсдад Бурханы өгсөн Ариун Сүнс юм (Үйлс 5:29-32).

Юутай эр зориг вэ! Дагалдагч нар аиж сүрдэхгүй гэнэ. Петр амиа хайрлахаа болжээ. Амиа бодохоос чөлөөлөгдөж, Ариун Сүнсээр дүүрчээ. Зүрхэнд нь Бурханы хайр давалгаалж байна. Ром 5:5 дээр “Найдвар нь биднийг гонсойлгодоггүй. Учир нь бидэнд өгөгдсөн Ариун Сүнсээр дамжин Бурханы хайр зүрхэнд маань цутгагдсан байдаг” гэдэг.

Ариун Сүнс Бурханы хайрыг бидний амьдралд авчирдаг нь тодорхой ажээ. Түүнчлэн дагадаг хүмүүст л Ариун Сүнс

өгөгддөг болох нь Петрийн үгээс тодорхой байна. Дэндүү олон итгэгч дагахгүй атлаа хайрыг хүсдэг.

Хэлээр ярих нь Бурханы хайр зүрхэнд чинь нутаглаж буйн баталгаа болохгүй. Ариун Сүнсээр дүүрэх нь ганц удаагийн явдал биш. Бичээсийг цээжээрээ мэддэг, хэлээр дуржигнатаал ярьдаг эсэх чинь хамаагүй. Бурханы өмнө дуулгавартай амьдрахгүй бол, хайр чинь хөрнө. Хайр дуулгаваргүй үйлдэл бүртэй хамт ширгэх!

Есүс “Ёс бус явдал өссөнөөс болж олонхын хайр хөрнө” (Матай 24:12) хэмээн айлдсан билээ. Есүс чухам агалэ хайрын тухай өгүүлрүүн. Есүсийг хүлээж авсан хүмүүс л энэ хайрыг эзэмшдэг. Сүнсээр дүүрсэн атлаа Сүнсний жинхэнэ хайраар хомдох боломжтой!

Петр, Иохан хоёрын дуулгавартай байдал нь тэдэнд үлэмж эр зориг өгч, зүрхийг нь хайраар дүүргэжээ.

Тэд элч нарыг дуудаж авчран, ташуурдаад Есүсийн нэрээр дахин ярихгүй байхыг тушааж, тэднийг суллав. Түүний нэрийн төлөө доромжлогдон зовох нь зохистой гэж тооцогддогт баярлалдан тэд Зөвлөлөөс гарч явлаа (Үйлс 5:40-41).

Петр, Иохан хоёр удирдагч нараас айж сүрдэх нь бүү хэл, үнэндээ дотроосоо баярлажээ. Тэд цэцэрлэгт унтаж байсан хоёр дагалдагчаас тэс өөр болжээ. Тэд Эзэндээ хэрэгтэй байгаадаа, хайр, итгэмжтэй байдаа дахин харуулах шинэ боломждоо баясан хөөрч байв. Эдүгээ Петр зөвхөн мэдрэмжээрээ бус, харин эд эс, байгаа бүхнээрээ хайлрадаг болжээ.

Фоксын “Дэлхий даяар Христэд итгэх итгэлээсээ болж алуулсан хүмүүс” номд Есүсийн айлдсанаар Петр итгэлээсээ болж алуулсан тухай тэмдэглэсэн байдаг. Түүнийг цовдлохын өмнө Петр “Би Эзэн шигээ үхэх хувьгүй” гэж хэлсэн тул хүмүүс түүнийг урвуу нь харуулж цовдолжээ. Петр энэ дэлхийгээс ялан дийлэгч болоод явжээ.

Хэнээс айна - түүгүндээ үйлчилнэ.

Арван нэгдүгээр бүлэг

БУРХАНААС ЭМЭЭХ, ХҮНЭЭС АЙХ

Бидний сурсан бүхэн маань эдүгээ айлган сүрдүүлгийг ялах амин чухал энэхүү бүтэц дээр авчирлаа. Энэ нь зүйл айлган сүрдүүлэгтэй нүүр тулахад төдийгүй, амьдралын бүхий л талбар дээр чухал! Би Эзэнээс эмээхүй тухай ярж байна.

Чулган Эзэнээс эмээхүйг ойлгодоггүй. Гэтэл энэ нь Христэд итгэх ялгуусан амьдралын амин чухал бүтэц учраас, харамсалтай яа. Исаиа Есүсийн тухайд “Таалал нь ЭЗЭНээс эмээхүйд. Тэр нүдэндээ үзэгдсэнээр шүүхгүй, Чихэндээ сонсогдсоноор шийдэхгүй” (Исаиа 11:3) гэсэн. Түүний баярладагт бид баярлах ёстой!

ЭЗЭНээс эмээдэг хүн хэн юм бэ? Түүнд тэрээр сонгох ёстой замыг нь зааварчилна (Дуулал 25:12). Сэтгэл нь сайнд оршиж, Үр удам нь газар нутгийг эзэгнэх болно (Дуулал 25:13).

ЭЗЭНээс эмээхүй нь Мэргэн ухааны эхлэл. (Дуулал 9:10, 1:7, 2:5). ЭЗЭНээс эмээхүй нь амьдралыг уртасгах (Сургаалт үгс 10:27). Ариуслыг мөшгөгтүн. Үүнгүйгээр хэн ч Эзэнийг үзэхгүй (Еврей 12:14, 2Коринт 7:1). Эзэнээс эмээхүйн талаар хэлсэн Библийн үгсээс цөөн хэд нь л энэ.

Айлган сүрдүүлгээс бүрэн эрх чөлөөтэй байх цорын ганц арга нь Эзэнээс эмээхүй болой. Библи “Эзэнээс эмээхүй дотор бат итгэл байдаг” (Сургаалт үгс 14:26) гэдэг. Бат итгэл нь хүний замаар бус, Бурханы замаар явах эр зориг өгнө. Бурханаас эмээх, хүнээс айхын ялгааг үзье.

Эзэнээс эмээхүй, хүнээс айхыг тодорхойлъё

Нэгдүгээрт - Бурханаас эмээхүй гэж юу вэ? Үүнд наад зах нь ядаж Бурханыг хүндэтгэх явдал орно. Бурханаас эмээхүй гэдэг нь Бурханд бүрэн эрхэт алдар, хүндэтгэл, эрхэмлэл, талархал, магтаал, өргөмжлөлийг нь өргөх (Өөрсдийнхөө бодсоны дагуух хэмжээгээр бус, харин Бурханы авах бүрэн эрхийнх нь дагуу гэдгийг тэмдэглээрэй). Бид Бурханыг Өөрийг нь, хүсэл сэтгэлийг нь өөрийнхөө хүслээс дээгүүр үнэлэхдээ, Бурханыг дээрх байр сууриинд залдаг. Бид Бурханы үзэн яддагийг үзэн ядаж, хайрладгийг нь хайлаж, Түүний оршихуй, Үгд чичирнэ.

Хоёрдугаарт - хүнээс айх тухай үзье. Хүнээс айх гэдэг нь мөнх бус хүний өмнө хулчигнах, айн түгших, зовних, балмагдах, аиж тэвдэх, аиж сэrdэх юм. Энэ айдсын хавханд орсон хүн гологодооос, нүүрэлдэхээс байнга зайлхийж, цаг үргэлж хор хохирол, зэмлэлээс нуугдан, зугтаж амьдардаг. Зогсоо зайдгүй өөрийгөө хамгаалан, хүмүүст үйлчлэх учраас, Бурханд ч үр дүнтэй үйлчлэхгүй. Хүн намайг яачих бол гэхээс айсандаа, Бурханд авах ёстой зүйлийг нь ч өгч чадахгүй.

Библи бидэнд “Хүнээс айх айдас нь урхинд унагах” (Сургаалт үгс 29:18) гэдэг. Урхи нь занга, хавх юм. Хүнээс айх айдас нь Бурханаас хүлээж авсан эрх мэдлийг чинь хулгайлдаг. Таны доторх Бурханы бэлэг унтарна. Бурханы хүч идэвхигүй болсон болохоор та зөвийг үйлдэх хүчгүй болно.

Исаиа 51:7-13 дээр “Үнэн зөвийг мэддэг, Зүрхэнд нь Миний хууль буй ард түмэн Намайг сонсогтун. Хүний зэмлэлээс бүү ай. Доромжлолоос нь бүү эмээгтун. ...Үхэх хүмүүнээс айн, Өвс мэт өгөгдсөн хүний хөвгүүнээс эмээх чи хэн бэ? Бүтээгч ЭЗЭНээ чи мартан...” хэмээн анхааруулжээ.

Хүн бид нүүр тулахаас айхдаа Эзэнээ мартдаг. Түүний үйлчлэлээс холддог. Учир нь “Хэрэв би эдүгээ хүргэл хүмүүст таацуулсаар байсан бол би Христийн зарц биш байх байсан” (Галат 1:10).

Бид аиж байгаа хүндээ үйлчилж, түүнийг дагана! Та хүнээс айдаг бол, хүндээ л үйлчилнэ. Та Бурханаас эмээдэг бол, Бурханд л үйлчилнэ. Хүнээс айдаг байж, Бурханаас эмээнэ гэж үгүй. Учир нь та хоёр эзэнд зэрэг үйлчилж чадахгүй! (Матай 6:24) Нөгөөтэйгүүр, та Бурханаас эмээдэг бол, хүнээс айхгүй!

Шинэ гэрээний итгэгч хүмүүс Бурханаас эмээх ёстой юу?

Эзэнээс эмээхүй нь Хуучин гэрээний ухмэл доктрин биш юм. Энэ нь амьдрах арга зам билээ. Та Бурханд хайртай бол, давхар Түүнээс эмээнэ. Эзэнээс эмээбэл, айдсыг залгих чинь багасна.

Хүмүүс Бурханыг тушаал гүйцэтгэдэг хүүхэд шиг ярихаар миний сэтгэл өвддөг юм. Бурханы талаар ийм маягаар ярьдаг хүн Эзэнийг жинхэнээсээ мэдэхгүй байгаа хэрэг. Есүсийн хамгийн дотны дагалдагч нар ч Түүнийг Эзэн, Эзэнтэн хэмээдэг байсан (Иохан 20:28). Бид Эзэнд “Аа, мэднэ мэднэ” гэх маягаар хандаад ирэхээрээ л Түүнийг зохих ёсоор нь хүндэтгэхээ больдог.

Ийм хандлага нь биднийг ямар ч хүндэтгэлгүй болгоно. Үүнийг “итгэгчдийн” хувийн амьдрал дотор ч, чуулган дотор ч харж болно. Тэд өөрийгөө итгэгч гэдэг ч, итгэгч гэдгийг нь амьдралын хэв маяг нь харуулж байна уу? Чуулганы хүмүүс олонтаа гашуудмаар, гашуудмаар зан авир гаргадаг. Чуулган эхлэхээс өмнө тэд өөр хоорондоо суудлаа булаалдана эсвэл суудал дээр нь хүн суучихлаа гэж гомдоллоно. Бас цуглаан дундуур ярина. Мөн цуглаан хэт удаан байна гэж үзэхээрээ эсвэл номлолд дургүй байхаараа, цуглаан дундуур босоод л явчихна.

Пастораа илт хүндэтгэхгүй байгаа нь ч гашуудмаар. Тэд пасторынхаа талаар яг л хэвлэл мэдээгээр улс төрчдийн талаар ярьж байгаа юм шиг л ярина. Магадгүй, пасторууд нь өөрсдөө Бурханы хүн шиг бус, харин улс төрч шиг авирласан байж болох. Тийм боловч тэд Бурханы зарц хэвээрээ бөгөөд Бурхан Өөрөө тэднийг шүүнэ. Бурханаас эмээдэг хүн Бурханы гэрийг ч, зарц нарыг ч хүндэтгэнэ. Саул хаан Бурханы наян таван тахилчийг алчихаад байхад ч, Давид түүнийг Бурханаар тослогдсон хүн гэж үзээд, өөдөөс нь гар далайгаагүй байдаг (1Самуел 22:11-23). Давид Бурханаас айдаг байж!

Итгэгч хүмүүсийн сонсож, үзэж, уншиж байгаа юмс нь намайг гашуудуулдаг. Зарим айлд орохоор тэдний амьдрал дэлхийгээс ямар ялгаатай гэж гайхмаар. Тэд тэнцвэртэй байх гэж, хүмүүст таалагдах гэж, хэвийн амьдрах гэж чармайхдаа, дэлхийн “хэвийн” гэж үздэг юмсыг Эзэн “хэвийн” гэж үздэггүйг мартжээ. Бурханд жинхэнээсээ хайртай, Түүнээс эмээдэг хүн дэлхийн амьдралаар бус, зориулагдсан амьдралаар амьдарна.

Петр ч үүнийг ухуулан ятгажээ:

Харин та нарыг дуудсан Ариун Нэгэний адил өөрсдийн бүх л зан байдалдаа бас ариун байгтун. Яагаад гэвэл “Би ариун учраас та нар ариун байгтун” гэж бичигдсэн юм. Та нар ялгаварлалгүйгээр хүн бүрийг үйлсийнх нь дагуу шүүдэг Нэгэнийг Эцэг гэж дууддаг юм бол, энд байх хугацаандаа эмээн биеэ авч яв (1Петр 1:15-17).

Бурханаас эмээхүй нь биднийг бурханлаг бус байдлаас сахин хамгаалах хамгийн том хөдөлгүүр мөн билээ.

Чуулган аиж байна уу?

Үйлс 2 дээр дагалдагч нар Ариун Сүнсээр дүүрээд, хэлээр ярьж, эш үзүүлсэн байдаг. Тэд хэт дүүрсэндээ, согтуу хүмүүс шиг болцгоожээ. Тэр шинэ итгэгчдээс инээд, баяр хөөр асгарсан. Бурхан тэднийг бэхжүүлж, сэргээж байв. Бурхан ингэх дуртай. Тэрбээр дүнсгэр харанхуйд дуртай, шийтгэгч Бурхан бус, харин хайр, өршөөл, зөвт байдал, амар тайван, баяр хөөрт дуртай Бурхан.

Ийнхүү хэдхэн өдрийн дотор олон хүн аврагдав. Гэвч тэр шинэ итгэгчдийн зарим нь Эзэнийг Өөрийг нь хайж бус, харин Эзэний ерөөлийг горьдож иржээ. Иймээс тэд адагтаа Бурханыг зохих ёсоор нь хүндэтгээгүй. Яваандаа тэд Бурханыг “мэднэ, мэднэ” гэдэг болжээ. Энэ байдал нь тэднийг Бурханы юмст байdag л юмс шиг ханддаг болоход хүргэсэн байна. Тэд Бурханы оршихуйд ч, үгд ч чичрээгүй. Үйлс 5-аар бүлэг дээр үүний нотолгоо бий.

Эр, эм хоёр зарсан газрынхаа үнийн дүнгээс өргөл болгон авчиржээ. Тэд газраа зарсан бүх мөнгөө өгөөгүй ч, бусад итгэгчдийн нүдэнд мундаг харагдахыг хүсчээ. Тэд үнэнээс илүү үзэмжийг хүндэтгэж, Бурханаас илүү хүнээс аижээ. Тэд өргөлөө авчраад, худлаа яриад (ийм төрлийн худлыг ихэнх хүмүүс цагаан худал гэж үздэг), ухэдхийн унасан.

Тэд Бурханы алдрын оршихуйд дор худлаа ярьсан учраас, үхжээ. Би “Хүмүүс номлогчдод зөндөө л худлаа ярьдаг. Гэхдээ үхдэггүй шүү дээ. Яагаад?” гэж их боддог байж билээ. Ганц би

ч гэлтгүй, та ч ингэж бодож байгаа байх.

Тэгэхээр, миний бодлоор Үйлс номын үед Бурханы оршихуй өнөөдрийнхөөс хавьгүй хүчтэй байж. Жишээлбэл, Петрийг Иерусалимын гудмаар явж өнгөрөхөд, сүүдэр нь туссан өвчтэй хүмүүс эдгэрсэн тухай Үйлс дээр гардаг (Үйлс 5:15). Гэтэл өнөөдөр ийм гайхамшиг харагддаггүй.

Бурханы оршихуй, алдар өсөхөд Үйлс 5 дээр гардагтай адил гайхамшиг болно гэдэгт би итгэдэг. Нөгөө эр, эм хоёрыг үхэхэд юу болсныг тэмдэглэнэ үү.

Чуулган даяар, энэ бүхнийг сонссон бүгд дээр үлэмжийн айdas ноёлов (Үйлс 5:11).

Эзэнээс эмээх гүн эмээхүй, хүндэтгэл сэргэжээ. Хүмүүс Бурханы оршихуй, тосолгоонд хандах хандлагаа дахин нэг эргэцүүлж, дахин нэг ухаарав.

Бурхан “Надад ойртон ирэгсдээр дамжин Би Өөрийгөө ариун хэмээн үзүүлж, бүх ард олны өмнө Би алдаршуулагдах болно” (Леви 10:3) хэмээн айлдсан.

Бурхан чимээгүй байх үед бидний зүрх илчлэгддэг

Бурхан биднийг шалгаж, бэлтгэхээр алдраа татах үе бий. Оршихуй нь харагдахгүй үед ч бид Бурханыг эмээн хүндэтгэсээр байх нь уу? Өнөөгийн чуулган олон талаараа Израилийн хүүхдүүд шиг л авирладаг. Үнэндээ Паул Израилийг хүүхдүүдийг бидэнд үлгэр жишээ болгох үүднээс бичсэнийг хэлсэн билээ (1Коринт 10:6).

Бурхан ерөөж, гайхамшиг үйлдэж байгаа цагт Израилийн хүүхдүүд баяртай байсан. Бурхан Зэгсэн тэнгисийг яран, тэднийг хуурай газраар гаргаад, дараа нь дайснуудыг нь булашлахад, Израильчууд дуулж, бүжиглэж, ялалтын уухайгаа хадаасан (Гэтлэл 15:1-21). Тийм боловч хэдхэн өдрийн дараа Бурханы хүч харагдахгүй, хоол унд хомсдоход нөгөөдүүл чинь Бурханд гомдоллосон (Гэтлэл 15:22).

Хожим Мосе хүмүүсийг Бурханд өргөхөөр Синай ууланд

авчирдаг. Бурхан хүмүүсийг харж байхад нь уулан дээр бууж ирэв. Энэ нь аянга, цахилгаан нижигнүүлж, уулыг өтгөн үүлсээр бүрхсэн, үнэхээрийн бишрэхүйеэ үйл явдал байлаа. Дараа нь Моше хүмүүсийг Бурхантай уулзуулахаар хуарангаас нь гаргаж авчирсан ч, “хүмүүс энэ бүхнийг үзээд, бэмбэгнэн холуухан зогсчээ (Гэтлэл 20:10-18). Тэд Бурханаас эмээсэндээ бус, үхэхээс айсандaa айдаст автан, ухарсан байна. Бурхан бууж ирэхдээ, тэднийг Өөрийг нь хайрлахаасаа илүү өөрийнхөө аминд хайртай болохыг нь ойлгожээ.

Тэд Мосед “Та бидэнтэй яриач. Бид сонсьё. Харин Бурхан бидэнтэй бүү яриг. Эс тэгвэл бид үхнэ” гэж хэлэхэд, Моше тэдэнд “Бүү ай. Учир нь Бурхан та нарыг зөвхөн шалгахын тулд ирсэн. Мөн Түүнээс эмээхүй нь та нарт байж та нарыг нүгэл бүү үйлдээсэй гэсэндээ ирсэн юм” (Гэтлэл 20:19-20) гэж хэлжээ.

Бурханаас эмээхүй нь нүглийг ялах хүчийг өгдөг болохыг тэмдэглээрэй. Сургаалт угс 16:6 дээр “ЭЗЭНЭЭС ЭМЭЭВЭЭС ЁР МУУГААС ЗАЙЛНА” гэдэг.

Гэтлэл 20:21 дээр “Бурханы байгаа түнэр харанхуйд Мосег ойртон очих үед ард түмэн хол зогсож байв” гэдэг. Моше Бурханд хүмүүсийн үгийг дамжуулаад, хэрхэн аиж байгаа тухай хэлтэл, Бурхан “Энэ ард түмний чамд хэлсэн үгийг Би сонслоо. Тэдний хэлсэн бүхэн зөв зүйтэй. Тэдний зүрх хэвээр үлдэж, Надаас үргэлж эмээж, Миний бүх тушаалыг сахин тэд бас тэдний хүүхдүүд үүрд сайн сайхан байх болтугай!” (Дэд хууль 5:28-29) хэмээн хариулжээ.

Мосе ойртох байхад, хүмүүс холдож байгааг тэмдэглээрэй. Эндээс Моше, Израилийн ялгааг харж болно. Моше Бурханаас эмээсэн учраас, юунаас чайгаагүй. Хүмүүс Бурханаас эмээгээгүй учраас, айсан. Бурханаас айх айдас Бурханы оршихуйгаас холдуулах бус, ойртуулдаг. Харин хүний айдас таныг Бурханы алдраас холдуулна.

Хүнээс айх айдаст баригдсан хүн Бурханы оршихуйд бус, хүний хажууд л байх дуртай! Чуулган дотор ч тэр. Үүний учир нь: Бурханы оршихуй бидний зүрхийг задалж, ял зэмлэл авчирдаг.

Синай бус, Сион

Эзэнээс эмээхүй нь Шинэ гэрээний ойлголт гэдгийг батлахын тулд Еврей номын үйл явдлыг үзэх хэрэгтэй:

Учир нь та нар хүрч болох уул өөд мөн дүрэлзэх гал, харанхуй, түнэр харанхуй, хуй салхи, бүрээн хүнгэнээн ба угсийн дуу чимээ уруу ирээгүй. Үүнийг сонсогчид нь дахин үг бүү айлдаач хэмээн гүйж байсан юм. Учир нь тэд “Амьтан ч гэсэн ууланд хүрэх аваас түүн уруу чулуу шидэгтүн” гэсэн журмыг тэвчиж чадаагүй юм. Энэ үзэгдэл аймшигтай байсан тул Мose “Би айдаст автаж, чичирсэн” гэв. Харин та нар Сион уул, амьд Бурханы хот, тэнгэрлэг Иерусалим уруу, баярын цугларалт дахь үй түмэн тэнгэрэлч нар... (Еврей 12:18-22).

Бидэнд эхлээд Синай ууланд болсон явдлыг сануулжээ. Дараа нь бидний ирсэн Сион уулын тухай хэлжээ. Бурхан газар дээр Синай уулан дээрээс ярьсан. Дараа нь тэр л Бурхан тэнгэрээс Сион хэмээх энэ шинэ уулан дээрээс ярьж байна.

Айлдагчийг үл хэрэгсэхээс та нар сэрэмжил. Учир нь газар дээр тэдэнд сануулсан нэгнийг тэд үл хэрэгсэх үедээ зугтаагүй бол тэгэх тусмаа тэнгэрээс сануулагч Түүнээс бид нүүр буруулан зугтаж чадна гэж үү? (Еврей 12:25)

“Тэгэх тусмаа” гэдэг үгийг тэмдэглэнэ үү! Бид Бурханы дуу хоолойг сонсохгүй, дуулгавартай дагахгүй бол, шүүх маань хавьгүй хүнд байх нь байна. Шинэ гэрээн дор бидэнд өгөгдсөн нигүүлсэл нь биднийг дураараа амьдрахад зориулагдаагүй ажээ. Израильчууд яагаад Түүний дуу хоолойд анхаараагүй вэ? Тэд Бурханаас айгаагүй. Үргэлжлүүлэн уншихдаа үүнийг санаж явбаас, шинэ гэрээний дорх хүмүүс сонсдоггүй нь мөн л ижил шалтгаантай болохыг тодорхой харна:

Тиймээс бид үл ганхах хаанчлалыг хүлээн авсан тул талархалаа илэрхийлцгээе. Үүгээр хүндлэл, айdas бүхий тааламжит үйлчлэлийг Бурханд өргөх юм (Еврей 12:28).

“Хүндлэл, айдас бүхий” гэснийг тэмдэглээрэй. Бурханаас эмээхүй нь хүндэтгэлээр хязгаарлагддаг байсан бол, бичээч бурханлаг эмээхүйг тусад нь нэр цохож хэлэхгүй л байсан болов уу. Түүнчлэн бичээч “Манай Бурхан бол хайр” гэж хэлэлгүй, харин “Бидний Бурхан бол залгигч гал” гэж дүгнэсэн байхыг тэмдэглээрэй. Бурханы талаарх энэ мэдэгдэл нь Израилийн хүүхдүүдийн Бурханы оршихуйгаас ухарсан шалтгаантай адилхан байна. “Тэгэхээр бид одоо юунд үхэх ёстой юм бэ? Энэ их гал биднийг залгина. Хэрэв бид ЭЗЭН Бурханыхаа дууг цааш нь сонсвол ухнэ” (Дэд хууль 5:25). Бурхан өөрчлөгдөөгүй! Тэрбээр ариун хэвээрээ, залгигч гал хэвээрээ!

Бид сул хайрыг номлодог. Үүнд биднийг зориулагдсан амьдрал руу хөтлөх хүч байхгүй. Энэ бидний галыг унтрааж, царцаасан. Бид аавыгаа хүндэтгэдэггүй, цадиггүй хүүхдүүд болсон! Бид Эзэнээс эмээхгүй бол, Бурханыг “мэднэ, мэднэ” гэдэг болж, Түүний ариунд тооцдог юмыг байдаг л юмс шиг үзэж эхэлнэ.

Түүнчлэн “Тиймээс бид үл ганхах хаанчлалыг хүлээн авсан тул талархлаа илэрхийлцгээе. Үүгээр хүндлэл, айдас бүхий тааламжит үйлчлэлийг Бурханд өргөх юм” (Еврей 12:28) гэснийг тэмдэглээрэй. Нигүүлсэл нь бидний хүндэтгэлгүй хандлага, нүглийг хайцаалахын төлөө өгөгдөөгүй, харин Бурханд зохистой үйлчлэх хүчтэй болгохын төлөө өгөгдсөн билээ. Гагцхүү хүндэтгэл, бурханлаг айдас бүхий хайраар л Бурханд зохистой үйлчлэх боломжтой.

Үүнтэй холбогдуулан Паул бас “Иймээс хайртууд минь, та нар үргэлж дуулгавартай байсныхаа адил, зөвхөн намайг байхад ч биш, харин эдүгээ байхгүй байхад минь бүр илүүгээр өөрсдийн авралыг айдас ба чичрэлээр гүйцээ” (Филиппой 2:12) гэсэн билээ. Бидний айдас чичрэл хаана байна? Бурхан Шүүгч гэдгийг бид мартаа юу? Түүний шүүхийг мартаа юу? Дараах ятгалгыг анхааралтай уншина уу:

Тийм ээ, тэд итгэлгүйдээ тастагдсан бол та итгэлээрээ зогсож байна. Бүү дээгүүр санаарх харин эмээ. Хэрэв Бурхан төрөлх мөчруүдийг хэлтрүүлээгүй бол таныг ч гэсэн хэлтрүүлэхгүй. Тиймээс Бурханы энэрэл хийгээд хатуурхлыг харагтуун. Унагсад дээр хатуурхал байдаг тул Бурханы энэрэлд үлдвээс тан дээр энэрэл оршино. Эс бөгөөс та ч гэсэн тастагдана (Ром 11:20-22).

Бид Бурханы сайны мэргэжилтнүүд болсон. Гэхдээ дан

ганц сайныг нь авч үзээд байж болохгүй. Бурханы хатууг ч мэдэх хэрэгтэй. Бурханы сайн нь биднийг Бурханы зүрхэнд ойртуулдаг бол, хатуу чанар нь бардамнал, бүх төрлийн нүглээс сахин хамгаална. Бурханы дан сайн сайхныг л авч үздэг хүн өөрийг нь бардамнал, дэлхийн замаас сахин хамгаалдаг айдсыг орхигдуулна. Мөнчлөн Бурханы дан хатууг л авч үздэг хүн дорхноо хуульчлалд урхицуулна. Бурханы хайр, эмээхүй хоёр нь хоёулаа биднийг амьдралын нарийн зам дээр байлгана.

Тэгэхээр, “өнөөгийн чуулган Бурханаас эмээхүйг үл тоодог болсон” гэж зориуд хэлснийг минь одоо та ойлгосон байх аа. Би Бурханд үнэн голоосоо хайртай, Түүний хүүхэд болсондоо хязгааргүй баясч, Түүнд үйлчлэхээ az завшаан гэж үздэг. Бурханы сайн сайхан л биднийг гэмшилд аваачдаг (Ром 2:4) болохыг би мэднэ. Түүнчлэн Бурханаас эмээхүй, Түүний шүүх нь биднийг санаатайгаар нүгэл үйлдэхээс сахин хамгаалдгийг ч мэднэ.

Учир нь бид үнэний мэдлэгийг хүлээн авсныхаа дараа зоргоороо нүгэл үйлдсээр байвал нүглийн төлөөх тахил цаашид үлдэхгүй. Харин шүүлт хийгээд эсэргүүцэгчдийг шатаах галын хилэнг айн чичирч хүлээх л үлдэнэ. Мосегийн хуулийг үл хэрэгсэгч нь хоёр буюу гурван гэрчтэйгээр өршөөлгүй үхдэг. Тэгвэл Бурханы Хүүг уландаа гишгэж, өөрийг нь ариусгасан гэрээний цусыг бузар хэмээн тооцож, нигүүлслийн Сүнсийг доромжлогч нь хэр зэрэг илүү хүнд шийтгэл эдэлбэл зохино гэж та нар бодож байна? Учир нь “Өшөө авалт нь Минийх. Хариуг нь Би өгнө” гээд, дахиж “Эзэн Өөрийн хүмүүсийг шүүнэ” гэж айлдсан Түүнийг бид мэднэ. Амьд Бурханы гартоорох нь аймшигтай хэрэг (Еврей 10:26-31).

Хүн Бурханы ариун гэж үздэг юмсыг байдаг л зүйл шиг үзэж, “мэднэ, мэднэ” гээд ирэхээрээ л нүгэлд өдөөгдөнө. Бид Бурханы чухалчилдаг юмст хөнгөн хуумгай хандаж, Бурханы хөнгөн үздэг юмсыг чухалчлах нь олонтаа. Бид хүмүүст таалагдах тал дээрээ хамгаас анхаардаг ч, Бурхан үүнийг бидний зүрхний сэдэл шиг чухалчилдаггүй.

“Би Есүст хайртай” гээд л нүгэл үйлдээд яваад байдаг эрчүүдийг би мэддэг байлаа. Тэд сүнсний нөхцлөө Есүсийн

талаарх мэдрэмжээрээ хэмжжээ. Гэтэл тэд өөрсдийг нь боолчилж байгаа нүгэлдээ үхэтлээ Есүсийг хайлласан уу? Үгүй ээ, тэд Бурханаас эмээдэггүй!

Бэлгийн нүгэл үйлдсэн, мөнгө идэж уусан хэргээр шоронд суусан нэгэн үйлчлэгчийг эргэтэл тэрбээр надад: “Жон, би Есүст дандаа л хайртай байсан. Мэхлэгдээд байхдаа ч тэр. Есүс миний Аврагч байсан. Гэхдээ Эзэн байгаагүй” гэж хэлсэн юм. Тэрбээр хүнээс айх айдсаараа шийдвэр гаргадаг байжээ. Тэрбээр хүмүүст л таалагдахыг хүсч. Тэрбээр хүний магтаал сайшаалыг хүссэн байна. Тэгээд энэ бүхэн нь түүнийг завхралд хүргэж. Гэвч Бурхан түүнд хайр, өршөөлөө үзүүлж, Эзэнээс эмээхүйг зааж өгчээ. Эдүгээ тэрбээр Эзэнээс эмээдэг болсон бөгөөд амьдрал нь сэргэжээ.

Бурханы урилгаас татгалзах

Синай Уулан дээр болсон явдал руу дахин эргээд, олон хүний анзааралгүй өнгөрдөг нэгэн зүйлийг цохон тэмдэглэмээр байна. Бурхан Мосед ч, Ааронд ч уулан дээр гарч ирэх заавар өгсөн (Гэтлэл 19:24). Мое явсан бол, Аарон тодорхойгүй шалтгаанаар хуарандаа үлдэв! (Гэтлэл 32:1) Би л хувьдаа, Аарон Бурханы оршихуйд байхаасаа илүү “итгэгчдийн” дунд байх дуртай байсандаа хуаран руугаа буцсан гэж итгэдэг. Өнөөгийн чуулганы хүмүүс бид ингэдэггүй гэж үү? Бид Эзэнтэй хамт байхаасаа илүү чуулгандаа явж, бусад итгэгч нартай нөхөрлөж, чөлөө завгүй үйлчилдэг. Бид Бурхантай хоёулханаа байхаас зугтаж, хоосрол гансралаа дүүргэхийн тулд өөрийгөө хүмүүс, үйл ажлаар хүрээлдэг.

Гэтэл Иошуа Бурханы зүрхний араас явдаг байсан. Аль болох Бурханы оршихуйд л ойрхон байхыг хүссэн. Мосег Бурхантай хамт байх үеэр Иошуа уулын бэлд дөч хоног хүлээсэн (Гэтлэл 32:17). Иошуа Мое, Аарон хоёрыг л урьсан тэр газарт дураараа хүрч очилгүй, харин аль болох ойртож очжээ. Иошуа Бурханаас эмээдэг байсандаа, дураараа авирлаагүй.

Иошуаг уулан дээр хүлээж байх хооронд хуаранд хүмүүс үймэлдэж эхэлжээ. Тэд хүний нутагт, удирдагч нь сар гаруй алга болчихсон бол, Бурхан Өөрийгөө илчлээгүй л байв. Тиймээс хүмүүс Бурханд ч, Мосед ч эргэлзэж эхэлжээ.

Мосег уулнаас бууж ирэлгүй саатсаныг ард түмэн хараад Аарон дээр цугларч, түүнд —Бос. Бидний өмнө явах бурхдыг бидэнд бүтээж өг. Учир нь биднийг Египет нутгаас гаргасан хүн болох энэ Мосед юу тохиолдсоныг бид мэдэхгүй байна гэж хэлэв (Гэтлэл 32:1).

Хүмүүс гаднаа Бурханыг хүндэтгэж, Түүнээс эмээх мэт харагдаж байв: “Өө Моисе, Бурхан бидний хувьд дэндүү аугаа юм аа. Та өөрөө Бурхантай яриад, үгийг нь бидэнд дамжуулаач. Бид сонсоод дагая.” Тэд Бурханыг юутай аймшигтай, хүчирхэг болохыг нь дөнгөж сая үзсэн атлаа Түүнээс эмээлгүй, өөрсөддөө зориулж шүтээн бүтээсэн. Бурханыг чимээгүй байх үеэр тэдний жинхэнэ мөн чанар илчлэгдэв.

Бурхан гайхамшиг үйлдэж, хүчээ үзүүлж байхад Бурханаас эмээх амархан. Гэвч Бурхан биднийг аавыгаа эзгүй хойгуур ч, оршихуй, хүч нь үзэгдэхгүй цагаар ч үгэнд нь ордог хүүхдүүд шиг Өөрийг нь хүндэтгэж, эмээдэг байгаасай гэж хүсдэг. Хараа хяналтгүй үед л дагаж байгаа нь жинхэнэ дуулгавартай хүмүүс мөн!

Бурхан Израильд “Би эртнээс хойш чимээгүй байсны улмаас Чи Надаас эмээхгүй болсон уу?” (Исаиа 57:11) хэмээсэн. Бурхан үнэндээ “Миний хүмүүс яагаад Надаас эмээхүй байна вэ?” гэж л асуужээ. Дараа нь хэсэг хугацаанд аймшигт хүч чадлаараа Өөрийгөө харуулаагүй учраас, хүмүүс айхаа больсныг нь ажиглаад, Өөрийнхөө асуултад Өөрөө хариулжээ. Өөрөөр хэлбэл, хүмүүс Түүний аиж гайхмаар дүр байдлыг үзэхгүй болохоороо Түүнийг байхгүй юм шиг л авирлажээ. Бурханы нам гүм байдал хүмүүсийн зүрхний жинхэнэ сэдлийг илчилсэн байна.

Тосолгоотой, хүчирхэг цуглаан дээр бус, сорил шалгууртай цөл дунд л жинхэнэ итгэгч хүн илчлэгдэнэ. “Шахуурга” дунд илчлэгдсэн хүн чинь л жинхэнэ та мөн. Тэгвэл дарамт дор Аарон юу хийснийг үзнэ үү:

Аарон тэдэнд —Эхнэр, хөвгүүд, охидынхoo чихэнд байгаа алтан ээмгүүдийг мулталж, надад авчир гэв. Бүх ард түмэн чихнээсээ алтан ээмгүүдээ мултлан Ааронд авчрав. Аарон алтыг тэдний гараас авч хайлуулж цутгаад, багажаар цутгамал тугал болгов. Тэд —Израильчууд аа,

АЙЛГАН СҮРДҮҮЛГИЙГ ЯЛАХУЙ

та нарыг Египет нутгаас гаргасан бурхан чинь энэ юм гэцгээв (Гэтлэл 32:2-4).

Хүмүүс Бурханы ерөөл - Египетийн хөрөнгөөр бурхан бүтээжээ. Гэвч хамгийн аймшигтай нь тэр бурханыг нь уул руу яваагүй Ааронтан бүтээсэн байна. Аарон чинь Мосегийн “ам” шүү дээ. Тэрбээр Мосегийн дэргэд зогсоод, гайхамшиг, гамшигийг үзсэн. Гэтэл одоо хүмүүсээс айсандaa, хүссэнийг нь хийгээд өгчихсөн. Тэрбээр Бурханаас илүү хүнээс айдаг учраас, шууд л сүрджээ. Түүнд Бурханы болд зориг байхгүй тул Бурханы бэлэг унтарчээ. Иймээс тэр сул удирдагч болсон. Мосетэй нүүрэлдэх үедээ Аарон бурууг өөрийг нь сүрдүүлсэн хүмүүс рүү чихжээ.

Аарон —Миний эзний уур хилэн бүү дүрэлзэг. Энэ ард түмэн ёрын мууд өртөмтгийг гэдгийг та мэднэ. Тэд надад “Бидний өмнө явах бурхдыг бидэнд зориулан бүтээж өг. Учир нь биднийг Египет нутгаас гаргасан хүн болох энэ Мосед юу тохиолдсаныг бид мэдэхгүй байна” гэж хэлсэн. Тэгээд би тэдэнд “Алттай хүмүүс нь түүнийгээ мулталж өг” гэж хэлсэн. Тэд алтнуудаа надад өгсөнд би галд хаясан бөгөөд энэ тугал гарч ирсэн юм гэж хэлэв (Гэтлэл 32:22-24).

Аарон хийсэн хэрэгтээ хариуцлага хүлээгээгүй. Тийм ээ, тэр үнэн хэлсэн. Энэ нь Аароны бус, хүмүүсийн санаа байсан. Гэвч тэр хүмүүсээс айсандaa, сүргээс ирэх айлган сүрдүүлгийг тасар татаж, зөв зүг рүү хөтлөн дагуулж чадаагүй. Аарон хүнээс айх айдаст бариулжээ.

Хүнээс айдаг удирдагч нар ухраад, хүмүүст хэрэгтэй зүйлийг нь бус, хүссэн зүйлийг нь өгнө! Тэд айлган сүрдүүлэгт амархан бариулна. Бурханд болоод хүмүүст мянга хайртай гэж хэллээ ч, хүнээс айдаг удирдагч өөрөө ч, удирдаж яваа хүмүүс нь ч жинхэнээсээ өсөн дэвшихгүй!

Бурханаас айдаг хүн гагцхүү Бурхан түүний талаар юу гэж хэллэх бол гэдэгт л анхаарна. Хүнээс айдаг хүн Бурханы бодолд бус, хүмүүсийн бодолд л анхаарна. Тэрбээр хүнийг гомдоохгүйн тулд Бурханыг гомдооно.

Удирдагч нар хүмүүст хүссэн зүйлийг нь өгөх шийдвэр

гаргаж байхыг би харсан. Тэд хүмүүсийн дунд нэр хүндээ алдахыг хүсэхгүй. Мэдээж, тэд үүнийгээ хүлээн зөвшөөрөхгүй - магадгүй бүр ухаарах ч үгүй явaa байх. Тэд шийдвэрээ зөвтгож, “Би хүмүүсийг гомдоохыг хүсэхгүй”, “Ингэх нь хэн хэндээ ашигтай”, “Ингэвэл, илүү олон хүнд үйлчилж чадна” гэх мэт шалтаг тоочих. Гэтэл Бурханы хаанчлал чинь хаанчлал болохоос ардчилал биш. Алдар нэр хамаагүй. Тэд айдас, айлган сүрдүүлгээс болж ийнхүү үйлдэж байгаагаа ойлгодоггүй. Үйлдэл нь хүмүүсийг бус, өөрийгөө хайрлах хайран дээр үндэслэжээ.

Бурханаас айхгүй бол, юу болох вэ?

Бурхан Мосед “Тэдний зүрх хэвээр үлдэж, Надаас үргэлж эмээх болтугай!” (Дэд хууль 5:29) гэсэн. Гэвч хүмүүс тэгээгүй. Тэгээд юу болсныг үз.

Жил хэртээ цөлд амьдарсны дараа Израильчууд хөдөлж, амлагдсан газрыг авах цаг нь болжээ. Эзэн Мосед “Миний Израилийн хүүхдүүдэд өгч байгаа Канаан нутгийг тандуулахаар туршуул илгээ” (Тооллого 13:1) хэмээсэн. Бурхан “Тэр газрыг тандаад, авч чадах эсэхээ мэд” гэж хэлээгүй, чухам “Миний өгч байгаа” гэж хэлснийг тэмдэглээрэй.

Тийнхүү Моше туршуулаа илгээв. Туршуул нь дөч хоног яваад, тэр газар нь том, том хоттой, бат бэх хамгаалалттай, хүчирхэг оршин суугч нартай болохыг нь олж мэджээ.

Арван хоёр туршуул бүгд нэг л ижил хүмүүс, цэрэг, цайз хэрэмтэй хот, үлэмж биетэй хүмүүсийг үзсэн. Иошуа, Калеб хоёр шууд дайраад, Бурханы амласныг авахад бэлэн байсан бол, бусад арван туршуул нь харсан зүйлээсээ сүрджээ. Тэд их цэрэг, аварга хүмүүсийг л харсан бол, Иошуа, Калеб хоёр Бурханы сайн, итгэмжтэйг үзсэн!

Арван туршуул хүмүүст тэр газрыг авах боломжгүй гэсэн. Тэд дөрвөн зуугаас олон жил боол явсан учраас, нутгийн цэргүүд шиг дайны ур чадваргүй гэнэ. Тиймээс хүмүүс шууд айж, гомдолложээ:

ЭЗЭН юунд биднийг энэ нутагт авчирч байна вэ? Эхнэрүүд болон бяцхан хүүхдүүдийг маань олз болгохоор, биднийг

илдэнд унагаахаар уу? Египет уруу буцсан нь бидэнд дээр байх юм биш үү? гэцгээж байв (Тооллого 14:3).

Энэ эшлэлээс бид “Энэ нь бидэнд ашигтай бус уу?” гэдэг хүний айдын үндсийг харж байна. Хүмүүс өөрийгөө л бодсон учраас, аиж сүрджээ. Тэд “Бурханы үг л хамгийн чухал” гэж хэлээгүй, оронд нь “Бидэнд юу нь дээр вэ?” гэж асуусан.

Яагаад энэ вэ? Хүнээс айх айдын үндэс нь амиа хайрлах хайр байдаг. Аминдаа хайртай хүн амиа аврах гэдэг. Аминд заналхийлсэн бүхнээс шууд сүрдэнэ.

Бурхан тэр хүмүүсийг Өөрт нь найдахаас өөр аргагүй газарт авчиржээ. Тэд нутгийнханы гаргт сүйрэх юм шиг л харагдаж байв. Гэтэл тэд Бурханд итгэхийн оронд Бурхан тэднийг Канаанчуудаар алуулах гэж л Египетээс аварсан юм шиг авирласан. Хөгийн гэмээр сонсогдож байгаа ч, бид ч бас Эзэнийг аюултай, амь насанд халтай гэмээр нөхцөл байдал дундуур дагах шаардлагатай болдог.

Ийм нөхцөлд Бурхан сайн гэдэгт итгэдэг хүн л энэ бүхэн дундуур Бурханыг дагадаг. Бурханд зөвхөн сайн сайхан л бий. Бурхан бидэнд мөнхийн гарз хохирол авчраад, Өөртөө ашиг хонжоо олох замаар хэзээ ч биднийг гаргахгүй! Бурхан бүгдийг өнө мөнхөөр шүүдэг бол, хүн юмыг дал, наян жилээр л шүүдгийг бүү март!

Бурханд гологдох уу, хүнд гологдох уу?

Калеб, Иошуа хоёр бэрх замыг сонгосон. Бурхан тэднийг өөр сүнстэй бөгөөд Өөрийг нь бүрэн дагадаг гэжээ. Бусад нь Бурханыг дагаж далдагнаад, аюулгүй байдлаа алдахыг хүсээгүй. Бурхан Калеб, Иошуа хоёрт итгэмжтэй байсан. Тухайн үеийнхэн дундаас энэ хоёр хүн л Амлагдсан газарт орж чадсан юм (Тооллого 14:24, 30-ийг үзнэ үү).

Амиа аврах гэж оролдсон хүмүүс бүгд амиа алдсан. Бурхан тэдний хувь тавиланг ийнхүү мэдэгджээ: “Харин та нарын хувьд, цогцсууд чинь энэ цөлд унах болно. ...та нар Миний дургүйцлийг мэдэх болно” (Тооллого 14:32,34). Олон хүн хүнд гологдохос айсандаа, Бурханд гологддог гэхээр аймаар.

Олон хүндуртайяа Эзэнээс эмээдэг байгаасай гэж би залбирна.

Бурханаас эмээх, хүнээс айх

“ЭЗЭНЭЭС ЭМЭЭХҮЙ НЬ АМИЙН УНДАРГА. ҮХЛИЙН ЗАНГАНААС ЭНЭ Л ЗАЙЛУУЛДАГ” (Сургаалт үгс 14:27). ДАРААГИЙН БҮЛГЭЭРЭЭ ЭЗЭНЭЭС ЭМЭЭХҮЙ НЬ АЙЖ СҮРДЭХ ЦАГТ ХЭРХЭН ТУСАЛДГИЙГ ҮЗЬЕ.

*Эзэхийн нь итгэлтэй байдал,
эр зорилгийг төрүүлдэг.*

Арван хоёрдугаар бүлэг

ҮЙЛДЭЛ ХИЙХ ҮҮ, МЭДРЭМЖ ҮЗҮҮЛЭХ ҮҮ?

Айлган сүрдүүлэг нь нөхцөл байдал, бодол, хүмүүсээр дамжиж ирж болно. Ихэнх хүмүүс бусдаас ирэх айлган сүрдүүлэгтэй их зөрчилддөг. Хүнээс айх айdas нь ийм төрлийн дарамтын оновчтой дүрслэл болно.

Хүнээс айх айdas биднийг Бурханд гологодох талаар бодолгүйгээр, хүнд л гологодохоос, хүний зүгээс хор хохирол үзэхээс, хүний дургүйг хүргэхээс зайлсхийхэд хүргэдэг. Хүнээс айдаг хүн нүдэнд харагддаг хүнийг гомдоогүйн үүднээс нүдэнд үл харагдах Бурханыг гомдоодог.

Есүс биднийг “Би та нарт хэлье. Андууд минь, махбодыг хөнөөгчдөөс бүү ай. Хөнөөсний дараа тэд яаж ч чадахгүй. Харин хэнээс аиж эмээвэл зохихыг та нарт сануулъя. Хөнөөсний дараа тамд хаях эрх мэдэлтэй Нэгэнээс эмээгтүн. Тийм ээ, Би та нарт хэлье, Түүнээс эмээгтүн” (Лук 12:4-5) хэмээн ятгасан.

Та хүнээс айдаг бол, Бурхан таныг хүнд, бэрхээр дагуулах үед өөрийгөө сахин хамгаалах гэж оролдоно. Бурханы хүслийг хайхын оронд та өөрийнхөө хүслийг хэрэгжүүлэх гэж оролдоно. Харин Эзэнээс айдаг бол, та Бурханд хүндэтгэлтэй хандах арга байдлаар л бэрхшээлийг даван туулна. Бурханаас өөр хэн ч таныг сахин хамгаалж чадахгүйг та мэдэж, өнө мөнхийн хэмжүүрээр юу нь шилдэг болохыг Бурхан л мэднэ гэдэгт итгэнэ.

Сургаалт үгс дээр Эзэнээс эмээхүйн талаар хэлсэн хүчирхэг амлалт бий:

ЭЗЭНЭЭС эмээгчдэд бат итгэл. Энэ нь хүүхдүүдэд нь хоргодох газар. ЭЗЭНЭЭС эмээхүй нь амийн ундарга. Үхлийн занганаас энэ л зайлцуулдаг (Сургаалт үгс 14:27).

Нөгөө сонголтыг нь ч Бичээс тодорхой хэлжээ:

Хүнээс айх айдас занга тавих (Сургаалт үгс 29:25).

Айлган сүрдүүлэг нь урхи, хавх боловч, Эзэнээс эмэхүй нь чухам энэ л айлган сүрдүүлгийн урхи, хавхнаас чөлөөлөх багаж зэмсэг болох бат итгэл, эр зоригийг төрүүлдэг.

Дарамт илчилдэг

Би хоёр хааныг сөргүүлэн харьцуулъя. Тэр хоёрын хэн, хэн нь нэг л хаанчлалыг захирч явсан, нэг л Бурханд мөргөж явсан. Нэг нь Бурханд гологдсон бол, нөгөө нь Бурханд Өөрт нь Бурханы зүрхийг мөшгидөг хүн хэмэн үнэлэгдсэн. Энэ хоёр хүний амьдралыг жишигдээ, бид Бурханаас айх, хүнээс айхын ялгааг тов тодорхой ойлгох болно. Тэгэхээр, бүгдээрээ Саулын амьдралын хамгийн онц сонирхолтой боловч, бараг судлагдаагүй нэгэн тохиолдлыг авч үзье.

Саул хоёр жил хаанчлаад байв. Ер нь бол “бал сарын” энэ хугацаанд хүний жинхэнэ зан чанар барагтай илчлэгдээд байдаггүй. Тийм боловч цаг хугацаа өнгөрөх тусам, Саулын сэдэл ил болов.

Саулыг шилдэг дайчидтайгаа Мишхамт байх үеэр Филистинчүүд түүнтэй тулалдахаар цэргээ цуглувужээ (1Самуел 13:5-15). Энэ бол Саултай байлдахаар ирсэн хамгийн хүчирхэг цэрэг байв. Дайсны талд гучин мянган морин тэрэг, зургаан мянган морьтон цэрэг, эргийн элс шиг олон мянган явган цэрэг байжээ. Их цэрэг гэхээс өөр юу гэхэв! Гучин мянган морин тэрэг чинь одоогийнхоор бол гучин мянган танк. Дээрээс нь тоолохын аргагүй их цэрэг! Израилийн хувьд үнэхээрийн зүрх үхмээр үзэгдэл!

Саулын цэргүүд ухаан алдтал айсандaa өвс ургамал, нүх сүв, ангал хавцал, хад чулуунд нуугдав. Тэд балмагдсан. Зарим нь явгаараа Иордан голыг гатлаад, Гад, Гилеадын нутаг руу талийсан бол, Саултай хамт үлдсэн нь айсандaa бэмбэгнэж байв.

Тулааны өмнө Израиль Эзний өмнө мөргөл үйлддэг байжээ. Самуел Эзэнээс ирсэн тушаалыг Саулд дамжуулаад, өөрөө Эзний өмнө тахил өргөхөөр очихоо хэлсэн. “Самуельн тогтоосон хугацаа болох долоо хоног Саул хүлээсэн боловч

Самуел Гилгалд ирсэнгүй. Ард олон түүнийг орхин тарцгааж байв” (1Самуел 13:8).

Дарамтанд орсон Саул “шатаах тахил, энхийн тахилыг аваад ир” гэж хэлжээ. Тэгээд тахилаа шатаасан бөгөөд түүнийг дуссахтай зэрэгцэн Самуел ирэв.

Самуел Саулаас юу хийснийг нь асуусан. Гэтэл Саул юу гэж хариулсан байгааг анхааралтай харна уу:

Харин Самуел —Та юу хийв? гэсэнд Саул —Ард олон намайг орхин тарцгаахыг би харж бас та ч тогтоосон хугацаандаа ирсэнгүй, филистчүүд ч Михмашт цугларсан тул би “Филистчүүд Гилгалд миний эсрэг одоохон ирэх нь, бас ЭЗЭНИЙ тааллыг би гүйгаагүй байна” гээд би өөрийгөө хүчилж, аргагүй шатаалт тахил тахив гэж хариулав (1Самуел 13:11-12).

Тэгэхэд нь Самуел Саулыг Эзэний тушаалыг сахиагүйгээрээ мунхаг юм хийснийг нь хэлээд, зэмлэсэн.

Болсон түүхийг мэдсэн болохоор одоо та өөрийгөө Саулын оронд тавиад үз дээ. Та болоод танай цэргүүд дайсны аймшигтай том армитай долоо хоногоос ч илүү хугацаанд тулаад байна. Танай тал тоогоороо дайсны цэргүүдээс хол дутах бөгөөд өдөр ирэх тусам цэргүүд чинь зугтаж, тоо чинь хорогдох учраас, дайсны тал өдөр өдрөөр уlam л томорсоор. Танай цэргүүд дайснаасаа айгаад, аргагүйн эрхэнд зугтжээ. Үлдсэн хэд нь ухаан алдталаа айна. Та Бурханы эш үзүүлэгчийг хүлээсээр байв ч, мань хүн цагтаа ирж тахилаа өргөдөггүй!

Тан дээр дааж дийлэхийн аргагүй дарамт байна. Энэ бол “тосон шахуурга” юм. Эргэн тойрны чинь хүмүүс “Хаантан минь, алив хөдлөөч. Бид үхэх нь байна!” гэж шаламдуулна. Та Эзэний тушааснаар хүлээх үү эсвэл амиа аврах нүүдэл хийх үү?

Саул хаанд ийм л нөхцөл тулгарсан (1Самуел 13:1-8-ыг үзнэ үү). Харамсалтай нь Саул дарамт дор хага үсэрсэн юм. Тэрбээр дуулгаваргүй авирлан, өөрөө тахил өргөсөн. Тэгээд ямар шалтаг тоочсоныг нь үзнэ үү: “би өөрийгөө хүчилж, аргагүй шатаалт тахил тахив” (1Самуел 13:12). Саул хүмүүст таалагдах гэж тахил өргөсөн атлаа Самуелд “өөрийгөө хүчилсэн” хэмээн сүнслэгжүүлэх гэж оролджээ. Үнэндээ Саул мэдрэмжээрээ үйлдээд, айлган сүрдүүлгийн урхинд унасан байна.

АЛИВ ЭЭ, ХӨДЛӨӨЧ!

Олон хүн нэг юмуу олон удаа ийм байдалд ордог. Танд “Бурхан намайг зүгээр хүлээ гэсэн ч, би энэ нөхцөл байдлыг өөрчлөхийн төлөө хөдлөх ёстой” гэж бодогдож байсан удаа бий юу?

Миний л хувьд, найзууд юмуу ажилтнууд маань “Жон, хөдлөөч!” гэж шаллаа ч, Бурхан хөдөл гэж хэлэхгүй байхыг зүрхэндээ мэдээд байх үе байсан. Бурхан чимээгүй байдаг.

Ялангуяа Бурхан юу ч хэлэхгүй, чимээгүй байх үед Түүнийг хүлээх шиг хэцүү зүйл байдаггүй! Ялангуяа өнөөгийн хувьд. Бурхан хөдлөхгүй байсан ч, яндашгүй эх үүсвэр, мөнгтэтэй Америкчууд бид өөрсдөө хийгээд л болгочихож чаддаг улс. Бид Бурханыг огт оролцуулалгүй, өөрийнхөө талант, чадвараар үйлдчихээд, үүнийгээ Бурханы үйлс мэт харагдуулж чаддаг улс.

Шийдвэр гаргах тал дээр - биднийг яг ингэ, тэг гээд заагаад өгөх Библийн бүлэг, эшлэл байхгүй. Бид Бурхан бидэнд алхам тутамд маань хэлж байгаа үгийг мэдэх хэрэгтэй. Бурхан ярихгүй байгаа мэт үедээ ч ярьдаг! Бурхан: “Миний хийгээрэй гэснийг л хийсээр бай. Миний санаа өөрчлөгдөөгүй!” гэдэг. Үүнийг нэн ялангуяа аиж сүрдсэн үед хийх хамгийн хэцүү.

Шинэ жилийн өдөр Бурханы надад өгсөн үгийг би тантай хуваалцмаар байна. Тэр өдөр би дөчин зургаан цагийн аялал, өдрийн хоёр удаагийн номлолдоо ядраад, гадаадын нэгэн улсад нам унтаж байсан юм. Гэтэл гэнэт үүрийн хоёр цагт дуг нойрнооскоо сэргчихэв. Гуравхан цаг унтсан атлаа жигтэйхэн сэргэг байсан болохоор, би Эзэн л намайг сэргээснийг мэдэв.

Эзэн надад хувьчлан өгсөн үгийг би тэр бүр олонд дэлгээд байдаггүй л дээ. Гэвч энэ удаа санаагаа батлах үүднээс Эзэн намайг хуваалцахыг зөвшөөрч байх шиг байна. Энэ үг ийм нөхцөлд байгаа олон хүнийг бэхжүүлнэ гэдэгт итгэж байна. Тэгэхээр, хэсэгхэнийг л толилуульяа:

Чи төвлөрч чадахгүй байсан нь шалгалтын маань нэгээхэн хэсэг байв. Чамайг Миний чиглүүлэггүйгээр дураараа хөдлөх эсэхийг чинь үзэхийн тулд Би чиний төвлөрлийг сарниулсан юм. Гэтэл Намайг чимээгүй байх хугацаанд дураараа үйлдээгүйг чинь Би таашаав. Намайг хөдлөөрэй гэж хэлээгүй байхад чи хөдлөөгүй, Миний нэрийг барин

хувийнхаа төлөвлөгөөг зохиогоогүй учраас, үүнээс хойш чи бүгдийг маш тодорхой харах болно. Учир нь Би чамд болоод чиний гэргийд - хоёуланд чинь том баяр хөөр авчрах тодорхой, том төлөвлөгөө өгнө.

Гэргий, бид хоёрыг гацаанд ороод байхад Эзэн энэ үгийг айлдаж билээ. Бидэнд биелэхгүй байгаа хувийн хүсэл, хэрэгцээ байлаа. Бид хоёр нилээд хэдэн жил маш хүнд дарамт дор амьдарсан юм. Найзууд маань биднийг чин сэтгэлээсээ хайрласандаа л янз бурийн алхам хийхийг зөвлөв ч, тэдгээр нь Эзэний үг мөн санагддаггүй байв. Тэдний буруу биш л дээ. Тэд бидний ороод байгаа нөхцөл байдалд хариу үйлдсэн нь л тэр. Гэтэл тэр нь бидний шалтгалт байжээ.

Бидэнд дарамтаа хөнгөлөхийн тулд хийж болох сонголтууд байсан л даа. Гэвч эргэлзээтэйгээ тэмцэлдэх дундаа “Гэхдээ энэ Бурханы хүсэл мөн болов уу?” гэж гайхширна. Бурхан бидэнд ямар нэгэн алхам хий гэж хэлэхгүй байгааг бид зүрхнийхээ гүнд мэддэг байлаа.

Тийнхүү шинэ он гараад сар ч болоогүй байхад, Бурхан бидний зүүдэнд ч ороогүй юмсыг үйлдэв! Сарын дотор тийм олон юм өрнөхийг би л хувьдаа үзээгүй. Сүүлийн таван жил амьдралд маань өрнөөгүй юмсыг Бурхан ганц сарын дотор хийчих шиг!

Дарамт дор мэдрэмжээрээ хөдлөхгүй байх нь чухал. Бид Эзэний үгийн дагуу л хөдлөх ёстой.

Бурханы зүрхийг мөшгидөг хүн

Саул аиж сүрдсэн. Бурхан түүнийг хүлээ гээд байхад, нэр хүнд, хаанчлалаа алдах дээрээ тулсан Саул мэдрэмжээрээ нүүдэл хийжээ. Самуел Саулыг зэмлээд, түүн дээр шүүх буулгасан байна:

Гэвч одоо таны хаанчлал үргэлжлэхгүй. ЭЗЭН Өөртөө зүрх сэтгэлийнхээ дагуух хүнийг хайн олж, тэр хүнийг Өөрийн ард түмний удирдагчаар томилсон. Учир нь танд ЭЗЭНИЙ тушаасныг та сахин биелүүлсэнгүй гэв (1Самуел 13:14).

Гэхдээ энэ нь Саулын сүрдүүлэгт нугарсан цорын ганц тохиолдол биш юм. Саул дарамттай нөхцөлд Эзэнд дуулгаваргүй авирладаг “ заншилтай” байжээ. Өөр нэгэн удаа Саул хүмүүсийн хүсэлд нийцэх гэсэндээ, Бурханы газартай тэгшлээрэй гэж тушаасан хотын олзыг нь авчихдаг. Саул хүмүүсийн тааллыг алдахыг хүсээгүй. Самуел нүүрэлдэх үед Саул “Би ард олноос айж, тэдний дуу хоолойг сонссон учраас ЭЗЭНий тушаал болон таны үгийг үнэхээр зөрчиж нүгэл үйлдлээ” (1Самуел 15:24) гэж буруугаа хүлээн зөвшөөрсөн.

Тийм боловч Саул дуулгаваргүй авирласандаа бус, нэр төрдөө л зовниж байсныг нь дараагийн мэдэгдэл нь харуулдаг. Тэрбээр Самуелд хэлсэн үгээрээ зүрхнээсээ урважээ: “Би нүгэл үйлдэв. Гэвч одоо миний ард олны ахмадууд ба Израилийн өмнө намайг хүндэлж, надтай хамт буцаж, Бурхан ЭЗЭНд мөргүүлж өгнө үү?” (1Самуел 15:30)

Саул дахиад л хүнээс айсандаа нүгэл үйлджээ. Тэрбээр айх тусмаа, улам л дарангуй удирдагч болж байв. Ер нь аймхай удирдагч нар голдуу ингэдэг. Тэд наанаа хүмүүсийг хянан захиргаадаж чадаж байгаагаа харуулах гэж харгисладаг ч, үнэндээ цаанаа айж, сүрдсэнээ л нууж байдаг.

Самуел Саулд “Бурхан тушаалыг нь сахидаг хүнд хаанчлалаа өгөх” тухай хэлсэн (1Самуел 13:14). Тэр хүн нь Давид байв. Зарим хүн өөрийгөө Бурханы зүрхийг мөшгидөг гэж ярьдаг л даа. Гэвч Бурхан түүний талаар Давидын талаар айлдсан шигээ айлдах болтугай: “Чиний зүрх Намайг дагадаг!” Мэдээж Бурханд хайртай итгэгч болгон л үүнийг хүснэ! Би Давид ямар хүн байсан болоод Бурхан түүнийг Өөрийнхөө зиндаанд тавьсныг нь мэдэх гэж, амьдралыг нь нарийн судалсан юм.

Тэгээд Давид юу ч байсан - Бурханаас үг сонсогүйгээр, дураараа алхам хийхгүй байхдаа туйлаас анхаардаг байсныг нь олж мэдэж билээ. Дарамттай нөхцөл болгон дээр Давид ахин дахин Бурханаас зөвлөгөө сонсдог байжээ (1Самуел 20-31). Mash эгзэгтэй нэгэн түүхийг авч үзье.

Үүнээс дордоно гэж байх уу?

Саулын хаанчлалын сүүлчийн жил, Давид эрчүүдтэйгээ Филистинчүүдийн нутагт орогнож байв. Хувь заяаны жигтэй тохиолоор Филистиний арми Израильтай байлдахаар цуглах үед

Давид эрчүүдтэйгээ Филистиний армид элсэж орхижээ. Тэгтэл цэрэгт нь Еврей эрчүүд дайтах гэж байгааг үзсэн Филистиний ноёд дургүйцээд, Давидыг эрчүүдтэй нь цэргэсээ хөөжээ.

Маргааш нь Давидын цэргүүд Зиклагт амьдарч байсан ар гэрээ зорив. Тулаанд орох гэсэн ажил нь бүтэлгүйтсэн болохоор Давидын цэргүүд гологдсон сэтгэгдэлтэй байсан байх. Тэднийг эх орон, эзэн хаан нь гадуурхаад зогсохгүй, орогнож байсан улс нь ч гадуурхжээ. Давид ч эх оронгүй, эзэнгүй хүн шиг л ганцаардсан байх. Товчхондоо, нэг их сайхан өдөр байсангүй. Гэхдээ энэ нь удахгүй тулгарах асуудлынх нь дэргэд юу ч биш байжээ. Гэртээ харьж иртэл юу угтсаныг анхааралтай уншаад, Давидын сэтгэл мэдрэмжийг төсөөлөх гээд үз дээ:

Давид ба түүний хүмүүсийг гурав хоногийн дараа Зиклагт буцаж ирэхэд амалекчууд Негев хийгээд Зиклаг уруу довтлон тонож, Зиклагийг цохиж галдан шатаасан байжээ. Тэд эмэгтэйчүүд ба тэнд байсан бүхнийг, жижиг ч бай, том ч бай бүх хүний нэгийг нь ч алалгүйгээр олзлон авч, өөрийн нутаг уруугаа явсан байлаа. Давид хүмүүстэйгээ хотод орж ирэв. Хотыг галдан шатааж эхнэр хүүхдүүд, охидыг нь олзоод явсныг тэд үзэв. Тэгэхэд Давид болон түүнтэй хамт байсан хүмүүс дуугаа өндөрсгөн уйлах ч тэнхээгүй болтлоо цурхиран уйлав. Давидын хоёр эхнэр болох иезреел эмэгтэй Ахиноам мөн Набалын эхнэр байсан кармел эмэгтэй Абигаил нарыг ч олзлон явсан байв (1Самуел 30:1-5).

Түүний шаналал төсөөлөгдөж байна уу? Гэр бүлийг нь хулгайлаад, үнэтэй сайтай бүхнийг нь тонож, үлдсэнийг нь шатааж! Давидын ар гэр төдийгүй, эрчүүдийнх нь ар гэр - бүгд байхгүй. Тэд хэнд ч хэрэггүй, эх оронгүй хүмүүс байсан бол, одоо бүр орон гэр ч үгүй, гэр бүл ч үгүй хүмүүс болов. Гэвч зовлон үүгээр дуусаагүй. Дараа нь юу болсныг үзнэ үү:

Түүнээс гадна ард олон бүгд өөр өөрсдийн хөвгүүд охидынхоо төлөө сэтгэл гашуудсанаас болж, Давид уруу чулуу шидэж, алахаар ярилцаж байсан учраас Давид ихэд шаналав (1Самуел 30:6).

Эдүгээ Давидын дэргэд байж, тулалдахаар явсан цорын ганц хүмүүс нь эхнэр, хүүхдээсээ болоод эргээд Давидыг чулуугаар нүүлгэж алахад бэлэн болж! Үүнээс дор юм гэж байх уу? Давидад Саулаас ч дор асуудал тулгарчээ. Түүнд туслах ширхэг ч хүн үлдээгүй. Саулд аймхай ч гэсэн арми, гэр бүл нь байсан бол, Давидыг өөрийнх нь талынхан чулуудаж алахад бэлэн байв.

Ихэнх итгэгч нарт амьдралд цор ганцаараа үлдэх үе ирдэг. Бурхан үүнийг зөвшөөрдөг байх аа гэж би итгэдэг. Бурхан ёрын муугийн зохиогч биш учраас, ганцаардалд оруулдаггүй боловч, энэ үед хөндлөнгөөс оролцохоос татгалздаг. Учир нь Бурхан цөхрөлийн энэ цагийг зорилготой болгодог. Ийм нөхцөлд Давид буугаад өгөх юмуу эсвэл дайсны араас хөөх зэргээр эр цэргүүддээ элдвээр таалагдах гэж оролдож болох байсан. Гэтэл үюнэ хийснийг нь үзнэ үү:

Гэвч Давид өөрийн Бурхан ЭЗЭНээр өөрийгөө зоригжуулав. Дараа нь Давид, Ахимелехийн хөвгүүн тахилч Абиатарт хандан — Ефод авч ирэгтүн гэж гүйсанд Абиатар, Давидад ефодыг авчирч өгөв. Давид, ЭЗЭНээс лавлан — Эдгээр дээрэмчдийн бүлгийг би мөрдөх үү? Би тэднийг хөөж гүйцэх үү? гэж асуухад ЭЗЭН түүнд — Мөрдөгтүн, чи тэднийг хөөж гүйцэх нь ч баттай, бүхнийг аврах нь ч лавтай гэж хариулав (1Самуел 30:6-8).

Давид аймшигтай дарамт дор ч Эзэний зөвлөгөөг авахаас нааш хөдлөөгүй байна. Давид Эзэн рүүгээ эргэн, өөрийгөө хатжуулжээ. Тэрбээр Бурханы итгэмжтэй чанар, гэрээг өөртөө сануулжээ. Тэгээд юу хийхээ асуусан байна. Бурхан “Хөө” гэсэн.

Давид дайсны араас хөөсөн.

“Ийнхүү амалекчуудад булаалгасан бүх зүйлээ Давид эргүүлэн авч, алдсан хоёр эхнэрээ ч бас авран чөлөөлжээ. Тэдний зүйлсээс жижиг ч, том ч, хөвгүүд ч, охид ч, олзлуулсан юмс ч, тэдэнд булаалгасан зүйлсийн нэг нь ч алдагдсангүй. Давид тэр бүхнийг буцааж авав”
(1Самуел 30:18-19).

Цөхрөл нь аугаа ялалт болов! Бидний Бурханд хэцүү юм гэж байхгүй. Давид хүнээс бус, Бурханаас айдаг байж. Тиймээс л

хамгийн түрүүнд Бурханд хандсан. Саулаас нилээд өөр байгаа биз.

Давид үйлдэл хийсэн бол, Саул мэдрэмж үзүүлсэн. Давид Бурханы үгийг мэдэж байсан болохоороо мэдрэмж үзүүлэлгүй, үйлдэл хийсэн. Христийн сэтгэлгээтэй хүн мэдрэмж үзүүлээд байх биш, үйлдэл хийх зүрх зоригтой байдаг.

Саруул ухаан

Айлган сүрдүүлгийг хүний агсам зоригоор бус, бурханлаг хүч, хайр, эрүүл саруул ухаанаар цэнэглэгдсэн эр зоригоор тасар татдаг тухай бид өмнө үзсэн.

Энэ шалтгааны улмаас, миний гар тавигдсанаар чамд буй Бурханы бэлгийг сэргээхийг чамд сануулья. Учир нь Бурхан бидэнд айдсын бус, харин хүч, хайр ба биеэ захирах сүнсийг өгсөн (2Тимот 1:6-7).

Тэгвэл, энэ гурван чанар нь Давидад хэрхэн ямар ч айлган сүрдүүлэгтэй мөргөлдөх зүрх зориг оруулж байсныг үзэцгээе:

1. Хүч. Давид Бурханыг мэддэг байсан. Бурхан ямар ч асуудалтай эгнэшгүй аугаа, хүчирхэг гэдгийг мэддэг байсан.
2. Хайр. Давид Бурханд өөрөөсөө илүү хайртай байсан.
3. Саруул ухаан. Давид ямар ч дарамтанд орсон бай - Эзэний үг, сэтгэлгээг хүлээн авахаас нааш, хөдөлдөггүй байсан.

Сүнс хүч, хайр, Эзэний үгээр дүүрэх үед бид айлган сүрдүүлгийн идэш болохгүй. Аль нэг нь чанар нь бус, харин гурван чанар гурвуулаа нийлж байж биднийг бэхэлнэ. Бурханлаг эр зориг дотор алхаад маань гурвуулаа хэрэгтэй.

Хүч, хайрыг нь бид хэдийнээ задалж үзсэн. Тэгвэл одоо Эзэний оюун санаатай байхыг сурцгаая.

*Саруул ухаан нь эдүгээ
Бурхан юу хэлж, хийж байгааг мэддэг.*

Арван гуравдугаар бүлэг

САРУУЛ УХААНЫ СҮНС

Мэдлэггүй байдлаас илүү айлган сүрдүүлдэг зүйл үгүй.¹ Мэдлэггүй байдал гэдэг нь мэдлэг дутмаг байдал юм. Бичээс мэдлэгийн үнэ цэнийн талаар их ярьдаг. Сургаалт үгс 24:5 дээр “Чадалтайгаас мэргэн нь Хүчтэйгээс ухаантай нь илүү” гэдэг бол, Сургаалт үгс 11:9 “Сүсэг бишрэлгүй нь амаараа хөршөө хөнөөнө. Зөвт хүн мэдлэгээр аврагдана” гэдэг. Мэдлэг нь айлган сүрдүүлгийн урхинаас суллагдах хүчийг өгдөг.

Жирийн бөгөөд сүнсний мэдлэг гэж байдгийг мэдээрэй. Сүнслэг мэдлэг, цэц ухаан нь жирийн мэдлэг, цэц ухааныг давна. Тиймээс *л ер бусын* гэгддэг учиртай. Энэ нь жирийн зүйлээс хол давна.

Тимот 1:6-7 дээр элч Паул Тимотод айдсыг (айлган сүрдүүлгийг) ялан дийлэхэд шаардлагатай гурван түлхүүр бүтцийг дурьдсан нь хайр, хүч, саруул ухаан болой. Энэ бүлгээрээ энэ тухай ярья.

Эрүүл саруул ухаан гэж юу вэ? Бичээсийн мэдлэг мөн үү? Дагалдагч нар харанхуй бүдүүлэг загасчид хэмээн үзэгдэж байсан боловч, тэдний цэц ухаан, болд зоригийг Израилийн хамгийн боловсролтой бүлэг болох Санхедрин үзээд, хуйхаа маажсан.

Эрдэм номгүй, юм сураагүй Петр, Иохан хоёрын зоригтой байгааг тэд хараад гайхацаан, Есүстэй хамт байсныг нь мэдэв (Үйлс 4:13).

Бэлбэсэн авгайчуулд хоол хүнс хүргэх үйлчлэлтэй байсан Степан гэдэг эр өндөр мэдлэгтэй синагогийн удирдагч нарыг

бажигдуулсан. Библи энэ тухай “Гэвч тэд түүний, Сүнс болон мэргэн ухаанаар ярьж байсныг сөрж чадсангүй” (Үйлс 6:10) гэдэг.

Саруул ухааны сүнс нь хүний төрөлх цэц ухаанаас юмуу Бичээсийн онцгой сургалтаас бий болдоггүй нь шууд харагдаж байна. Тэгэхээр, саруул ухааны сүнс нь хаанаас гардаг байх нь?

Илчлэгдсэн мэдлэг

Эрүүл саруул ухаан нь Христийн ухааныг мэдэхээс төрнө. Бичээсийг мэдэх нь Христийн ухааныг мэдэх явдал биш юм. “Учир нь үсэг хөнөөдөг бол, Сүнс амь өгдөг аж” (2Коринт 3:6) гэдэг билээ.

Фарисайчууд сүнсийг нь мэдэхгүйгээр Бичээсийг цээжээрээ мэддэг байсан учраас, үйлчлэл нь үхлийг бий болгодог байжээ. Тэдний үйлчлэл хүмүүсийг Бурханы зүрх рүү бус, Бурханы зүрхнээс чангаадаг байв. Тэд Бурханыг зүрхээрээ бус, тархиараа ойлгосноороо төлөөлөн, хүмүүсийг хуульчлалын мэдлэгээрээ Бурханаас тусгаарладаг байж.

Есүс ““Хүн зөвхөн талхаар бус, харин Бурханы амнаас гарах үг бүрээр амьдарна” гэж бичигдсэн байдаг” (Матай 4:4) гэсэн. Есүс “гарсан” гэж хэлээгүйг тэмдэглээрэй. Энэ бол өнгөрсөн цаг. Бичээс нь Бурханы амнаас гарсан. Гэтэл Есүс “гардаг” хэмээн одоо цаг дээр хэлжээ. Бид Бурханы амнаас өнөөдөр юу *гарч байгааг* мэдэхийн тулд Бичээсийн Эзэнийг нь мэдэх хэрэгтэй.

Иохан 16:13-14 дээр Есүс “Харин үнэний Сүнс ирэхдээ та нарыг бүхий л үнэн өөд удирдана. Тэр Өөрөөсөө биш харин алив сонсох юмаа ярина. Ирэх зүйлийг Тэр та нарт мэдүүлнэ. Тэр Минийхийг авч та нарт мэдүүлэх учир Намайг алдаршуулна” гэсэн. Есүс “сонссон” бус, “сонсох” гэж хэлсэн байгааг тэмдэглэнэ үү. Ариун Сүнсний хүчээр бид Есүсийн айлдаж буй үгийг мэдэж чадна.

Та “Тэгвэл Бичээс ямар ач тустай?” гэж асуух байх. Бичээс нь бидэнд тусалж, чиглүүлэх хөтөч болой. Бичээс нь Бурханы амьсалаар төрсөн бөгөөд Ариун Сүнсээр хөндөгдхөн үедээ тархинд маань оршоод байх бус, харин зүрхэнд маань амилна. Бичээс нь бидний хувьд, Бурханы Сүнснээс сонссон зүйлээ баталгаажуулах жишиг болой. Ариун Сүнс хэзээ ч

Бичээстэй сөргөлдөх зүйл ярихгүй. Харин бид Ариун Сүнсний уг, үйлсийг Бичээсийн талаарх төрөлх ойлголтынхоо цар хүрээндээ тааруулан хязгаарлаад ирэхээрээ л төвөг ургуулдаг. Парисайчууд яг энэ алдааг гаргасан юм.

Бүлэг, эшлэлийг мэдэх хангалтгүй

Фарисайчууд маш мэдлэгтэй хүмүүс байсан. Үнэндээ тэд Хуучин гэрээний эхний таван номыг цээжилдэг байж! Тэд Бичээсийг судлан, Мессаиаг харуулдан хүлээж байсан. Гэвч тэд Аврагчийг Бичээсийн талаарх ухааныхаа ойлголтоор л харуулджээ. Тэд Исаиагийн зөгнөлийг мэддэг байв:

Учир нь бидний төлөө Хөвгүүн төрж, Бидэнд Хүү өгөгдсөн аж. Засаглал Түүний мөрөн дээр байж, Түүний нэрийг Гайхамшигт Зөвлөгч, Хүчит Бурхан, Мөнхийн Эцэг, Энхийн Жонон гэж дуудна. Давидын сэntий дээр Түүний хаанчлал дээгүүр засаглал хийгээд амар тайван нь тэлэхүйд эцэс үгүй. Шударга ёс, үнэн зөвөөр үүнийг өдгөөгөөс өнө мөнхөд тогтоон тулна. Түг түмдийн ЭЗЭНий зүтгэл үүнийг гүйцэлдүүлэх болно (Исаиа 9:6-7).

Тэдний Мессаиа нь газар дээр хаанчлалаа байгуулаад, тэднийг Ромын дарлалаас чөлөөлөөд, Давидын сэntийд залрах байв. Тиймээс Есүсийг Галилын Назарын мужааны дүрээр ирээд, өөрийгөө харанхуй бүдүүлэг загасчид, татвар хураагчдаар хүрээлэхэд нь Парисайтнууд бүдэрсэн.

Фарисайчууд Бичээсийн талаарх хүнийхээ ойлголтоор байнга Есүстэй сөргөлддөг байсан. Тэд Мессаиаг аугаа их үндэсний удирдагч болно гэдэгт бат байв. Тиймээс Есүстэй “Та Мессаиа юм бол, байгуулах хаанчлал чинь хаана байна? Яагаад Давидын сэntийд залрахгүй байгаа юм?” гэх зэрэг асуултаар мөргөлдөж байсан.

Үүнд нь Есүс “Бурханы хаанчлал ажиглагдахуйцаар ирэхгүй. Хэн ч “Хараач, тэнд байна” гэх юмуу эсвэл “Хараач, энд байна” гэж хэлэхгүй. Харагтун, Бурханы хаанчлал нь та нарын дунд байна” (Лук 17:20-21) гэж хариулсан. Өнөөдөр бид Есүс үхээд, дахин амилсан гэдгийг мэдэж байгаа. Гэтэл тухайн

үед Фарисайчууд өөрсдийгөө зөв гэдэгт бат итгэж байв. Тэд Бичээсийг ойлгох тархины ойлголтоороо л ийнхүү итгэлтэй байжээ. Тэдэнд Сүнсний ойлголт байгаагүй.

Сүнсээр илчлэгдсэн

Симеон гэдэг хүн Мессаиаг харуулдан хүлээж байжээ. Тэрбээр Фарисайчууд шиг Их мэдэх байсангүй. Гэтэл түүний талаар Библию гэснийг үзнэ үү:

Үзэгтүн, Иерусалимд Симеон гэгч зөвт агаад сүсэгт хүн байв. Тэр хүн Израилийн тайтгарлыг хүлээж байсан бөгөөд түүний дээр Ариун Сүнс байлаа. Эзэний Христийг үзэхээс нааш өөрийг нь үхэхгүй хэмээн Ариун Сүнс түүнд илэрхийлсэн байжээ. Тэр, Сүнсэнд хөтлөгдсөөр сүмд ирэв. Хүү Есүсийнхээ төлөө хуулийн ёслол үйлдэхээр эцэг эх нь Түүнийг сүмд авчрах үед Симеон, Есүсийг гар дээрээ авч, Бурханыг магтаад

—Эзэнтэн, Та үгийнхээ дагуу Зарц намайгаа амар тайван явуултугай. Учир нь нүд минь Таны авралыг харлаа. Хүүгийн эцэг эх Түүний тухай хэлсэн энэ үгэнд ихэд гайхаж байлаа (Лук 2:25-30,33).

Есүсийг Эзэнд даатгахаар сүмд авчрах тэр үед Есүс зургаан сараас хоёр насны хооронд л байсан. Сүм ч хэд хэдэн барилгатай, нүсэр байгууламж байв. Тэнд ер нь бол хэдэн зуу, хэдэн мянган хүн холхилдоно.

Одоо үүнийг төсөөлөн бодно уу: Энэ түм түчигнэж, бум бужигнасан газар Галилын нэгэн мужаан гэргий, зургаан сартай хүүгээ дагуулсаар явна. Тэднийг тэр олон хүний дунд явж байтал, мөнөөх Симеон гуай хүрч ирээд, нялх хүүг өргөөд “Миний Мессаиа!” хэмээн эш үзүүлжээ. Иосеф, Мария хоёр ч гайхаж хоцорсон нь аргагүй!

Симеон “МЭӨ 4-ээр зуунд *Мессаиа ирэх 101 шалтгаан*” гэдэг номыг уншиж судлаад, Мессаиа айсуйг мэдээгүй шүү. Тэрбээр энэ мэдээллийг Бичээсээс уншиж судлаагүй. Тэрбээр Мессаиа айсуйг Ариун Сүнсний илчлэлээр л мэджээ. Тэрбээр Ариун Сүнсний хөтөлгөөгөөр сүмд ирж!

Бодохуйяа гайхмаар баримт шүү. Хуулийн мэдлэггүй тэр хар бор хүн зургаан сартай Есүсийг Мессаиа мөн болохыг нь таньчихаад байхад, гучин жилийн дараа Фарисайчууд нүдэн дээр нь чөтгөрийг хөөж, өвчтэйг эдгээж, сохрыг нүд оруулж, үхсэнийг амилуулах Есүсийг Мессаиа болохыг таниагүй! Эзэний ухаантай байх, Бичээсийн мэдлэгтэй байхын ялгаа энэ.

Тэгвэл Фарисайчууд Хуучин гэрээг хязгаарласан шиг, бид ч бас Шинэ гэрээгээ хязгаарлачихаагүй байгаа? Доктрин Бурхан, бидний хооронд харилцаа тогтоохгүй, зүгээр л тодорхойлдог! Би хуriman дээрээ “Зөвшөөрч байна!” гэж хэлэхдээ, гарын авлага хүлээн аваагүй, харин гэргийтэйгээ хувийн харилцаа эхлүүлсэн.

Тэгэхээр, Библиэ уншихаа болих ёстой юу? Үгүй юм аа! Гэхдээ арай өөрөөр унших хэрэгтэй байх. Би Библиэ авахдаа, Ариун Сүнснээс Эзэний үгийг илчилж өгөхийг ямагт гүйдаг. Тэгээд уншихад, зүрхэнд маань үнэн тэсэрдэг. Энэ үнэн нь миний амьдрах ёстой уг болой!

Саруул ухаан нь Бурхан яг одоо юу хэлж, хийж байгааг мэддэг. Зөвхөн Бурханы Сүнс л үүнийг хийж чадна. Тэрбээр Бурханы үгийг зүрхэнд маань зүгээр л мэдүүлнэ эсвэл аяархан, зөвлөн дуугаараа хэлнэ. Бурханы хэлсэн үгийг мэдэхдээ, бид ганхашгүй хадан дээр суурилна.

Тэрбээр эрх мэдлээр өгүүлдэг

Сайн мэдээ Есүсийг эрх мэдэлтэй ярьсан тухай байнга өгүүлдэг. Дараах явдлыг үзнэ үү:

Тэгээд Есүсийг үгээ гүйцээмэгц ард олон сургаалыг нь гайхаж байлаа. Тэр хуулийн багш нар шиг бус, эрх мэдэлтэй Нэгэний хувьд тэдэнд зааж байв
(Матай 7:28-29).

Есүс эрх мэдэлтэй яриад зогсохгүй, эрх мэдэлтэй үйлдсэн. Өөр нэгэн түүхийг үзнэ үү:

Бүгд гайхаж, өөр хоорондоо —Энэ юун сургаал вэ? Тэр эрх мэдэл хийгээд хүчээр бузар сүнснүүдэд тушаахад тэд гарцгаах юм гэж ярилцаж эхлэв (Лук 4:36).

Есүсийн амьдрал, үйлчлэлийн эрх мэдлийг Ромын цэргийн дарга ч олж харсан байдаг. Тэрбээр Есүст “Таныг тушаахад л зарц маань эдгэрнэ” (Матай 8:5-10) гэсэн. Ромын цэргийн дарга Есүсийн эрх мэдлийн ундаргыг ойлгожээ. Есүс Өөрт нь Аавынх нь хүслийг илчилдэг Ариун Сүнсэнд бүрэн захирагддаг байв.

Цэргийн дарга “Би өөрөө эрх мэдэлд захирагддаг хүн, миний дор ч цэргүүд бий” гэж хэлсэн. Энэ уг нь Есүсийг бишруүлсэн. Эрх мэдэл дор байх нь эрх мэдэлтэй байхын үндэс гэдгийг Ромын цэргийн дарга ойлгосон байв! Есүс Өөрөө эрх мэдэл дор байсан учраас, эрх мэдэлтэй үйлддэг байжээ. Есүс Өөрт нь Аавынх нь хүслийг илчилдэг Ариун Сүнсэнд бүрэн төгс захирагддаг байж. Есүс:

“Учир нь Би Өөрөөсөө яриагүй, харин юу хэлж, юу ярих тушаалыг Намайг илгээсэн Эцэг Өөрөө өгсөн юм” (Иохан 12:49) гэж хэлсэн.

Мөн:

“Би юуг ч Өөрөөсөө үйлдэж чадахгүй. Би сонссоноороо шүүх бөгөөд шүүлт минь шударга. Учир нь Би Өөрийнхөө хүслийг бус харин Намайг Илгээгчийн хүслийг хайдаг” (Иохан 5:30) гэж хэлсэн.

Эрх мэдэл нь Ааваас нь болохыг Есүс тодорхой тайлбарласан:

“Би Эцэгийн дотор, Эцэг Миний дотор байгаа гэдэгт чи итгэхгүй байна уу? Миний та нарт хэлж байгаа угсийг Би Өөрөөсөө хэлээгүй. Харин Миний дотор оршигч Эцэг үйлсээ хийж байгаа юм” (Иохан 14:10).

Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Эцэгээс хийж харуулсныг нь л Хүү хийхээс Хүү юуг ч Өөрөөсөө хийдэггүй. Учир нь Эцэг юу хийнэ, Хүү нь бас эдгээрийг түүнчлэн хийдэг (Иохан 5:19).

Есүс Бурханы Хүү мөн боловч, Бурханы Сүнсээр дүүрэн хүн шиг амьдарсныг бүү мартаарай. Тэрбээр тэнгэрийн эрх ямбаасаа бүрэн буусан. Тийм боловч, Есүс гайхаж ангаймаар

эрх мэдлийг тушаадаг байв. Учир нь Тэрбээр Бурханы Сүнсний удирдамжаар ярьж, үйлддэг байжээ. Бурхан хэзээ ч аиж сүрдээгүй учраас, Есүс хэзээ ч аиж сүрдээгүй билээ. Бурханыг давах хүч, чадал, мэдлэг үгүй!

Фарисайчууд хуулийн, зальжин асуултаараа айлган сүрдүүлэх гэж оролдож байхад ч, Есүс эрх мэдлээ сахин хамгаалсан. Тэд Есүсийг хэлсэн үгээр нь ороож, доош хийх гэж оролдсон. Гэвч тэдний урхи хичнээн зальжин байсан ч, Есүс айлган сүрдүүлгийг тасар татан, Ариун Сүнсээрээ хариулдаг байв. Есүс цэц ухаанаараа тэднийг хилэгнэн айлган сүрдүүлэхээс өөр аргагүй болтол нь барьц алдуулдаг байв.

Хэн ч хариуд нь Түүнд үг хэлж чадаагүй бөгөөд тэр өдрөөс хойш нэг ч хүн Түүнээс юм асууж зүрхэлсэнгүй (Матай 22:46).

Аав намайг илгээсний адил

Тэгэхээр, хамгийн гайхамшигтай мэдээ нь: “Амар амгалан та нарт байх болтугай. Эцэг Намайг илгээсний адил Би бас та нарыг илгээнэ” (Иохан 20:21). Бид Түүн шиг л амьдарч, ярьж, үйлдэх ёстой. Тиймээс Есүс биднийг:

Өөрийгөө хамгаалах гэж урьдаас бэлдэхгүйн тулд зүрх сэтгэлээ төвшитгө. Та нарыг эсэргүүцэгчдээс нэг нь ч эсэргүүцэж, хориглож чадахааргүй үг болоод мэргэн ухааныг Би та нарт өгөх болно (Лук 21:14-15) хэмээн урамшуулжээ.

Зарим хүн Библийн үгийг судлачихаад, зөвхөн оюуныхаа хүрээнд л авч үздэг учраас, эрх мэдэлтэй ярьж, зааж, номлож чаддаггүй. Тэд Бурханы хэлж, хийж байгаа зүйлсийг бус, хийсэн, хэлсэн юмысг л ярих! Бид Бурханы Сүнсээр ярьсан нөхцөлд л эрх мэдэлтэй ярина.

Байгаа юмандаа сэтгэл хангалуун байж, амьдрал чинь мөнгийг хайлрахаас чөлөөтэй байг. Учир нь Тэр Өөрөө “Би чамайг хэзээ ч орхихгүй мөн чамайг хаяхгүй” гэж

айлдсан. Тиймд бид зоригтойгоор “Эзэн миний туслагч. Би айхгүй. Хэн надад юу хийж чадах вэ?” гэдэг
(Еврей 13:5-6).

Юу гэж хэлсэн байгааг нь дахин анхааралтай харна уу. Бид Бурханы хэлж ярьж байгааг мэдэж байгаа цагтаа эр зориг, эрх мэдэлтэй ярина! Бурханы үгийн баталгаа нь бидэнд эр зориг өгдөг. Бурхан биднийг Өөрийнх нь үгийг мэдэж, Бурхан бидэнтэй хамт гэдэгт итгэж байгаа цагтаа “Хүн намайг яах юм бэ?” гэж зоригтой тунхаглаж чадна хэмээн баталгаажуулжээ. Энэ бат итгэлээр амьдарч байгаа цагт бид айж сүрдэхгүй!

Орчин цагийн Фарисай

Нэг удаа надтай миний хэлдгээр орчин цагийн Фарисайчууд буюу Сүнсгүй хүмүүс ирж уулзсан юм. (Тэд бол хэлээр ярьдаг ч, Бурханы Сүнсгүй хүмүүс!) Тэд бүлэг, эшлэлийг бусдаас хурдан хэлж чадна.

Энэ хүмүүс миний дөнгөж сая номлосон бас магадгүй миний бичсэн зүйлээр надтай халз тулсан юм. Би ойлгохгүй учраас, суралцахын тулд асуулт асуудаг хүмүүсийн талаар яриагүй шүү. Тийм хүмүүст би дуртай. Би бүхнийг өөрсдийнхөө шашны параметрээр гүйлгээд, доктриных нь хайрцагт багтаагүй хүн бүр, юм бүрийг няцаадаг хүмүүсийн талаар ярьж байна.

Харилцан яриа хоёр чиглэлийн аль нэгээр нь өрнөдгийг би ажигласан билээ. Нэгдүгээрт - би тэдэнтэй Бичээсийн талаар оюуны яриа өрнүүлээд, цуцаж болно - ялангуяа санаагаа батлах эшлэлээр зэвсэглэсэн хүмүүстэй ийм маягаар ярилцбал, их цуцна. Тэд ялна, би сүрдэнэ. Би ийм занганд орохгүй байхыг сурсан!

Хариулах нөгөө зам нь Ариун Сүнсийг сонсож, зүрхэндээ сонссоноо ярих. Тэр үед Бурханы цэц ухаан тодорч, хүмүүсийн маргаан намждаг. Бурханы цэц ухаан ямагт Бичээсээс төрдөг боловч, Ариун Сүнсний амьсгалаар амилуулагдсан байдал.

Хэдэн жилийн өмнө би нэгэн үйлчлэгчтэй хамт нисч явав. Бид хоёр тэр онгоцонд маш хурц ухаантай, хэл ам нь гүйцэгдэхгүй нэгэн Еврей эмэгтэйтэй таарсан юм. Бидний дунд Эзэн Есүсийн талаар хурц яриа өрнөв. Бид хоёр ч Есүс бол Мессаина мөн болохыг батлах гэж ар араас нь янз бүрийн

мэдэгдэл хийж байлаа. Энэ хооронд эмэгтэй Есүсийг Мессаиа биш болохыг батлах гэж оролдоор байв.

Гэтэл би гэнэт юу хийж байгаагаа ухаарч, энэ оюуны мэтгэлцээн юунд ч хүргэхгүйг мэдэх нь тэр. Тиймээс би дотроо Ариун Сүнснээс чиглүүлэг хайтал, Тэрбээр надад юу хэлэх ёстойг мэдүүлэв. Би эмэгтэй рүү хараад, Ариун Сүнсний үгийг хэллээ. Үүнийг хэлэх хооронд миний дуу хоолой өөрчлөгдж, үгээс маань эрх мэдэл ханхлав. Эмэгтэй тэр үгийг сонсоод, нүд нь томорч, дуугаа хураасан юм. Эмэгтэйд бидний мэтгэлцээн нэмэр болоогүй бол, харин Эзэний үг шууд тусжээ.

Биднийг онгоцноос буухад, надтай хамт явсан үйлчлэгч: “Жон, чамайг тэр үгийг хэлэхэд Эзэний оршихуй мэдрэгдсэн шүү. Эмэгтэй хэлэх үггүй болсныг чи харсан уу?” гэж билээ. Бичээсийн талаарх тархины ойлголтоороо үр дүнгүй хэрүүл бүү хий. Үүний оронд Ариун Сүнснээс сүнсний цэц ухаан хүлээн ав.

Бид үүнийг хүний мэргэн ухааны сургасан үгсээр бус, харин Сүнсний сургаснаар, сүнслэг зүйлсийг сүнслэгт нь тайлбарлан ярьдаг. Харин сүнслэг нь бүхнийг шүүдэг байхад, түүнийг хэн ч шүүж цэгнэдэггүй. Тэгээд ч “Түүнд зааварлахуйцаар Эзэний оюун ухааныг хэн мэдсэн юм бэ?” Гэвч бидэнд Христийн оюун ухаан бий
(1Коринт 2:13, 15-16).

Христийн ухаантай хүн шүүгдэхгүй, аиж сүрдэхгүй! Би Бурханы Сүнс рүү хараагүй цагтаа хичнээн ч удаа аиж сүрдэж явлаа.

Биднийг Есүстэй адилхан яваарай гэсэн (1Иохан 2:6). Есүс Ариун Сүнсний хийгээрэй гэснийг л хийдэг байсан. Бид ч ингэх аваас, эрүүл ухаантай байж, айлган сүрдүүлэг, хянан захиргаадалтыг ялан дийлэх болд зоригтой байна.

Эзэн минь, би яах билээ?

Бид Христийн ухаангүй байвал, хөшиж царцаад, Христийн хийлгэхээр илгээсэн даалгаврыг гүйцэтгэж чадахгүй нөхцөлд орно. Яг ийм нэгэн явдал надад Мексикт тохиолдож билээ.

Би Мексикийн Монтерей хотод хотыг хамарсан сайн мэдээний цуглаанд номлохоор уригдсан юм. Би нэг л орой номлох байсан бөгөөд бүх зардлаа өөрөө дааж явав. Тэнд очоод хагас өдөр залбирлаа. Залбирч байхдаа, бидний цуглах байран дээр хар үүл хуралдаж байхыг үзэв. Тэгээд Эзэнээс юу болохыг нь асуутал, Эзэн: “Жон, энэ харанхуй оройн цуглааныг эсэргүүцэн босч байна. Залбираасаар бай” хэмээлээ.

Над дээр маш хүчтэй тосолгоо бууж, залбирах хүчтэй болгов. Гучин минутын дотор би өөр зүйл харлаа. Байшингийн оройгоос хурц гэрэл тэнгэр өөд харвав. Би дахиад л юу болохыг нь Эзэнээс асуулаа. “Энэ бол өнөө оройн цуглаан дээр буух миний шууд алдар” хэмээн Эзэн миний сүнсэнд хэлэв. Миний баярласан гэж.

Цуглаан оройн зургаан цагт эхлэх ёстой байв. Бид яльгүй эрт ирэхдээ, тэр цуглааныг зохион байгуулагч пастортай албаны хүмүүс уулзахаар ирсэн байхтай таарлаа. Тэр албан тушаалтныг хоёр дүрэмт хувцастай цагдаа дагалджээ.

Пастор албаны хүмүүсийг өрөөндөө дагуулж оров. Албаны хүн пастортай хэсэг Испаниар ярьж байснаа, над руу эргээд: “Та Испаниар ярьдаг уу?” гэж англиар асуулаа.

“Үгүй ээ” л гэлээ.

Тэгтэл албаны хүн надад: “Та өнөө орой цугласан хүмүүст аялал жуулчлалтай холбоотой үйл ажиллагааны талаар л ярина шүү” гэв.

Тэгээд дахин пасторт хандан юм ярив. Би пасторыг хараад л байлаа. Тэрбээр ямар ч баяр хөөргүй - үнэндээ айсан, тун базаахгүй царайтай харагдана.

Албаны хүн яриагаа дуусгаад, хоёр цэргээ дагуулаад яваад өгөв. Пастор намайг зайдуу аваачаад: “Жон, энэ хүн бол засгийн газрын ажилтан... чамайг номлож болохгүй гэж байна. Мексикийн иргэн биш л бол, номлох зөвшөөрөл олгохгүй гэсэн хууль байдаг. Уг нь энэ хуулийг хэрэгжүүлээд байдаггүй. Гэхдээ энэ хүн чамайг үнэхээр энд байлгахыг хүсээгүй болтой - энэ хуулиар түрүү барьж байна. Мөн чамайг Нэг дэхь өдрийн өглөө есөн цагт албан өрөөндөө байгаарай гэнэ” гэлээ.

Би чихэндээ ч итгэсэнгүй. Тэгээд шууд л пасторт: “Би номлох гэж л энэ хол замыг туулж ирсэн. Чи миний төлөө зовниж байгаа бол, зүгээр. Би номлоно” гэж хэллээ.

Тэгтэл пастор: “Жон, энэ бүхэн манай чуулганд ч нөлөөлнө.

Бөөн асуудал болно. Энэ хүн өндөр албан тушаалтан. Чи номлоогүй нь дээр” гэв. Тэр цуглааныг зохион байгуулагч - эрх мэдэлтэн нь айж сурдсан учраас, надад залбирахаас өөр ямар ч арга байсангүй.

Би тэр цуглаан хийгддэг, Монтерейн төвд байрладаг гимназийн байрнаас гарлаа. Би байрны урд байсан маш том далбааны шонг тойрон залбирч эхлэв. Тэр цуглаан дээр Бурханы алдар гийхийг Бурхан надад харуулсныг би мэднэ. Бурхан намайг энд ирэхийг зааварласан. Гэтэл би одоо ацан шалаанд орчилоод байдаг. Толгойд минь *Тэр сүрдүүлэгч албан тушаалтан надаар дамжуулан хийх Бурханы ажлыг зогсоох гээж үү?* гэсэн бодол эргэлдэнэ. Тэгтэл *Тэр хүн залбиралд минь Бурханы харуулсан ажлыг зогсоож чадахгүй гэж бодогдоно. Би одоо яах вэ?* гэдэг бодолтой босон суун тэмцэлдэв.

Тэгж байснаа: “Аав аа, би юу хийхээ мэдэхгүй. Гэхдээ Та энэ бүхэнд цочирдохгүй. Та үүнийг мэдэж байсан. Тиймээс надад Таны зөвлөгөө, цэц ухаан хэрэгтэй байна” гэж хэлээд Сүнсээр залбирч эхлэв. Тэгтэл толгойд

“Хүний зүрхэн дэх зорилгууд гүний ус Ухаан бодролт хүн үүнийг гадагш гаргах” (Сургаалт үгс 20:5) гэдэг уг орж ирэх нь тэр.

Есүс итгэгч хүмүүсийн зүрхнээс амьд усны гол урсаж гарна гэсэн (Иохан 7:38). Надад Бурханы зөвлөгөөний гол хэрэгтэй байлаа. Надад Христийн ухаан хэрэгтэй байлаа. Хэлээр залбирбал, энэ бүхэн ирнэ.

Ийнхүү хэдэн минут залбирсны дараа оюун ухаан маань намжин, Бурханыг сонсох чих улам онгойв. Зүрхэнд маань *Хүмүүст Мексикт зочлох хамгийн аугаа Жуулчны талаар ярьж өг* гэсэн бодол хөөсөрлөө.

Тэгээд би: “Яг! Тэр хүн намайг жуулчлалын талаар ярьж болно гэсэн. Би тэдэнд Мексикт айлчлах хамгийн аугаа Жуулчин - Есүс Христийн тухай ярина!” гэж хаширлаа. Дотроос минь баяр хөөр гижигдэж, би хөхөрч гарлаа.

Тэгээд байшин руу гүйж оров. Золоор, Бурхан пасторыг тайтгаруулсан байсан бөгөөд тэрбээр надад: “Бурхан надтай ярлаа. Түүний хэлснийг л хэлэхийг чамд хэллээ” гэв.

Би цуглааныг “Өнөөдөр намайг жуулчлалын талаар л яриарай гэсэн. Тиймээс би та нарт Мексикт айлчлах хамгийн аугаа Жуулчны талаар ярьж өгье” гэсээр нээлээ.

Тэгээд Эзэн, Аврагч Есүсийн тухай бүтэн цаг номлов. Есүс Христийг Эзэнээ болгон хүлээн авах дуудлагад хэсэг хүмүүс хариулсны дотор тахир татуу нэгэн хүн байлаа. Намайг тэр хэсэг хүмүүсийн авралын төлөө залбирсны дараа Эзэн надад: “Би түүнийг хамгийн түрүүнд эдгээмээр байна” гэсэн юм.

Би нөгөө хүн рүү хараад: “Эрхэм ээ, Бурханы Сүнс таныг эдгээхийг хүсч байна” гэж хэлээд, гар тавин залбирав. Тэгээд гараас нь хөтөлтөл, нөгөө хүн явж эхлэв. Эхлээд туйлын болгоомжтой хандаж байснаа сүүл сүүлдээ улам хурдалсаар, бүр надтай хамт гүйх нь тэр. Эцэстээ би түүний гарыг тавьж, тэрбээр өөрөө гүйлээ.

Цугласан хүмүүс бужигнаж гарав. Янз янзын өвчтэй хүмүүс урагш тайз руу гүйлдэв. Гэтэл энэ бүх бужигнаан дунд манай орчуулагч хаашаа ч юм алга болчихсон юм. Хэдэн зуун хүн тайзыг бүслэн оволзоно. Олон хүн эдгэрсний дунд нэг чих нь төрөлхийн таг дүлий, нөгөө нь муухан сонсголтой нэгэн эмэгтэй байв. Тэрбээр энгэрээ шалба нортол уйлж билээ. Үнэхээр гайхамшигтай!

Гэтэл нөгөө албан тушаалтан намайг номлобол, шууд баривчлаарай гээд хоёр хүнийг цуглаан руу явуулсан байсныг нь би мэдээгүй юм. Тэд намайг мөнөөх тахир татуу хүний төлөө залбирч байх үеэр иржээ. Тэднийг угтагч мэдсэн бөгөөд “Түүний юу хийхийг харж байгаад, баривчилья” гэж ярилцахыг нь сонсчээ.

Тахир татуу хүн эдгэрэх үед нэг нь нөгөөгөөсөө “Энэ үнэн болов уу?” гэж асуужээ. Тэд илүү ойртож зогсоод, Бурханы үйлсийг ажигласан байна.

Тэгээд мөнөөх дүлий эмэгтэйг эдгэрэх үед нэг нь “Үнэн юм шиг байна” гэж хэлсэн гэдэг.

Тэгж байтал таван настай нэгэн хүү Бурханы хүчинд автан, шалан дээр унав. Үүнийг харсан хоёр маань өөр хоорондоо “Яг үнэн байна!” гэж зөвшилцөөд, намайг баривчлахаар ирсэн хүмүүс чинь залбируулахаар урагш гарч ирэв!

Би албан тушаалтны ирж уулзаарай гэсэн тушаалыг биелүүлэлгүй, маргааш нь Мексикээс явсан юм. Долоо хоногийн дараа Мексик пастор Америкт нисч ирэхдээ, надад Монтерейн өдрийн сониныг авчирч өгөөд, сонини эхний нүүрэнд хэвлэгдсэн цуглааны талаарх нийтлэлийг уншиж өгөв.

Тэнд албаны хүмүүс намайг мөнгө хөөсөн доншуурчин -

залилагч хэмээн мэдээллэсэн тухай бичжээ (Ийнхүү би тэр улсаас ширхэг зоос ч авалгүй, бүх зардлаа өөрөө даасан нь ийм учиртай байсныг ойлгов). Тийм атлаа сонин дээр цааш нь хүмүүс жинхэнээсээ өдгөрэхийг харсан тухай бичсэн байв! Бурхан алдаршиг!

Албан тушаалтан айлан сурдуулгээрээ намайг зогсоохыг хүссэн. Пастор, бид хоёр заналхийлэлд нь автсан бол, бидний амьдрал дахь Бурханы бэлэг унтрах байж. Тэр орой хэн ч Бурханы үйлчлэлийг үзэхгүй, аврагдахгүй өнгөрөх байж. Миний эсрэг хуйлран боссон айлан сурдуулгийг хугачих эр зоригийг надад Ариун Сүнсээр дамжин ирсэн Бурханы Үг хайлажээ. Саруул ухааны хүч гэж энэ болой.

*Хүний үл тоодог юмсаар
Бурхан боломжгүйг үйлддэг.*

Арван дөрөвдүгээр бүлэг

ДАВШСААР БАЙ

Нехемиа Израилийг дарлалд байх үеэр амьдарч байсан Еврей хүн байв. Хэдэн жилийн өмнө Вавилончууд дайрч ирээд, Иерусалимыг устгаад, нэг хэсэг оршин суугчийг нь алаад, дийлэнхийг нь Вавилон руу олзоод аваад явжээ.

Бурхан Нехемиагийн зүрхэнд Иерусалимд буцаж очоод, хотын ханыг сэргээн босгох дуудлага өгсөн байна. Нехемиа харийн хаанд итгэмжтэй үйлчилсээр, хааны тааллыг олжээ. Хаан ч түүнд явж, зүрхэнд нь суулгасан Бурханы хүслийг биелүүлэх зөвшөөрөл олгосон байна. Нехемиа тэр даруй Иерусалимд очоод, Израилийн үлдэгсдийг цуглуулаад, дайсны устгасан бүхнийг сэргээн босгохыг урамшуулан ятгав.

Гэтэл тэдэнд аймшигтай эсэргүүцэл тулгарав. Санбаллат, Тобиа, Гешем гэгч нутгийн гурван албаны хүн ханыг сэргээн босгох ажлыг эсэргүүцжээ. Тэд Израилийн хөгжил цэцэглэлийг жадлан эсэргүүцсэн. Тэд Нехемиаг болоод Бурханы хүмүүсийг зогсоохоор шийдээд, тэднийг зүйл бүрээр айлган сүрдүүлэв.

Тэр удирдагч нар анх Нехемиагийн төлөвлөгөөг олж мэдэхдээ “шоолон басамжилсан” (Нехемиа 2:19) гэдэг. Тэд Нехемиагийн багийн урмыг хугалаад зогсохгүй, хүмүүсийн нүдэнд мунхаг харагдуулахыг хүсчээ. Тэгээд “Босгож байгаа юмныхы нь дээгүүр хэрэв үнэг харайвал тэдний чулуун хэрмийг нураачихна” (Нехемиа 4:3) хэмээн доош нь хийжээ.

Хүмүүс ч таныг шоолж, ажил үйлсийг чинь үл тоох байдлаар айлган сүрдүүлэхийг оролдоно. Тэд таныг басамжилж, зүрхэнд чинь Бурханы өгсөн бүхнийг үнэхээр хийх чадвартай эсэхэд чинь эргэлзүүлнэ. Тэд энэ явуулгаа нүүрэн дээр чинь хийж болно эсвэл ар нуруугаар чинь хүмүүсийн дунд хийж болно. Эсвэл хүмүүс биш, харин *Хүмүүс юу гэж бодох бол?* Намайг

элэглэх болов уу? Би бүтэлгүйтэх болов уу? гэсэн бодол таныг дотроос чинь бөмбөгдөж байж болох.

Энэ тохиолдолд бид Бурхан “цэцдийг ичээхийн тулд өртөнцийн мунхгийг сонгож, хүчтэйг ичээхийн тулд өртөнцийн мөхсийг сонгосон” (1Коринт 1:27) гэдгийг санан, Бурханы өгсөн зааврыг мэдэж байх нь амин чухал. Хүний үл тоодог юмсаар Бурхан боломжгүйг үйлддэг. Тэгээд бүх алдрыг авах!

Нехемиа Эзэний ухаантай болтлоо мацаг барин залбирчээ. Тэгээд “Тэнгэрийн Бурхан бидэнд амжилтыг өгнө. Тиймээс Түүний зарц нар бид босоцгоон барих болно. Харин та нар Иерусалимыг босгосны дараа ямар нэг хувь, эрх эсвэл дурсагдах зүйл хайсан ч та нарт юу ч ногдохгүй” (Нехемиа 2:20) хэмээн дайснаа зоригтой сөржээ.

Дайсан Нехемиаг зогсоож барахгүй, Израильчуудын ажил урагшилсаар байгааг ойлгоходоо, галзууртлаа уурласан. Тэд инээхтэй манатай болов. Тиймээс хот руу довтлон, хамаг төслийг самрах хуйвалдаан боловсруулжээ (Нехемиа 4:7-8).

Айлган сүрдүүлэх өөр нэгэн зэвсэг нь уурхилэн юм. Уурхилэн таныг чичрүүлэн, барьц алдуулах зорилготой. Уур хилэнгээс нэг бол эрээ цээргүй, нөгөө бол чимээгүй заналхийлэл ирнэ. Ийм маягаар самууруулах нь айлган сүрдүүлэх тун үр нөлөөтэй багаж болдог. Хүмүүс бусдын уур хилэнгээс зайлсхийсэндээ, зөв хэмээн мэдсээр байгаа зүйлээсээ ухрахыг би олонтаа харсан. Тэд хуурамч энх тайвныг сахихын тулд тусгай буулт хийдэг.

Гадаад, дотоодын дарамт

Нехемиа руу бурханлаг бус харийнхан дайрч давшлаад зогсохгүй, тулгарч байгаа нөхцөл байдалдаа цуцсан өөрийнхөн нь ч төрөл бүрийн асуудал гаргаж эхэлжээ. Бурхан бидэнд захирамж өгөх үед гадна, дотны эсэргүүцэл ихэсдэг нь байdag л зүйл.

Нехемиагийн эрчүүдихэд цуцсан. Тэдний бүтээн байгуулалтын ажилд хэрэгтэй, хэрэггүй баахан саад тулгарсан (Нехемиа 4:10). Эдгээрийн нэг нь хөрөнгөтэй ажилчид нь өртэй айл өрхүүдээс тариан талбайгаа ашиглуулсны түрээс гэж өндөр хүү, татаас авч, санхүүгийн маш хүнд ачаа үүрүүлж байжээ (Нехемиа 5:1-8). Үүнээс болж хүмүүс гэр бүлээрээ зүдэрч байв. Дотоодын энэ асуудал нь гадаадын дайсны халдлагаас ч хүнд тусч байжээ.

Тал талаас айлган сүрдүүлсэн нь

Би яг ийм нөхцөлд орж байсан. Намайг дөнгөж аялж эхэлж байхад, пасторгүй болсон нэгэн цуглаан ирж туслахыг гүйсан юм. Тэр цуглаан найман зуухан хүнтэй, алс хязгаарын нэгэн хотын цуглаан байв. Хоёр цуглааны дараа өсвөр насынхан бүгдээрээ, дээрээс нь зарим насанд хүрэгчид гэмшиж, Бурханы хүчийг үзэв. Энэ бүхний ачаар цуглааны ирц хоёр дахин нэмэгдлээ. Гэргий, бид хоёр тэр хүмүүсийг үнэн голоосоо хайлласандаа, тэр цуглааныг шинэ пасторт нь бэлтгэн, баг бэх суурь тавихаар шийдэн, ирэх зургаан долоо хоногийн хамаг аяллаа цуцалсан юм.

Гэтэл миний номлол зөвлөлийн зарим гишүүний гэдэнг хөдөлгөжээ. Нэг эр гуравдугаар цуглаанд иртэл, түүний гэргийтэйгээ суудаг эхний хоёр эгнээг нь өсвөр насынхан эзэлчихсэн байсанд ундууцав. Өмнө нь өсвөр настын хөвгүүд, охид цуглааны араар л суудаг байж.

Зарим нь намайг хэт хүчтэй үйлчилж байна гэв. Товчхондоо - зөвлөлийн гишүүд намайг хянан захиргаадахыг хүсчээ. Тэд цуглаанаа өөрийнхөөрөө л авч явахыг хүсчээ. Тэдэнтэй хэд хэдэн удаа уулзсан хойноо би: “Би энд байх зургаан долоо хоногийнхоо хугацаанд л эрх мэдэлд байгаад, шинэ пасторт чинь шилжүүлнэ. Өөр замгүй. Өөрсдөө шийд” гэж хэлсэн юм.

Тэдний саналаа хэлэх өдөр тэр газрын хар тамхины наймаачин над руу залгав. Түүний эхнэр нь цуглаанд явдаг байлаа. Эхнэр нь түүнд хамгийн сайн найзтай нь явалдсаар байгаагаа илчилсэнд, мань эр уур бухимдлаа надад болоод чуулганд гаргахаар шийдсэн юмсанж. Тэгээд мань хүн тэр шөнө хэрэг тарина гэлээ.

Би ч түүний заналхийлэлд нэг их ач холбогдол өгсөнгүй. Хэдэн цагийн дараа биднийг дэмжиж байсан зөвлөлийн нэгэн гишүүн манай руу яриад, мөнөөх хар тамхины наймаачин цуглааны цагаар бөмбөг дэлбэлнэ гэж заналхийлсэн тухай мэдэгдэв. Би ч түүнд: “Цагдаагийн газарт шалгаж өгөх хүсэлт гарга” гэсэн заавар өглөө.

Хэдэн цагийн дараа цагдаагийн газраас ярив. Цагдаагийн албан хаагч: “Бивэр, та цагдаагийн газарт ирээд, тэр хүнийг баривчлах бичиг дээр гарын үсэг зурна уу” л гэж байна.

АЙЛГАН СҮРДҮҮЛГИЙГ ЯЛАХУЙ

Тэгэхээр нь би түүнд: “Офицер оо, би наад хүнийг чинь баривчлуулмааргүй байна. Наад хүн чинь зовж байгаа. Зүгээр л өнөө орой цуглааны байрыг тодорхой хэмжээнд хамгаалж өгөхийг л хүсч байна” гэлээ.

Цагдаагийн ажилтан: “Би дөрвөн цагийн дараа буулаа. Манайхаас гадна хамгийн ойрын цагдаагийн газар жараад километрийн зайд бий. Тэд өнөө шөнө хүн илгээж чадахгүй” гэв.

Тэгэхээр нь би: “Гэхдээ л би наад хүнийг чинь баривчлуулмааргүй байна” гэлээ.

Тэгсэн цагдаагийн ажилтан: “Бивэр, та энд хэр удаан амьдарч байгаа билээ?” гэж байна.

Би ч тэр хотод амьдардаггүй болохоо хэллээ.

Цагдаа: “Бивэр, би тэр хүнийг мэднэ. Ер нь бол зартай хүн. Хар тамхины наймааны хэргийн сэжигтэн. Хэдэн аяга шар айраг уучихсан байвал, би л лав зүгээр суллаад явуулчихгүй байсан” гэв.

Би чихэндээ ч итгэсэнгүй. Тэр хүнийг цагдаа өөрөө аюултай гэж байгаа бол, аюултай л хүн байж таарах нь. Гэсэн ч би түүнийг баривчлах бичиг дээр гарын үсэг зурмааргүй байлаа. Тиймээс татгалзаад, цагдаагийн ажилтанд талархлаа.

Надад тэр хүний заналхийлэл төдийгүй, зөвлөлийнхэн том асуудал болж байв. Тэгээд “*Ёстай хөгтэй юм. Зөвлөлийнхэн надад бөөн төвөг учруулжс байдал. Тэд намайг явуулахыг хүсч байгаа. Гэтэл бас нэг галзуу хүн гарч ирээд, манай гэр бүлийг занаад уналаа*” гэж бодлоо.

Би шууд л хөлийнхөө тоосыг сэгсрээд, гэр бүлээ аваад, нар жаргахаас өмнө тэр хотоос арилаад өгмөөр байв. Би ч Бурхан намайг илгээснийг мэдээгүй байсан бол, гэр бүлээ бодоод яваад л өгөх байсан. Гэтэл дараах шалтгааны улмаас хаяад явахыг зүрх маань зөвшөөрсөнгүй: Нэгдүгээрт - Бурхан намайг ииш нь илгээсэн бөгөөд намайг яваарай гэж хэлээгүй. Хоёрдугаарт - би Бурханы мутар хүрэлцсэн тэр олон хүнийг зүгээр хаяж явахыг хүссэнгүй. Гуравдугаарт - хүн айж сүрдсэндээ нэг зугтсан бол, дараа нь дахиад л зугтдаг.

Зөвлөлийнхэн намайг үлдээх шийд гаргабал, Би Эзэний ухаантай байж, үлдэхээр шийдэв. Тэгээд үдээс хойшжин залбирлаа. Тэр залбирал миний амьдралын хамгийн хүчтэй залбирлын нэг байсан байх. Бурханы бэлэг намайг бэхжүүлж, би оройн цуглаанд бэлэн болов.

Тэгээд цуглаан дээр явж очтол, намайг үлдээхээргүй болсон байлаа. Зөвлөлийнхэн цуглааны өмнө хуралджээ. Тэгээд намайг явуулахаар болсныг нэг дикон нь мэдэгдэв. Тэр орой би тэнд эцсийн удаа номлосон юм.

Хичнээн гашуудаж байсан ч, би тэр орой хүмүүсийн төлөө Бурханы хийх үйлс дээр л төвлөрөхөөр шийдэв. Би ч хүчтэй номлож, Бурхан ч хүчтэй бууж, хүмүүс ч газраар нэг тэрийж унаалаа. Итгэлээсээ няцсан олон хүн Эзэнд дахин амьдралаа өргөв. Заналхийлэгч цуглаанд үзэгдсэн ч үгүй. Цуглааны дараа би зөвлөлийнхэн намайг явуулахаар шийдсэн тухай мэдэгдсэнд, хүмүүс ч шаагилдаад л явчихав. Би хагарал авчрахаар ирээгүй. Тиймээс явах гэж байгаадаа тайван байлаа.

Долоо хоногийн дараа нөгөө зөвлөлийнхэн маань нэгэн пасторыг сонгосон нь хожим ижил хүйстэн байсан нь илэрчээ. Ирэх жил нь тэд дөрвөн пастор сольсон байна. Тэр чуулганы зөвлөл дунд ажилладаг айлган сүрдүүлгийн сүнс тус чуулганыг ихэд сүйрүүлсэн гэдэг.

Хүчтэй байж, төвлөр

Нехемиа дотоодын зөрчлөө шийдвэрлэв үү үгүй юу бас нэгэн айлган сүрдүүлгийн цохилтод өртөв.

Санбаллат, Гешем нар надад захидал илгээн —Ирнэ үү! Оногийн талд Хефиirimд бүгдээрээ уулзацгаая! гэв. Гэвч тэд намайг хорлох санаатай байв. Тиймээс би тэдэн уруу элч нарыг илгээж, “Би агуу ажил хийж байгаа бөгөөд очиж чадахгүй. Би үүнийг орхиж та нар уруу очих хооронд энэ ажлыг зогсоох хэрэг юу байна вэ?” гэж хэлүүлэв. Тэд надад ийм утгатай захидал дөрвөн удаа илгээсэн бөгөөд би тэдэнд нөгөө л утгатай хариугаа өгөв (Нехемиа 6:2-4).

Санбаллат, Гешем хоёр Нехемиаг сатааруулах гэж үзсээр байгаа ч, Нехемиа хүчтэй байж, Бурханы тушаал дээр төвлөрсөөр байна. Тэрбээр захирамжаасаа няцсангүй.

Дайсан бидний ажил үйлсийг үр дүнгүй болгохын тулд сарниулах гэж үзнэ. Сатан ганц удаа хийгээд зогсохгүй ээ. Сатан тууштай. Тиймээс бид энэ тал дээр Сатанаас ч тууштай

байх ёстой. Тиймээс л Библи “бат итгэлээрээ түүнийг эсэргүүц” (1Петр 5:9) гэдэг. Бат гэдэг нь “хүчтэй, хатуу, хөдлөшгүй” гэсэн үг. Олон хүн ялан ялтлаа гүрийсээр байхын оронд дайсандаа хэд цохиулаад л буугаад өгдөг.

Санбаллат тав дахь удаагаа Нехемиа руу зарцаа илгээсэн бөгөөд энэ удаа Нехемиаг Иудагийн хааныг унагах бослого хөдөлгөөн дэгдээх хэрэгт ялласан захидал өгч илгээсэн байна (Нехемиа 6:5-7). Энэ нь оп үндэсгүй худал байв.

Тэгэвч Нехемиа зогссонгүй. Тэрбээр гүтгэгч нарын аар саар явуулгад автахааргүйгээр бат төвлөрсөн байв. Гэтэл бид айлган сүрдүүлэгч дайсантайгаа учир зүйгээ олох гэсээр замаасаа гарах нь олонтаа.

Би олон ч удаа хүн рүү харж байгаад: “Чи яагаад энэ хүний худлаар Бурханыхаа дуудлагыг баллана вэ? Тэр хүн чамайг яллалаа гээд, түүний зөв юмуу тэрбээр үнэнийг хүсч байна гэсэн үг биш! Чиний талаар Бурхан юу хэлж буйг, чамд Бурхан юу төлөвлөснийг л мэд. Мунхаглалтай учир зүйгээ ололцно гэж байх уу?” гэж хэлж явсан даа. Библи “Мунхаглалаар мунхагт бүү хариул, адил болуузай” (Сургаалт үгс 26:4) гэдэг.

Нехемиаг зогсоох гэж үзсэн сүүлийн хүн нь “дайсан алахаар айсүй учраас, сүмд очиж нуугд” (Нехемиа 6:10) хэмээн Нехемиад эш үзүүлжээ. Нехемиа амиа аврахаар ажлаа орхисон бол, ажилчид нь суларч, ажлаа гүйцээж чадахгүйд хүрэх байжээ.

Тиймээс үүнд нь Нехемиа “Над шиг хүн зугтаах гэж үү? Над шиг нэг нь сүм уруу ороод амиа аварч чадах уу? Би орохгүй” (Нехемиа 6:11) гэж хариулсан. Тэгээд дараа нь тэр хүнийг Бурхан илгээгээгүй, харин Тобиа, Санбаллат нар хөлсөлсөн болохыг нь олж мэддэг. Үүний дараа Нехемиа юу гэж хэлснийг үзнэ үү:

Намайг айлгаж, ийм аргаар нүгэл үйлдүүлэх гэж тэрээр хөлслөгдсөн бөгөөд ингэснээр намайг буруутгах муу нэрийг тэд өгч чадах байлаа (Нехемиа 6:13).

Дайсан таныг ямар ч үнээр хамаагүй амиа хамгаалтал сүрдүүлэн, муу нэрийг зүүж орхиж чадна. Нехемиа Эзэний ухаантай байсан тулдаа муу бөгөөд худлаас цэвэр бөгөөд үнэнийг ялгаж таньжээ.

Санбаллат, Гешем, Тобиагийн төлөвлөгөөг Нехемиа ингэж дүгнэсэн юм:

Учир нь тэд бүгдээрээ “Тэд ажилдаа мохож, ажил нь гүйцэд хийгдэхгүй” гэж бодож, биднийг айлгахыг хичээж байв. Харин одоо, гарыг минь тэнхрүүлээч Бурхан минь ээ (Нехемиа 6:9).

Мөн л “биднийг Бурханы хүслийг гүйцэлдүүлэх, айлан сүрдүүлгийг сөрөх чадалгүй болтол сульдаах” айлан сүрдүүлгийн зорилгыг харж байна. Айлан сүрдүүлгийн өөдөөс бат сөрөхгүй бол, тээглэж унана шүү.

Биднийг дайсны газар нутагт нэвтрэх үед дайсан - диавол бүх төрлийн айлан сүрдүүлгийг хэрэглэнэ. Нэг удаа оролдоод л буугаад өгөхгүй. Тэр биднийг зогсоож, хойшлуулж, сулруулж чадбал, Бурханы хаанчлалын ажлыг саатуулж чадлаа гэсэн үг.

Нехемиагийн багханаа бүрэн босгосон. Эдүгээ хамгаалалттай болсон хот цааш сэргээн босгогдох боломжтой болжээ. Энэ бүхэн амар байгаагүй. Алхам тутмаа аймшигтай эсэргүүцэл, сөргөлдөөнтэй тулгарсан. Гэвч хүмүүс Бурхан үгээ айлдсаныг мэдэж байсандаа, ухраагүй юм.

Эсэргүүцлийг сэтэлж гарах

Нехемиагийн гүргэр чанар итгэгч хүмүүсийг:

Би хэдийнээ олж авсандаа эсвэл хэдийнээ төгс болчихсондоо бус, харин Христ Есүст юуны төлөө баригдсан, түүнийг л барьж авахын тулд мөрдөхөд (давшихад) (Филиппой 3:12) улам бүр ятгах ёстой.

Түлхүүр уг нь *давших*. Нехемиатай адил зүйл бүрийн байнгын эсэргүүцлийг сөрж гарсан Паул Ариун Сүнсээр “Би давшдаг” гэж хэлжээ. Бид эсэргүүцлэлтэй мөргөлдөөд, зогсчихож болохгүй. Бид эсэргүүцлийг сэтлээд гарах ёстой. Паул цааш нь:

Христ Есүс дотор Бурханы дээш чиглэсэн дуудлагын шагналын төлөө бария өөд урагшилдаг (Филиппой 3:14) гэж хэлжээ.

Өндөр дуудлага, бага дуудлага гэж байна. Өндөр дуудлага нь

газар дээр тэнгэрийн жишгээр амьдарч, хувийнхаа амьдарлаар Бурханы хаанчлалыг харуулах амьдрал болой. Өндөр дуудлагаар аж төрдөг хүмүүс хүрээлэн буй орчноо хянадаг. Тэд эрх мэдэл дээрээ байснаараа дарамттай сүнсний уур амьсгалыг эрх чөлөө болгож хувиргадаг.

Харанхуй гэрлийг барахгүй. Гэрэл харанхуйг хөөх. Гэрэл хүрц байх тусмаа, их харанхуйг хөөнө. Бид Бурханы хаанчлалын эрх мэдэл дор алхах үед ийм юм болно. Бид орчин тойрноо Бурханы хаанчлалын эрх мэдэл дор оруулна.

Есүс уур амьсгалыг захирч байсан учраас л, нүгэлтнүүдтэй хамт идэж уусан. Та Бурхан дотор диавол доторх үл итгэгчээс илүү хүчтэй байвал, уур амьсгалыг захирна. Муу доторх үл итгэгч нь зөвт байдал доторх итгэгчээс илүү хүчтэй байвал, үл итгэгч сүнсний уур амьсгалыг захирна.

Та өндөр дуудлагаар амьдрахаар шийдэхдээ, эсэргүүцэлтэй заавал тулгарна. “Үнэндээ, Христ Есүс дотор сүсэг бишрэлтэй амьдрахыг хүсэгч бүх хүн хавчигдах болно” (2Тимот 3:12). “Бид олон зовлон туулж байж Бурханы хаанчлалд орох ёстой” (Үйлс 14:22).

Тийм атал Христэд итгэдэг хүмүүс бага дуудлагаар амьдрах санаа зорилготой байдаг. Яагаад? Тэд өндөр дуудлагын төлөө давшихад дагалдаж ирдэг эсэргүүцэлтэй мөргөлдөхийг хүсдэггүй. Тэд орчноо бурханлаг халз тутаанаар өөрчилж байснаас уур амьсгалдаа уусан зохицохыг хүснэ. Онцгойрохоос уусах нь амархан. Зарим хүн эсэргүүцэлтэй тутаахаараа аль болох найраа хийж, аль болох эсэргүүцэл багатай арга замыг л сонгох.

Эсэргүүцэхийг хүсэхгүй байх дургүйцэл маань билний амьдралын ая тух, аюулгүй байдалтай их бага хэмжээгээр холбоотой гэдэгт би итгэдэг. Бид амьдралынхаа хэв маягийг аль болох бэрхшээлийг тойруулж засдаг. Би мэдээж зохиомол бэрхшээлийн талаар яриагүй. Тийм боловч бид Бурханд итгэхээсээ илүү өөрийнхөө төлөвлөгөө, хөтөлбөрт найдаж явдгийг би итгэлтэй хэлнэ.

Бид даатгалтай. Өвдөх юм бол, залбирахаасаа өмнө төлбөрийг нь даатгалаараа төлчих учраас, эмч рүү гүйнэ. Хоёр долоо хоногийн зайдай цалингаа авчихна. Ажилгүй болбол, ажилгүй болсны нөхөн төлбөртэй. Тэр мөнгөө дуусбал, нийгмийн халамжтай. Нийгмийн халамжгүй болсон ч, залхуурлыг маань хөхүүлэн дэмжих, ямар нэгэн өөр халамжийн хөтөлбөрт хамрагдана.

Зурагт нь бидний идэвхигүй амьдралыг бүр ч хөхүүлэн дэмжээд өгнө. Америкчууд долоо хоногт дунджаар хорин дөрвөн цаг зурагт үздэг!¹¹ Бид юуг яаж бодож сэтгэхээ Холливүүд тэргүүтэй сүлжээгээр заалгадаг болсон. Бид тэдний хөтөлбөрөөс шингээсэн ойлголтоороо санаа бодлоо хэлбэршүүлдэг болсон.

Богино долгионы зуух, түргэн хоолны газрууд нь биднийг хүч хөдөлмөр багатай, түргэн хоолоор хангадаг болсон. Бүр арван таван минутын дотор хоол нь гарахгүй бол, үнэгүй идэж болно гэж байгаа. Түргэн шуудан, нэг цагийн хими цэвэрлэгээ, нэг цагийн зураг, машины тос тосолгоо солих гялс төв, цагийн хязгааргүй дэлхийн мэдээг унших зэрэг нь бидний эдэлдэг тав тухын наадзах нь билээ.

Мэдээж ихэнх нь биднийг гол ажлаа хийх цаг завтай болгодог, чухал юмс. Тийм боловч бид гол ажлаа мэдэхээ байжээ. Өнөөдөр маш олон хүн ажил хөдөлмөрөөс зугтдаг болсон.

Харамсалтай нь энэ сэтгэлгээ манай Барууны чуулганд ч нэвчжээ. Бурханы өндөр дуудлагыг биелүүлэхэд шаардагдах зан чанарыг бий болгохын төлөө тууштай явж байгаа нь тун цөөхөн. Эсэргүүцэл үзэв үү, үгүй юу шууд эсэргүүцэл багатай зам руу эргэнэ. Зугтах зам нь эхэндээ амар, сайхан сонголт шиг харагддаг л юм. Гэвч энэ зам буулт, хайхрамжгүй зан, амиа бодох зэрэг царцуу зан чанараас л тогтоно.

Есүс бидэнд дайсагналын уултай нүүр тулбал, уул зайлтуулагдана гэж зааварласан. Тухайлбал: Чулуу чулуугаар нь ширхэглэн зөөх ёстой болсон ч, тэр уулыг нураа! Христ доторх жинхэнэ дайчид Нехемиа шиг итгэдэг хүнд бүх зүйл боломжтой гэдэгт бат итгэн (Матай 17:20) уулыг сэтлэхээр урагш давшдаг юм. Тэгвэл зарим нь асуудлыг шийдэхээс зайлан, уулыг тойрсон, амар замыг сонгодог.

Энэ дэлхийн урсгалыг агаарын хүчиний ханхүү тогтоодог (Ефес 2:2). Тэнгэрийн ноёрхол энэ урсгалыг шууд сөрдөг. Тэнгэрийн замаар явах нь дэлхийн системтэй байнга мөргөлдөнө гэсэн үг. Харамсалтай нь, энэ дэлхийн систем чуулганд ч ноёлдог.

Би энэ эсэргүүцлийг ширүүн урсгалтай голыг сөрж сэлүүрдэхтэй зүйрлэдэг юм. Урсгал сөрөхийн тулд амсхийлгүй сэлүүрдэх ёстой. Усанд сэлүүрээ лав зоогоод, тасралтгүй сэлүүрдэнэ. Нэг ч зогсож болохгүй. Зогсох л юм бол, өмнөх сэлүүрийнхээ эрчээр нэг хэсэгтээ өөдөө явж болох ч,

төдөлгүй хар эрчээрээ урсгал даган урсана. Завь чинь урсгал өөдөө харсаар байж болох ч, урсалаа даган урсана. Энэ бол давшдаггүй итгэгч хүмүүсийн дүр зураг юм. Тэд Христэд итгэх итгэлийн зүг харсаар байж болох ч, ар нуруугаараа дэлхийтэй хамт урсана. Тэд шашиналаг болно. Тэд хүчээ алдаж, үр дүнгүй болно. Есүсийн Өөрийнх нь хэлдгээр тэд “юунд ч хэрэггүй” болно! (Матай 5:13).

Хүчтэй бай!

Паул Тимотод Бурханы бэлгийг сээрээ гэж хэлээд, тэр даруй араас нь “Иймд хүү минь, Христ Есүст буй нигүүлслээр зоригтой бай” (2Тимот 2:1) гэсэн байдаг. Айлган сүрдүүлгийг ялж, давшихын тулд бид хүчтэй байх ёстой.

Паул Коринтын чуулганд “Сээрэмжтэй бай. Итгэлдээ бат зогс. Эршүүд бай, хүчтэй бай” (1Коринт 16:13) хэмээн анхааруулсан. Зоригтой итгэгч бэрхшээлээс хулгалгүй, шууд нүүрэлддэг.

Бурхан Иошуаг зоригтой, хүчтэй байхыг нэг бус, долоогийн долоон удаа урамшуулсан!

Гагцхүү тууштай бөгөөд чин зоригтой бай. Миний зарц Мосегийн чамд тушаасан бүх хуулийг сахин биелүүл. Үүнээс баруун тийш ч, зүүн тийш ч бүү хазай. Тэгвэл чи хaa явсан газраа амжилт олно (Иошуа 1:7).

Бурхан Иошуаг хүчтэй, зоригтой бай гэжээ. Яах гэж? Дайнд ялах гэж үү эсвэл аугаа удирдагч болох гэж үү? Үгүй юм аа. Эзэний Үгийг сахихын тулд. Ингэснээрээ Иошуа аугаа удирдагч болж, тулаан бүртээ ялалт байгуулах байв! Айлган сүрдүүлэг таны Бурханы Үг, хүслийг дагах эрх чөлөөг хуулдаг. Тиймээс байнга хүчтэй, зоригтой байхгүй л бол, нэг л мэдэхнээ зөвөөс дайжиж одсон байх бий.

Урам зориг гэдэг үгийг тодорхойль ё.

Энэ нь бэрх, аюултай, зовиуртай хэмээн хүлээн зөвшөөрөгдөх юмсаас ухарч зугтахын оронд нүүр тулж, шийдвэрлэх хандлага, хариуцлага юм.²

Тэгвэл урам зоригийн эсрэг зүйл нь юу вэ? Та шууд л айдас юмуу дорой байдал гэх байх л даа. Тодорхой хэмжээгээр үнэн л дээ. Тийм боловч ард нь -гүй нөхчлийг нэмье л дээ. Тэгвэл урам зориггүй гэдэг үг үснэ. Тэгэхээр, Бурхан Иошуад зүрхэндээ

урам зориггүй байдлыг зөвшөөрөлгүй, хүчтэй, зоригтой байхыг тушаажээ. Урам зориггүй байдал нь биднийг Бурханы хүслийг биелүүлэхээс хорьдог!

Урам зориггүй байдлыг тодорхойль ё:

Урам зоригоор дутах; итгэл үнэмшил, найдваргүй болох; зүрх үхэх.³

Елиа Иезебелийн айлган сүрдүүлэгт яаж дарлуулсныг санаж байна уу? Шууд ухраад, зугтсан. Зүрх үхсэндээ, эрх мэдлээсээ унасан. Бид урамгүй байдлыг дайснаа гэж үзэх ёстай. Урамгүй байдал биднийг Бурханы өндөр дуудлагыг биелүүлэхээс чангаах чадалтайг бид мэдэхгүй байна. Бурхан Өөрөө Иошуад хүчтэй, зоригтой бай гэж долоон удаа хэлсэн бол, бид ч үүнд анхаарах ёстай. Урамгүй байдал бол алуурчин! Халз тулахгүй л юм бол, биднийг ухрахад хургэнэ.

Харин зөвт хүн итгэлээр амьдарна. Хэрэв тэр ухрах аваас Сэтгэл минь түүнийг эс таална (Еврей 10:38).

Бурхан хулчгар занг таалдаггүй. Бидэнд “Ялагч нь үүнийг өвлөх бөгөөд Би түүний Бурхан болж, тэр Миний хүү болно. Харин хулчгар, итгэлгүй, жигшүүрт, алуурчид, завхайрагчид, мэргэчид, шүтээнд мөргөгчид болон бүх худалчуудад ногдох хувь нь хоёр дахь үхэл буюу хүхэр, галаар шатаж буй нуур юм” (Илчлэл 21:7-8, тодруулгыг нэмэв) гэж хэлсэн.

Хулчгар гэдэг нь “Зовлон, аюул үзээд шившигтэйгээр айdag хүн.”⁴ Бурхан хулчгар хүмүүсийг алчуурчид, бэлгийн ёс бусчудтай нэг ангилалд багтаасан нь аймшигтай бус уу? Тийм байтал бид хулчгар занг сул тал хэмээн шалтаглан өмөөрөх.

Үгүй юм аа. Хулчгар зан нь итгэлгүй байдлаас төрдөг. Итгэлгүй байдлаасаа болж Израилийн хүүхдүүд амиа алдсан. Тэд амлагдсан газартаяа хэзээ ч ороогүй. “Итгэлгүй учир тэд орж чадаагүйг бид хардаг” (Еврей 3:19).

Өнөөдөр ч ялгаагүй. Хулчгар хүн ялахгүй. Тэрбээр амлалтыг хүлээн авахгүй. Эзэн биднийг элч Паулаар дамжуулан ятгасан:

Христийн сайнмэдээнд л зохицой амьдар. Тэгвэл би ирээд, та нарыг харлаа ч эсвэл байхгүй байлаа ч та нарыг сайнмэдээний итгэлийн төлөө нэг сэтгэлээр хамтдаа зүтгэж, нэг сүнс дотор бат зогсоцгоож мөн эсэргүүцэгчдийн юунаас ч айж сүрдэхгүй байгааг чинь би сонсоно. Энэ нь тэдэнд сүйрийн тэмдэг, харин

та нарт Бурханаас ирдэг авралын тэмдэг юм (Филиппой 1:27-28).

Дайсанд айлган сүрдүүлэх боломж олголгүй, бат зогс. Зоригтой, хүч, урамтай байж, эсэргүүцлээс зугталгүй, нүүрэлдээд, шийдвэрлэ! Паул дараагийн эшлэлдээ:

Учир нь Христийн төлөө Түүнд зөвхөн итгэх бус, Түүний төлөө бас зовох нь та нарт соёрхогджээ (Филиппой 1:29) гэж хэлсэн.

Бид ямар зовлон үзэх вэ? Үүнд Петр хариулжээ:

Иймээс Христ нэгэнтээ махбодоороо зовсон тул та нар ч гэсэн ижил санаагаар өөрсдийгөө зэвсэглэ. Учир нь махбодоороо зовсон нь нүглийг дуусгасан. Энэ нь биеэр амьдрах үлдсэн хугацаандаа цаашид хүний хүсэл тачаалын төлөө бус, харин Бурханы хүслийн төлөө амьдрахын тулд юм (1Петр 4:1-2).

Махан бие маань юмуу бусдын нөлөө биднийг нэг зүг рүү явахыг дарамталж байхад, Бурханы хүсэл биднийг нөгөө зүг рүү явахыг чиглүүлэх үед бид зовлон үзэж, эдэлдэг. Бидэнд Эзэний үгийг сахихын тулд хүчтэй бөгөөд зоригтой байхыг тушаасан.

Петр биднийг үүний төлөө зэвсэглээрэй гэсэн. Зовлонд бэлтгэлгүй, зэвсэггүй Христэд итгэдэг хүн дайнд зэвсэггүй яваа цэрэгтэй л адил. Тэр цэрэг нэг бол олзлуулна эсвэл алуулна. Зовлонд зэвсэггүй Христэд итгэдэг хүн амархан олзлуулж, хүнээс айх айдын - айлган сүрдүүлгийн хоригдол болно.

Бид өндөр дуудлагыг маань дагаж ирдэг эсэргүүцлтэй тулахад бэлэн байх ёстой хэдий ч, Паул “Эзэн, намайг алив ёрын муу үйлээс гэтэлгэж, тэнгэрлэг хаанчлалдаа аваачих болно. Түүнд алдар нь үеийн үед байх болтугай. Амен” (2Тимот 4:18) гэдгийг бушуухан хэлжээ. Бурхан биднийг үргэлж алдар руугаа чөлөөлнө.

Доорх Бурханы ятгалга үгийг үзнэ үү. Хэзээ ч дуулж яваагүй үг мэт уншаарай. Үг бүр дээр зогсоод, Ариун Сүнсээр эрэлтүүлэн, тунгаан бодоорой.

Тэгвэл бид эдгээр зүйлийн тухайд юу хэлэх вэ? Хэрэв Бурхан бидний талд юм бол, хэн биднийг эсэргүүцэх вэ? (Ром 8:31)

Хэн биднийг Христийн хайраас салгах юм бэ? Гамшиг уу, шахалт уу, хавчлага уу, өлсгөлөн үү, нүцгэрэл үү, аюул уу, илд үү? ...Харин бид энэ бүхний дотор биднийг хайрладаг Түүгээр дамжин давуулан дийлдэг (Ром 8:35, 37).

Бяцхан хүүхдүүд ээ, та нар Бурханых бөгөөд тэднийг дийлсэн. Учир нь та нарын дотор байгаа Тэр бол дэлхийд байгчаас аугаа (1Иохан 4:4).

Зүрхнийхээ цэврийг хамгаалж, Бурханы хүүхдийн бөгөөд зарцын эрх мэдэл дээрээ зогс. Тэр цагт та:

*Эзэн миний туслах, Би айхгүй.
Хүн намайг яах юм бэ?”*

хэмээн зоригтой тунхаглана.

Эпилоги

Эцэст нь хэлэхэд, өмнөх алдаа эндэлдээ бүү боолчлуул. Өнгөрснөөр ирээдүйг бүү шүү. Ингээд байвал та үлдсэн амьдралаа өнгөрсөндөө л барна. Ямар хүчтэй унасан байсан ч, бидэнд аугаа найдвар бий: Бурхан адгийн хулчгарыг аварга болгодог мэргэжилтэн! Биднийг сүл дорой үед Түүний хүч төгс ажилладаг.

Би таныг Петрийн дүү Андрейгийн амьдралаар урамшуулмаар байна. Есүсийг баривчлагдсан тэр шөнө “... бүх шавь нар Түүнийг орхин зугтжээ” (Матай 26:56). Петр ганцаараа айсан юм биш, Андрей ч бас амиа авран зугтжээ. Гэхдээ нэг удаа хулчийснаасаа болж Андрей насан турш хулчгар хэвээрээ үлдээгүй юм. Есүсийг амилсны дараа Андрей Ромын захиргаанд байсан Етиопт очиж номложээ. Есүсийг алдаршуулсан Андрейгийн түүхээс дурьдъя:

Андрей хичээнгүй номлолоороо олон түмнийг Христэд итгэлд дагуулахад, захирагч Эйгос Ромын сенатаас Христэд итгэгчдийг албадан Ромын бурхадад мөргүүлж, тахил өргүүлэх зөвшөөрөл хүсчээ. Андрей Эйгостой нүүр тулахаар шийдэв. Андрей Эйгост хүний шүүх нэн түрүүнд тэнгэрийн Шүүгчээс эмээх ёстойг хэлжээ. Түүнчлэн ухаан санаанаасаа бүх худал бурхад, сохор шүтээнийг устгаж, жинхэнэ Бурханд мөргөх хэрэгтэй гэв.

Андрейгийн ярианд автсан Эйгос Андрейгаас “саяхан бурхдын сүмийг нурааж, хүмүүсийг Христэд итгэхийг ятгасан, Ромчуудын хууль бус гэж зарласан “сэжиг бүхий сект” чи мөн үү?” гэж лавлав.

Харин Андрей түүнд Ромын захирагч нар үнэнийг ойлгохгүй байгааг хэлжээ. “Ромын бурхад нь чөтгөрүүд бөгөөд жинхэнэ Бурханыг эсэргүүцэж, Түүнээс нүүр буруулахыг хүн төрөлхтөнд заадаг гэж Есүс сургасан юм. Есүс бол Хүний дүрээр ирсэн Бурханы Хүү болой. Диаволд үйлчилсэнээрээ хүн өөрөө муу

ёрын болсон. Тэд үхсэн ч, муу ёрын үйлс нь л дурсагдана.”
Андрей ингэж л яржээ.

Зөвлөл Андрейг цаашид ийм юм бүү номло, номлох аваас даруй цовдлох ялтай хэмээн тушаав. Харин Андрей “Хэрэв би загалмайн үхлээс айдаг байсан бол, загалмайн алдар, хүндэтгэлийн талаар номлохгүй байсан юм” гэж хариулжээ. Түүнд “гаж сургааль” зааж, Ромын бурхдын шашныг доромжилсон хэргээр цовдлох ял оноосон юм.

Андрей цаазын тавцан руу алхаж явахдаа ч, өөрийг нь цовдлох загалмайг хараахдаа ч зангаа хувиргаагүй, угээсээ ч буцаагүй. Үхэх гэж буй хүн шиг тэрбээр ухаан ч алдсангүй, зорилгоосоо ч няцсангүй. Андрей: “Хамгаас үгүйлж, хамгаас хүссэн загалмай минь! Чиний дээр өлгөгдсөн Эзэнтэний боол би чам дээр сайн дураараа, баяртайгаар ирж байна. Би чамайг хичнээн ч их хайлаж, хичнээн ч их санагалзав” гэж хэлжээ.

Есүсийг баривчлагдахад амиа авран зугтсан тэр Андрей биш гэлтэй. Андрей өөрчлөгджээ.

Үнэндээ мөнөөх орой зугтаж явсан дагалдагч нар Есүс Христийг гэрчилснийхээ төлөө эцэстээ бүгд алуулсан юм. Бурхан тэдэнд зугтсан зүйлтэйгээ нүүрэлдэх завшаан хайлажээ. Тэд амиа өгснөөрөө айлан сүрдүүлгийн хүчийг тасар татсан!

“Та нарын дотор сайн үйлийг эхлүүлсэн Тэрбээр үүнийгээ Христ Есүсийн өдрийг хүртэл төгс төгөлдөр болгоно гэдэгт би бат итгэж байна” (Филиппой 1:6) гэдэг үг танд тайвшрал авчрах буй за. Бурхан бүтэлгүйтлийг ялалт болгож хувиргадгийг та дагалдагч нарын амьдралаас хараа биз? Бүү ухар. Харин таныг хайлласан Нэгэн таны төлөө амиа өгсөн гэдэгт итгэсэн шиг итгэ!

Одоо хамтдаа залбиръя:

*Аав аа, хайр болон цэц үхаанаараа намайг хүчтэй болгооч.
Хүнд бэрх цагт аж амьдрал, ая тухаа бодон ухарч
байсныг минь өриөөгөөрэй. Эзэн Есүс минь, өнөөдөр
би өөрийгөө үгүйсгэж, загалмайгаа аваад, Таныг дагах
шиийдвэр гаргаж байна. Би бол Таны зарц; би Таны Үг,
хүслийг эр зоригтой, хайраар ярьж биелүүлэхийн тулд
хүчирхэг нигүүлслийг тань хулээн авья.*

Харин одоо айдас, хяналтын сүнсэнд ийнхүү тушаа:

Би өөрийнхөөт амаар хэлсэн эсвэл өрөөлийн амнаас сонссон бүх айдас сүрдүүлэг, хяналтын үгийг амьдралаасаа тас татаж байна. Амьдралыг минь хүлж байгаа, “хүнээс айх айдсын” атгыг би тасалж байна. Харанхуйн сүнсүүд ээ сонс, би өөрийгөөт Бурханд өргөж, та нарыг эсэргүүцэж байна. Та нар миний амьдралд байх газаргүй. Тиймээс Есусийн нэрээр зайл. Амень.

*Та нарыг бүдрэхээс хамгаалж, Өөрийнхөөт алдрын оршихууд үлэмжийн баяр хөөртэйгөөр, гэм зэмгүйгээр зогсоож чадах
Түүнд, бидний Аврагч болох цорын ганц
Бурханд, бидний Эзэн Есус Христээр алдаф суу, сүр жавхлан, ноёрхол,
эрх мэдэл нь бүх цагаас өмнө,
эдүгээ болоод мөнхөд байх болтугай. Амен.*

Иуда 24-25

ӨНӨ МӨНХӨӨР ХӨТЛӨГДӨХҮЙ

Өнөөдөр ч, үүрд мөнхөд ч
унэ цэнэтэй байх амьдрал



Энэ амьдралын нөгөө талд юу ч байхгүй гэж хүмүүс боддог. Гэтэл Бичээс “Хүн энэ ертөнцөд хэрхэн амьдарснаараа нөгөө ертөнцөд хэрхэн амьдрахаа шийднэ” гэх. Энд л хэрхэн амьдарснаараа, тэнд авах шагнал, шийтгэлээ шийдүүлнэ.

Жон Бивэр бидэнд 2Коринт 5:9-11 дээрх зарчмыг сануулаад, хүн бүр Христийн өмнө үйлсийнхээ дагуу шүүгдэж, олон хүн мөнх настгүй зүйлд хамаг амьдралаа зориулсанaa ойлгоод цочирдохыг хэлжээ. Тэгвэл хүн яаж ач холбогдолтой амьдрах вэ? “Өнө мөнхөөр хөтлөгдөхүй” ном таныг амьдралынхаа дуудлагыг олох, хүлээж авсан бүхнээ өсгөн үргүүлэх мөнхийн зарчимд сургаж, өөрийгөө өнө мөнхөд үнэлэгдэх ажилд зориулахад чинь чиглүүлнэ.

Татаж аваарай:



MessengerX.com

АФФАБЕЛ

Өнө мөнх рүү өнгийх цонх
(Сонсдог жүжиг)



“Аффабел” нь Жон Бивэрийн бичсэн сонсдог жүжиг юм. Үүнд энэ дэлхийн амьдралаас цаашхи бодит амьдралыг өгүүлэх бөгөөд үүгээр Бурханы хаанчлалын олон үнэнийг тусган харуулдаг. Итгэгч хүмүүс өнө мөнхийн хараатай амьдрах ёстой ч, олон хүн өнө мөнх гэж юу болохыг ч мэддэггүй.

Энд та Аугаа хаан Жэйлинтэй, харанхуйн хар санаат эзэн Дагонтай, Өгөөмөр, Бие даагч тэргүүтэй гол дүрүүдтэй, Аффабел хэмээх ер бусын нутагтай бас Ганц хэмээх аймшигт хөсөр газартай танилцаарай. Гол дүрүүдийн амьдралаар дамжин зүрхний чинь үнэн төрх илчлэгдэх үед та өөрийнхөө амьдралын талаар нэгийг бodoх буй за. “Аффабел” сонсдог жүжиг нь сонсогчийг нэгэнт ухааруулахын төлөө бүтээгдсэн “Өнө мөнхөөр хөтлөгдөхүй” номын жүжигчилсэн хэлбэр болно.

Татаж аваарай:



MessengerX.com

САТАНЫ УРХИ

Өстөн дайсныхаа ухлийн занганаас
эрх чөлөөтэй амьдар



“Сатаны урхи” ном нь ерөөсөө л гомдлын талаар өгүүлнэ. Гомдол нь итгэгч хүмүүсийг Бурханы хүслээс гаргахдаа тогтмол ашигладаг, дайсны хайртай урхи ажээ. Олон хүн энэ урхинд мэдээгүй явж орчилоод, орсон хойноо ч мэддэггүй.

Хүн энэ дэлхий дээр байгаа цагтаа гомдоос дархлаатай оршиж чадахгүй ч, гомдох эс гомдохоо сонгож чадна. Гомдлыг шийдвэрлэсэн хүн л хорслыг даваад, улам хүчирхэгжиж, Бурхантай саадгүй харилцана.

Хорсол, бухимдал, хар сэр, үл итгэлцлээс чөлөөлөгджэй, Бурханы хүсэл дор алхлан, амьдралаа Бурханд бүрэн даатгаж, училал, эвлэрэл, баяр хөөрөөр дүүрэн амьдрахын нууцыг эндээс сураарай.

Татаж аваарай:



MessengerX.com

САТАНЫ УРХИ

Өстөн дайсныхаа ухлийн занганаас
эрх чөлөөтэй амьдар
(Монгол бичгээр)



“Мараната” үйлчлэл Өвөр Монгол дахь Христийн чуулганы итгэгч хүмүүсийг итгэлд бэхжүүлэхийн төлөө мөн Монгол бичгээр унших хүснэгтэй бүх хүнд зориулж зохиолч Жон Бивэрийн Монгол хэл дээрх (кирилл бичиг дээрх) номуудыг Монгол бичиг дээр хөрвүүлэн буулгаж байгаа бөгөөд анхны бүтээл болох “Сатаны урхи” номоо та бүхэнд өргөн барьж байна.

Энэ номыг CloudLibrary.org хаяг дорх “Монгол бичиг” гэсэн хэсгийг сонгоод, үнэ төлбөргүй татаж авна уу. Монгол чуулганы энэ бэлэгийг Өвөр Монгол дахь Христийн итгэл нэгт ах, эгч дүүсдээ болоод Монгол бичигт нэвтэрсэн бүх хүнд түгээн дэлгэрүүлээрэй!

Татаж аваарай:



MessengerX.com

САЙНЫГ УУ, БУРХАНЫГ УУ?

Бурхангүй “сайн” сайн биш байдгийн учир



Сайн л бол, Бурханаас байх учиртай. Тийм үү? Өнөөдөр “сайн” хийгээд “Бурхан” гэдэг хоёр үгийг ижил утгатай үгс шиг хэрэглэх болжээ. Бид “сайн” гэж үздэг зүйлсээ Бурханы хүсэлтэй төгс эгнэх учиртай гэж итгэдэг. Өгөөмөр, даруу, шударга зан чанар нь сайн юмс. Амиа хоохойлох, тоомжиргүй зан, харгислал нь муу юмс. Ядах юмгүй ялгачихмаар харагдаж байна. Гэхдээ ингээд л боллоо юу? Сайныг ялгахад тийм амархан юм бол, Библи яагаад сайн, мууг ялгах хараатай бай гэж хэлсэн юм бол?

Энэ ном нь бас л нэгэн төрлийн хувь хүний хөгжлийн гарын авлага биш юм. Энэ ном танаас зүгээр нэг сайн сайхан, зөв хүн болохыг шаардахгүй. Энэ ном таны Бурхантай тогтоосон харилцааг хэзээ ч байгаагүй өндөрлөгт гаргаж, амьдралыг чинь эд эсээр нь ширхэглэн сэгсэрч, үндсээр нь эргүүлнэ.

Татаж аваарай:



MessengerX.com

ГЭРЛЭЛИЙН ТҮҮХ

Гэрлэлтээ авар



Эртээ урьдын цагт... Гэрлэлт бол үүрд өнө зүйл. Энэ нь нэг эрэгтэй, нэг эмэгтэйг холбож зангидал гэрээ бүхий харилцаа юм. Энэ холбоо тэднийг бүтээгдсэн анхны зорилгоор нь хөглөж, хүчирхэгжүүлнэ. Тэд тусдаа биш, хамтдаа байхдаа л хүчтэй. Харин энэ бүхний эхлэл нь хуrim юм. Хуrim нь амар сайхандаа жаргахын төлөө амьдралын босгыг давж буй, ариун нандин үйл явдал болой. Энэ амьдралын төлөөх сонголт бүр, үйлс бүр чухал. Зүрхээрээ нийлж, гараараа хөтлөлцсөн нөхөр, эхнэр хоёр тааж мэдэшгүй ирээдүйг чиглэн Бүтээгчийн хайраар амьдралаа сүндэрлүүлнэ.

Гэтэл бид энэ хайрын түүхээс хагацжээ. Тэгвэл “Гэрлэлтийн түүх” номоороо Жон, Лиза хоёр гэрлэлтэд хандсан Бурханы анхны төлөвлөгөөг дэлгэж байна. Та гэрлэсэн байна уу, гэрлэж амжаагүй байна уу, сүй тавьсан байна уу – Бурханы их хайрын түүхийн нэгээхэн хэсэг мөн болой.

Татаж аваарай:



MessengerX.com

АРИУН СҮНС

Түүнтэй танилцахуй



Анхны дагалдагч нар Есүстэй 3 жил хамт байж, Түүний заасан бүхнийг сонсож байсан. Харин загалмайд цовдлогдохынхоо өмнө Есүс: “Би явж Ариун Сүнс ирэх нь та нарт илүү дээр юм” гэжээ. Хэрэв Есүстэй өдөр бүр байсан дагалдагч нарт Ариун Сүнс амин хэрэгтэй байсан юм бол, бидэнд бүр их хэрэгтэй бус уу?

Жон Бивэр танд Ариун Сүнсийг танилцуулж, Ариун Сүнсний мөн чанар, хүч чадлыг заажээ. Таны итгэлийн төлөвшил ямар ч төвшинд байсан “Ариун Сүнс: Түүнтэй танилцахуй” ном танд Бурханыг улам ихээр дотно танин мэдүүлнэ.

Татаж аваарай:



MessengerX.com

СЭЛЭМТЭЙ ОХИД

Загалмайгаа жинхэнэ баатар шиг үүрье



Бурханы Үг болох илдний тухай судлах нь илдийг сугалж хэрэглэхээс амархан бөгөөд таатай байдаг. Охид бид тэнгэрийг газартай холбох цаг болжээ. Дэлхий даяар эмэгтэйчүүд алив гадуурхал, бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлийн бай болсоор байна.

Лиза Бивэр энэ номдоо эмэгтэйчүүдийн өнгөрснийг биш, харин ирээдүйг өгүүлжээ.

Тиймд Бурханы дайчин охид оо, эр зоригтойгоор босоод, ялгах чадвараа ашиглан, училж, мэргэн байж, сэлмээ эргүүлэн баатарлаг үйлсийг бүтээгээрэй.

Татаж аваарай:



MessengerX.com

КРИПТОНИТЫГ УСТГА

Хүчийг чинь сорогч зүйлийг устга



Супермэнд дайснаа дарах ер бусын хүч байдаг шиг, Христийн дагалдагч бидэнд ч тийм нэгэн хүч бий. Гэвч криптонит гэгч нэгэн бодис Супермэний хүчийг ч, дагалдагч бидний хүчийг ч ховх сордог. Мэдээж Супермэн, криптонит хоёр зохиомол зүйлс боловч, сүнсний криптонит нь жинхэнэ зүйл юм.

Анхны чуулганы итгэгч нарт байсан тэнгэрийн хүч яагаад өнөөгийн бидэнд байхгүй байгааг энэ ном тайлбарлана. Түүнчлэн криптонит гэж юу болох, яаж үйлчилдэг болох бас үүнийг хэрхэн устгахыг зааж өгнө.

Энэ номыг амьдралаа жинхэнээсээ өөрчлөх хүсэлтэй Христийн дагалдагч нарт зориулав. Уншсан шиг уншаарай!

Татаж аваарай:



MessengerX.com

БУРХАН МИНЬ, ТА ХААНА БАЙНА?!

Цөл дунд зорилготой бөгөөд хүчтэй байх



Өмнө нь Бурхан ярьдаг байснаа одоо таг дуугүй болжээ. Өмнө нь та итгэлээр явдаг байсан бол, одоо Бурханы оршихуй бараа сураггүй болжээ. Тэгвэл Бурханаас амлалт хүлээж аваад, энэ амлалт биелэхийг харах хоёрын дунд оршдог дамжин өнгөрөхөд тавтай морил.

Гэхдээ энэ нь ямар ч зорилгогүй хөсөр газар биш юм. Бурхан цөлөөр дамжуулан биднийг хувь тавиланд маань бэлтгэн, боловсруулдаг - гэхдээ ганцхүү та зөв хариу үйлдсэн тохиолдолд шүү. Олон хүний боддог шиг - энэ улирлаар туулах нь зүгээр л Бурханыг хүлээгээд суух явдал биш юм. Цөл дундуур жолоогоо зөв залахад таны үүрэг оройл их. Морин тойруулгаар эргэлдэж цагаа гарздах гээгүй л юм бол, цөлийг мэддэг байх хэрэгтэй.

Нүд тайлсан энэхүү номоороо бестселлер зохиолч Жон Бивэр таныг хуурай, бэрх улиралдаа жолоогоо зөв залсаар, Бурханы зэхсэн бүхэнд нэвтрэхэд чинь туслах Библийн түлхүүр болсон ухаарал, гүн түүхээр өсгөн боловсруулж байна.

Татаж аваарай:



MessengerX.com

ЭРСЛЭН СЭРЭВ

Сэргээд, ертөнцөө өөрчил



Бид бусдыг ямагт өрсөлдөгчөө хэмээн үзэж, өрсөлдөөн харьцуулалтаар өөрийгөө боомилдог нь цаанаа шалтгаантай юм. Үүний цаанаа биднийг өөр хоорондоо хэвэнд цутгагдчихсан мэт ялгарашгүй байлгахаар оюун санаа, хүсэл, сэтгэл мэдрэмж рүү маань байнга халдан довтолж байдаг дайсан бий. Бид энэ тойротг орохдоо дотно харилцаа холбоонаосоо тасарч, өөрийгөө хэн болоход эргэлзэж, зорилгоо гээдэг.

Өрсөлдөөнийг өөртөө ашигтайгаар эргүүлж, өөрийнхөө шилдгийг гарга. Өөрийнхөө тухай ярианаас бүү зугт. Эмэгтэйчүүд таarahгүй, тэнцэхгүй, гэнэдүү, гэнэн гэдэг маргаанд хариу барь.Хүйсийн өрсөлдөөнийг шийдвэрлэж, эрчүүдтэй мөр зэрэгцэн ажиллахыг сур. Өрсөлдөгчгүй амьдрах цаг иржээ!

Татаж аваарай:



MessengerX.com

Х: Бурханаас хүлээж авсан хүчин чадлаа үржүүл



Та Бурханы Хаанчлал дотор үзэгч юм шиг мэдрэмж тээж явна уу? Үйлчилмээр байгаа боловч хэрхэн гэдгээ мэдэхгүй байна уу? Бурханд үйлчлэхийг хүсдэг ч дараах асуултад хэрхэн хариулаахаа мэдэхгүй зөрчилдөж явна уу: Надад хандсан Бурханы хүслийг алдаагүй гэдгээ хэрхэн баталгаатай мэдэх вэ? Бурханы Хаанчлалын төлөө надад өгөгдсөн бэлэг авьяас ямар үүрэгтэй вэ? Бурханы өгсөн хүчин чадал дотор амьдарч байгаа гэдгээ хэрхэн баталгаатай мэдэх вэ? Би “Чуулганд” бүтэн цагаар үйлчилдэггүй. Тэгэхээр миний дуудлага чухал биш гэсэн үг үү гэх мэт асуулт танд байна уу?

Тэгвэл энэ бүх асуултад энэхүү ном хариулах болно. Бурханаас хүлээн авсан бэлэг авьяасаа үржүүлэн Түүнийг алдаршуулж амьдрахад тань энэ ном чиглүүлж тусална.

Татаж аваарай:  MessengerX.com

ХҮНДЭТГЭЛИЙН ШАГНАЛ:

Мартагдсан чанарын хүчийг тайлахуй



Христэд итгэдэг хүн Бурханыг хязгаарлахыг хүсэхгүй ч, олонх маань “хүндэтгэл” хэмээх сүнсний нэгэн зарчмыг мэдэхгүйгээсээ болоод амьдралд маань хүрэлцэх Бурханы чадварыг санаандгүйгээр хумидаг байна. Хүндэтгэл нь манай соёлд мартагдах шахсан ойлголт болсон хэдий ч, энэ нь Бурханы хаанчлалыг бидний амьдралын тал бүр дээр нэвтрүүлэгч гол судас болохыг та энэ номын хуудсаас харах болно.

Хүндэтгэлийн шагнал номдоо Жон Бивэр таныг Бурханы үнэлэмжийн системтэй зэрэгцүүлж, Бурханы ерөөл бүрийг хүлээн авах байр сууринд гаргах хүндэтгэх дуудлагыг хэрхэн хүлээж авахыг зааж өгчээ. Библийн хөдлөшгүй үнэнийг эдгээр зарчмыг үйл хөдлөл болгох хүчирхэг түүхтэй хавсаргасан энэ ном танд энэхүү мартагдсан чанарыг цоо шинээр харах хараа өгөхөөс гадна хамгийн чухал нь үүнийгээ амьдралынхаа тал бүр дээр хэрэгжүүлэх гал халуун хүсэл тэмүүллийг авчирна.


Татаж аваарай:



MessengerX.com



Газар газрын хүн бүрт зориулсан дагалдагчийн аян




- 110 гаруй хэл дээр үнэ төлбөргүй үзэх боломжтой.
- Апп хэлбэрээр ч, онлайн хэлбэрээр ч хэрэглэх боломжтой.
- Таны өсөлт төлөвшилд зориулагдсан материал.
- Өөрийн түүх, дагалдагчийн аяныг хянах боломжтой.



Бүх төрлийн төхөөрөмж дээр үзэх, унших, сонсох боломжтой цахим ном, сонсдог ном, богино хэмжээний кино, видео сургаал, Библи зэрэг дагалдагч бэлтгэхэд нэн шаардлагатай бүх материалыг Messenger сангаас хүлээн авна уу.

MessengerX.com



Дэлхий даяар App Store болоод Google Play дээр үзэх боломжтой.

**ХЭРХЭН АЙДСАА ЯЛЖ, АМЬДРАЛД ТАНЬ ӨГСӨН
БУРХАНЫ БЭЛЭГ АВЬЯАСЫГ БҮРЭН ХЭРЭГЛЭХ ВЭ?**

ҮГҮЙ гэж хэлэхэд хэцүү байна уу?

НҮҮР ТУЛАХААС та айж байна уу?

ТА ҮНЭТ ЗҮЙЛДЭЭ ЭРГЭЛЗЭЖ байна уу?

БУСДАД ТААЛАГДАХЫИН тулд шийдвэр гаргадаг уу?

БУСАД ХҮН ТАНЫГ ХЯНАХ гэдэг ѿ?

Хэрэв эдгээрийн аль нэгэнд нь та ТИЙМ гэж хариулж байгаа бол Айдсыг Ялахуй ном танд хэрэгтэй ном юм. Энэ ном айdas сүрдүүлгийг илчилж, айдсын савраас чөлөөлж, таны амьдралд өгсөн Бурханы бэлэг авьяас ба эрх мэдлийг хэрхэн эргүүлэн сэргээхийг зааж өгөх болно. Дарамт, ирээдүйн найдваргүй байдал, эргэлзээнээс чөлөөлөгдхөн цаг болжээ. Айдас таныг бүү хойш нь татаг!



ЖОН БИВЭР - шилдэг зохиолч, нэрт номлогч. Тэрбээр гэргий Лизагийн хамт 1990 онд Messenger International байгууллагыг үүсгэн байгуулжээ. Өдгөө тус үйлчлэл нь дэлхий даяар сайн мэдээ дэлгэрүүлж, 214 оронд “Мессенджер” нэртэй долоо хоног тутмын телевизийн нэвтрүүлэг цацдаг даян дэлхийн хэмжээний үйлчлэл болжээ. Жон Бивэр “Сatanы урхи”, “Эзэннээс эмэхүй”, “Эрх мэдэл дор” тэргүүтэй олон тооны хүчирхэг ном бичсэн юм. Жон Лиза хоёр дөрвөн хүүгийн хамт Америкийн Колорадо мужид аж төрдөг.



Үнэ төлбөргүй материал, видео дамжуулалтыг MessengerX.com хаягаас хүлээн авна уу.



MESSENGER
INTERNATIONAL
MessengerInternational.org

Энэхүү ном нь Зохиолчийн бэлэг.
ХУДАЛДАХЫГ ХОРИГЛОНО.

Илүүг эндээс

